

**Байгаль орчин, Аялал жуулчлалын
Яам**

**Биологийн олон янз байдлын тухай
конвенцын үндэсний VI тайлан
(2015-2018)**

(Санал авах эцсийн хувилбар)

Улаанбаатар

2019

Боловсруулж, эмхэтгэсэн багийн гишүүд:

Б.Батхуяг (PhD) – Багийн ахлагч & Редактор

Е.Батчулуун (PhD) – Зорилго 1 & 2

С.Гомбобаатар (PhD) – Зорилго 3 & 4 & Бүлэг VII, Монгол орны биологийн олон янз байдал

Б.Чимэддорж (Магистр) – Зорилго 3 & 4

Б.Мөнхчулуун (Магистр) – Зорилго 5

М.Дагвасүрэн (Магистр) – Зорилго 7 & 8

Г.Даваадорж (PhD) – Зорилго 6, 9 & 10

А.Бакей (PhD & ScD) – Зорилго 11, 12, 13 & 14

Оролцогчид:

С.Баярхүү (Нагоягийн протокол ба БНМ)

Ө. Баярсайхан (Орчуулга)

Ё.Онон (Байгалийн нөөцийн менежмент)

Б.Оюунтүлхүүр (Тусгай хамгаалалттай газар)

С.Пүрэвдорж (Ус ба бохирдол)

Г.Сэлэнгэ (Боловсрол)

М.Ууганбаяр (ГМС & Газрын зураг)

Агуулга

| | |
|---|----|
| Товчилсон үгийн тайлбар | 5 |
| I. Улсын хэмжээнд хэрэгжүүлэх зорилтын талаарх мэдээлэл | 7 |
| II. Үндэсний зорилтыг хангах шинжлэх ухаан, техникийн хэрэгцээ болон хэрэгжүүлэх арга хэмжээ тэдгээрийн үр нөлөөг үнэлэх болон тулгарах саад бэрхшээлүүд..... | 9 |
| ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛАЛ, ЗОХИСТОЙ АШИГЛАХ ТАЛААРХ ШИЙДВЭР ГАРГАГЧ, ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ ХАНДЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ..... | 9 |
| Зорилго 1. Бүх шатны боловсролын түвшний агуулгад тогтвортой хөгжлийн үзэл санааг тусгаж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн 5-аас доошгүй хувь нь энэ талаар мэдээлэл түгээдэг болох..... | 9 |
| Зорилго 2. Байгаль орчны мэдээллийн сангийн биологийн олон янз байдлын мэдээллийн нэр төрөл, хүртцийг нэмэгдүүлж, биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглахтай холбоотой шийдвэр гаргахад ашиглах тогтолцоог бүрдүүлэх | 17 |

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН НӨӨЦИЙН ТАЛААРХ ШИНЖЛЭХ
УХААНЫ ҮНДЭСЛЭЛД ТУЛГУУРЛАН ЗОХИСТОЙ АШИГЛАХ БОЛОН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ БИЙ
БОЛГОН ХЭРЭГЖҮҮЛЭХ..... 24

Зорилго 3. Эдийн засгийн ач холбогдолтой зүйлүүдийн генетикийн нөөцийг хамгаалах,
ашиглах, түүний үр өгөөжөөс шударга хүртэх эрх зүйн орчин бүрдүүлж зохистой ашиглах,
генетикийн доройтол, хомсдолоос сэргийлэх..... 24

Зорилго 4. Унаган, нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөрийг бүрэн
хэрэгжүүлэх..... 31

Зорилго 5. Экосистемийн үндсэн төлөөлөл тус бүрийн 30-аас доошгүй хувь, уур амьсгалын
өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг бүхэлд нь тусгай хамгаалалттай газар нутгийн
сүлжээнд хамруулж, менежментийг нь сайжруулах 37

Зорилго 6. Хөрс, усны нөөцийг химийн болон органик бохирдлоос хамгаалах..... 49

Зорилго 7. Ойн биологийн олон янз байдлыг хамгаалах болон ойн менежментийг сайжруулах
замаар 2025 он гэхэд ойгоор бүрхэгдсэн талбайн 9%-д хүргэж нэмэгдүүлэх..... 56

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ТОГТВОРТОЙ АШИГЛАХ НӨХЦӨЛИЙГ
ХАНГАХ 59

Зорилго 8. Төр, нутгийн иргэд болон хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох замаар
байгалийн нөөц, ялангуяа агнуурын амьтны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах
менежментийн арга хэрэгслийг нэвтрүүлэх 59

Зорилго 9. Малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулсан хууль эрх зүй, эдийн засгийн
хөшүүрэг бий болгон монгол орны бэлчээрийн доройтлыг 70 хүртэл хувиар бууруулж
сайжруулах..... 64

Зорилго 10. Тариалангийн үйлдвэрлэлийн техник технологи, үйл ажиллагааг орчныхоо
агробиоценоз дахь биологийн төрөл, зүйлүүдийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг
хангахад нийцүүлэн шинэчлэх 68

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ
ХАМГААЛАХ, АШИГЛАХ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ..... 70

Зорилго 11. Биологийн олон янз байдлын талаарх шалгуур үзүүлэлтийг үндэсний тооцооны
системд нэвтрүүлж, холбогдох салбарын хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний
тогтолцоонд тусган хэрэгжүүлэх 70

Зорилго 12. Байгаль орчны стратегийн үнэлгээнд үндэслэн хөдөө аж ахуй, эрдэс баялаг, дэд
бүтэц, эрчим хүч, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаас хэрэгжүүлж байгаа
биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа болон нөлөөлөх магадлалтай үйл
ажиллагаанд төсвөөс татаас болон хөнгөлөлт үзүүлэхгүй байх эрх зүйн орчин нөхцөлийг
бүрдүүлэх 75

Зорилго 13. Бэлчээр, усны нөөц, ойн экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, ач холбогдлыг
тооцож нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг тогтвортой хадгалах, байгалийн нөөцийг
зохистой ашиглах, хамгаалах тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх 82

| | |
|--|-----|
| Зорилго 14. Биологийн олон янз байдлын стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн боломжит гол эх үүсвэрийг тодорхойлж, үр нөлөөтэй ашиглах тогтолцоог бүрдүүлэх | 87 |
| III. Үндэсний зорилт тус бүрийн ахиц, дэвшил | 94 |
| IV. Биологийн олон янз байдлын Айчигийн зорилтод оруулсан үндэсний хувь нэмрийн тодорхойлолт | 96 |
| Биологийн олон янз байдлын Айчигийн зорилтуудын үр дүнд оруулсан хувь нэмэр | 96 |
| Тогтвортой хөгжлийн зорилгууд оруулж байгаа хувь нэмэр | 98 |
| V. Биологийн олон янз байдлын төлөв байдал | 98 |
| Ургамлын аймаг | 99 |
| Гуурст дээд ургамал | 99 |
| Хөвд | 103 |
| Замаг | 105 |
| Мөөг | 106 |
| Хаг | 109 |
| Бичил биетэн | 112 |
| Амьтны аймаг | 114 |
| Шавж | 114 |
| Загас | 118 |
| Хоёр нутагтан | 122 |
| Мөлхөгчид | 125 |
| Шувуу | 127 |
| Хөхтөн | 137 |
| Бүлэг V – Иш татсан бүтээлийн жагсаалт | 153 |

Товчилсон үгийн тайлбар

| | |
|------------|--|
| БОЯБК | Биологийн олон янз байдлын конвенц |
| ОНИН | Орон нутгийн иргэдийн нөхөрлөл |
| ТХБ | Тогтвортой хөгжлийн боловсрол |
| НХХААБ | НҮБ Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| ДДБОС | Даян дэлхийн байгаль орчны сан |
| ГТХАГ | Германы Техникийн хамтын ажиллагааны газар |
| ДНХЗДДБ | Дэлхийн нутагшуулсан болон харь зүйлийн даян дэлхийн бүртгэл |
| ГСГНМ/УННМ | Голийн сав газрын нэгдсэн менежмент / Усны нөөцийн нэгдсэн менежмент |
| БХ | Боловсролын хүрээлэн |
| БХОУХ | Байгаль хамгаалах олон улсын холбоо |
| ГУКХБ | Герман улсын KfW Хөгжлийн банк |
| НТБТ | Насан туршийн боловсролын төв |
| ОНХГ | Орон нутгийн хамгаалалттай газар |
| МШУА | Монголын Шинжлэх Ухааны Академи |
| БСШУЯ | Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам |
| БОАЖЯ | Байгаль орчин Аялал Жуулчлалын Яам |
| ХХААХҮЯ | Хүнс, Хөдөө Аж Ахуй Хөнгөн үйлдвэрийн яам |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| МУБИС | Монгол Улсын Боловсролын Их Сургууль |
| БОЯБСҮАХ | Биологийн олон янз байдлын стратеги, үйл ажиллагааны хөтөлбөр |
| ҮХГ | Үндэсний хөгжлийн газар |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| БОЯБҮХ | Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| МУИС | Монгол Улсын Их Сургууль |
| ХГ | Хамгаалалттай газар |
| ХГЗ | Хамгаалалттай газрын захиргаа |
| Т-ХХТ | Төр – хувийн хэвшлийн түншлэл |
| РDPR | Бог малын мялзан өвчин |

| | |
|-------|--------------------------------------|
| ТХЗ | Тогтвортой хөгжлийн зорилго |
| ТХГ | Тусгай хамгаалалттай газар |
| ТХГЗ | Тусгай хамгаалалттай газрын захиргаа |
| БХБ | Байгаль хамгаалал байгууллага |
| НХХ | НҮБ Хөгжлийн хөтөлбөр |
| ДДБХС | Даян Дэлхийн байгаль хамгаалах сан |
| ЛАСН | Лондоны Амьтан судлалын нийгэмлэг |
| БСШУЯ | Боловсрол соёл шинжлэх ухааны яам |
| МУБИС | Монгол Улсын Боловсролын Их Сургууль |
| МТ | Монгол төгрөг |

Улсын хэмжээнд хэрэгжүүлэх зорилтын талаарх мэдээлэл

Монгол Улс Биологийн олон янз байдлын тухай конвенцын 2011-2022 оны стратеги төлөвлөгөө болон Айчигийн зорилтод нийцүүлэн үндэсний биологийн олон янз байдлын хөтөлбөрийн зорилтуудыг тодорхойлсон

Эсвэл

Монгол Улс Биологийн олон янз байдлын конвенцын Айчигийн зорилтод үндэсний биологийн олон янз байдлын хөтөлбөрийн зорилтыг нийцүүлээгүй байгаа ба уг зорилтыг тайлбар болгон ашиглаж байна.

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025)

Монгол улс нь 1993 оны 9-р сарын 30-нд Биологийн олон янз байдлын тухай конвенцод нэгдэн орсноор БОЯБ-ын талуудын бага хурлын шийдвэр болон конвенцын шаардлагыг хэрэгжүүлэх, хариуцлага, үүргийг хүлээсэн. Конвенцод нэгдэн орсон улс орон бүр биологийн олон янз байдлын стратеги, төлөвлөгөөг боловсруулж биологийн олон янз байдалд нөлөө үзүүлдэг бүх салбарын үйл ажиллагаа болон төлөвлөгөөтэй уялдуулсан байх зөвлөмж гаргасан юм. Даян дэлхийн байгаль орчны сангийн санхүүгийн дэмжлэгээр 1994-1995 оны хооронд хамгийн анхны Биологийн олон янз байдлыг хамгаалах үндэсний хөтөлбөрийг боловсруулав. Анхны хөтөлбөрийн үр дүнг 2010 онд эцэслэн дүгнэж хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилт 96 хувьтай байна гэж дүгнэсэн.

2010 онд талуудын бага хурлын 10 дугаар хуралдаанаас Айчигийн Биологийн олон янз байдлын зорилтыг тусгасан биологийн олон янз байдлын конвенцын 2011-2002 стратеги төлөвлөгөөний зорилтуудыг баталсан юм. Нэмж хэлэхэд анхны Биологийн олон янз байдлын стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойших сүүлийн хорин жилийн турш Монгол улсад хөгжлийн бүхий л чиглэлд эрс өөрчлөлт гарсан юм.

Тиймээс 2014-2015 оны хооронд олон удаагийн зөвлөлдөх уулзалт хийгдэж 2015-2025 онуудад хэрэгжүүлэх биологийн олон янз байдлын хамгаалал болон тогтвортой менежментийг төрийн бодлого, шийдвэртэй уялалдуулсан Биологийн олон янз байдлыг хамгаалах үндэсний хөтөлбөр II-ийг боловсруулсан юм. Айчигийн зорилтод нийцүүлэн боловсруулсан тус үндэсний хөтөлбөр нь салбар болон салбар хоорондын бодлого, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангах замаар олон улсын конвенц болон одоо хэрэгжүүлж байгаа биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой менежментийг улам бэхжүүлэх юм.

Энэхүү үндэсний хөтөлбөр нь Монгол орны биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах зорилтыг хангасан 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд багтах 14 зорилго, 29 зорилт, 74 хүрэх үр дүнгээс бүрдэх бөгөөд 2015 оны 8-р сарын 4-ны Засгийн Газрын 325 дугаартай тогтоолоор баталсан.

БОАЖЯ-аас 2018 онд “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг” гаргав. Энэ удаагийн Үндэсний тайланд дунд хугацааны төлөвлөгөө хэрэгжиж эхлэхээс өмнө хийгдсэн үйл ажиллагааны үр дүнг оруулсан болно.

Үндэсний зорилго, шалгуур үзүүлэлт, болон Айчигийн зорилтуудтай холбогдох үндсэн зорилтуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн дөрөвдүгээр бүлэг болох “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл, зорилго, зорилт болон хүрэх үр дүн” хэсгээс харах боломжтой.

English: <https://www.cbd.int/doc/world/mn/mn-nbsap-v2-en.pdf>

Mongolian: <https://www.cbd.int/doc/world/mn/mn-nbsap-v2-mn.pdf>

II. Үндэсний зорилтыг хангах шинжлэх ухаан, техникийн хэрэгцээ болон хэрэгжүүлэх арга хэмжээ тэдгээрийн үр нөлөөг үнэлэх болон тулгарах саад бэрхшээлүүд

Доорх загварыг ашиглан өөрийн улс дахь үндэсний хэмжээний биологийн олон янз байдлын талаарх стратеги ба үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд авч буй үндсэн арга хэмжээнүүдийг тайлагнана. Түүнчлэн эдгээр арга хэмжээнүүдийн үр дүнгийн нөлөөний үнэлгээг хамт өгнө үү. Энэ загвар нь тайлагнасан арга хэмжээ бүрд ашиглагдах болно.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛАЛ, ЗОХИСТОЙ АШИГЛАХ ТАЛААРХ ШИЙДВЭР ГАРГАГЧ, ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ ХАНДЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Зорилго 1. Бүх шатны боловсролын түвшний агуулгад тогтвортой хөгжлийн үзэл санааг тусгаж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн 5-аас доошгүй хувь нь энэ талаар мэдээлэл түгээдэг болох

Зорилт 1. тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгч болон олон нийтийн хамтын ажиллагааг уялдуулах, сайжруулах

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ


2010 онд батлагдсан “Боловсрол”-ын үндэсний хөтөлбөрт бүх түвшний боловсролын агуулгад тогтвортой хөгжлийн үзэл санааг тусгах, өөрийн болон бусад үндэсний түүх, соёлд хүндэтгэлтэй хандан улмаар бүтээлч, шинээр сэтгэх ур чадварыг төлөвшүүлэх урьдач зарчмыг оруулсан.

2018 онд батлагдсан “Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хөтөлбөрт бүх түвшний сургалтын хөтөлбөр болон боловсролын бодлогод нийцсэн “байгалийн нөөцийг ариглан, аюул осолгүй, эрүүд, байгаль орчинд ээлтэй амьдралын хэв маяг”-ийг тодорхойлсон бүлэг зорилтыг оруулсан. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд шууд нөлөө үзүүлсэн бодлогын хэрэгжилтийн гол ололтуудыг боловсролын түвшин тус бүрд доорх байдлаар нэгтгэн оруулав.

Боловсрол, Соёл Шинжлэх ухааны яам (БСШУЯ) 2014 онд сургуулийн өмнөх боловсролын түвшинд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зургаан чиглэлийг багтаасан “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-ийг баталсан. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах нь “Тогтвортой хөгжил 2030” зорилгын шалгуур үзүүлэлтийн нэг бөгөөд 2017 оны байдлаар Монгол улсын хувьд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 92.1 хувь нь хамрагдаад байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахын тулд сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаанд оролцдог 3 багш тутмын нэг нь багшлах үйл ажиллагааны стандартын дагуу мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтад жил бүр хамрагдаж (1 багц цаг буюу 24 цаг) багшлах арга зүйгээ сайжруулах, сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх мөн интерактив сургалтын арга зүй зэрэгт суралцдаг.

БСШУЯ-аас 2011 онд тогтвортой хөгжлийн боловсролын зарчмуудыг бага болон дунд сургуулийн хөтөлбөрт нийцүүлэх ажлын хэсгийг бий болгож “12 жилийн боловсролын хөтөлбөрт Тогтвортой хөгжлийн боловсролын агуулгыг оруулах нь” гарын авлагыг боловсруулан хөгжүүлэв. Улмаар 2015 онд БСШУЯ-аас “Бага болон дунд сургуулийн хичээлийн хөтөлбөр болон сургалтын үйл ажиллагаанд Тогтвортой хөгжлийн боловсролын агуулгыг нийцүүлэх ерөнхий чиглэл болон шаардлага” баримтыг батлав.

Уламжлалаас харахад, Монгол улсын хувьд сургуульд хамрагдах хувь их өндөр, тухайлбал 2017 онд бага сургуулийн насны хүүхдийн 96.3 хувь нь, дунд сургуулийн насны хүүхдийн 94 хувь нь, нийт Монголын хүн амын 20.1 хувь нь сургуульд суралцаж байна. Хүйсийн тэнцвэртэй байдлын ялгааны индексийн хувьд 1.00, хүйсийн тэнцвэрт байдлын ялгаа бага гардаг ба энэ харьцаа нь бага сургуулийн хувьд (0.95), дунд сургуулийн хувьд (0.98), ахлах сургуулийн хувьд (1.19) тус тус байна.



Зураг 1. ТХЗ-ын суралцахуйн зорилтод харгалзах цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын тархалт (хувиар) (Эх сурвалж. Н.Нэргүй нар, 2018)

2018 онд гарсан үнэлгээний тайланд сургалтын хөтөлбөрт Тогтвортой хөгжлийн зорилгууд тусгагдсан байдал харилцан адилгүй байгаа бөгөөд тухайлбал ТХЗ-ын 3 дахь зорилго нь хамгийн их тусгагдсан бол ТХЗ-ын 14 дэх зорилго нь хамгийн бага орсон байна. Түүнчлэн, бага боловсролын бүх хөтөлбөрийн 25.0%, суурь боловсролын хөтөлбөрийн 38.3%, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн 36.7%-д ТХЗ ямар нэг хэмжээгээр тусгагдсан байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт 2012 онд байгуулагдсан сургуулийн өмнөх, бага, суурь болон бүрэн дунд боловсролын багш нарын чадавхыг сайжруулах, мэргэжил дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж эхэлсэн болно. Тус институт дээр нэг жилд 5070 багш (үндэсний хэмжээнд нийт багш нарын 13.7%) мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж байгаа бөгөөд багш нарт зориулсан энэхүү сургалтын хөтөлбөрт Тогтвортой хөгжил, Ногоон хөгжил ба ТХБ-д холбогдох сэдвүүд тусгагдаж байна.

Коллеж болон их сургуулийн түвшинд БСШУЯ-аас 2014 онд гаргасан ерөнхий гурван удирдамжийн дагуу сургалтын хөтөлбөрийг хөгжүүлж байна. Эдгээр удирдамжийн дагуу коллеж, их сургууль бүрт Хөтөлбөрийн хороо ажиллаж тухайн мэргэжилд шаардлагатай сургалтын хөтөлбөр боловсруулж байна. 2018 оны байдлаар, 96 их сургууль, коллежоос 72 их сургуулийн 250 хөтөлбөр нь Магадлан Итгэмжлэх Үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэгдсэн бөгөөд 18 их сургуулийн 90 хөтөлбөр олон улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдээд байна. Магадлан итгэмжлэлийн нэг шалгуур үзүүлэлт нь ТХЗ, ТХБ-ын үзэл санааг сургалтын хөтөлбөр болон үйл ажиллагаандаа тусгасан байдал байдаг. Гэвч энэ нь их

сургууль болон коллежийн түвшинд төдийлөн хангалттай бус, үндэсний хэмжээнд хийсэн тодорхой үнэлгээ байхгүй байна.

Хайрцаг 1. ТХБ-Их, дээд сургуулийн түвшинд хэрэгжиж буй жишээ

- Байгаль орчин, Аялал жуулчлалын Яам болон НҮБ-ын Дасан Зохицох сангийн дэмжлэгтэйгээр “Уур амьсгал ба Экосистем”, “Уур амьсгалын өөрчлөлт ба Нийгэм” мөн “Уур амьсгалын өөрчлөлт, нөлөөллийг бууруулах ба дасан зохицох” гэсэн 3 модуль бүхий 2 кредит цагийн “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуйн сургалтын хөтөлбөр” боловсруулсан ба үүнийг 2016 оноос МУБИС-д заавал судлах хичээл болгон судалж байна.
- Хүмүүнлэгийн их сургууль “Хүрээлэн буй орчны сэтгүүл зүй” мэргэжлийн ангид “Экологи, Тогтвортой хөгжил” сэдэвт 3 багц цагийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ мэргэжлээр жил бүр 20 оюутан суралцаж байна.
- МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургууль дээр “Тогтвортой хөгжил” сэдэвт 2 багц цагийн хичээлийг заавал үзэх хичээл болгон ордог.

2014-2018 оны хичээлийн жилийн байдлаар их сургууль болон коллеж төгсөгчдийн 26.1 хувь нь бизнесийн удирдлага, 27.5 хувь нь хуулийн мэргэжлээр суралцсан ба нийт оюутны 59.4 хувь нь эмэгтэй байна. Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгагдаж буй Тогтвортой хөгжлийн зорилтын зарчим, үзэл санаа нь удаан хугацаанд үр нөлөөгөө үзүүлэх тул одоогоор тодорхойлох боломж хомс байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 гэхэд, Тогтвортой хөгжлийн үзэл санааг бүх шатны сургалтын хөтөлбөрт тусган боловсон хүчнийг чадавхжуулсан байна.

Тогтвортой хөгжлийн боловсролын зарчмыг бүх түвшний боловсролын системийн агуулгад (сургуулийн өмнөх, бага, дунд, ахлах болон их сургууль) тусган бага болон дунд сургуулийн багш нарын чадавхыг дээшлүүлэх, давтан сургалтад хамруулах үйл ажиллагааг тогтмол явуулж байна.

Холбогдох вэб хуудас, холбоос болон файлууд

Бурмаа, Б., нар (2011). Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг ерөнхий боловсролын 12 жилийн сургалтын хөтөлбөрт тусгах нь. БСШУЯ, ШХА, хуудас 81, Соёмбо принтинг ХХК, УБ

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 дугаар тушаал

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаал

БШУ-ны Сайдын 2014 оны А/240-р тушаалын хоёрдугаар хавсралт

Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/370 дугаар тушаал

БШУ-ны Сайдын 2015 оны А/220-р тушаалын хавсралт

БШУС-ын “Чиглэл батлах тухай” 2015 оны А/458 дугаар тушаал

БСШУЯ, МУБИС, 2018, “ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт тогтвортой хөгжлийн үзэл санаа, агуулга, арга зүй тусгагдсан байдлын судалгаа”, Улаанбаатар, хуудас 210.

БСШУСЯ. (2018). Статистик мэдээ. УБ.

Нэргүй, Н., нар. (2018). ЕБС, Цэцэрлэгийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрт ТХБ-н үзэл санаа, агуулга, арга зүй тусгагдсан байдлыг үнэлэх судалгаа. Улаанбаатар: БМДИ.

“Хөдөөгийн, нүүдэлчин болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох” төслийн тайлан, 2014


Зорилго 1. Бүх шатны боловсролын түвшний агуулгад тогтвортой хөгжлийн үзэл санааг тусгаж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн 5-аас доошгүй хувь нь энэ талаар мэдээлэл түгээдэг болох;

Зорилт 2. Иргэдэд тогтвортой хөгжлийн үзэл санааг системтэй, цогц байдлаар олгох.

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Улс орны нийгэм-эдийн засгийн хөгжилд тогтвортой хөгжил, ТХБ-ын зарчмуудыг тусган тодорхойлсон бодлогын баримт бичиг Монгол улсад цөөнгүй байдаг. Эдгээр бодлогын баримт бичгүүдээс дурдвал Боловсролын тухай хууль (2015 онд нэмэлт өөрчлөлт хийсэн), Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024 (2015), “Боловсрол 2021” үндэсний хөтөлбөр (2010), “Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хөтөлбөр (2018), Ногоон хөгжлийн бодлого (2014) болон 2016 онд их хурлаас баталсан Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 зэрэг болно.

Эдгээр бодлогын баримт бичгүүдийн нийтлэг зүйл нь i) ТХБ-ын үнэт зүйлсийг онцгойлон авч үзсэн; ii) бүх насны бүлгүүдэд ТХБ-ыг хэрхэн олгох; iii) сургалтын олон янз хөтөлбөрүүдэд ТХБ-ыг хэрхэн тусгаж нийцүүлэхийг онцол авч үзсэн байдаг. Бүх түвшний боловсролын үйл ажиллагаанд ТХБ-ын зарчим, чиглэлүүдийг оруулж эхэлсэн эхний үе 2016 оноос хойш ТХБ-ын тухай ойлголт, зарчим, оролцоо улам бүр нэмэгдсээр байна.



Зураг 2. Эко сургууль, иргэдийн байгаль орчны боловсролын талаар бодлого, хөтөлбөрүүдэд туссан байдал

Тогтвортой хөгжил ба ТХБ-ын үзэл санааг хүргэх түгээн дэлгэрүүлэхэд “Эко-клуб”, “Эко-сургууль” зэрэг санаачилга ихээхэн үр дүн өгч байгаа бөгөөд үүнийг олон улсын болон иргэний нийгмийн байгууллагууд, мөн засгийн газраас ч ихээхэн дэмжиж байна. Монгол улсад “Эко-сургууль” санаачилга нь “Байгаль орчны боловсролын сан”-гийн гишүүн болох “Байгаль орчны мэдээлэл, сургалтын төв” ТББ-ын чиглүүлэг, удирдлагын дор IS 14001/ISO 14001 стандартын дагуу хэрэгжиж байна. 2015 оноос эхлэн энэхүү санаачилгыг “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн хүрээнд дэмжин ажиллаж байна. 2018 оны байдлаар, “Эко-сургууль”-ийн гэрчилгээ авсан сургууль 286 (Монгол улсын нийт сургуулийн 35.5%), цэцэрлэг 4 байгаа нь энэ санаачлагад сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын оролцоо маш бага байгааг харуулж байна.



Эко-клубүүд нь тухайн орон нутгийнхаа онцлогт тулгуурлан байгаль орчин, экологийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг уламжлал тогтоод удаж байна.

ТХБ-ын үзэл санааг албан бус боловсролын хэлбэрээр түгээн дэлгэрүүлэхэд үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд үйл ажиллагаагаа явуулдаг насан туршийн боловсрол (НТБ)-ын байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэж байна (Зураг 3). 2018 оны байдлаар “Насан туршийн боловсролын үндэсний төв” (НТБҮТ) –өөс гадна шулсын хэмжээнд НТБ-ын 425 төвд 630 хүн ажиллаж байна.



Зураг 3. НТБ-ын тогтолцоогоор дамжуулан ТХБ олгох байдал

2014-2018 оны хооронд НТБҮТ нь хөдөө орон нутагт тогтвортой хөгжил ба ТХБ-д зориулсан сургалтыг 36 удаа зохион байгуулсан байна. 2014 оноос эхлэн хэрэгжүүлсэн энэ сургалтад олон хүн хамрагдаж (Зураг 4) оролцоо сайжран, үр шимийг хүртэгчдийн тоо нэмэгдсээр байгаагаас гадна сургалтад хамрагдагсдын ихэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь Судалгаанаас харагдаж байна (Зураг 5).



Зураг 4. НТБ-ын төвүүдэд явагдсан сургалт ба хамрагдсан суралцагчдын тоо (2014-2018)

Зураг 5. НТБ-ын сургалтад оролцогчдын хүйсийн харьцаа

Гэвч энэхүү судалгааны дүнгээс үзэхэд ногоон хөгжил, ТХБ болон тогтвортой хөгжлийн тухай олон нийтийн ойлголт хангалтгүй хэвээр байгаа бөгөөд ялангуяа судалгаанд оролцогчдын дунд биологийн олон янз байдлын тухай ойлголт бүр ч тааруу байна (хүснэгт 1). Уг судалгаанаас үзэхэд нийслэл хот болон аймгийн хэмжээнд оролцоо хангалттай сайн (нийслэлд 45.6%, аймагт 33.5%) хэдий ч анхан шатны нэгж дээр хангалттай бус (7.3%) байна.

Хүснэгт 1. ТХ/НХ/ТХБ-ын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг

| | Хариулт | | |
|---|---------------|----------------|----------------|
| | Сайн | Хангалтгүй | Мэдэхгүй |
| ТХ/ТХБ-ын үндсэн ойлголтуудын талаар мэднэ. | 11,2% (60) | 76.8% (409) | 12% (64) |
| Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлогын талаар мэднэ. | 10.1% (54) | 64.1% (342) | 25.8% (137) |
| Экологийн ул мөрийн талаар мэднэ. | 7.3% (39) | 79.6% (424) | 13.1% (70) |
| Уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэднэ. | 6.1% (32) | 79.7% (425) | 14.2% (76) |
| Биологийн олон янз байдлын талаар мэднэ. | 1.7% (9) | 81.9% (437) | 16.4% (87) |

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
 Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
 Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд, Тогтвортой хөгжлийн боловсролын талаар бүх насныханд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны бодлого, төлөвлөгөөтэй болсон байна.

Нийгмийн олон нийтийн хувьд тогтвортой хөгжил болон ТХБ-ын зарчмуудыг удаан хүлээн авч байгаа үл харгалзан үзэх юм бол, улс орны хэмжээнд үндэсний бодлого болон хөтөлбөрүүдэд ТХ-ийн зорилгуудыг нийцүүлж хангах тал дээр гайхалттай амжилт, дэвшилттэй байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

Бурмаа, Б., нар (2011). Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг ерөнхий боловсролын 12 жилийн сургалтын хөтөлбөрт тусгах нь. БСШУЯ, ШХА, хууд..81, Соёмбо принтинг ХХК, УБ

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 дугаар тушаал

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/174 дүгээр тушаал

БШУ-ны Сайдын 2014 оны А/240-р тушаалын хоёрдугаар хавсралт

Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/370 дугаар тушаал

БШУ-ны Сайдын 2015 оны А/220-р тушаалын хавсралт

БШУС-ын “Чиглэл батлах тухай” 2015 оны А/458 дугаар тушаал

БСШУЯ, МУБИС, 2018, “ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт тогтвортой хөгжлийн үзэл санаа, агуулга, арга зүй тусгагдсан байдлын судалгаа”, Улаанбаатар, хуудас 210.

БСШУСЯ. (2018). Статистик мэдээ. УБ.


Нэргүй, Н., нар. (2018). ЕБС, Цэцэрлэгийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрт ТХБ-н үзэл санаа, агуулга, арга зүй тусгагдсан байдлыг үнэлэх судалгаа. Улаанбаатар: БМДИ.

“Хөдөөгийн, нүүдэлчин болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох” төслийн тайлан, 2014

Зорилго 2. Байгаль орчны мэдээллийн сангийн биологийн олон янз байдлын мэдээллийн нэр төрөл, хүртцийг нэмэгдүүлж, биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглахтай холбоотой шийдвэр гаргахад ашиглах тогтолцоог бүрдүүлэх
Зорилт 3. Биологийн олон янз байдлын талаарх судалгааны ажлыг дэмжих төр, хувийн хэвшлийн тогтолцоо, эдийн засгийн хөшүүргийг бий болгох

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Улсын болон бусад талуудын дэмжлэгтэйгээр биологийн олон янз байдлын үнэ цэнэ, хамгаалал, тогтвортой менежментийг хангах чиглэлээр олон тооны эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийгдэж байна. Тухайлбал Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Байгаль орчин, Аялал жуулчлалын яам (хуучин нэрээр Байгаль орчин, Ногоон Хөгжлийн яам)-ны саналд үндэслэн тусгагдсан зарим арга хэмжээний зардлыг улсын төсөвт тогтмол хуваарилан олгож байна. 2012-2018 онд Засгийн газраас ногоон технологийг дэмжих, ноу-хау нутагшуулах, үр ашигтай нөөцийн хэрэглээ, дахин ашиглалт болон дахин боловсруулах ялангуяа бохир усыг цэвэршүүлэх үйл ажиллагаанд зориулан 25,550.00 сая төгрөг (10 сая гаруй ам.доллар) хуваарилжээ. Энэхүү үйл ажиллагаа болон Шинжлэх, ухаан технологийн сангаар дамжуулан байгаль орчинтой холбоотой төсөл, биологийн олон янз байдлын чиглэлийн судалгааны ажлуудад нийт 900,000 орчим ам. долларын санхүүжилт хийсэн байна. Биологийн олон янз байдлын болон байгаль орчны эдгээр судалгааны ажилд их сургуулиуд, ялангуяа Монгол Улсын Их сургууль онцгой байр суурьтай оролцож ирснээс гадна Монголд үйл ажиллагаагаа явуулдаг олон улсын ТББ-ууд, бусад төсөл хөтөлбөрүүд ч чухал үүрэг гүйцэтгэж байна.



Зураг 6. Байгаль орчны чиглэлээр гарсан бүтээл болон тайлан, байгууллагуудаар (2012-2018)

Сүүлийн жилүүдэд, ШУА, их дээд сургуулийн эрдэмтэн судлаачдын өгүүллүүд Томсон Ройтерсийн индексийн жагсаалтад багтсан олон улсын сэтгүүлд олноор хэвлэгдэх болсон нь Монгол улсад хийгдэж буй судалгааны үр дүн олон улсын түвшинд хүрч буйг илтгэж байна. Гэвч, эдгээр судалгааны ажлууд зөвхөн гадаад хэл дээр хэвлэгдэж, олон нийтэд хүрэх явдал

хязгаарлагдмал байгаагаас гадна судалгааны үр нөлөө тодорхойгүй байна. Жишээ нь: гадны хөрөнгөө оруулалтаар санхүүжүүлсэн усны нөөцийн менежментийн төслийн хүрээнд англи болон бусад гадаад хэл дээр 84 судалгааны өгүүлэл хэвлэгдсэн ч монгол хэл дээр нэг ч ном, тайлан гараагүй нь уг төслийн ололт, үр дүн Монголын байгаль хамгааллын салбарын үйл ажиллагаанд огт хамааралгүй болгоход хүргэж байна.

Олон улсын түвшинд хэвлүүлсэн төдийгүй үндэсний түвшинд хийсэн ихэнх судалгааны үр дүн, тэдгээрээс гарсан сургамж, туршлага зэрэг нь орон нутгийн үйл ажиллагаа ба бодлого боловсруулахад дэмжлэг болж чадахгүй байна.

- Дээр дурдсан нөхцөл байдал биологийн олон янз байдлын хамгааллын талаар хувийн салбарт хийгдэж буй судалгаа, түүний тогтвортой ашиглалт, мэдээлэл сурталчилгааг бий болгоход чиглэн дэмжиж санхүүжүүлсэн ажлын үр өгөөж хангалтгүй болоход ч нэгэн адил нөлөөлж байна. Амьтны тухай шинэ хуульд дахь зэрлэг амьтдын популяцийн тоо толгойн үнэлгээ дээр суурилсан ангийн зөвшөөрлөөр 12 аймагт байгаа агнуурын 60 бүс нутагт хувийн аж ахуйн нэгж болон нутгийн иргэдийн нөхөрлөлүүд хариуцан зэрлэг амьтан болон агнуурын амьтны үнэлгээнээс 300 сая төгрөгийн (ойролцоогоор 120,000 ам. дол.) орлого төсөвт оруулахаар болсон.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд, Биологийн олон янз байдал (цаашид “БОЯБ” гэх)-ын үнэ цэнэ, ач холбогдол, хамгаалал, зохистой ашиглалттай холбоотой нэн шаардлагатай судалгааны ажлыг төр, хувийн хэвшил хамтран санхүүжүүлэх тогтолцоог бий болгосон байна.

Засгийн газар, олон улсын байгууллагууд, их сургуулиуд болон олон улсын ТББ нь биологийн олон янз байдлын хамгааллын судалгаа, тогтвортой ашиглалт болон мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэхэд чиглэсэн ихэнх судалгааны ажлуудыг санхүүжүүлж байна. Биологийн олон янз байдалтай холбоотой судалгааны ажил болон агнуурын менежментэд оролцох хувийн секторын үйл ажиллагаа, оролцоо сул хэвээр байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

Annex to the Government Resolution # 120. 2012

Annex to the Government Resolution # 45. 2016

Зорилго 2. Байгаль орчны мэдээллийн сангийн биологийн олон янз байдлын мэдээллийн нэр төрөл, хүртцийг нэмэгдүүлж, биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглахтай холбоотой шийдвэр гаргахад ашиглах тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 4. Биологийн олон янз байдлын үнэ цэнэ, ач холбогдол, хамгаалал, зохистой ашиглах талаарх мэдээллийг шийдвэр гаргагч болон олон нийтэд ойлгомжтой, системтэйгээр хүргэх тогтолцоог бүрдүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол улсад хэрэгжиж буй бүх хөтөлбөр, стратеги, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн менежмент болон тогтвортой ашиглалттай холбоотой ад холбогдох бодлогын баримт бичиг, хөтөлбөрт олон нийтийн ойлголт, мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэхэд чиглэсэн заалт тусгагдсан байдаг. Монгол улсын Засгийн газар 1999 онд байгаль орчны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, зохицуулах чиглэлээр Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн.

Гэвч байгаль орчны боловсрол, мэдээлэл сурталчилгааг дээшлүүлэх чиглэлээр 2008-2012 онд хэрэгжүүлсэн ажлуудын үр дүнгээс үзэхэд энэ чиглэлээр зөвхөн улсын байгууллагуудаас хийж хэрэгжүүлсэн тайлан мэдээлэл голлож, хувийн хэвшлийн оролцоо хангалтгүй хэвээр байгаа нь харагдаж байна.

“Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хөтөлбөрийг 2018 онд баталсан нь олон нийтийн дунд тогтвортой хөгжил, байгаль хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон байгаль орчинд ээлтэй, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлахад чиглэсэн бодлогын чухал баримт бичиг болсон юм. Хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон 4 зорилтын 3 зорилт нь олон нийтийн сурталчилгаа ба оролцоог хангахад чиглэж; i) тогтвортой үйлдвэрлэл, ii) боловсрол, мэдээллийн хүртээмжийг тэгш, шударга түгээх; iii) Тогтвортой хөгжлийн боловсролыг хэрэгжүүлэхэд бүх салбарын бодлого, салбар дундын зохицуулалт хийх тухай тус тус заасан байдаг.

Хэвлэлийн хүрээлэнгээс сүүлийн 20 жилийн турш Монголын хэвлэл мэдээллийн салбарын тайланг жил бүрээр нэгтгэн гаргаж байна. Энэ тайлангаас харахад 2018 оны 5-р сарын байдлаар улсын хэмжээнд 434 хэвлэл мэдээллийн байгууллагад 4462 хүн ажиллаж байгаа нь 2017 оныхтой харьцуулахад цаасан хэвлэл буюу сонин сэтгүүлийн тоо цөөрч, хүн амын ихэнх хэсэг (судалгаанд оролцогчдын 90%) нь мэдээллийг телевизээс авч байгаа бөгөөд мэдээллийн хоёр дахь том эх үүсвэр нь интернэт болж байна (судалгаанд оролцогчдын 48.3%). Энэ нь интернэтийн хурд сайжирсан, нийгмийн сайтуудыг хэрэглэгчдийн өссөнтэй холбоотой юм. Гэвч байгаль орчинтой холбоотой мэдээлэл 2006 оноос хойш тогтвортой, 2018 оны байдлаар хэвлэгдэн гарч байгаа сонин сэтгүүлийн мэдээний 1.7%, радио, телевизийн нэвтрүүлгүүдийн 1.3% нь л зөвхөн байгаль орчны асуудлуудыг хөндсөн байна.

Энэ асуудлыг шийдэхийн тулд 2009 оноос Хэвлэлийн хүрээлэн, НҮБХХ, ХХАБ, ТХЗ болон Дэлхийн байгаль хамгаалах сангийн санаачилгаар сэтгүүлчдийн мэргэжлийн ур чадварыг

сайжруулах, байгаль орчны сэтгүүл зүйг хөгжүүлэх зорилгоор “Ногоон дэлхий” сэтгүүлчдийн клубийг бий болгосон. ТХБ төслийн хүрээнд сэтгүүлч болон сургагч багш нарт зориулан “Ногоон хөгжил, ТХБ ба тогтвортой хөгжлийн талаар ярилцлага” гарын авлага гаргажээ.

Хайрцаг 2. “Тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол, ногоон хөгжлийг сурвалжлахуй” Сэтгүүлчдийн албан бус боловсролд зориулсан сургагч багшийн гарын авлага, 5 модульд багтах 21 хичээлийн сэдэв

1. Тогтвортой хөгжлийг сурвалжлахуй
2. Тогтвортой хөгжлийн боловсролыг сурвалжлахуй
3. Байгаль орчны сэтгүүл зүй
4. Уур амьсгалын өөрчлөлт
5. Байгалийн нөөцийн ашиглалт
6. Байгаль орчны бохирдол
7. ISO 14000 цуврал стандарт
8. Ногоон эдийн засаг ба ногоон хөгжлийн бодлого
9. Ногоон эдийн засагт шилжих шилжилт
10. Тогтвортой ба ногоон үйлдвэрлэл, тогтвортой ба ногоон хэрэглээ
11. Компанийн нийгмийн хариуцлага
12. Ногоон ажлын байр ба ногоон оффис
13. Ногоон худалдан авалт
14. Нийгмийн хүртээмжийг сурвалжлахуй
15. Жендер ба сэтгүүл зүй
16. Хүний эрхийн асуудлууд ба хүмүүнлэгийн сэтгүүл зүй
17. Хэвлэл мэдээллийн хөгжлийн шалгуур үзүүлэлт, мэргэжлийн ёс зүй ба сэтгүүлчийн нийгмийн хариуцлага
18. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй
19. Цахим сэтгүүл зүй
20. Дата сэтгүүл зүй
21. Иргэний сэтгүүл зүй, орон нутгийн хэвлэл мэдээлэл болон хүйн радио

ТХБ төслийн хүрээнд 2018 онд хийсэн үнэлгээгээр судалгаанд оролцогчдын 40 хувь нь тогтвортой хөгжлийн талаарх өөрсдийн мэдлэгээ хангалтгүй, 55.5 хувь нь тодорхой хэмжээний мэдлэгтэй, 3.9 хувь нь маш сан мэдлэгтэй гэж үзжээ. Энэхүү судалгаанд оролцогчдын хандлагаас үзэхэд байгалийн баялгийг хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгаль орчинд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй үйлдвэрлэлийг илүү чухалд үзсэн байв. Мөн хөдөө орон нутаг болон хот, суурин газрын иргэдийн хувьд мэдээллийн хэрэгцээ ялгаатай байгааг энэ үнэлгээ харуулсан болно.



Зураг 7. Байгаль орчин ба тогтвортой хөгжлийн мэдээлэл авах олон нийтийн хэрэгцээ

Засгийн газар болон олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр төрөл бүрийн мэдээллийн сан, веб сайт ажиллан, мэдээлэл цуглуулах, түгээхэд чухал байр эзэлж байна. Тухайлбал, БОАЖЯ-ны “Байгаль орчны мэдээллийн сан нь” (www.gov.mn, www.i.gov.mn) нь ГМС болон хиймэл дагуулын өгөгдөлд суурилсан газрын зураг, бусад нарийвчилсан мэдээлэл агуулдаг ба хэрэглэхэд хялбар, 30 дэд сангаас бүрдэж байна. Энд буй мэдээллийн жагсаалтыг г хайрцаг 3-г үзүүлэв.

Хоёр дахь чухал мэдээллийн сан нь ШУА-ийн Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн (<http://irt.igg.gov.mn>) 10 салбарын, мэдээллийн 6 төрөл (газрын зураг, видео, илтгэл, ном, судалгааны өгүүллэг болон тайлан) бүхий 441 эх сурвалжаас бүрдсэн портал сайт юм.

БОАЖЯ нь “Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн сан” төслийн хүрээнд 2017 онд Биологийн олон янз байдлын Ангилал зүйн үндэсний зөвлөлийг байгуулсан. Уг зөвлөлийн шинжээчид одоогийн байдлаар 1 зүйлийн дугариг амтан, 77 зүйлийн загас, 6 зүйлийн хоёр нутагтан, 23 зүйлийн мөлхөгч, 513 зүйлийн шувуу, 140 зүйлийн хөхтөн амьтан нийт 760 зүйлийн нугаламт амьтад, 5,919 зүйлийн нугаламгүйтэн амьтад (187 зүйлийн шимэгч хорхой, 15 зүйлийн шимэгч, 94 зүйлийн туузан хорхой, 69 зүйлийн дугариг хорхой, хатгуур толгойт хорхой, 46 зүйлийн нематод, 90 зүйлийн хүрд хорхой, 34 зүйлийн зөөлөн биетэн, хэвэл хөлтөн, 545 зүйлийн аалз хэлбэртэн, 10 зүйлийн сахал хөлт хавч, 22 зүйлийн салаа сахалт хавч, циклоп, 50 зүйлийн хавч хэлбэртэн, 103 зүйлийн өдөрч, 59 зүйлийн шулуун далавчтан, 56 зүйлийн хаварч, 3166 зүйлийн цох, 9 зүйлийн шимэгч бөөс, 143 зүйлийн сарьсан далавчтан, хуниасан далавчтан, 71 зүйлийн шоргоолж, 198 зүйлийн хоовгон, 186 зүйлийн бүүрэг, нохой бөөс, 573 зүйлийн хайрсан далавчтан, 46 зүйлийн шумуул, 166 зүйлийн тэмээлзгэнэ), 3163 зүйлийн гуурст ургамал, 570 зүйлийн хөвд, 2248 зүйлийн замаг, 630 зүйлийн мөөг, 1069 зүйлийн хаг, 241 төрлийн бичил биетэн тус тус тэмдэглээд байна (Gombolt et al. (eds), 2019). Биологийн олон янз байдлын мэдээллийн санд эдгээр бүх нугаламтан болон нугаламгүйтэн амьтанд бүртгэгдээд байна.

Хайрцаг 3. Байгаль орчны мэдээллийн сангийн бүрдэл (eis.mn)

1. Газар ашиглалт
2. Хөрс
3. Газрын хэвлий, ашигт малтмал
4. Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын лавлагаа
5. Ус, рашаан
6. Ой
7. Амьтан
8. Байгалийн ургамлын мэдээллийн сан
9. Агаарын бохирдлын мэдээллийн сан
10. Гадаад орчны цацрагийн түвшний мэдээллийн сан
11. Уур амьсгалын мэдээллийн сан
12. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн мэдээллийн сан
13. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн мэдээллийн сан
14. Зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдаа, ан агнуурын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан
15. Байгаль орчинд ээлтэй технологийн мэдээллийн сан
16. Байгаль орчны статистик тайлангийн мэдээллийн сан
17. Байгалийн гамшгийн мэдээллийн сан
18. Тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан
19. Байгаль орчны эрх зүйн мэдээллийн сан
20. Хог хаягдлын мэдээллийн сан
21. Химийн хорт болон аюултай бодисын мэдээллийн сан
22. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан
23. Бодлого, төсөл, хөтөлбөрийн мэдээллийн сан
24. Мета мэдээллийн сан
25. Орчны доройтол, бохирдлын мэдээллийн сан
26. Цөлжилтийн мэдээллийн сан
27. Гео-мэдээллийн сан
28. Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээллийн сан
29. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн мэдээллийн сан
30. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүний нөөцийн мэдээллийн сан

Гэхдээ, эдгээр мэдээллийн сангийн ашиглалтын үр өгөөжийн талаар хийгдсэн судалгаа, дүн шинжилгээ байхгүй байгаа. Шийдвэр гаргагчид болон олон нийтийн хувьд мэдээллийн санг ашиглах явдал нь алдаг оног хэдий ч шинжлэх ухаан болон боловсролын салбарт ажиллаж байгаа хүмүүс, тодорхой сэдвээр сонирхож буй хүмүүст эдгээр мэдээллийн сан нь ихээхэн ашиг тустай байдаг.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилгод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2016 он гэхэд, БОЯБ-ын төлөв байдлыг илтгэх мэдээллийн төрөл, агуулга, цуглуулах арга замыг тодорхойлсон байна;
- 2018 он гэхэд Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлогод БОЯБ-ын үнэ цэнэ, ач холбогдлын талаарх мэдээллийг системтэйгээр нэвтрүүлэхэд чиглэсэн арга хэрэгслийг тусгасан байна.

Монгол улсын хувьд олон нийтэд мэдээллийг түгээх, боловсруулах, цуглуулах мэдээллийн сангийн сүлжээг бий болгосон. Гэхдээ, эдгээр мэдээллийн сангийн ашиглалтын үр өгөөжийн талаар хийгдсэн судалгаа, дүн шинжилгээ байхгүй байна. Шийдвэр гаргагчид болон олон нийтийн хувьд мэдээллийн санг тогтмол буй ашигладаг хэдий ч шинжлэх ухаан болон боловсролын салбарт ажиллаж байгаа хүмүүс, тодорхой сэдвээр сонирхож буй хүмүүс түлхүү ашиглаж байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

Gombobaatar, S., Shar, S., Aibek, U., Gerelmaa, G. and Bayarkhuu, S. 2019. Biodiversity of Mongolia: a checklist of invertebrate and vertebrate animals. V.1. National University of Mongolia, Ministry of Environment and Tourism and Mongolica Publishing. Ulaanbaatar, Mongolia. 317 pp.

Gombobaatar, S., Suran, D., Soninkhishig, N., Batjargal, B., Sunjidmaa, R. and Gerelmaa, G. (eds). 2019. Biodiversity of Mongolia: a checklist of plants, fungi and microorganisms. V.2. National University of Mongolia, Ministry of Environment and Tourism and Mongolica Publishing. Ulaanbaatar, Mongolia. 420 pp.

Survival and the Knowledge of Biodiversity in the Public and Sustainable Development and Gender Diversity in Mongolia. (2018). SD Report, United Nations Development Programme. Ulaanbaatar

<https://www.legalinfo.mn/annex/details/8620?lawid=13595>

https://drive.google.com/file/d/1K4ccW4p7sFOwzXigw7DdrH_-9I5sQ13r/view

http://esd.mn/wp-content/uploads/2016/10/Base-line-report_Mon.pdf.

<http://www.icc.mn>

<http://irimhe.namem.gov.mn>

<https://igg.ac.mn>

<http://portal.igg.ac.mn>

<http://eic.mn>

www.mongol-species.mn

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН НӨӨЦИЙН ТАЛААРХ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛД ТУЛГУУРЛАН ЗОХИСТОЙ АШИГЛАХ БОЛОН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ БИЙ БОЛГОН ХЭРЭГЖҮҮЛЭХ

Зорилго 3. Эдийн засгийн ач холбогдолтой зүйлүүдийн генетикийн нөөцийг хамгаалах, ашиглах, түүний үр өгөөжөөс шударга хүртэх эрх зүйн орчин бүрдүүлж зохистой ашиглах, генетикийн доройтол, хомсдолоос сэргийлэх

Зорилт 5. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх малын үүлдэр, омог, унаган болон таримал ургамлын сорт, тэдгээрийн зэрлэг овог, төрөл, зүйлийг бүртгэлжүүлэх, төлөв байдлын үнэлгээ хийх, хомсдолоос хамгаалах

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх бичил биетэн, ургамал, амьтны генетик нөөц болон түүнтэй холбоотой мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах, судлах харилцааг зохицуулахад чиглэгдсэн Генетик нөөцийн тухай хуулийг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Генетик нөөцийн тухай хууль гарснаар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх амьтан, ургамал, бичил биетний гаралтай үнэ цэнэ бүхий генетик нөөцийг олж илрүүлэх, бүртгэх, ашиглах, хамгаалах, тэдгээртэй холбоотой мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, тэдгээрийн өмчлөлтэй холбоотой харилцаа болон үндэсний генийн сан байгуулах нөхцөл бүрдэнэ.

2017 оноос эхлэн НҮБХХ-ийн санхүүжилт, дэмжлэгтэйгээр “Нагояагийн протоколыг хэрэгжүүлэх хүний нөөц, эрх зүйн орчин, байгууллагын чадавхыг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн зорилго нь i) үндэсний хууль эрх зүйн орчныг бий болгох ii) үндэсний эрх бүхий байгууллагууд, холбогдох агентлаг, шинжлэх ухааны байгууллага, судалганы хүрээлэн болон бусад оролцогч талуудын буюу хувийн хэвшил, орон нутгийн чадавхыг бэхжүүлэх iii) уламжлалт мэдлэгийг хамгаалах чиглэлээр бүтцийг бий болгох, хөгжүүлэх iv) генетик нөөцийн ашиглагчид ба эзэмшигчдийн хооронд итгэлцлийг бий болгох механизмыг сайжруулах v) генетик нөөцийн ач холбогдол, хэрэглээг олон нийтэд таниулах сурталчилгаа хийх зэрэг болно. Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын нутаг дэвсгэр дэх генетик нөөц болох гэрийн тэжээвэр амьтан, унаган болон таримал ургамал тэдгээрийн зэрлэг өвгийг илрүүлэх, бүртгэх, ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

Шинжлэх ухааны байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс 2012-2017 оны хооронд байгалийн ургамал, амьтан болон бичил биетнийг экспортлохоор гаргасан 1450 гаруй мэдүүлгийг Гаалийн ерөнхий газар хянан шийдсэн байна. Гэсэн ч Монголын адил зах зээлийн үнэ өртөг нь хэдэн

арван сая доллароор хэмжигдэх хил, гаалиар дамжин нэвтэрч байгаа амьтан, ургамал, бичил биетэн болоод эдгээрийн генетик нөөцийг ашиглан ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулж байгааг хянах боломжгүй байна. НҮБХХ-ийн санхүүжүүлэн БОАЖЯ-ны захиалгаар хийгдсэн “Монгол улсад генетик нөөц ашиглалтын ирээдүйн чиг хандлага, түүнээс хүртэх эдийн засгийн үр ашиг” судалгааны дүн нь Монгол улс нь хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, биотехнологи, эрүүл мэндийн салбар дахь генетик нөөцийн ашиглалтаас 2.5 их наяд төгрөгийн (~1 тэрбум ам. доллар) ашиг хүртэх боломжтойг харуулсан.

Эдгээрээс үзэхэд Монгол улс нь хэдэн их наяд доллароор хэмжигдэх генетик болон биологийн нөөц баялагтай. Иймд Монгол улсад генетик нөөцийг ашиглах, судлахдаа олон улсын стандарт, шаардлагад нийцсэн генетик нөөцийн эдийн засгийн эргэлтийг харгалзан үзэх шаардлагатай.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилгод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2017 он гэхэд, Генетик нөөцийн ашиглалтын талаарх нөхцөл байдлын судалгаа хийгдсэн байна.
- 2020 он гэхэд, Генетик нөөцийн судалгаа хийж уламжлалт мэдлэгийг бүртгэн мэдээллийн санд оруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, генетик нөөцийг тогтвортой ашиглах эрх зүйн баримт бичгийг батлан мөрдүүлж, үйл ажиллагааны нэгдсэн удирдлагатай болгоно.

Монгол улсын нутаг дэвсгэрийн хүрээнд малын үүлдэр, омог, байгалийн болон үр тарианы ургамлын олон төрлийг тодорхойлж бүртгэх, тэдгээрийн байгаль дээрх холбоотой зүйлийг бүртгэх, суурийг бий болгох зорилгоор “Нагоягийн протоколыг хэрэгжүүлэх хүний нөөц, эрх зүйн орчин, байгууллагын чадавхыг бэхжүүлэх” төслийг 2017 оноос эхлүүлэв.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<http://www.mn.undp.org/content/mongolia/en/home/projects/strengthening-human-resources--legal-frameworks--and-institution.html>

www.fk.mn/undp/bs.mn

<https://www.legalinfo.mn/law/details/13051>

Зорилго 3. Эдийн засгийн ач холбогдолтой зүйлүүдийн генетикийн нөөцийг хамгаалах, ашиглах, түүний үр өгөөжөөс шударга хүртэх эрх зүйн орчин бүрдүүлж зохистой ашиглах, генетикийн доройтол, хомсдолоос сэргийлэх

Зорилт 6. Хөрс, усыг химийн болон шим бодисын бохирдлоос хамгаалах

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол улс Нагояагийн протоколын оролцогч тал бөгөөд Нагояагийн протоколын Мэдээлэл Солилцох Нэгдсэн Системийн бүрэлдэхүүн хэсэг болох 8 мэдээллийн сангийн 2-ыг нь нэвтрүүлсэн бөгөөд одоо боловсруулан, хэлэлцүүлж байгаа Генетик нөөцийн тухай хууль батлагдсаны дараа үлдсэн мэдээллийг оруулахаар ажиллаж байна. Мөн “Нагояагийн протоколыг хэрэгжүүлэх хүний нөөц, эрх зүйн орчин, байгууллагын чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд мэдээллийн нэгдсэн сан, мэдээлэл солилцох нэгдсэн систем хөгжүүлэхээр ажиллаж байна. Энэ веб нь дараах мэдээллүүдээс бүрдэнэ:

- Нагояагийн протоколын танилцуулга
- Генетик нөөцийн тухай хууль
- Генетик нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин
- Үндэсний зохицуулагчийн танилцуулга
- Үндэсний удирдлагын газар
- Генетик нөөцийн үнэ цэний тухай мэдээлэл
- Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн үнэ цэний тухай мэдээлэл
- Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн мэдээллийн сангийн холбоосууд

Одоог хүртэл хэвлэгдсэн мэдээлэлд үндэслэн Монгол улсын боломжит генетик нөөцийг (хүснэгт 2) уламжлалт мэдлэг, түүний ашиглалт, хамгаалалт болон ургамал, амьтан, бичил биетний биологи, экологийн мэдээллийг давхар оруулан тодорхойлоод байна. Энэ мэдээллийн санд нэвтрэх эрх нь шийдвэр гаргагчид, судлаачид, хувийн салбар, төрийн бус байгууллага, нөхөрлөл болон оюуны өмчийн байцаагч зэрэг хэрэглэгчдийн ялгаатай байдлаас хамааран өөр өөр байна. Одоогийн байдлаар мэдээллийн сан нь дараах мэдээллүүдийг агуулж байна:

- Ардын эмчилгээнд хэрэглэдэг амьтны биеийн хэсэг 212, бүтээгдэхүүн гаргахад ашигладаг амьтны биеийн хэсэг 53, хөдөө аж ахуйд ашигладаг амьтны биеийн хэсэг 2
- 276 овгийн 561 зүйлийн ургамлыг ардын эмнэлгийн 558 жорд ашиглаж, 90 зүйл ургамлыг нүүдэлчдийн өдөр тутмын ахуй хэрэгцээнд, 50 зүйл ургамлыг хүнсэнд хэрэглэдэг.
- Бичил биетний мэдээллийн санд одоогоор 53 омгийн бичил биетний мэдээлэл байна. Эдгээр бичил биетнүүдийг хөрс, ургамлын үндэс, уламжлалт сүүн бүтээгдэхүүн, төрөл бүрийн исгэлтийн хөрөнгө (талхны хөрөнгө гэх мэт.), монгол оронд ургадаг байгалийн жимс, жимсгэнэ, өвчин үүсгэгчийг тээгч мэрэгч амьтад, хортон шавж, төл, залуу амьтдын ходоод гэдэсний агуулагдахуун болон газрын тос зэрэг төрөл бүрийн эх үүсвэрээс ялгаж авсан байна.
- Хөдөө аж ахуйн салбарт 127 уламжлалт мэдлэг бүртгэсний 63% нь тэжээл бэлтгэх, 23.6% нь хоол хүнс боловсруулах, 12.6% нь гар урлал, уламжлалт аргаар бүтээгдэхүүн хийх, 0.8% нь бордоо хийх уламжлалт мэдлэг тус тус байна.
- Монголын эрдэмтэд уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг 11,000 гаруй жорыг тогтоогоод байна. Эдгээрээс ардын эмнэлэгт чухал байр эзэлдэг 200 орчмынх нь амьтан, ургамлын хэсгүүдээс бүрдэх жорын найрлагыг нарийвчлан судлаад байна. Энэ

200 жорд 300 орчим зүйлийн эмийн ургамал, 100 орчим амьтны гаралтай хэсэг ордог бөгөөд эдгээрээс 150 зүйл ургамлыг нь олон улсад хэрэглэдэг байна.

Хүснэгт 2. Генетик нөөцийн мэдээллийн сангийн бүрдэл (2018 оны байдлаар)

| Ангилал зүйн бүлэг/салбар | Зүйлийн тоо | Уламжлалт мэдлэгийн хэрэглээний төрөл | | | | |
|---------------------------|-------------|---------------------------------------|-----|------------|------|------|
| | | Эм | ХАА | Үйлдвэрлэл | Хүнс | Ахуй |
| Амьтан | 102 | 212 | 2 | 53 | | |
| Ургамал | 561 | 558 | | | 50 | 90 |
| Бичил биетэн | 53 | | | | | |
| ХАА-н салбар | 127 | | 127 | | | |
| Эмзүйн салбар | 11000 | 11000 | | | | |

Дарханы Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн нь олон жилийн турш таримал ургамлын генетик нөөцийг цуглуулах, хадгалах ажлыг хийж байна. Тус хүрээлэнгийн гений банк нь үр тарианы 70 сортын 20,500 янзын үр, эмийн ургамлын 1300 үр, ашигт ургамлын 245 зүйлийн үрийг хадгалж, ашиглахын зэрэгцээ туршилтын талбайд үр тарианы 70 сортын 135 үрийг хадгалж байна.

“Нагояагийн протоколыг хэрэгжүүлэх хүний нөөц, эрх зүйн орчин, байгууллагын чадавхыг бэхжүүлэх” төсөл нь монголын тэргүүлэх хэвлэл, мэдээллийн агентлагаас сонгож авсан 20 сэтгүүлчээс бүрдсэн олон нийтэд генетик нөөцийн мэдээлэл, сурталчилгаа болон генетик нөөцийн хууль эрх зүйн орчны хэрэгцээ шаардлагыг түгээх мэдээлэл, сурталчилгааны багийг бий болгосон. Төслийн гүйцэтгэлийн үр дүнг хуваалцах, генетик нөөцтэй холбоотой бодлог, техникийн мэдээллийг зорилтот бүлэг болон олон нийтэд хүргэх зорилготой фейсбүүк (www.facebook.com/undbs.mn) хуудсыг үүсгэсэн.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд, Генетик нөөц, хувиргасан амьд организмын бүртгэлийн систем, сан бүрдүүлэх мэдлэг, туршлагыг бий болгосон байна.

Хувиргасан амьд организм болон генетик нөөцийн бүрэн гүйцэд бүртгэсэн мэдээллийн сан бий болоогүй. Гэсэн хэдий ч хэвлэлийн материал дээр үндэслэн мэдээллийн санд Монгол улсын боломжит генетик нөөцийг тодорхойлон оруулаад байна. Мэдээллийн санд ахуйн хэрэглээ, үйлдвэрийн үйл ажиллагаа, хүнс, хөдөө аж ахуй, эмийн үйлдвэрт ашигладаг 102 зүйлийн амьтан, 561 зүйлийн ургамал, 53 зүйлийн бичил биетнийг бүртгэсэн. Мөн Дарханы Ургамал газарзүйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн генийн банканд үр тарианы 70 сортын 20,500 үр, эмийн ургамлын 1300 үр болон ашигт ургамлын 245 зүйл байна.

Хувиргасан амьд организмын зохицуулалттай холбоотой Биоаюулгүй байдлын Картагены протоколын хэрэгжилтийн үндэсний тайланг 2010-2016 оны байдлаар хэвлэж гаргасан. Энэхүү тайлан монгол англи хэлээр бичигдсэн. Монгол улсад ашиглагдаж байгаа, гарган авсан, судалгаа шинжилгээний зориулалттай хувиргасан амьд организмын дүн бүртгэлийн хувд судалгааны түвшинд 3 зөвшөөрөл олгогдсон. Мөн Төв, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул аймгийн нутагт овъёосны, тосны ургамал тариалагдаж байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/law/details/536>

www.facebook.com/undp.abs.mn

<http://www.mn.undp.org/content/mongolia/en/home/projects/strengthening-human-resources--legal-frameworks--and-institution.html>

<http://www.biosafety.mn>

<http://bch.cbd.int>

Bayarsukh, N. (2015). Strengthening the conservation and sustainable use of plant genetic resources for food and agriculture in Mongolia. Journal of agricultural sciences №15 (02) pp. 173-179

Narantsetseg, Ya. Namjilsuren, J. Ayursaikhan, T. Research on Genetic Resources of Food and Agriculture of Mongolia

Ochgerel, N. Enkhtuya, L. (2019). Collection of genes of herbaceous herbs and plants. Ulaanbaatar, Mongolia. pp. 1-272.

Зорилго 3. Эдийн засгийн ач холбогдолтой зүйлүүдийн генетикийн нөөцийг хамгаалах, ашиглах, түүний үр өгөөжөөс шударга хүртэх эрх зүйн орчин бүрдүүлж зохистой ашиглах, генетикийн доройтол, хомсдолоос сэргийлэх

Зорилт 7. Генетикийн нөөцийг ашиглах, үр өгөөжийг шударга хүртээх тухай хууль эрх зүйн орчин бүрдүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол улсын Их Хурлаар баталсан “Тогтвортой хөгжлийн зарчмууд -2030”, “Ногоон хөгжлийн бодлого”, Монгол улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2015) зэрэг нь генетик нөөц болон холбогдох мэдлэгийн эрх зүйн орчныг бүрдүүлж байна.

Энэ хүрээнд БОАЖЯ-аас Генетик нөөцийн тухай хуулийг боловсруулах ажлын хэсгийг томилон ажиллуулж байна. 2018 оны 2-р сард Байгаль Орчны сайд ажлын хэсгийнхэнтэй генетик нөөцийн тухай хуулийн төсөл, явцын үр дүн болон олон улсын генетик нөөцийн хамгаалал, генетик нөөцөөс хүртэх мөнгөн ба мөнгөн бус ашиг тусын талаарх туршлага дээр үндэслэсэн хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага болон генетик нөөцийн уламжлалт мэдлэгийн мэдээллийн сан, үндэсний аргачлалын зарчмуудын талаар уулзав.

Хайрцаг 4. Генетик нөөцийн тухай хуулийн онцлох заалтууд

1 хэсэг. Хуулийн зорилт, хамрах хүрээ, зарчим, генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг эзэмшигч, мөн генетик нөөцтэй холбоотой Төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг, үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ хууль нь генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгээс хүртэх нутгийн иргэдийн ашиг, эрхийг хамгаалах мөн генетик нөөцийг ашигласнаас үүдэх үр шим, ашгийг тэгш шударгаар хуваах хүртээх зарчмыг тодорхойлсон.

2 хэсэг. Генийн мэдээллийн санг үүсгэх, уламжлалт мэдлэгийг хамгаалах, генетик нөөцийг хамгаалах, уламжлалт мэдлэгтэй холбоотой мэдээлэл болон генетик нөөцийг нэгтгэсэн мэдээллийн нэгдсэн сангийн уялдааг зохицуулсан.

3 хэсэг. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах зохицуулга, хуулийн этгээд эсвэл гадаадын хуулийн этгээдийн генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглахад хэрэгтэй үндэслэл, уламжлалт мэдлэгийг эзэмшигчтэй хийх харилцаа, генетик нөөцийг арилжааны зорилгоор ашиглах тохиолдолд генетик нөөцийг эзэмшигч төрийн байгууллага болон уламжлалт мэдлэгийг эзэмшигчтэй хийхэд шаардлагатай харилцааг зохицуулна.

4 хэсэг. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглаж байгаа талаар тайлагнах мөн хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг зохицуулна.

Генетик нөөцийн тухай хууль нь Монгол улсын нутаг дэвгэр дээрх генетик нөөцийн менежменттэй холбоотой бүхий л чиглэлийг хамарч, генетик нөөцийн ашиглалт, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хадгалж, хамгаалах, судлах, бүртгэх болон тэдгээрийг

ашигласнаас үүдэх үр шим, ашгийг шударга, тэгш хүртээх харилцааг зохицуулна. Өөрөөр хэлбэл, энэ хууль нь гэрийн мал, хөдөө аж ахуйн таримал ургамлаас бусад ургамал, амьтан, бичин биетнээс гаргаж авсан генетикийн нөөц, мөн эдгээртэй холбоотой уламжлалт мэдлэгийн харилцааг зохицуулна.

Генетик нөөцийн тухай хуулийг боловсруулах явцад “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийг 2017 оны 12-р сарын 14-нд Монгол Улсын Их Хурлын чуулганаар батлав. Энэ хууль нь өмнөх “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах” тухай хуулийг сольж малын генетик нөөцийн талаарх дэлхийн чиг хандлага, малын генетик нөөцийг хамгаалах зайлшгүй хэрэгцээг тусгасан болно.

Малын генетик нөөцийн тухай хуулийг баталсан нь мал аж ахуйн бүтээгдэхүүнээр хүн амыг хүнсээр хангах, үндэсний боловсруулах үйлдвэрүүдэд сайн чанарын малын түүхий эд нийлүүлэх, мөн малын генетик нөөцийг ашиглах менежментийг сайжруулснаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг хадгалах болон экологийн тэнцвэрт байдлыг хангахад чухал холбогдолтой. Энэ хууль нь мөн малын үүлдэр, угсааг сайжруулах, шинээр үүлдэр, омог гаргах, малын тэжээл, мал тэжээх, адгуулах технологи болон малын генетик нөөцийн экспорт, импортын үйл ажиллагаанд хяналт тавих, харь зүйлийн тархалтаас сэргийлэх эрх зүйн орчныг тодорхой болгох юм. Мөн оролцогч талуудын эрх, үүргийг хуульд нарийвчлан тогтоосноор малын генетик нөөцийг судлах, хамгаалах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд тодорхой болгож, Монгол улсыг олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл бүрдэнэ.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилгод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

➤ 2017 он гэхэд, Генетик нөөцийн эрх зүйн нөхцөл байдлын судалгаа хийгдсэн байна. Малын генетик нөөцийн тухай хууль 2017 онд батлагдаж, ингэснээр Монгол улсад үндэсний хэмжээнд малын генетик нөөцийг ашиглах, судлах, хөгжүүлэх хууль эрх зүйн суурь тавигдсан.

Генетик нөөцийн тухай хууль нь төслийн шатандаа байгаа бөгөөд энэ хууль нь Монгол улсын нутаг дэвсгэрийн хүрээнд генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хадгалж, хамгаалах, судлах, бүртгэх болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр шим, ашгийг шударга, тэгш хүртээх харилцааг зохицуулна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/law/details/536>

www.facebook.com/undp.abs.mn

<http://www.mn.undp.org/content/mongolia/en/home/projects/strengthening-human-resources--legal-frameworks--and-institution.html>

Ochgerel, N. Enkhtuya, L. (2019). Collection of genes of herbaceous herbs and plants. Ulaanbaatar, Mongolia. pp. 272.

Зорилго 4. Унаган, нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх

Зорилт 8. Монгол орны унаган, нэн ховор, ховор зүйлийг цогцоор хамгаалах, ашиглах хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол улсын засгийн газрын 2011 оны 277 тоот тогтоолоор баталсан “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-т ховор, нэн ховор зүйлийн талаар өргөн цар хүрээтэй боломж олгосон. Энэ хөтөлбөр нь хоорондоо уялдаа холбоо бүхий нэн ховор, ховор амьтдын тоо толгой цөөрөхөөс сэргийлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах, зүйлийг байгалийн жамаар өсөж үржих, тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, цөм популяцийг хамгаалж, өсгөн үржүүлэх замаар популяцийг өсгөх зорилттой.

Амьтны тухай хуульд зэрлэг амьтныг нэн ховор (Дэлхийн байгаль хамгаалах холбооны “Устаж байгаа” зэрэглэлтэй дүйцүүлэн), ховор (уг холбооны “Устаж болзошгүй” зэрэглэлтэй дүйцүүлэн) ангилсан бөгөөд Монгол орон дахь 31 зүйл (дэд зүйл) хөхтөн, шувуу болон загас нь нэн ховор буюу “Устаж байгаа” амьтны жагсаалтад орсон байна. Гэсэн хэдий ч дээрх хууль болон холбогдох хавсралтад 14 зүйлийн хөхтөн, 24 зүйлийн шувуу, 1 зүйлийн загас, 1 зүйлийн дугариг амтан, 20 зүйлийн шавж, 2 зүйл хавч хэлбэртэн, 4 зүйлийн зөөлөн биетэн орсон байдаг ч зүйл, дэд зүйлийн шинжлэх ухааны нэр ихэд зөрүүтэй бичсэн нь хамгаалал, хариуцлага тооцох ажлын үр нөлөөг бууруулах боломжтой. Тийм учир Үндэсний хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт хийхдээ энэ зөрүүтэй байдлыг зайлшгүй засах шаардлагатай.

Хайрцаг 5. Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөрийн зорилтууд

Зорилт 1. Нэн ховор, ховор амьтдын тоо толгой буурах, амьдрах орчин доройтохоос урьдчилан сэргийлэх болон тэдгээрийг байгалийн жамаар нөхөн сэргээх, өсөлтийг хангахтай холбогдсон эрх зүй, эдийн засгийн орчныг сайжруулах;

Зорилт 2. Нэн ховор, ховор амьтдыг уугуул нутагт нь хамгаалж, байгалийн жамаар өсөж, үржих нөхцөлийг хангах зорилгоор тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, менежментийг сайжруулах;

Зорилт 3. Үндэсний болон дэлхийн хэмжээнд устах аюулд орсон амьтдыг сэргээн нутагшуулах, зориудын орчинд өсгөн үржүүлэх, удмын санг хадгалах замаар тэдгээрийн тоо толгойн тогтвортой өсөлтийг хангах дэвшилтэт арга технологийг нэвтрүүлж, ашиглах;

Зорилт 4. Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн нөөцийн хомсдол болон уур амьсгалын өөрчлөлтөөс нэн ховор, ховор зүйлийг хамгаалах салбар хоорондын уялдааг зохицуулах бодлогыг хэрэгжүүлэх;

Зорилт 5. Нэн ховор, ховор зүйлийн талаар иж бүрэн судалгааны ажлыг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх, мөн шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх болон олон нийтэд нэн ховор зүйлийн талаар мэдлэг олгох мэдээлэл, сурталчилгааг хүргэх зэрэг болно.

Нэн ховор, ховор зүйлийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг баталснаас хойш уг хөтөлбөрийн хэрэгжилтэд нэгдсэн дүн шинжилгээ хийгээгүй.

2018 онд, БОАЖЯ-наас үндэсний хөтөлбөрийн гүйцэтгэлийг ойролцоогоор 80%-тай байна гэж үнэлсэн (зорилт 1 нь 86%; зорилт 2 нь 85%; зорилт 3, 4, 5 нь хувьд 87, 72, 70% гэсэн тус тус гүйцэтгэлтэй). Гэсэн хэдий ч нэн ховор, ховор зүйлийн талаарх мэдээлэл нь 2011 оноос өмнөх буюу Үндэсний хөтөлбөр батлагдахаас өмнөх өгөгдөл, баримт болно.

Сүүлийн 20 гаруй жилийн судалгааны дүнгээр Монгол орны нэн ховор, ховор амьтан болох мазаалай баавгай багадаа 28, хүрэн баавгай 500, баданга хүдэр 6500, Төв Азийн минж 300, голын халиу 100, суусар булга 3500, цоохор ирвэс 900-1200, тахь 649, халиун буга 10000 орчим, хулан 10000, янгир 11000, аргаль 13000, молцог хандгай 16400, хавтгай тэмээ 800-1200, цаа буга 140-200, хар сүүлт 12000, зэрлэг гахай 35000, Монгол бөхөн 4000 гаруй тоо толгой тус тус байгаа ажээ. Түүнчлэн цагаан зээр 3 сая орчим байна (Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018, БОАЖЯ 2019 он).

Үндэсний хөтөлбөрт нэмэлт өөрчлөлтийг оруулахдаа зүйлүүд, тэдгээрийн амьдрах орчинд үзүүлж буй бусад хүчин зүйлсийн нөлөөг тооцох, олон улсын болон үндэсний хэмжээний арга хэрэгслийг ашиглан гаргасан амьтдын тоо толгойн өөрчлөлтийн үнэлгээний үр дүнг оруулах хэрэгтэй.

Дээр дурдсан цөөн ололт амжилт нь Амьтны тухай хууль болон бусад хууль эрх зүйн орчинд хуулийн давхцал, цоорхойг илрүүлэх, мөн зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах хууль, түүний холбогдох эрх зүйн журам заалтуудыг сайжруулах зорилгоор оролцогч талуудын хамтран зохион байгуулсан олон талт үйл ажиллагааны үр дүн юм.

Биологийн олон янз байдлын ангилал зүйн үндэсний зөвлөлийг байгуулсан нь Монголын биологийн олон янз байдлын ангилал зүйн асуудалд зөвлөх, зохицуулах, нэн ховор болон шинэ зүйлийг бүртгэх, нэн ховор зүйлийн статусыг тогтоох, тэдгээрийн хамгаалал, тогтвортой менежментийн үйл ажиллагааны зөвлөмж гаргах, мөн Монгол улсад нэн ховор зүйлийн хамгааллын үйл ажиллагааг оновчтой болгоход чухал алхам боллоо.

2015 оны хооронд аргаль, тахь, халиун буга болон янгирыг сэргээн нутагшуулах, эдгээр нэн ховор зүйлийн генетик олон янз байдлыг нэмэгдүүлэх зарим ажлуудыг гүйцэтгэсэн. 2017-2018 онд Прагын амьтны хүрээлэнгээс 8 тахь авчирч Их говийн дархан цаазат газрын Б хэсэгт суллав.

Амьтны тухай хуульд заасны дагуу агнуурын мэргэжлийн компани болон нөхөрлөл нь агнуурын тодорхой бүс нутагт ховор зүйлийн спорт агнуурыг зохион байгуулах тогтвортой менежментийн үйл ажиллагааг зохион байгуулдаг. 2018 онд 81 аргаль, 38 буга, 92 янгир агнах, 490 тул загасны “барих-буцаан тавих” зөвшөөрлийг агнуурын бүс нутагт ангийн менежментийн төлөвлөгөөнд үндэслэн өгчээ.

Нэн ховор, ховор амьтныг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд агнуурын 60 бүс нутагт зарцуулсан 300 сая төгрөг (~120.000 ам дол.)-өөс өөр тодорхой санхүүгийн дэмжлэг энэ чиглэлээр хомс байна. 2014-2016 онд агнуурын нөөцийн менежмент, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон популяцийн үнэлгээг гаргах судалгаанд 1.5 тэрбум төгрөг зарцуулаад байна.

Монгол орны ургамлын аймаг нь 25 овгийн 64 төрлийн 151 унаган зүйлийг агуулдаг. Эдгээр зүйлээс 8 зүйл нь нэн ховор, 27 зүйл нь ховор, 3 зүйл нь үлдвэр зүйл, 20 зүйл нь Улаан номд, 8 зүйл нь Улаан дансанд тус тус орсон.

Хүснэгт 3. Монгол орны гуурст ургамлын улаан жагсаалт (Ургамал ба бусад, 2019)

| Улаан дансны зэрэглэл | Үнэлсэн зүйлийн тоо (2012) | Үнэлсэн зүйлийн тоо (2019) |
|-----------------------|-------------------------------|-------------------------------|
| Устаж байгаа | 16 | 31 |
| Устаж болзошгүй | 39 | 109 |
| Эмзэг | 55 | 164 |
| Ховордож болзошгүй | 22 | 79 |
| Анхааралд өртөхөөргүй | 10 | 42 |
| Мэдээлэл дутмаг | 4 | 60 |
| Үнэлэх боломжгүй | 2 | 5 |
| Бүгд | 148 | 490 |

2017-2018 онд Монгол улсын “Биологийн олон янз байдлын мэдээллийн санг” бий болгоход МУИС, ШУА, бусад их дээд сургууль, ТББ-ын судлаач, шинжээчид эмийн болон зарим унаган зүйл ургамлыг агуулсан 471 зүйл ургамлын морфологи, амьдрах орчин, тархалт, хамгааллын статус, хэрэглээ болон тариалах арга зүйгээс бүрдсэн мэдээллийн санг үүсгэсэн (Гомбобаатар ба бусад, 2018).

Хүснэгт 3-т үзүүлсэн Монгол орны гуурст ургамлын төлөв байдал нь түгшүүрийн дохио асаасан хэдий ч 2015 онд анхны хувилбарыг нь гаргасан нэн ховор, ховор ургамлын зүйлийг

хамгаалах, түүний тогтвортой менежментийг тусгасан “Байгалийн ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөр” нь одоог хүртэл батлагдаагүй.

2018 онд Ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж салбарын судлаач, эрдэмтдийн дунд хэлэлцүүлэн цаашид боловсронгуй болгон нэгтгэх явц үргэлжилж байна. Ургамлын тухай шинэчилсэн хууль батлагдсанаараа ургамлын нөөцийг нөхөн сэргээх, зохистой ашиглах, байгалийн ургамал, тэдний олон янз байдлыг хамгаалах бодлогыг сайжруулах болно.

2013 онд БОНХ сайд болон Зам, Тээврийн сайд нар зэрлэг амьтан, түүний амьдрах орчин болон зэрлэг амьтдын нүүдлийн зам, байгаль орчинд зам, тээврийн үзүүлэх нөлөөг багасгах түүний норм, стандартыг тогтоох, холбогдох хууль, эрх зүйн орчныг сайруулах чиглэлээр ажиллаж зөвлөх хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай А-192/145 дугаартай хамтарсан тушаал гаргав. Энэ ажлын дүнд Монгол улс нь Төв Азийн орнуудаас анх удаа “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр замын дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц” байгуулах стандарттай болсон. Энэхүү санаачилга нь улмаар ДДБХС санаачилга болон бусад талуудын дэмжлэгтэйгээр 2018 онд хамтран боловсруулсан “Уулархаг нутгийн авто зам, замын байгууламжийн дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц” байгуулах стандарт болсон юм. Энэ хоёр стандарт нь цаашид улам бүр өсөж байгаа уул уурхайн үйлдвэрлэлийн дэд бүтцийн хэрэгцээ, өсөлтийн дагууд нэмэгдэх Монгол орны замын сүлжээнд зэрлэг амьтныг нэвтрүүлэх гарц байгуулах боломжийг олгож байгаа юм.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилгод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Unkn

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2016 он гэхэд, Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны хэрэгжилтийн үнэлгээ хийсэн байна.
- 2018 он гэхэд, Дэд бүтцийн хөгжлийг БОЯБ-д ялангуяа нүүдлийн зүйлд ээлтэй, сөрөг нөлөө багатай төлөвлөх салбар хоорондын уялдааг хангасан байна.

Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн гүйцэд үнэлээгүй ч БОАЖЯ-наас хийсэн үнэлгээгээр үндэсний хөтөлбөрийн биелэлтийг ойролцоогоор 80%-тай байна гэж дүгнэв (зорилт 1 нь 86%; зорилт 2 нь 85%; зорилт 3, 4, 5 нь хувьд 87, 72, 70% гэсэн тус тус гүйцэтгэлтэй). Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх механизм болон санхүүжилт аль аль нь тодорхойгүй байгаагаас хөтөлбөрийн хэрэгжилт сайн биш. Тийм учраас бичил биетэн, ургамал болон амьтны ангилал зүйн үндэсний зөвлөлийг санхүүжүүлэх

механизмыг зүй зохистой, ажиллах уян хатан бүтэцтэйгээр зохион байгуулах шаардлагатай. Нэн ховор, ховор зүйлийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт нь хувийн сектор болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд тулгуурласан агнуурын 60 бүс нутгийн хүрээнд төдий байна.

2015 онд батлагдсан “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр замын дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц”, 2018 онд батлагдсан “Уулархаг нутгийн авто зам, замын байгууламжийн дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц” хоёр стандарт нь төмөр зам, авто замын сүлжээ байгуулахад байгаль орчинд, ялангуяа нүүдэллэдэг зүйлийн хувьд ээлтэй бүтцийг бий болгох хууль, эрх зүйн орчныг бий болгосон. Мониторинг хяналт тавих, стандартыг хэрэгжүүлэх салбар дундын уялдаа холбоог хангасан зохицуулгыг цаашид бий болгох нь зайлшгүй.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд:

<https://www.legalinfo.mn/law/details/8670>

<https://eic.mn/flora>

Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (2018). Байгаль орчин, аялал жуулчлалын яам.

Гомбобаатар, С. Мөнхзаяа, Б. Лхам, С. Даваасүрэн, П. (2018). Монгол орны амьтан, ургамлын аймаг, мөөг, бичил биетний ангилал зүйн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх төслийн тайлан. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Шинжлэх ухаан технологийн сан, Монгол улсын их сургууль, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс.

Ургамал, М. (2017). Ургамлын аймгийн төлөв байдал, өөрчлөгдөл (1.1 бүлэг), Ургамлын олон янз байдлыг хамгаалах ба улаан данс (4.2 бүлэг). Монгол орны байгаль орчин” (I-V боть) бүтээлийн “Монгол орны биологийн олон янз байдал” III боть. БОАЖЯ. Улаанбаатар, Монгол улс. х.12-70, 257-267.

Ургамал, М. (2018). Монгол орны тарималжуулах шаардлагатай ургамлын төрөл зүйлүүд. (Зөвлөмж). Улаанбаатар, Монгол улс. х.1-16.

Ургамал, М., Оюунцэцэг, Б., Тунгалаг, Р., Гүндэгмаа, В., Оюундарь, Ч., Цэрэндулам, Ц., Мөнх-Эрдэнэ, Т., Солонго, Х. (2019). Монгол орны ховор ургамлын Улаан данс ба хамгааллын төлөвлөгөө. Улаанбаатар, Монгол улс. (хэвлэлтэнд).

Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018. (2019). Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Улаанбаатар.

Gombobaatar, S., Myagmarsuren, M., Conaboy, N., and Munkhjargal, M. (2014). The 5th National Report of Convention on Biological Diversity, Mongolia. Ministry of Environment and Tourism and Steppe Forward Programme, NUM. Ulaanbaatar, Mongolia. p. 1-142.

Gombobaatar, S. Conaboy, N. Urgamal, M. Terbish, Kh. and Gantigmaa, Ch. (2019). Biodiversity in Mongolia. Global Biodiversity, Volume 1: Selected Countries in Asia. APPLE Academic Press. Canada. p.351-395.

Зорилго 4. Унаган, нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх

Зорилт 9. Монгол оронд тархаж байгаа харь зүйл амьтан, ургамлыг судлах, түрэмгийлэгч харь зүйлийг тархан суурьшихаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Улсын Их Хурлаар баталсан Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалын нэг хэсэг нь байгалийн нөөц багасах, биологийн олон янз байдлын хомсдолоос сэргийлэх, мөн бичил биетэн, ургамал болон амьтны харь зүйлийн нөлөөнөөс биологийн олон янз байдлыг хамгаалах, урьдчилан сэргийлэх систем байгуулах зорилго юм.

Монгол улс нь “Байгалийн ургамлын тухай хууль”, “Амьтны тухай хууль”-ийн хүрээнд харь зүйлийн ургамлыг тарималжуулах зөвшөөрөл болон харь зүйлийг ашиглах эрх зүйн зохицуулалтыг авч үздэг. Гэсэн хэдий ч эдгээр хуулиудыг дахин шинэчлэн батлаагүй.

Харь зүйлийн хамгийн анхны бүрэн гүйцэд жагсаалтыг 2018 онд гаргасан бөгөөд 8 зүйлийн хөхтөн, 24 зүйлийн загас, 40 зүйлийн шавьж, 10 зүйлийн аалз, хачиг мөн 51 зүйлийн ургамал уг жагсаалтад бүртгэгджээ (<https://www.gbif.org/datasets/55b876-88f441-b752-38977f7d2f>).

Энэ мэдээлэл мөн “Харь болон нутагшуулсан зүйлийн дэлхийн бүртгэлд” мэдээллийн санд орсон бөгөөд улс орны түвшинд нутагшуулсан болон харь зүйлийг дахин нягтлан, баталгаажуулсан жагсаалтад багтсан. Харь зүйлийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тун тааруу байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд, Харь зүйлийн амьтан, ургамлын бүртгэл хийж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.

Монгол улс нь “Байгалийн ургамлын тухай хууль”, “Амьтны тухай хууль”-ийн хүрээнд харь зүйлийн ургамлыг тарималжуулах болон ашиглах зөвшөөрлийг тус тус зохицуулдаг. Гэсэн хэдий ч эдгээр хуулиудыг дахин шинэчлэн батлаагүй.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

[unkhnst, D., huluunjiv, ., Urgiml, ., ggd, S. nd Wng, LJ. \(2018\). GIIIS hkklist f Intrdudd nd Inv\[siv\]S\[i\]s - ngli Vrsin 2.2. Jurnl f Inv\[siv\]S\[i\]s S\[i\]list](#)

Зорилго 5. Экосистемийн үндсэн төлөөлөл тус бүрийн 30-аас доошгүй хувь, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг бүхэлд нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, менежментийг нь сайжруулах
Зорилт 10. Газар зохион байгуулалтын улсын болон орон нутгийн төлөвлөгөөнд экосистемийн төлөөлөлд суурилсан тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийг тусган сүлжээг өргөтгөж бэхжүүлэх;

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол улс 1995 онд “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай”, 1997 онд “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай” хуулийг батлан гаргасан. Өнөөг хүртэл Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн тухай хуульд 12, ТХГН-ийн орчны бүсийн тухай хуульд 1 удаа нэмэлт өөрчлөлт орсон нь ТХГН-ийн менежментийн хэрэгцээ шаардлагын үүднээс бус бусад хуульд орсон нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэх зорилгын хүрээнд хийсэн өөрчлөлт. Өөрөөр хэлбэл, эдгээр нэмэлт өөрчлөлтөд ТХГН-ийн тогтвортой байдал, санхүүжилтийн эрх зүйн орчин, экосистемийн үйлчилгээгээр дамжуулан ДНБ-д оруулж буй хувь нэмэр зэрэг хэд хэдэн зорилтот судалгаагаар илрүүлсэн ТХГН-ийн менежментэд тулгамдаж буй асуудал, шийдэл, нөөц боломжууд тусгагдаагүй байна.

2014-2018 онд БОАЖЯ, төрийн бус байгууллага (ТББ), олон улсын байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан талуудын зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж хэлэлцүүлсэн.

Хуулийн төсөлд Монгол улсын ТХГН, түүний менежментийн чиглэлээр хийсэн судалгаа шинжилгээний ажлын үр дүн, зөвлөмжүүд болон олон улсын сайн туршлага, хөгжлийн чиг хандлага, менежментийн арга аргачлал, нэр томъёоны талаар тусгасан. Ялангуяа, тусгай хамгаалалттай газар хоорондын холбоос нутаг, түүний менежмент; ТХГН-ийн менежментэд төр хувийн хэвшлийн түншлэлийг нэвтрүүлэх, менежментийг нутгийн иргэдийн байгууллагад бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хариуцуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх; ТХГН-ийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж тэдгээрээс орсон орлогын дийлэнх хувийг эргээд ТХГН-ийн хамгааллын менежментэд зарцуулах боломжийг бүрдүүлэх чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна.

2018 оны 11 дүгээр сард ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ)-д хүргүүлсэн боловч ХЗДХЯ-аас түр буцаасан бөгөөд төслийг сайжруулах ажил үргэлжилсээр байна.

Мөн энэ хугацаанд шинэчлэн найруулж буй хуулийн төслийг батлагдан гарахад дагаж сайжруулах, нэн тэргүүнд мөрдөх шаардлагатай дараах нэр бүхий журмын төслүүдийг боловсруулсан. Үүнд: ТХГН-т нэвтрэх хураамж, ТХГН-т судалгаа, шинжилгээний ажил явуулах, ТХГН-т бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх, Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах, Орон нутгийн хамгаалалттай газар (ОНХГ)-ын хамгааллын менежментийг хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулах тухай журмын төсөл зэрэг болно.


“Газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах заавар”-ыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас шинээр боловсруулж, тус газрын даргын 2017 оны 3-р сарын 16-ны өдрийн А/73 тоот тушаалаар батлан гаргасан. Улсын хэмжээнд энэхүү зааврыг мөрдөж эхэлсэнээр газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авахтай холбоотой эрх зүйн болон бусад зөрчлүүд буурсан эерэг үр нөлөө гарч байна.

2015 онд УИХ-ын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооноос “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн чадавхыг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг батлан гаргасан нь ТХГН болон түүний орчны бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа 177 нөхөрлөлийн хувьд чухал байв. Эдгээр нөхөрлөлүүдийн зарим нь орчны бүсийн менежмент болон ТХГН-т байгаль хамгаалах ажлыг хамтран хийх чиглэлээр албан ёсны түншлэл, хамтын ажиллагааг бий болгон сайн туршлагуудыг дэлгэрүүлж эхлээд байна.

УИХ-аас 1998 онд “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”-ийг баталж, 1999 онд Засгийн газрын тогтоолоор ТХГН-ийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний үе шатны арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхэлсэн. Үндэсний хөтөлбөрт голлох экосистем тус бүрийн 30 хувийг ТХГН-ийн сүлжээнд хамруулах зорилтыг дэвшүүлсэн. Энэ зорилтыг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”-д дэвшүүлэн дахин баталгаажуулж, тус бодлогын томоохон баримт бичгийн 20 гол шалгуур үзүүлэлтэд оруулсан.

2015 онд ТХГН-ийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнд бие даасан зөвлөхүүд дүн шинжилгээ хийсэн бөгөөд хэрэгжилтийг 65%-тай гэж дүгнэсэн. 2017-2018 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, бусад хамаарах судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд үндэслэн ТХГН-ийн үндэсний хөтөлбөрийн төслийг шинэчлэн боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх 3 дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол улсын ТХГН-ийгн менежментийг олон улсын жишигт хүргэн, тогтвортой хөгжлийн загвар нутаг болгон хөгжүүлэхээр төлөвлөж байна.


2008 – 2017 онд БОАЖЯ нь Дэ Нэйче Консерванси байгууллага (TNC), ДБХС (WWF) болон бусад талуудтай хамтран Монгол орны үндсэн 4 экобүс нутагт экологийн бүс нутгийн үнэлгээг хийж дуусгасан. Үүгээр нийт 434,153.97 км² талбайг хамрах биологийн олон янз байдлын хувьд чухал 216 газар (Зураг 8)-ыг тодорхойлон гаргахын зэрэгцээ тэдгээрийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан 3 үе шаттайгаар 2030 он хүртэл нэн тэргүүнд ТХГН-ийн сүлжээнд хамруулахаар эрэмбэлсэн.



Зураг 8. ТХГН болон хамгаалалтад авахаар санал болгож буй газар нутгууд (Эх сурвалж: БОАЖЯ)


Эдгээрээс 131 газар нутгийг ТХГН-ийн сүлжээнд хамруулахаар 2018 оны 12-р сард Монгол улсын Засгийн газраас баталсан Улсын Газар Зохион Байгуулалтын Ерөнхий Төлөвлөгөө 2019-2030 баримт бичигт албан ёсоор тусгасан.

2016-2019 онд УИХ-ын тогтоолоор 7 ТХГН-ийн хилийн заагийг өргөтгөн, шинээр 18 газрыг улсын тусгай хамгаалалтад авч сүлжээг 4.4 сая га-аар өргөжүүлсэн. Ийнхүү Монгол улс ТХГН-ийн сүлжээг жилээс жилд өргөтгөн нэмэгдүүлсээр 2019 оны байдлаар нийт 30,27 сая га талбай бүхий 115 хэсэгт хамаарах улсын ТХГН-ийг байгуулсан нь нутаг дэвсгэрийн 20.11 хувийг хамарч байна. Үүнээс Дархан цаазат газар 20 (IUCN-Ia, Ib&II), Байгалийн цогцолборт газар 34 (IUCN-Ib, II&V), Байгалийн нөөц газар 47 (IUCN-IV), Дурсгалт газар 34 (IUCN-III) тус тус байна. 2019 оны 5-р сард Монгол Улсын Их Хурлаас улсын тусгай хамгаалалтад авахаар шийдвэр нь гарсан 14 байгалийн нөөц болон байгалийн дурсгалт газруудын хилийн заагийг Засгийн газар тогтоон, Үндэсний кадастрын мэдээллийн санд албан ёсоор бүртгэснээр ТХГН-ийн сүлжээ дахин 1.33 сая га-аар нэмэгдэх юм.



Зураг 9. Улсын ТХГН-ийн сүлжээг өргөтгөсөн байдал (Эх сурвалж: БОАЖЯ)

Экосистемийн үндсэн төлөөллийн хувьд ерөнхийдөө 30 хувийг хамруулах зорилтдоо хүрч байгаа ч хээрийн экосистемийн хувьд дэвшүүлсэн зорилтдоо хараахан хүрээгүй байна. 2019 оны байдлаар хээрийн экосистемийн ердөө 8.5 хувь нь ТХГН-ийн сүлжээнд хамрагдсан бөгөөд хээрийн бүсэд орших ТХГН-ийн хагас нь Байгалийн нөөц газар буюу IUCN-ий IV буюу – Уламжлалт менежментийн аргаар тодорхой зүйл, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах гэсэн ангилалд хамаарч байна. ТХГН-ийн тухай хуулиар Байгалийн нөөц газрын менежмент, санхүүжилтийг тухайн орон нутгийн удирдлага хариуцах үүрэгтэй байдаг нь Засгийн газраас орон нутагт хуваарилах төсвөөс ихээхэн хамааралтай болгодог.



Зураг 10. Улсын ТХГН-ийн сүлжээнд экосистемийн төлөөллийн хамрагдсан байдал (Эх сурвалж: БОАЖЯ)

Улсын тусгай хамгаалалттай газрын зэрэгцээ тухайн аймаг, сум ИТХ-ынхаа шийдвэрээр зарим газар нутагтаа орон нутгийн тусгай хамгаалалтад авдаг. Орон нутгийн хамгаалалттай газар нь IУ□N-ний VI буюу байгалийн нөөцийг тогтвортой ашиглах гэсэн ангилалд хамаардаг. Түүний хамгааллын менежмент, хамгаалалтад авах хугацаа болон хамгааллын дэглэмийг нь аймаг, сумын ИТХ-ын шийдвэрээр батлан гаргадаг. 2019 оны 2-р сарын байдлаар нийт 24.02 сая га талбай бүхий 1118 газрыг байгалийн нөөц болон дурсгалт газрын ангиллаар аймаг, сумдын ИТХ-ын шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалтад авчээ. Эдгээр нь Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 15.36 хувийг хамарч байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2016 он гэхэд, ТХГН-ийн санхүүгийн тогтвортой байдал, хамтын менежментийн зарчмыг хангасан хууль эрх зүйн орчин бүрдүүлсэн байна
- 2020 он гэхэд, ТХГН-ийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээнд үндэслэн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж экосистемийн төлөөлөл, тогтвортой менежмент, санхүүжилтийн тогтолцоог хангах механизмыг бий болгоно.

Одоо мөрдөгдөж байгаа ТХГН-ийн тухай хууль, ТХГН-ийн орчны бүсийн тухай хууль болон ТХГН-ийн үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахад чиглэсэн хэд хэдэн судалгааны ажил хийгдэж холбогдох зөвлөмжүүдийг гаргасан. Эрх зүйн орчин, бодлогын баримт бичгийг сайжруулан албан ёсоор баталгаажуулаагүй байгаа ч ТХГН-ийн сүлжээг өргөжүүлэх, менежментийг хэрэгжүүлэх асуудлыг одоогийн хууль эрх зүйн орчны хүрээнд зохих түвшинд хийж байна.

ТХГН-ийн сүлжээгээр дамжуулан нийт нутаг дэвсгэрийн 30 хувийг хамгаалах зорилгыг улсын хэмжээнд оролцогч бүх талууд хүлээн зөвшөөрч, энэ нь Монгол улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийн 20 гол шалгуур үзүүлэлтийн нэг болсон юм.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

[http\[s\]://m\[s.mr\]m.g\[v.mn\]/m\[s.](http://m.s.mr/m.g.v.mn/m.s.)

<https://www.legalinfo.mn/law/details/479?lawid=479>

<https://www.legalinfo.mn/law/details/478?lawid=478>

Батжаргал З., Шийрэвдамба Ц. (2016). Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх боломж. Улаанбаатар.

Chimed-Ochir B., Herzman T., Batsaikhan N., Batbold D., Sanjmyatav D., Onon Yo. Munkhchuluun B. (2010). Filling the gaps to Protect the Biodiversity of Mongolia. WWF Mongolia Programme Office. Admon Printing House. Ulaanbaatar. pp. 136

НҮБХХ. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын аялал жуулчлал ба экосистемийн үйлчилгээнд концесс хэрэгжүүлэх боломж. (2013). Улаанбаатар.

Майкл Хайнер ба бусад. (2013). Экологийн бүс нутгийн үнэлгээний тайлан: Монгол орны өмнийн говь нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь. Дэ Нэйче Консерванси (TNC Mongolia). Улаанбаатар.

Майкл Хайнер ба бусад. (2017). Экологийн бүс нутгийн үнэлгээний тайлан: Монгол Алтай, Их Нууруудын хотгор, Нууруудын хөндийн экологийн бүс нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь. Дэ Нэйче Консерванси (TNC Mongolia). Улаанбаатар.

Майкл Хайнер ба бусад. (2017). Экологийн бүс нутгийн үнэлгээний тайлан: Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь. Дэ Нэйче Консерванси (TNC Mongolia). Улаанбаатар.

Монгол Улсын Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, 2016-2020 он. (2018). Монгол Улсын Засгийн газар. Улаанбаатар.

Мөнхчулуун Б. (2018). Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээ. Улаанбаатар.

Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөр, 2015-2025 он. (2015). Монгол Улсын Засгийн газар. Улаанбаатар.

Тусгай хамгаалалттай газар нутгийн Үндэсний хөтөлбөр. (1998). Монгол Улсын Их хурал. Улаанбаатар.

Ус Үндэсний хөтөлбөр. (2010). Монгол Улсын Их хурал. Улаанбаатар.

НҮБХХ. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тогтвортой санхүүгийн механизмыг хангах боломжит хувилбарууд. (2012). Улаанбаатар.

Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016 он. (2017). Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Улаанбаатар.

Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018. (2019). Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Улаанбаатар.

Шийрэвдамба Ц. (2012). Тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийн эрх зүйн орчинд үнэлгээ өгч, санхүүгийн тогтвортой байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, зөвлөмж. Улаанбаатар.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030. (2016). Монгол Улсын Их хурал. Улаанбаатар.

НҮБХХ. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үйлчилгээний салбарын хөгжилд оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнэ. (2015). Улаанбаатар.

Зорилго 5. Экосистемийн үндсэн төлөөлөл тус бүрийн 30-аас доошгүй хувь, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг бүхэлд нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, менежментийг нь сайжруулах


Зорилт 11. Талуудын оролцоонд тулгуурласан ТХГН-ийн менежмент, чадавхыг сайжруулах

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Өнөөгийн ТХГН-ийн менежментийн тогтолцоог 1990 оны сүүлчээр Байгаль орчны хяналтын улсын хорооны Төрийн хяналтын газарт Дархан газрын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаал бий болгож ажиллуулснаар эхэлсэн гэж үздэг. Тэгвэл өнөөдөр ТХГН-ийн менежментийн удирдлагыг үндэсний хэмжээнд БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар (ТХНУГ) эрхэлж, тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи бодлогыг тодорхойлох, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх, ТХГН-ийн хамгаалалтын захиргааны чадавхийг сайжруулах, хамгааллын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, ТХГН-уудыг ерөнхий удирдлагаар хангах үүрэгтэйгээр ажиллаж байна.

Одоогоор ТХНУГ-ын ерөнхий удирдлага дор нийт 34 Хамгаалалтын захиргаа байгуулагдан газар дээрээ хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаагаас 30 нь улсын төсвөөс санхүүжиж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмын хүрээнд 4 хамгаалалттай газрын менежментийг орон нутаг болон ТББ бүрэн эсвэл хэсэгчлэн хариуцаж байна. Энэхүү менежментийн шинэ зарчмаар 1994 оноос “Хустайн цогцолборт газар” төв ТББ Монгол улсын Засгийн газартай гэрээ байгуулж Хустайн нурууны БЦГ-ын менежментийг, 2013 оноос Их Нартын БНГ-ын менежментийг хариуцагчаар Аргаль, агнуур судлалын төв ТББ, 2013 оноос Хар ямаатын БНГ-ын менежментийг 10 жилийн хугацаагаар хариуцахаар Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) (ДБХС)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2017 оноос Тост Тосон бумбын нурууны БНГ-ын менежментийг хуулийн дагуу Өмнөговь аймгийн Засаг дарга, гэрээний дагуу судалгаа, шинжилгээний ажлыг Ирвэс хамгаалах сан ТББ хариуцан хамтран ажиллаж байна. Энэ нь Монгол улсад ТХГН-ийн менежментийн түвшинд хүний нөөц, санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна.

БОНХ-ийн сайдын 2013 оны 1-р сарын 4-ний А-06 тоот тушаалаар ТХГН-ийн хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоо, бүсийн төвүүдийн байршлыг, Засгийн газрын 2006 оны 4-р сарын 19-ны өдрийн 87-р тогтоолоор нэг байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн хэмжээг тогтоосон. Гэвч, улсын төсвийн санхүүгийн чадамжаас хамааран тоог хамгийн бага түвшинд байлгаж байгаа нь менежментийн бодит хэрэгцээг хангахгүй байна. 2019 оны байдлаар улсын төсвөөс санхүүжиж байгаа ТХГН-ийн 30 хамгаалалтын захиргаанд нийт 547 хүн ажиллаж байгаагаас 390 нь байгаль хамгаалагч (зураг 11) ба нийт ажилчдын 25 хувь эмэгтэй байна.




Зураг 11. ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын хүний нөөц (Эх сурвалж: БОАЖЯ, 2019)

Санхүүгийн хязгаарлагдмал байдлаас үл хамааран, Засгийн газрын зүгээс ТХГН-ийн хамгаалалтын захиргааны ажилтнуудын чадавхыг сайжруулах ажлыг хийсээр байна. 2016 оноос ТХГН-ийн мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын чадамжийг дээшлүүлэх цахим сургалт явуулах, сертификатжуулах тогтолцоог бүрдүүлж түүгээр дамжуулан сургалт зохион байгуулж, чадавхыг тогтоох, үнэлэх шалгалтыг авч эхэлсэн. Шалгалтын үр дүнг тухайн хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтний үр дүнгийн гэрээг үнэлэх, цалингийн сүлжээг шинэчлэх тогтолцоонд ашиглаж байна. Энэхүү үнэлгээний систем нь мэргэжилтний чадавхад илүү анхаарч, байгаль хамгаалагчдын чадавхад харьцангуй бага анхаарал хандуулж буйг харуулж байна.

ТХГН-ийн мэргэжилтэн болон байгаль хамгаалагчдын чадавхыг сайжруулах ажлын цар хүрээг хязгаарлаж буй нэг хүчин зүйл нь ТХГН-уудын санхүүжилт сүүлийн 4 жилийн хугацаанд өсөлтгүй тогтмол хэмжээнд байж (зураг 12), энэ нь ДНБ-ний бодит өсөлт, инфляц, мөнгөний ханш, үнийн өсөлттэй уялдахгүй, дутагдалтай хэвээр байгаа явдал юм. Үүний зэрэгцээ, ТХГН-аас нэвтрэх хураамж (2018 оны байдлаар 117,000 US\$), газар ашигласны төлбөр (2018 оны байдлаар 7.6 сая US\$) зэрэг орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсээр байна.

Тусгай хамгаалалттай газар, ТХГН-ийн чадавхыг дээшлүүлэх чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрүүд мөн хэрэгжиж байна. 2015-2018 онд ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх чиглэлээр олон улсын 4 төсөл хөтөлбөр хэрэгжиж, 2019 оноос 64.1 сая ам. долларын төсөв бүхий 4 төсөл хэрэгжихээр төлөвлөгдөөд байна.



Зураг 12. ТХГН-ийн улсын төсвийн санхүүжилт-сая төг. (Эх сурвал: БОАЖЯ, 2019)

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд, ТХГН-ийн хамгаалалтын захиргааны хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх баримт бичгийг боловсруулсан байна.
- 2020 он гэхэд, ТХГН-ийн хамгаалалтын захиргааны дэд бүтцийг сайжруулан, хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлсэн байна.

Өнөөгийн байдлаар ТХНУГ-ын ерөнхий удирдлага дор нийт 34 Хамгаалалтын захиргаа байгуулагдан газар дээрээ хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаагаас 30 нь улсын төсвөөс санхүүжиж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмын хүрээнд 4 хамгаалалттай газрын менежментийг орон нутаг болон ТББ бүрэн эсвэл хэсэгчлэн хариуцаж байна. Ажиллагсдын тооны хувьд улсын төсвийн нөхцөл байдалд тулгуурлан Засгийн газраас

баталсан орон тоо нь ТХГН-ийн менежментийн өнөөгийн бодит хэрэгцээг хангаж чадахгүй байна.

Түүнчлэн БОАЖЯ-наас орон нутагт ажиллагсдын мэргэшлийн чадавхыг сайжруулах зорилгоор цахим сургалт явуулах тогтолцоог бий болгосон хэдий ч хөрөнгө төсвөөс шалтгаалан бодит хэрэгцээтэй харьцуулахад хязгаарлагдмал хэвээр байна. Одоогоор олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэг нь Монгол улсын ТХГН-ийн сүлжээний чадавхыг нэмэгдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.imf.org/en/Countries/MNG>

Батжаргал З., Шийрэвдамба Ц. (2016). Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх боломж. Улаанбаатар.

Chimed-Ochir, B. Herzman, T. Batsaikhan, N. Batbold, D. Sanjmyatav, D. Onon, Yo. Munkhchuluun, B. (2010). Filling the gaps to Protect the Biodiversity of Mongolia. WWF Mongolia Programme Office. Admon Printing House. Ulaanbaatar. pp. 136

НҮБХХ. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын аялал жуулчлал ба экосистемийн үйлчилгээнд концесс хэрэгжүүлэх боломж. (2013). Улаанбаатар.

Мөнхчулуун Б. (2018). Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээ. Улаанбаатар.

НҮБХХ. Монгол Улсын тусгай хамгаалалттай гарар нутгийн тогтвортой санхүүгийн механизмыг хангах боломжит хувилбарууд. (2012). Улаанбаатар.

Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016 он. (2017). Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Улаанбаатар.

Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018. (2019). Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Улаанбаатар.

НҮБХХ. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үйлчилгээний салбарын хөгжилд оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнэ. (2015). Улаанбаатар.


Зорилго 5. Экосистемийн үндсэн төлөөлөл тус бүрийн 30-аас доошгүй хувь, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг бүхэлд нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, менежментийг нь сайжруулах

Зорилт 12. Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг тодорхойлж, хамгаалах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Дэ Нэйчэ Консерванси (TNC) байгууллагын дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн “Экологийн бүс нутгийн үнэлгээ”-ний хүрээнд өвөрмөц, уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг экосистемийг экологийн бүх бүсүүдэд нарийвчлан зурагласан бөгөөд эдгээр нь Монгол орны нийт газар нутгийн 9.5% -г хамарч байна. 2019 оны 9-р сарын байдлаар энэхүү эмзэг, өвөрмөц экосистемийн 26.4 хувь буюу 3.9 сая га талбай бүхий газар нутаг улсын ТХГН-ийн сүлжээнд хамрагджээ. Энэ нь 2014 оны түвшинтэй харьцуулахад 439,408 га-р нэмэгдсэн хэдий ч ТХГН-т

хамрагдсан эдгээр өвөрмөц экосистемүүдийг тусгайлан хамгаалахад чиглэсэн арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. ТХГН-уудын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан хамгааллын үнэт зүйлүүдэд ялангуяа, өвөрмөц экосистемд уур амьсгалын өөрчлөлт нь томоохон хэмжээний сорилт болж байгааг тодорхойлсон байна. Тухайлбал, Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн зарим зүйлүүдийн амьдрах орчин уур амьсгалын өөрчлөлт болон хүний буруутай үйл ажиллагааны нөлөөгөөр хомсдож байна. Монгол орны мөлхөгчдийн гуравны нэг (түүний 2/3 нь нэн ховор) тархсан Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг болох Ногоон цавын хөндий, Монгол орны хоёр нутагтны 66% тархсан Сэлэнгэ аймгийн Шаамар сумын нутаг болох Их бага Бүүрэг хэмээх газар нутгийг судлаачид хоёр нутагтан, мөлхөгчдийн хувьд чухал, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өвөрмөц 2 чухал газар нутаг болохыг тодорхойлон хамгаалах шаардлагатайг дурджээ.



Зураг 13. Өвөрмөц экосистемүүд, тэдгээрийг улсын ТХГН-ийн сүлжээнд хамруулсан байдал (Эх сурвалж: TNC, 2019)

ТХГН-ийн хувьд эдгээр өвөрмөц экосистемүүдийг менежментийн төлөвлөгөөндөө хамгааллын үнэт зүйлээр сонгон оруулсан хэдий ч уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нөлөөллийг бууруулах болон төлөв байдлын үнэлгээ, мониторинг хийхэд чиглэсэн тодорхой зорилт, үйл ажиллагааг төлөвлөөгүй байна. Улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, эмзэг байдлын үнэлгээг ой, шавж, ирвэс, аргаль хонь, цагаан зээр, цэн тогоруу зэрэг томоохон бүс нутаг, сонгосон амьтдын амьдрах орчны хүрээнд хийж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон сааруулах арга хэмжээг тодорхойлсон байдаг ч эмзэг, өвөрмөц экосистемийн хувьд нарийвчилсан судалгаа, мэдээлэл байхгүй байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилгод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

- Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:
- 2017 он гэхэд, Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг тодорхойлж, мэдээллийн сан бүрдсэн байна.
- 2020 он гэхэд, Экологи, нийгэм, эдийн засгийн хувьд хамгийн чухал ач холбогдолтой уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийн сэргэх чадварыг тэтгэсэн хамгаалал, зохистой ашиглалтын төлөвлөгөө боловсруулсан байна.

Дэ Нэйче Консерванси (DNC) байгууллагын дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн “Экологийн бүс нутгийн үнэлгээ”-ний хүрээнд өвөрмөц, уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг экосистемийг экологийн бүх бүсүүдэд нарийвчлан зурагласан бөгөөд эдгээр нь Монгол орны нийт газар нутгийн 9.5% -г хамарч байна. 2019 оны 5-р сарын байдлаар энэхүү эмзэг, өвөрмөц экосистемийн 26 хувь буюу 3.9 сая га талбай бүхий газар нутаг улсын ТХГН-ийн сүлжээнд хамрагджээ.

Гэсэн хэдий ч эдгээр өвөрмөц экосистемүүдийг тусгайлсан судалсан ажил дутмаг байгаа учраас ТХГН-уудын менежментийн төлөвлөгөөнд өөрсдийн газар нутагт байгаа эмзэг, өвөрмөц экосистемд нөлөөлөх уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах талаар ямар нэгэн үйл ажил тусгаагүй байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

Майкл Хайнер ба бусад. (2017). Экологийн бүс нутгийн үнэлгээний тайлан: Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь. Дэ Нэйче Консерванси (DNC) (DNC). Улаанбаатар.

Майкл Хайнер ба бусад. (2017). Экологийн бүс нутгийн үнэлгээний тайлан: Монгол Алтай, Их Нууруудын хотгор, Нууруудын хөндийн экологийн бүс нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь. Дэ Нэйче Консерванси (DNC) (DNC). Улаанбаатар.

Майкл Хайнер ба бусад. (2013). Экологийн бүс нутгийн үнэлгээний тайлан: Монгол орны өмнийн говь нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь. Дэ Нэйче Консерванси (DNC) (DNC). Улаанбаатар.

Kh. Munkhbayar & M. Munkhbayar. (2012). Environmental diversity of the Mongolian steppe and its conservation issues. *Environmental Biology* (2012) (12): 203–212

Зорилго 6. Хөрс, усны нөөцийг химийн болон органик бохирдлоос хамгаалах
Зорилт 13. Хотжилт, уул уурхай болон үйлдвэрлэлээс үүсэж байгаа химийн бохирдлын талаарх хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад засгийн газар болон олон нийтийн хамтын ажиллагааг бий болгох

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол улсад усан хангамж, ус ашигласны төлбөр, усны нөөцийг сэргээх, хамгаалах, зүй зохистой ашиглах харилцааг зохицуулахад чиглэсэн есөн хууль байдаг.


2004 оны Усны тухай хууль нь устай холбогдох орон нутгийн болон төвийн засаг захиргааны байгууллагуудын эрх, үүргийг дахин хуваарилахдаа усны нөөцийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаатай холбоотой асуудлыг аймаг, сум дүүргийн засаг дарга хариуцахаар тогтоож, мөн анх удаа Усны нөөцийн нэгдсэн менежментийг нэвтрүүлсэн юм.

012 онд 2004 оны “Усны тухай” хуулийн шинэчлэн найруулж “Усны тухай” тухай хуулийг шинэчилж нь хуулийг сольж усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах үүрэг бүхий төрийн байгууллагын эрх үүргийг тодорхой болгож усны нөөцийн менежментийн төвлөрлийг сааруулах, хөнгөвчлөх зорилгоор Сав газрын захиргааг байгуулах, усны нөөцийн менежментийн үйл ажиллагаанд иргэдийн үүрэг, оролцоог тодорхой болгон хуульчилсан юм.

Усны тухай хуулийн дагуу 29 усны сав газрыг байгуулж, сав газар тус бүрд усны сав газрын нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх зорилгоор 21 Сав газрын захиргаа болон Сав газрын зөвлөлийг байгуулав. Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг 29 сав газар тус бүрдээ бий болгон БОАЖЯ-д хүргүүлэн батлуулаад байна.

Сав газрын захиргаа болон орон нутгийн захиргааны хийсэн томоохон алхмуудын нэг нь Усны тухай хуулийн заалтуудын дагуу голын дагуу хязгаарлалтын бүсийг бий болгож голын сав газрын хүрээнд хязгаарлагдмал ашиглах болон хориотой бүсийн хилийг бий болгосон явдал юм. ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын дэмжлэгтэйгээр Монголын зүүн болон баруун нутгуудад 5.2 сая га талбай бүхий голын татмын бүсийг ялгаж Усны тухай хуульд заасны дагуу орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр хязгаарлалтын бүсийг батлав. Бусад бүх Сав газрын захиргаад өөрсдийн хариуцсан газар нутагт орон нутгийн захиргаатай хамтран дээрхтэй адил хязгаарлалтын бүсийг тогтоохоор ажиллаж байна.

Усны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2021 он гэхэд Монгол улсад усны эх бүрэлдэх газрын 80 хувийг ТХГН-ийн сүлжээнд хамруулж эдгээр газарт сөрөг нөлөө бүхий аливаа үйл ажиллагааг багасгаж зогсоох болон бусад зорилгоор “Ус” үндэсний хөтөлбөрийг бий болгов.



Зураг 14. Усны эх бүрэлдэх газар (Эх сурвалж: WWF, 2014)

БОАЖЯ 29 сав газарт 9,1 сая га бүхий усны эх бүрэлдэх газрын хилийг 2015 онд тогтоосон (зураг 14) бөгөөд 2018 оны байдлаар 3.3 сая га талбай бүхий усны эх бүрэлдэх газар нутаг нь ТХГН-ийн сүлжээнд хамрагдаад байна (БОАЖЯ, 2019).

2017-2015 оны Байгаль орчны төлөв байдлын тайланд усан сан бүхий газар 686.1 мянган га газар буюу Монголын нийт газар нутгийн 0.4%-ийг эзэлж байна.

Монгол орны гадаргын усны чанарын хяналт-шинжилгээний улсын сүлжээ нь Монгол улсын хэмжээнд 94 гол, 18 нуур дээр 191 цэгт усны хими, чанарыг хэмжин тайлан гаргадаг.

Гадаргын усны чанарын үнэлгээний тайланд эдгээр 191 цэг дээр 2013-2016 оны хооронд хийсэн хэмжилтийн дүнд нийт гол, нуурын 91-95% нь “маш цэвэр, цэвэр”, 3-5% нь “бага бохирдолтой”, 0-1% нь “бохирдолтой”, 3-4% нь “маш бохирдсон” гэсэн үзүүлэлттэй гарсан байна. Гэсэн хэдий ч 2018 оны судалгаагаар нь 88.5% нь “маш цэвэр, цэвэр”, 7.9% нь “бага бохирдолтой”, 2.1% нь “бохирдолтой”, 1.6% нь “маш бохирдсон” гэж гарсан байна.

Хүснэгт 4. Гадаргын усны бохирдлын төвшин/ %/-гийн өөрчлөлт

| Цэвэршлийн төвшний ангилал | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|----------------------------|------|------|------|------|------|------|
| Маш цэвэр, цэвэр | 93,0 | 95 | 93 | 91 | 89,2 | 88,5 |
| Бага бохирдолтой | 5 | 5 | 3 | 5 | 5,9 | 7,9 |
| Бохир | 0 | 0 | 0 | 1 | 1,6 | 2,1 |
| Маш бохир | 3,0 | 3 | 4 | 3 | 3,2 | 1,6 |

Туул, Хангал, Хүдэр гурван гол нь хамгийн их бохирдолтой гол байна. Эдгээр голын эхний хоёр нь Улаанбаатар болон Эрдэнэт хотын бохир усыг цэвэршүүлэх байгууламжийн хүчин чадал хангалтгүй улмаас бохирдсон бол Хүдэр гол нь голын эхэн хэсэгт явуулж байгаа алтны уурхай үйл ажиллагаанаас үүдэн бохирдсон байна.

Монгол улсад улсын хэмжээнд 340 цэгт хөрсний чанарын хяналт шинжилгээг 5 жил бүр хөрсний чийг, ялзмаг, сульфат (SO₄), фосфат (P₂O₅), нитрат, (NO₃), аммоний (NH₄) болон хүнд металлыг хэмжих замаар хийж орчны үнэлгээг хийдэг. Мөн 1-2 жил бүр хот, суурин газар дахь

бохирдсон хөрснөөс 11 хүнд элементийн тухайлбал хар тугалга (□), кадмий (□d), мөнгөн ус (□g), хром (□r)-ийн дээж авч шалгадаг. Монгол улсын “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”-ний □ NS5850:2008 стандарттай харьцуулж бохирдолтын түвшин, үнэлгээг гаргадаг.

2014, 2016 болон 2018 оны тайлангуудаас үзэхэд Улаанбаатар хотын 4 дүүргийн 85 цэг, 21 аймаг дахь 85 цэгээс авсан хөрсний дээжид кадмий, хар тугалга, мөнгөн ус, бром, циркон, зэс, кобальт, хром тус тус илэрсэн байна. Нийслэл болон аймаг, сумын төвийн хөрс нь нүхэн жорлон, хог, хаягдлын зохицуулалт хангалтгүйгээс хөрсний бичил биетний бохирдол тархсан бол хөдөө орон нутагт хөрсний бохирдол ихэвчлэн уул уурхайгаас үүдэлтэй байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд, Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх, усны нөөц бүхий газруудын хамгаалалтыг сайжруулах, дагаж мөрдөх журам, дүрмийг батлах.
- 2020 он гэхэд, Хотжилт, уул уурхай үйлдвэрлэлтэй холбоотой бохирдлоос хамгаалах тухай хууль, эрх зүйн орчны хэрэгжилтэд хяналт тавих төрийн болон олон нийтийн хамтын оролцоог хангана.

Усны тухай хуулийн дагуу 29 усны сав газрыг байгуулж, сав газар тус бүрд усны сав газрын нэгдсэн менежментийн төлөвлөөг боловсруулах, хэрэгжүүлэх зорилгоор 21 Сав газрын захиргаа болон Сав газрын зөвлөлийг байгуулав. Одоо Сав газрын захиргаад болон орон нутгийн удирдах байгууллагууд хамтран Усны тухай хуулийн голыг дагуух хязгаарлалтын бүсийн тухай заалтыг хэрэгжүүлэхийн тулд голын сав газрын дагуу хязгаарлалтын болон хориотой бүсийн хил заагийг тогтоохоор ажиллаж байна. Усны тухай хуульд заасны дагуу орон нутгийн удирдлагууд одоогоор 5.2 сая га талбай бүхий голын татмын хязгаарлалтын бүсийг ялган тодорхойлж, батлаад байна.

Гадаргын усны чанарын хяналт-шинжилгээний үндэсний сүлжээ нь Монгол орон даяар 94 гол, 18 нуур дээр 191 цэгт хими болон усны чанарын хэмжилт хийн тайлан мэдээ гаргаж байна.

Монгол улсын хэмжээнд 340 цэгт хөрсний чанарын хяналт шинжилгээг 5 жил бүр хөрсний чийг, ялмаг, сульфат (S□4), фосфат (□□5), нитрат, (N□3), аммоний (N□4) болон хүнд металлыг хэмжих замаар хийж орчны үнэлгээг хийдэг. Мөн 1-2 жил бүр хот, суурин газар дахь бохирдсон хөрснөөс 11 хүнд элементийн тухайлбал хар тугалга (□), кадмий (□d), мөнгөн ус

(Hg), хром (Cr)-ийн дээж авч шалгадаг. Мөн 1-2 жил бүр хот, суурин газар дахь бохирдсон хөрснөөс 11 хүнд элементийн тухайлбал хар тугалга (P), кадмий (Cd), мөнгөн ус (Hg), хром (Cr)-ийн дээж авч шалгадаг. Монгол улсын “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”-ний MNS5850:2008 стандарттай харьцуулж бохирдолтын түвшин, үнэлгээг гаргадаг.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

Mongolia National Program on Reduction of Air and Environmental Pollution (2017). Attachment to the Government Resolution # 98 of 2017.

Report of State of the Mongolian Environment, 2015-2016. (2017). Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar.

Report of State of the Mongolian Environment, 2017-2018. (2019). Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar.

Mongolia: Environmental Performance reviews. (2018). Environmental Performance Reviews Series No. 49. UNECE, ECE/CEP/182. United Nations. New York and Geneva. pp. 193-251

Mongolia Water Security Assessment. (2017). ADB TA 8855: Country Water Security Assessment. Mongolia Water Forum Uskhelts. Mongolia. pp. 121

Зорилго 6. Хөрс, усны нөөцийг химийн болон органик бохирдлоос хамгаалах

Зорилт 14. Хөдөө аж ахуйд хэрэглэж байгаа химийн бодисуудын улмаас биологийн олон янз байдалд үзүүлж байгаа шууд болон дам нөлөөний талаар олон нийтэд хүргэх мэдээлэл, сурталчилгааг нэмэгдүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Улсын хэмжээнд эдийн засгийн хөгжил болон хүн амыг хангах хэмжээний, чанартай усны нөөц хангалтгүй байдаг. Бүс нутгаар тухайлбал эдийн засаг, хотжилтын төв болох Улаанбаатар хот мөн уул уурхайн гол түшиц газар болох говийн бүс нутагт усны асуудал нь нийгэм-эдийн засгийн тулгамдсан асуудлыг бий болгож байна.

Малчдын ердөө 50 хувь нь баталгаатай ариун цэврийн байгууламж хэрэглэх боломжтой. Ихэнх малчид задгай ус, гар худаг ашиглаж байна. Нүүдлийн мал аж ахуй эрхэлж буй иргэд цэвэр усны хангамж ашиглах болон ариун цэврийн байгууламжтай байх боломж үгүй байдаг. Хөвсгөл, Алтай, Хангайн уулархаг мужийн мөнх цэвдгийн бүсэд гар болон өрөмдмөл худаг гаргах асуудал нэн бэрхшээлтэй учир өвлийн улиралд ихэнхдээ цас, мөсний усыг ашиглаж байна. Засгийн газраас бэлчээрт гүний худаг гаргах ажлыг санхүүжүүлж байгаа нь мал, малчдын усан хангамжийг нэмэгдүүлж өрхөд зарим талаар ашиг тусаа өгч байгаа хэдий ч асуудлыг бүрэн шийдээгүй, мөн гөргөж буй худгууд нь ундны усны шаардлага хангах эсэх талаар дүгнэлт мэдээлэл гаргахгүй байна.

2018 оны тооллогоор Монгол улс нь түүхэндээ хамгийн их мал буюу 66.4 сая мал, хонин толгойд шилжүүлснээр 106 сая мал тоолуулсан. Сүүлийн жилүүдэд төрөөс олгосон ноосны татааснаас үүдэн мал сүргийн тоо толгой огцом өссөн.

Түүнчлэн ашиглалтгүй байсан бэлчээрт шинээр худаг гаргасан нь малын тоо толгой өсөх бас нэг шалтгаан болж байна.

Хайрцаг 6. 432,000 га талбай нь малын төлөө юу аль эсвэл зэрлэг амьтдаас булаан авсан уу?

2017 онд Засгийн газраас ойролцоогоор 760,000 ам. доллар зарцуулан хөдөө орон нутагт бэлчээрт гүний өрөмдлөг худаг гаргасан. Энэ хөрөнгө оруулалтын хүрээнд 288 худгийг өмнө нь малын бэлчээрт ашиглаж байгаагүй 432 мянган га талбайд гаргасан бөгөөд 1400 малчин өрх үр шимийг нь шууд хүртэж байна.

Монгол орны бэлчээрийн даац олон газарт их хэмжээгээр хэтэрсэн бөгөөд малын бэлчээрийн даац хэтэрч байгаа нь Монгол орны нутаг дэвсгэрийн хүрээнд бэлчээрийн доройтол үүсэх гол хүчин зүйл нь болж байна.

Бэлчээрийн даац хэтэрч байгаа асуудал нь гар худаг болон өрөмдөн гаргасан худаг зэргийн усны эх үүсвэрийг тойрон гарч байна. Уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн дүр төрхөөс харахад 2030 он гэхэд ганийн давтамж өсөхийн зэрэгцээ бэлчээрийн даацыг хэтрүүлэн хэрэглэх нь нөхцөл байдлыг улам муутгахын хажуугаар хөрсний ихэнх хэсгийг эмзэг болгохоор байна. Уст цэгүүдийн зохицуулалтгүй хөгжүүлэлтийн улмаас бий болж байгаа бэлчээрийн удаан хугацааны доройтол нь нь буцаж сэргэхгүй эрсдэл үүсгэхийн зэрэгцээ уст цэгүүдэд оруулсан хөрөнгө оруулалтаас гарах эдийн засгийн үр өгөөжийн хооронд тэнцвэрт бодлого барих зайлшгүй шаардлага нь мал аж ахуйн салбарыг улам бүр нарийн төвөгтэй болгож байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд, Хөдөөгийн хүн ам, мал, бэлчээрийн усан хангамж, хүрэлцээг оновчтой зохион байгуулах менежментийг сайжруулна.
- 2020 он гэхэд, Химийн бодисын БОЯБ-д үзүүлэх шууд болон дам нөлөөний талаар малчид, газар тариалан эрхлэгчид цогц мэдлэгтэй болж хэрэглэгчдийн мэдлэг нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд хүн ам болон эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг хангахад усны нөөц болон чанар хангалттай хэдий ч, малчин өрх болон мал аж ахуйн салбарыг тогтвортой усаар хангах

асуудал шийдэгдээгүй байна. Шинээр уст цэг гаргах нь малчдын усны хангамжийг нэмэгдүүлж байгаа хэдий ч энэ нь малын тоо толгойг нэмэгдүүлэхэд хүргэж улсын хэмжээнд газрын доройтлыг улам хурцатгаж байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

From vulnerability to sustainability: Environment and Human Development. (2011) NHDR 2011. Government of Mongolia, UNDP, SIDA. Ulaanbaatar. pp. 46-66

Mongolia Water Security Assessment. (2017). ADB TA 8855: Country Water Security Assessment. Mongolia Water Forum Uskhelts. Mongolia. pp. 121

State Policy on Food and Agriculture. (2003). Parliament of Mongolia. Ulaanbaatar

Targeted Analysis on Water Resources Management Issues in Mongolia, Final report. (2014). 2030 Water Resources Group. PricewaterhouseCoopers Private Limited. Gurgaon, India. pp. 48

Зорилго 6. Хөрс, усны нөөцийг химийн болон органик бохирдлоос хамгаалах

Зорилт 15. Ургамал хамгаалах бодис (пестицид), бордоог тогтвортой ашиглах хяналт-шинжилгээний механизмыг бий болгох

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол улсад пестицидийг хэрэглээ нь химийн хорт болон аюултай бодисыг импортлох, экспортлох, улсын хилээр дамжуулан тээвэрлэх, худалдах, устгах харилцааг зохицуулсан “Химийн хорт болон аюултай бодисын тухай” (2006) хуулиар зохицуулагдана. Мөн “Ургамал хамгааллын тухай” (2007) хуулиар пестицидийг хэрэглэхэд тавих хяналт, шинэ пестицидийг шалгах зохицуулалтыг агуулсан эрх, үүргийг зохицуулдаг.

Эдгээр хуулийн дагуу БОАЖ-ын сайд, ХХААХҮ-ийн сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалаар Монгол улсад хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох агро-химийн бодисын жагсаалтыг баталсан. Тухай жил бүр гаднаас импортлох агро-химийн бодисын хэмжээг ХХААХҮЯ-наас тодорхойлон гаргаж БОАЖЯ зөвшөөрснөөр тогтоодог.

1990-ээд оны үед салбарын уналтын улмаас агро-химийн бодисын хэрэглээ бараг байхгүй болсон байна.

2008 онд Засгийн газраас “Атрын гурав дахь аян” зарлаж, хөтөлбөрийн хүрээнд тариаланчдад хөнгөлөлттэй үнээр үр, бордоо, ургамал хамгаалах химийн бодис түүнчлэн хөдөө аж ахуйн машин, техникийг худалдан авах хөнгөлөлттэй зээл авах боломж олгосон байна. Аяны хүрээнд засгийн газраас гурилын үйлдвэрүүдэд зарагдсан улаан буудайн тонн тутамд ойролцоогоор 40 ам. долларын татаас олгож эхэлсэн. Улаан буудайн дотоодын хэрэгцээг хангах зорилготой урамшууллын энэ арга хэмжээ нь тариаланчдын агро-химийн бодисыг хэрэглээг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна (хүснэгт 5).

Хүснэгт 5. Тариалангийн зориулалтаар импортолсон химийн бодис

/физик жингээрб ХХААХҮЯ-ны тайлан 2018/

| Импортолсон химийн бодисын төрөл | Хэм жих нэгж | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|------------------------------------|--------------|--------|--------|--------|--------|---------|
| Фунгицид | тн | - | 9,0 | 4,8 | 8,49 | 45,7 |
| Гербицид | тн | 330,0 | 425,5 | 673,0 | 476,8 | 1313,2 |
| Инсектоцид | тн | - | - | - | - | 87,3 |
| Родентицид | тн | - | - | - | - | 7,2 |
| Нийлмэл бордоо / NPK/ | тн | 215,0 | 998,9 | 7900,0 | 3040,0 | 11812,0 |
| Тариалангийн нийт эргэлтийн талбай | мян/га | 924,32 | 1028,2 | 1067,7 | 1327,8 | 1329,0 |

2018 оны байдлаар Монголын газар тариалангийн салбарт хэрэглэж байгаа бордооны хэмжээ нь бусад оронтой харьцуулахад бага буюу 8.9кг/га байна. Пестицидийн хэрэглээ нь үүнтэй мөн адил дүр төрхтэй буюу тухайлбал га тутамд хэрэглэж байгаа гербицидийн хамгийн их хэрэглээ нь 0.98кг байгааг интернэтийн орчин дахь бусад улсуудын мэдээтэй жишиж үзэхэд Хятад болон ЭЗХАХБ-ын гишүүн улсуудад гербицидийн хэрэглээ нь 5.8кг/га болон 5.5кг/га тус тус байна.

Хүснэгт 6. Тариалангийн нэгж талбайд ногдох хэмжээ химийн бодис, кг

| | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|------------|------|-------|--------|--------|-------|
| Фунгицид | | 0,009 | 0,0046 | 0,0064 | 0,034 |
| Гербицид | 0,35 | 0,41 | 0,63 | 0,36 | 0,98 |
| Инсектоцид | | | | | 0,065 |
| Бордоо | 0,23 | 0,97 | 7,3 | 2,29 | 8,9 |

2017 онд Монгол улс “Органик хүнсний тухай” хуулийг баталж фермерүүд, ялангуяа хүнсний ногооны фермерүүдийн хувьд пестицидийн хэрэглээг больж илүү биологийн болон органик гаралтай бордоогоор тухайлбал ялзмагийн найрлага бүхий бордоогоор сольж хэрэглэхэд түлхэц үзүүлэв.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд, Төрөөс газар тариалангийн салбарт олгогддог дэмжлэгийг оновчтой болгох хувилбарыг боловсруулсан байна.

Санхүүгийн хангалттай дэмжлэг авахын тулд газар тариалангийн химийн хэрэглээг хамгийн бага байсан. Үүний зэрэгцээ засгийн газар агро-химийн хэрэглээг багасгахад хөшүүрэг болсон “Органик хүнс” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхэлсэн.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

Law on toxic and hazardous substances (2006)

<https://www.legalinfo.mn/law/details/517>

<https://www.legalinfo.mn/law/details/526>

<https://www.legalinfo.mn/annex/details/5292?lawid=8065>

<https://www.legalinfo.mn/law/details/11884>

<https://www.legalinfo.mn/law/details/14135>

Зорилго 7. Ойн биологийн олон янз байдлыг хамгаалах болон ойн менежментийг сайжруулах замаар 2025 он гэхэд ойгоор бүрхэгдсэн талбайн 9%-д хүргэж нэмэгдүүлэх Зорилт 16. Ойн талаар баримтлах үндэсний бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний талаар салбар дундын хамтын ажиллагааг хангах

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

2018 оны байдлаар Монгол орны ойн нийт нөөц нь 1252.5 сая шоо метр бөгөөд үүний 78.7 хувь нь шинэс (*Larix sibirica* Ldb.), 9.3 хувь нь хуш (*Pinus sibirica* Du Tour.), 6.1 хувь нь хус (*Betulla* sp.), 5.0 хувь нь нарс (*Pinus Sylvestris* L.), 0.23 хувь нь гацуур (*Picea obovate* Ldb.), 0.02 хувь нь жодоо (*Abies sibirica* Ldb.), 0.2 хувь нь улиас (*Populus* sp.), 0.05 хувь нь улиангар (*Populus* sp.), 0.01 хувь нь хайлаас (*Ulmus pumila* L.), 0.28 хувь нь бургас (*Salix* sp.), 0.002 хувь нь тоорой (*Populus diversifolia* Schrenk.), 0.15 хувь заг (*Haloxylon ammodendron* C.A.Mey.) тус тус байна.

Хүснэгт 7. Ойн нөөц модны төрлөөр (сая шоо метр)

| Модны төрөл | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|-------------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|-------|-------|-------|-------|-------|
| Шинэс | 1033,0 | 1074,9 | 1058,4 | 1058,5 | 1034,1 | 1035,1 | 1304,7 | 977,1 | 977,3 | 978,1 | 985,9 | 985,9 |
| Нарс | 97,1 | 86,7 | 66,7 | 66,7 | 63,7 | 63,7 | 63,8 | 61,8 | 61,8 | 62,1 | 62,1 | 62,1 |
| Хуш | 150,5 | 129,8 | 126,7 | 126,8 | 120,8 | 120,8 | 120,8 | 116,1 | 116,1 | 116,9 | 116,9 | 116,9 |
| Гацуур | 3,4 | 4,3 | 3,6 | 3,6 | 3,6 | 3,6 | 3,6 | 2,9 | 2,8 | 2,8 | 2,8 | 2,8 |
| Жодоо | 0,3 | 0,3 | 0,2 | 0,2 | 0,2 | 0,2 | 0,2 | 0,2 | 0,2 | 0,2 | 0,2 | 0,2 |
| Хус | 89,4 | 91,7 | 86,5 | 86,5 | 83,9 | 83,9 | 81,9 | 76,8 | 76,8 | 76,8 | 76,2 | 76,2 |

| | | | | | | | | | | | | |
|----------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|--------|
| Улиас | 1,8 | 2,5 | 2,4 | 2,4 | 2,3 | 2,6 | 2,5 | 2,2 | 2,2 | 2,2 | 2,2 | 2,2 |
| Улиангар | 1,5 | 1,8 | 1,3 | 1,3 | 1,3 | 1,3 | 1,1 | 0,7 | 0,67 | 0,67 | 0,67 | 0,67 |
| Хайлаас | 0,06 | 0,08 | 0,05 | 0,05 | 0,08 | 0,09 | 0,09 | 0,08 | 0,08 | 0,08 | 0,08 | 0,08 |
| Бургас | - | 1,5 | 1,8 | 1,8 | 1,9 | 3,1 | 3,5 | 3,4 | 3,4 | 3,4 | 3,5 | 3,5 |
| Заг | 1,4 | 1,5 | 1,5 | 1,5 | 1,5 | 1,8 | 1,8 | 1,8 | 1,8 | 1,8 | 1,8 | 1,8 |
| Тоорой | - | - | - | - | - | 0,01 | 0,01 | 0,03 | 0,03 | 0,03 | 0,03 | 0,03 |
| Бүгд | 1379,2 | 1395,3 | 1349,5 | 1349,5 | 1313,4 | 1316,3 | 1313,7 | 1243,1 | 1243,4 | 1245,4 | 1252,5 | 1252,5 |

**Эх сурвалж: Ойн судалгаа, хөгжлийн төв*

Шилмүүст ойн дундаж наслалт 133.4 жил, нэг га дахь нөөц нь 151.3м³ бол навчит ойн дундаж наслалт 46.1 жил, нэг га дахь нөөц нь 46.2м³ тус тус байна.

Тогтвортой ойн менежментийг дэмжих зорилгоор Засгийн газрын өргөн боловсруулсан “Төрөөс ойн тухай баримтлах бодлого” баримт бичгийг Улсын Их Хурлын 2015 оны 5-р сарын 14-ний 49 дүгээр тогтоолоор баталсан байна. 2017 онд “Төрөөс ойн тухай баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний дунд хугацааны төлөвлөгөөг” шууд хэрэгжүүлэх эхлэхээр баталж тухайн оны эцэс гэхэд төлөвлөсөн ажлуудын 50.6 хувийг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнтэй зэрэгцэн Байгаль орчны хамгаалах тухай, Ойн тухай болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиудад өөрчлөлт хийж Тогтвортой Ойн Менежмент болон хууль бус мод бэлтгэхтэй тэмцэх хууль эрх зүйн орныг сайжруулав.

Эдгээр бодлогын түвшний өөрчлөлтийн дүнд Засгийн газраас хөдөө орон нутагт мэргэжлийн ойн менежментийн системийг бий болгож 38 сум дундын ойн анги байгуулав. Таримал ойг үнэлэх, ойжуулалтын үнэлгээ 2-3.5 дахин өсөж, засгийн газар хувийн салбараас таримал ойг худалдан авах эсвэл эзэмших эрх шилжүүлэх боломжтой болсон.

2018 оны байдлаар 1281 ойн нөхөрлөл 3,345.4 мянган га талбайг, 90 аж ахуйн нэгж 681.4 мянган га ойн санг тус тус гэрээгээр эзэмшиж байгаа бөгөөд эдгээр нь ойн салбарын менежментийн хүрээнд явуулж байгаа засгийн газрын бодлого юм.

Эдгээр ажлууд нь аль хэдийн эерэг үр дүн үзүүлж эхэлсэн бөгөөд 2018 оны үзүүлэлтийг 2016 онтой харьцуулж үзэхэд онд ойн талбай 133.6 мянган га-гаар, ойн нөөц 7.1 сая м³-р тус тус нэмэгдсэн байна.

Гэсэн хэдий ч Монгол орны ой модонд үзүүлэх ойн түймэр болон ойн хортон шавжийн хөнөөл байсаар байна. Монгол оронд нийтдээ 28 багийн 193 овог, 874 төрөлд хамаарах 14000 орчим зүйлийн шавж бүртгэгдээд байна. Үүнээс 8 багийн 62 овог 316 төрөлд хамаарах 737 зүйлийн шавж нь мод болон сөөгөөр хооллож ой модонд ямар нэг хэмжээгээр хөнөөл учруулдаг. Хөнөөлт шавжтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд зарцуулдаг төсвийг үл харгалзан үзвэл 2016 онтой харьцуулан үзэхэд хөнөөлт шавжийн голомт үүсгэсэн талбайн хэмжээ нь жил бүр хийгддэг урьдчилан сэргийлэх ажил болон хяналт-шинжилгээний дүнд 45.5 хувиар багассан байна.

Ойн хөнөөлт шавжийн халдвараас гадна ойн болон хээрийн түймэр нь монгол орны ой модонд хөнөөл учруулагч нэг гол хүчин зүйл нь болдог. Хэдийгээр 2018 онд гарсан ойн түймэр нь 2017 онд гарсан түймрээс 10 дахин бага байсан боловч сүүлийн 37 жилийн удаан хугацааны хандлагын судалгааны дүн нь хаврын ойн түймэр гарах хугацаа 3-р сарын дундаас 2-р сарын

дунд -руу, намрын ойн түймрийн улирал 10-р сараас 11-р сарын сүүл, 12-р сарын эхлэл хүрч шилжсэн өөрчлөлтийг харуулж байна.

Хүснэгт 8. Ой, хээрийн түймрийн мэдээ, 2011-2018 он

| Үзүүлэлт | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|----------------------------|--------|---------|--------|---------|--------|--------|----------|---------|
| Ой хээрийн түймрийн тоо | | | | | | | | |
| Аймаг | 17 | 19 | 19 | 18 | 16 | 14 | 13 | 13 |
| Сум | 76 | 103 | 89 | 101 | 114 | 61 | 76 | 48 |
| Нийт | 161 | 229 | 198 | 281 | 354 | 138 | 220 | 77 |
| Нийт шатсан талбай, мян.га | | | | | | | | |
| Ой | 20.2 | 340.9 | 5,8 | 18,3 | 31 | 17.1 | 120.9 | 16,6 |
| Хээр | 2000.0 | 4700.0 | 5601,9 | 3080,8 | 5816.9 | 4700.0 | 466.6 | 552,0 |
| Нийт | 2020.0 | 5050.0 | 5607,7 | 3099,1 | 5847,9 | 2900.0 | 587,5 | 568,6 |
| Хохирол, сая.төг | | | | | | | | |
| Нийт | 2776.1 | 83723.8 | 6557,2 | 11149,8 | 6270,0 | 8649.9 | 77.790.2 | 39530,6 |
| Экологийн | 2479.4 | 82000,0 | 4921,5 | 10123,9 | 5940,0 | 8100,0 | 77.272.8 | 39277,9 |

Эх сурвалж: ОБЕГ

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилгод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
 Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
 Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
 Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2016 он гэхэд, Төрөөс ойн талаар баримтлах цогц бодлого, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр батлагдсан байна.
- 2019 он гэхэд, Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд талуудын хамтын ажиллагааг хангах оновчтой менежмент бий болсон байна.

Засгийн газрын өргөн боловсруулсан “Төрөөс ойн тухай баримтлах бодлого” баримт бичгийг Улсын Их Хурлаар 2015 онд баталж, 2017 онд “Төрөөс ойн тухай баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний дунд хугацааны төлөвлөгөөг” батлан, 2017 оны эцэс гэхэд дунд хугацааны төлөвлөлтийн 50.6 хувийг хэрэгжүүлсэн.

2018 оны байдлаар 1281 ойн нөхөрлөл 3,345.4 мянган га талбайг, 90 аж ахуйн нэгж 681.4 мянган га ойн санг тус тус гэрээгээр эзэмшиж байгаа бөгөөд эдгээр нь ойн салбарын менежментийн хүрээнд явуулж байгаа засгийн газрын бодлого юм.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/law/details/423>

Mongolian Multipurpose National Forest Inventory 2014-2017. (2019). Mongolian Ministry of Environment and Tourism. 2nd ed. Ulaanbaatar.

Report of State of the Mongolian Environment, 2017-2018. (2019). Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar.

State Policy on Forests. (2015). Parliament of Mongolia. Ulaanbaatar

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ТОГТВОРТОЙ АШИГЛАХ НӨХЦӨЛИЙГ ХАНГАХ

Зорилго 8. Төр, нутгийн иргэд болон хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох замаар байгалийн нөөц, ялангуяа агнуурын амьтны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах менежментийн арга хэрэгслийг нэвтрүүлэх

Зорилт 17. Нутгийн иргэдийн нөхөрлөл бэлчээр, ан амьтан, ургамал, ой, ойн дагалдах баялаг зэрэг хүрээлэн байгаа байгалийн нөөцөө цогцоор хариуцах эрх зүйн орчин бий болгох

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

2012 оноос эхлэн Монгол улс нь “эзэмшигч нь үнэлэх” зарчмаар байгаль орчны талаар баримтлах бодлогоо өөрчлөн, хэд хэдэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан нь нутгийн иргэдийн нөхөрлөл болон аж ахуйн нэгжүүдийг байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд татан оруулсан юм.

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ойн нөхөрлөлийн эрх, үүргийн харилцааг зохицуулсан хийгээд Амьтны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Монголд анх удаа нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг оруулж ирсэн. Ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг ажлын хэсэг эцэслэн боловсруулаад Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж байна.

Нэмэлтээр байгаль орчны багц хуулиудын шинэчлэл болон орон нутгийн иргэдийн байгалийн нөөцийг ашиглах болон хамгаалах эрх, үүрэг, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хууль, журам, зааврыг боловсруулж хэрэгжүүлж байна. Төрийн байгууллага, олон улсын төслүүд болон төрийн бус байгууллагууд хамтран “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл”-ийг бэхжүүлэх гарын авлага, сургалтын материалыг боловсруулахын зэрэгцээ сургалтыг зохион байгуулж байна.

Хайрцаг 7. Орон нутгийн иргэдийн нөхөрлөлийг агнуурын бүс нутгийн үйл ажиллагаа болон түүний менежментэд оролцуулах нь

2012 оноос өмнө Монгол улсын газар нутгийн 70 гаруй хувь нь үнэн хэрэгтээ агнуурын газар байсан бөгөөд ан агнуурын зөвшөөрлийг хот, суурийн газар болон тусгай хэрэгцээний газар нутгаас (ТХГН гэх мэт.) бусад газарт нутагт олгодог байсан. 2012 оны шинэчлэн найруулсан Амьтны тухай хуулиар нөхөрлөл болон хувийн аж ахуйн салбарууд менежментийн үйл ажиллагааг нь хариуцаж байгаа тодорхой агнуурын бүс нутагт ангийн үйл ажиллагааг явуулдаг болж ан агнуурыг хязгаарласан. 2008 оноос Баруун Монголд “Гулзат”-ын агнуурын бүс нутагт НҮБХХ, ДБХС-ийн хэрэгжүүлсэн “Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийн загвар” төсөл нь агнуурын зохистой үйл ажиллагаанд нутгийн иргэдийн бухимдлыг байнга төрүүлдэг тусгай сонирхлын агнуур болон нутгийн иргэдийг хамтад нь татан оролцуулахад чухал нөлөө үзүүлэхийн зэрэгцээ маш сайн сургамж, туршлага болсон юм.

2018 оны байдлаар Монгол улсын хэмжээнд 25 орон нутгийн нөхөрлөл, 7 ТББ болон 11 хувийн аж ахуйн нэгжүүд 171 ан агнуурын бүс нутгийг хариуцан ажиллаж байна.

Аж ахуйн нэгж, орон нутгийн иргэдийг байгалийн ургамлыг тогтвортой ашиглах болон хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулахад дэмжлэг үзүүлэхийн тулд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө “Ховор болон эдийн засгийн хувьд чухал холбогдолтой ургамлыг сэргээн нутагшуулах, тариалахад татвар, санхүү, хөрөнгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх” зорилтыг суулгасан. Өнгөрсөн хугацаанд хувийн салбарыг эдийн засгийн хувьд чухал холбогдолтой байгалийн ургамлыг аж ахуйн зориулалтаар тариалах ажилд хувийн салбарыг татан оролцуулахын тулд хэд хэдэн санаачилгыг бий болгон хэрэгжүүлэв. Улаан дансны шалгуураар 2019 онд 922 зүйл ургамлыг үнэлэв. Монгол орны ургамлын улаан дансны үнэлгээ, *хамгааллын төлөвлөгөөний* хоёрдугаар цуврал хэвлэгдэн гарч олон нийт хэрэглэх боломжтой болов. Түүнчлэн эрэлт ихтэй ховор ургамлын жагсаалт гаргаж эдгээр ургамлыг тариалах зөвлөмжийг гаргаад байна.

Үүний хажуугаар ашиглалтад өртөмтгий их шүүдэргэнэ (*Chlidonium majus* L.), час улаан долоогоно (*Trifolium sibiricum* L.), эмийн бамбай (*Viciniferia L.*), эмийн сөд (*Sanguisorba L.*), юлдэн тарваган шийр (*Chromolaena L.*), долгиотсон гишүүнэ (*Humulus lupul L.*), дэрвэгэр жиргэрүү (*Shnikovdivriti (Cuz.) Shishhk.*), нангиад зээргэнэ (*Chdrisini Stff*), хэвтээ дэгд (*Gntin d umbhs L.*), ээрэм (царван) шарилжийн (*rtmisi sivrtsin*) 10 зүйл ургамлыг түүж бэлтгэх, хатаах, савлах, тээвэрлэх, хадгалах стандартыг батлан хэрэгжүүлж байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2017 он гэхэд, Нутгийн иргэдийн нөхөрлөл байгуулж бэлчээр, амьтан, ургамал, ой, ойн дагалдах баялаг зэрэг хүрээлэн байгаа байгалийн нөөцийг цогцоор хариуцах эрх зүйн орчин бий болгосон байна.
- 2020 он гэхэд, Нутгийн иргэдийн нөхөрлөл болон бусад талууд байгалийн нөөцийн цогц менежментийн талаар бүрэн ойлголттой болсон байна.

Ойн тухай болон Амьтны тухай хуулийн шинэчилсэн найруулгын дүнд орон нутгийн иргэд, нөхөрлөлүүд хүрээлэн байгаа нөөцөө хууль тогтоомжийн дагуу тогтвортой ашиглах, хамгаалах, менежментийн хариуцлага хүлээх боломжтой болов.

Ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэгдэж байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/law/details/8670>

<https://www.legalinfo.mn/law/details/8935>

<https://www.legalinfo.mn/annex/details/5448?lawid=8644>

<https://www.legalinfo.mn/law/details/8663>

<https://www.legalinfo.mn/annex/details/6215?lawid=9794>

Report of State of the Mongolian Environment, 2015-2016. (2017). Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar.

Report of State of the Mongolian Environment, 2017-2018. (2019). Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar.

Зорилго 8. Төр, нутгийн иргэд болон хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох замаар байгалийн нөөц, ялангуяа агнуурын амьтны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах менежментийн арга хэрэгслийг нэвтрүүлэх

Зорилт 18. Агнуурын бүс нутагт ан агнуурын менежментийг нэвтрүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

2012 оноос эхлэн Монгол улс нь агнуурын бүс нутагт тогтвортой менежмент болон хамгааллын үйл ажиллагааг явуулахад хувийн салбарын хөрөнгө оруулалтыг татан оролцуулах,

идэвхжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх “эзэмшигч нь үнэлэх” гэсэн бодлогын шинэ парадигмийг хэрэгжүүлж эхлэв.

2012 хүртэл газар нутгийн 70 гаруй хувь нь агнуурын газар байсан бол 2018 он гэхэд 18 аймагт 171 агнуурын бүс нутагт (зураг 15) агнуурыг зөв менежментийн хүрээнд явуулах болсон.



Зураг 15. Монгол орны агнуурын бүс нутаг ба ТХГН-ын хамаарал (Эх сурвалж: БОАЖЯ, 2019)

Эдгээр 171 агнуурын бүс нутгийн 66 нь аргаль хонь, 42 нь янгир, 33 нь халиун буга, 13 нь бор гөрөөс, 8 нь зэрлэг гахай, 5 нь тул загас болон 4 газар нь агнуурын шувууд агнахад тус тус зориулагдсан.

Засгийн газраас монгол орны аргаль хонины популяцийн 42.9% (ойролцоогоор 7800 толгой), янгирын популяцийн 17.9% (6500 толгой), халиун бугын популяцийн 10% (1600 толгой) -ийг хамарсан эдгээр газар нутагт менежмент болон байгаль хамгаалах үйл ажиллагааг явуулахыг хувийн салбар болон орон нутгийн нөхөрлөлүүдэд хариуцуулав.

2018 оны байдлаар эдгээр 171 агнуурын бүс нутагт 25 нөхөрлөл, 7 ТББ, 11 аж ахуйн нэгжтэй нарийвчлан судалсны үндсэн дээр орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээний дагуу удаан хугацааны шинжилгээ хийсний дүнд урт хугацааны гэрээ байгуулан ажиллаж байна. Эдгээр 43 байгууллага нь орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээний дагуу өөрсдийн хариуцсан бүс нутагт жил бүр мэргэжлийн байгууллагуудаар байгаль орчны үнэлгээ хийлгэн, тайланг орон нутгийн удирдлагад хүргүүлнэ.

Хүснэгт 9. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу төвлөрүүлсэн орлого, зарлагын мэдээлэл

| Төрөл | Гүйцэтгэл /сая. төгрөг/ | |
|------------|-------------------------|---------|
| | 2017 он | 2018 он |
| Орлого | 5,093,8 | 5,847,7 |
| Зарцуулалт | 610,576 | 725,198 |

Эх сурвалж: БОАЖЯ, 2019

2017-2018 оны хооронд агнуурын зүйлээс 10.94 тэрбум төгрөг орлогыг Монгол улс олсон хэдий ч ердөө 3.1 сая төгрөгийг тодорхой зүйлийг хамгаалахад эргүүлэн зарцуулсан байна. Энэ нь Байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуульд заасан Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын доод хязгаар болох 50%-иас нэн доогуур үзүүдэлт юм.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2016 он гэхэд, Агнуурын бүс нутгийн менежментийг орон нутгийн иргэдийн нөхөрлөл болон хувийн аж ахуйн нэгжүүд бүрэн хариуцдаг болсон байна.
- 2020 он гэхэд, Байгалиас олборлосон ургамал, агнуурын амьтны экспортод тавигдах татварын эрх зүйн зохистой орчин бүрдүүлсэн байна.

2018 оны байдлаар эдгээр 171 агнуурын бүс нутагт 25 нөхөрлөл, 7 ТББ, 11 аж ахуйн нэгжтэй нарийвчлан судалсны үндсэн дээр орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээний дагуу удаан хугацааны шинжилгээ хийсний дүнд урт хугацааны гэрээ байгуулан ажиллаж байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.lg.gov.mn/lw/dt/ils/8670>

<https://www.lg.gov.mn/lw/dt/ils/8935>

<https://www.lg.gov.mn/nn/dt/ils/5448?lwid=8644>

<https://www.lg.gov.mn/lw/dt/ils/8663>

<https://www.legalinfo.mn/annex/details/6215?lawid=9794>

Report of State of the Mongolian Environment, 2015-2016. (2017). Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar.

Report of State of the Mongolian Environment, 2017-2018. (2019). Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar.

Зорилго 9. Малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулсан хууль эрх зүй, эдийн засгийн хөшүүрэг бий болгон монгол орны бэлчээрийн доройтлыг 70 хүртэл хувиар бууруулж сайжруулах

Зорилт 19. Газрын тухай багц хууль болон холбогдох бусад эрх зүйн баримт бичигт экосистемийн тэнцвэрт байдлыг бүрэн хамгаалсан мал аж ахуй эрхлэх эдийн засгийн хөшүүрэг бий болгох

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

1996 онд баталсан анхны хөтөлбөр болон 2 дахь “Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны үндсэн хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний аль алинд нь Монголын улсын газар нутгийн 72.1%-ийг хамрах тогтвортой бэлчээрийн менежмент нь экосистемийн доройтлыг бууруулах, бэлчээрийн хөрсний нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд нэг чухал тэргүүлэх чиглэл юм гэж үзсэн.

Үндэсний бусад хөтөлбөрүүдэд тухайлбал “Монгол мал” түүнчлэн “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” зэрэгт газрын доройтлыг бууруулах нь Монгол орны хөдөө орон нутагт тогтвортой амьжиргааг хангах арга зам юм гэж үзсэн байдаг. Түүнчлэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Бэлчээрийг хамгаалах тухай” хуулийг боловсруулж батлуулах, бусад холбогдох “Малын генетикийн нөөцийн тухай хууль”, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”, Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийг боловсруулан батлан замаар бэлчээр ашиглалт болон хамгаалалтыг сайжруулах улмаар Монгол оронд тогтвортой мал аж ахуй хөгжлийг хангах тухай орсон.

Гэсэн хэдий ч “Бэлчээрийн тухай хууль”-ийн төсөл дахин нэг удаа буцаагдаад байна. Үнэн хэрэгтээ сүүлийн 20 жилийн турш олон улсын хамтын нийгэмлэгүүд болон бусад оролцогч талуудын дунд яригдаж байгаа бэлчээрийн тухай хуулийг ярьж эхэлсэн эхний мөчид л байгалийн гамшигт үзэгдэл болох өвлийн зуднаар хөдөө орон нутагт 7 сая мал хорогдсон байдаг.

Өнөөдрийг хүртэл Монгол улсын хэмжээнд газар доройтолд нөлөөлж байгаа малын тоог толгойн өсөлтийг хязгаарлах тухай ямар нэг бодлого байхгүй байна. Үүний оронд сонгуулийн үеэр малчдаас дэмжлэг авахын тулд гаргасан популист шийдвэрүүдийн дүнд малын тоо толгойг нэмэгдүүлэх эдийн засгийн хөшүүргүүд нь (ноосны урамшуулал, ноолуурын үйлдвэрт олгож буй татаас гэх мэт) нөхцөл байдлыг улам хурцатгаж байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд, Бэлчээрийн экосистем дэх зэрлэг амьтдын хэрэгцээг бэлчээрийн даац тогтоох аргачлалд тусгасан байна.
- 2020 он гэхэд, бэлчээрийн харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчныг бий болгосон байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт багтсан “Бэлчээр хамгаалах тухай” хуулийг эс тооцох юм бол бусад хуультай хамтаар Бэлчээрийн тухай хуулийн төсөл буцаагдсан. Сүүлийн 20 жилийн турш олон улсын хамтын нийгэмлэгүүд болон бусад оролцогч талууд бэлчээрийн тухай хуулийг дэмжсээр ирсэн ч үр дүн хоосон хэвээр байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

Зорилго 9. Малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулсан хууль эрх зүй, эдийн засгийн хөшүүрэг бий болгон монгол орны бэлчээрийн доройтлыг 70 хүртэл хувиар бууруулж сайжруулах

Зорилт 20. Үржил шимийн доройтолд орсон хөрсийг нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг хөрсийг хамгаалах, доройтолд орохоос урьдчилан сэргийлэх санхүүгийн тогтвортой тогтолцоог бий болгох

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол орны нийт газар нутгийн 73.4 хувь нь хөдөө аж ахуйн газар эзэлдэг бөгөөд үүний 91.6% нь бэлчээрийн, 1.49% нь хадлангийн, 0.95% нь тариалангийн газар тус тус байна. Сүүлийн 40-өөд жилийн хугацаанд бэлчээр болон хадлангийн талбайн эзлэх хувь нь уул уурхай, замын сүлжээний улмаас бага хэмжээгээр буурсан. 1990-ээд оны үеэр орхигдсон тариалангийн талбайг нөхөн сэргээсний дүнд газар тариалангийн талбайн хэмжээ нэмэгдсэн.

Хүснэгт 10. Газрын нэгдмэл сангийн ангилал (мян. га)

| | Газрын сангийн ангилал | 2015 он | 2016 он | 2017 | 2018 | <u>2018</u> 2015 |
|----------------------|------------------------|----------|----------|----------|----------|---------------------|
| Хөдөө аж ахуйн газар | | 114982.8 | 114934.9 | 114843.6 | 114809.2 | -176.3 |
| ҮҮнд | Бэлчээр | 110613.6 | 110493.8 | 110391.6 | 110391.6 | -222,0 |
| | Хадлан | 1717.7 | 1742.4 | 1709.1 | 1709.1 | - 8,6 |
| | Тариалан | 1028.2 | 1067.7 | 1100.8 | 1100.8 | +72,6 |
| | Атаршсан газар | 305 | 260.6 | 231.6 | 231.6 | -73,4 |
| | ХАА-н барилга, | 74.4 | 110.6 | 116.4 | 116.4 | +42,0 |
| | ХАА-д тохиромжгүй | 1259.7 | 1259.7 | 1259.7 | 1259.7 | 0 |

Эх сурвалж: 1212.mn, 2019

2016 оны газрын доройтлын үнэлгээнээс харахад доройтсон газрын 92% нь (6.2 сая га) бэлчээрийн доройтлоос үүссэн байна. 2018 онд доройтсон бэлчээр 798.4 мянган га талбайгаар нэмэгдэж, улсын хэмжээгээр доройтсон газрын 95.1% нь бэлчээрийн доройтлын улмаас бий болсон байна.

Бэлчээрийн доройтол нь 7 үндсэн хүчин зүйлийн улмаас бий болж байгаа бөгөөд үүнээс бэлчээрийн даац хэтрэх болон хортон амьтдын (мэрэгч болон шавж) нөлөө нь гол байрыг эзэлж байна.

Хүснэгт 11. Бэлчээрийн талбайд гарсан хохирол, мян. га

| Өөрчилөгдсөн нөхцөл | 2014 он | 2016 он | 2018 | Зөрүү +- 2018 2014 |
|---|---------|---------|--------|--------------------------|
| Талхлагдсан | 1890,8 | 2005.0 | 1483.4 | -407,4 |
| Салхи, усны эвдрэлд өртсөн | 27,8 | 25.0 | 10.85 | -16,95 |
| Намагжсан | 15,7 | 15,7 | 0,35 | -15,35 |
| Элсний нүүдэлд орсон | 150,3 | 201.7 | 146,6 | -3,7 |
| Мэрэгч, шавьжид өртсөн | 1614,9 | 2400.0 | 4956,7 | +3341,8 |
| Цөлжсөн | 3750,0 | 1500.0 | 353,1 | -3396,9 |
| Ашигт малтмалын олборлолтод өртсөн / зам/ | 2,9 | 53.8 | 49,0 | +46,1 |
| Бүгд | 7452,4 | 6201,2 | 7000,0 | -452,4 |

Эх сурвалж: ХХААХҮЯ, 2019

Үлийн цагаан оготно (*Lasiopodomys brandtii* Raddle) болон царцааг бэлчээрийн даац хэтэрсэн газар нутгийг илэрхийлэгч зүйл гэж үзэх юм бол газрын доройтлын 92% хүртэл хувь нь бэлчээрийн даац хэтэрснээс үүдэхийн зэрэгцээ Монгол орны бэлчээрийн төлөв байдалд нөлөөлөгч өөр нэг чухал хүчин зүйл бол цөлжилтийн үйл явц бөгөөд газрын доройтлын 7.1% нь энэ хүчин зүйлээс болж үүсэж байна.

Бэлчээрийн доройтлын эсрэг авах арга хэмжээнд аймаг, сумын удирдлага жил бүр нөхөн сэргээх ажилтай холбоотой бага хэмжээний төсөв хуваарилдаг бөгөөд ХХААХҮ-ийн яамнаас

нөхөн сэргээлттэй холбоотой бүх ажлыг нэгтгэн зангиддаг. Доорх хүснэгтээр 2017 онд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнг нэгтгэн харуулж байна.

Хүснэгт 12. 2017 оны байдлаар бэлчээрийн талбайг сайжруулах талаар хэрэгжүүлсэн ажлын дүн.

| Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа | Талбай, га |
|------------------------------|------------|
| Элсний нүүдлээс хамгаалсан | 46,3 |
| Тордож сайжируулсан | 6618,5 |
| Хортон мэрэгчийг нь устгасан | 607846,2 |
| Хог хаягдлаас цэвэрлэсэн | 6641,0 |
| Даацад тохируулалт хийсэн | 331795,5 |
| Өнжөөж сайжируулсан | 51012,58 |
| Ээлж сэлгээтэй ашиглаж буй | 895092,1 |
| Бүгд | 1899052,18 |

Эх сурвалж: ХХААХҮЯ, 2019

Монгол улсын хэмжээнд хөрсний үржил шимийг зөвхөн тариалангийн талбайд үнэлдэг бөгөөд 2016 оны үнэлгээгээр монгол орны газар тариаланд хөнгөн шавранцар хөрс зонхилон тарах бөгөөд сул эвдэрсэн хөрснөөс жилд дунджаар 25.4 тн/га, дунд зэрэг эвдэрсэн хөрснөөс 133.4 тн/га, хүчтэй эвдэрсэн хөрснөөс 213 тн/га үржил шимт өнгөн хөрс алдагдаж байна. Эдгээр талбайгаас эвдрэлд сул өртсөн талбайгаас дунджаар 4.8-8.6 тн/га, дунд зэрэг эвдэрсэн хөрстэй талбайгаас 10-21.3 тн/га, хүчтэй эвдэрсэн хөрстэй талбайгаас 21.6-40.8 тн/га ялзмагийн бодис тус тус алдагдаж байна. Өнөөгийн байдлаар нийт талбайн 47.7% нь 0.9-1.9%-ийн ялзмагийн агууламжтай байгаа нь олон улсын ангиллаар хамгийн ядмаг агууламжтай ангилалд ордог байна. Сүүлийн 40 жилийн туршид 3% буюу түүнээс илүү ялзмагийн агууламжтай талбайн хэмжээ 9.5%, харин 2.0-2.9% болон 1.0-1.9%-ийн ялзмагийн агууламжтай талбайн хэмжээ 11.0% болон 23.2%-иар тус тус буурчээ. Түүнчлэн 1%-иас бага ялзмагийн агууламжтай талбай хэмжээ тодорхой хувиар нэмэгдсэн байна.

Хэдийгээр Тариалангийн тухай хуульд хөрсний агрохимийн шинжилгээг 5 жил тутамд заавал хийлгэх ёстой гэж заасан ч орон нутгийн засаг захиргааны хяналт, шалгалт байхгүй тохиолдолд тариаланчид үүнийг дагаж мөрддөггүй байна. Сүүлийн жилүүдэд үржил шимээ алдсан болон орхигдсон тариалангийн талбайг дахин нөхөн сэргээх арга хэмжээг авч байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилгод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2017 он гэхэд, Доройтолд орсон хөрсийг нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг хөрсийг хамгаалах, доройтолд орохоос урьдчилан сэргийлэх эдийн засгийн хөшүүргийг ХАА, уул уурхай, дэд бүтцийн холбогдох салбарын бодлого хууль, эрх зүйд тусгасан байна..
- 2020 он гэхэд, БОЯБ-д чухал газруудад доройтолд орсон хөрсийг нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг хөрсийг хамгаалах, доройтолд орохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эхлүүлнэ.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт багтсан “Бэлчээр хамгаалах тухай” хуулийг эс тооцох юм бол бусад хуультай хамтаар Бэлчээрийн тухай хуулийн төсөл буцаагдсан.

Хэдийгээр Тариалангийн тухай хуульд хөрсний агрохимийн шинжилгээг 5 жил тутамд заавал хийлгэх ёстой гэж заасан ч орон нутгийн засаг захиргааны хяналт, шалгалт байхгүй тохиолдолд тариаланчид үүнийг дагаж мөрддөггүй байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<http://mofa.gov.mn/>

Nyamsambuu, N. Ikhbayar, D. (2016). Cropland use and soil erosion of Mongolia. Journal of Soil Science of Mongolia. pp. 94-102

Report of State of the Mongolian Environment, 2015-2016. (2017). Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar.

Report of State of the Mongolian Environment, 2017-2018. (2019). Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar.

Зорилго 10. Тариалангийн үйлдвэрлэлийн техник технологи, үйл ажиллагааг орчныхоо агробиоценоз дахь биологийн төрөл, зүйлүүдийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангахад нийцүүлэн шинэчлэх

Зорилт 21. Хөдөө аж ахуйн салбарын газар ашиглалтыг биологийн олон янз байдлыг хамгаалах бодлоготой уялдуулах

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол бол газар тариалан эрхэлж байгаагүй уламжлалттай орон. 1950-иад оныг хүртэл айл өрхүүд улаан буудай, шар будаа болон арвайг өөрсдийн хэрэгцээнд зориулан бага хэмжээгээр тариалдаг байсан боловч төвлөрсөн төлөвлөгөөт системийн үед их хэмжээний газар тариаланг эрхлэх болсноор нөхцөл байдал өөрчлөгдсөн. Гэсэн хэдий ч тухай үед Монголын хуурай газар нутгийн хөрс нь механик хөнөөлд тун эмзэг байсан бөгөөд 1970 он гэхэд улсын хэмжээнд 260 мянган га талбайн хөрс салхины элэгдэлд өртсөн байв. Хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэх талаар 1974-1981 оны хооронд авсан Засгийн газрын удаа дараагийн шийдвэрийн үр дүнд 1985 он гэхэд хөрсний элэгдлийг 75%-иар багасган тогтоосон байна. Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар (2016) хөрс хамгаалах, сайжруулах арга хэмжээ болон байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх тухай заасан хэдий ч хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтэд өмнөх хуулийн нэгэн адил (2004) нөхцөл тулгарч байна.

Өнөөгийн байдлаар орхигдсон тариалангийн талбайн ихэнх нь Монгол орны баруун болон төвийн аймгуудад байгаа бөгөөд 30-аад жилийн турш ямар нэгэн хөнөөл, саад учраагүй мөн эргэн тойрных байгалийн ургамалжилт хэвий байсан хэдий ч эдгээр орхигдсон талбайд байгалийн сэргэн ургалт явагдахгүй байна. 2010 оны үеэр БОАЖЯ-аас эдгээр орхигдсон талбайн зарим хэсэгт нөхөн сэргээлт явуулахын тулд олон наст ургамал тариалахаар тодорхой хөрөнгө хуваарилсан юм. Гэсэн хэдий ч санхүүжилт тодорхойгүй байсан тул энэ ажлыг зогсоосон. Органик хүнсний тухай хууль (2016) болон дагалдах хуулиуд нь хувийн хэвшилд химийн бордоо ашиглаагүй, байгаль орчинд ээлтэй газар тариаланг практикт хэрэгжүүлэхэд нь эерэг нөлөөтэй хүчин зүйл болж байна.

Эсрэгээрээ, Засгийн газраас “Атрын 3-р аян”-ыг дэмжихийн тулд газар тариалангийн салбарт олгосон татаас, мөн тариаланчдад хөнгөлөлттэй үнээр үр, бордоо, ургамал хамгаалах химийн бодис худалдаж авах боломж олгосон нь тариаланчдын гербицид зэрэг агро-химийн бодисын хэрэглээг нэмэгдүүлж байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилгод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 онд гэхэд, Шинээр усалгаатай тариалан, хадлан бэлчээр бий болгох боломжтой газар нутгийн хайгуул, судалгаанд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийдэг болох, БОЯБ-д нэн чухал түшиц газрыг чөлөөлөх эрх зүйн үндсийг бий болгосон байна.
- 2020 он гэхэд, Уул уурхай, ХАА-н эдэлбэр газрын ангилалд байгаа БОЯБ-д нэн чухал түшиц газрыг экологи, нийгэм, эдийн засгийн нарийвчилсан судалгаанд үндэслэн ашиглалтаас чөлөөлж хамгаалалтад авсан байна.

Засгийн газраас “Атрын 3-р аян”-ыг дэмжихийн тулд газар тариалангийн салбарт олгосон татаас, мөн тариаланчдад хөнгөлөлттэй үнээр үр, бордоо, ургамал хамгаалах химийн бодис худалдаж авах болгож олгосон нь тариаланчдын гербицид зэрэг агро-химийн бодисын хэрэглээг нэмэгдүүлж байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/law/details/11641?lawid=11641>

<https://www.legalinfo.mn/law/details/471?lawid=471>

<https://www.legalinfo.mn/law/details/11644?lawid=11644>

<https://www.legalinfo.mn/law/details/12972?lawid=12972>

<https://www.legalinfo.mn/law/details/11725?lawid=11725>

<https://www.legalinfo.mn/law/details/11485>

<https://www.legalinfo.mn/annex/details/7409?lawid=12120>

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХАМГААЛАХ, АШИГЛАХ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ

Зорилго 11. Биологийн олон янз байдлын талаарх шалгуур үзүүлэлтийг үндэсний тооцооны системд нэвтрүүлж, холбогдох салбарын хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд тусган хэрэгжүүлэх

Зорилт 22. Цогц судалгаанд үндэслэсэн биологийн олон янз байдлын шалгуур үзүүлэлтийг тодорхойлж үндэсний тооцооны системд нэвтрүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

2014-2016 оны хооронд Монгол Улсын Их Хурал нь улс орныг тогтвортой хөгжлийн цогц бодлогыг тодорхойлсон гурван чухал бодлого, зохицуулалтын баримт бичгийг баталсан юм. Эдгээр гурван баримт бичиг нь 2014 онд баталсан “Ногоон хөгжлийн бодлого”, 2015 онд баталсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, 2016 онд баталсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” юм. Ногоон хөгжлийн бодлого нь 6 стратегийн зорилтой, зорилт бүр нь өөрийн салбар арга замуудыг тодорхойлсон бөгөөд 1-р үе шат нь 2014-2020 оны хэрэгжиж эхэлнэ. Бодлогын баримтад тусгагдсан 6 зорилтыг Үндэсний Статистикийн Хороотой хамтран боловсруулж биологийн олон янз байдлын шалгуур үзүүлэлтийг тусгасан. Эдгээр хөгжлийн урт хугацааны баримт бичгүүд нь байгалийн нөөцийг зохистой ашиглах, экосистемийн тэнцвэртэй байдлыг хадгалж, үр өгөөжийг урт хугацаанд хүртэх, эдийн засгийн хүртээмжтэй өсөлт, нийгмийн тогтвортой байдал болон хүний амьдралын чанарыг хангах нь байгаль орчны тогтвортой хөгжлийн үндэс гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”-н дээр дурдсан зарчмуудыг үнэлэх 20 шалгуур үзүүлэлтийн гурван үзүүлэлт нь биологийн олон янз байдалтай шууд хамааралтай юм. Эдгээр шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг тодорхойлох, хяналт тавих болон олон нийтэд тайлагнах ажлыг ҮСХ нь цахим хуудсаар дамжуулан гүйцэтгэдэг. НҮБ-ын Статистикийн комиссын 48-р чуулганаар тодорхойлсон дэлхий нийтийн ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэхээр тодорхойлсон 244 шалгуур үзүүлэлтийн дагуу ҮСХ нь улсын хэмжээнд үнэлгээг мөн явуулдаг.

Хүснэгт 13. Байгаль орчинтой холбоотой зарим үзүүлэлтийн төлөв байдал

| № | Үзүүлэлт, хэмжих нэгж | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2020 | Эх үүсвэр |
|---|--|------|------|------|------|-------|--------------------|
| 1 | Байгаль орчны багц үзүүлэлт, эзлэх байр | 111 | ... | 114 | ... | 105* | Иелийн их сургууль |
| 2 | Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ, % | 78.2 | 76.8 | ... | ... | 74.6* | БОАЖЯ |

| | | | | | | | |
|---|---|------|------|------|------|------|-------|
| 3 | Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ, % | 13.5 | 13.5 | 13.5 | 13.5 | 25** | БОАЖЯ |
|---|---|------|------|------|------|------|-------|

Эх сурвалж: sdg.gov.mn

Түүнчлэн Үндэсний Хөгжлийн газар нь “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”-н дунд хугацааны 2020-2025он хэрэгжилтийг үнэлэх 52 шалгуур үнэлгээний зорилтот түвшинг тодорхойлсны 9 нь байгаль орчин болон биологийн олон янз байдалтай холбогдож байна.

- Үр тарианы үйлдвэрлэлд тэг элдэншүүлэлтийн технологийг талбайн – 70 хувьд хүргэх
- Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 25 хувьд хүргэх
- Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн - 50 хувийг тусгай хамгаалтад авах
- Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 80 хувьд хүргэх
- Айл өрхийн сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хувийг 40 хувьд хүргэх
- Хүлэмжийн хийн ялгарлыг 2 хувиар бууруулах
- Ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэх
- Хот суурин газрын ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэх
- Хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх

Байгаль орчин, Эдийн засгийн дансны системийн хүрээнд “Материалын урсгалын данс”-ыг 2014 он анх эхлүүлж 2015 оноос хэрэгжүүлж байна. АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Байгаль орчин ба Эдийн засгийн данс байгуулах чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд ҮСХ нь “Эрчим хүчний урсгалын данс” болон “Байгаль орчны татварын данс”-ыг боловсруулсан. Байгаль орчны эдийн засгийн данс байгуулах зарим арга зүйг ҮСХ-ны даргын шийдвэрээр батлаад байна. Эдгээр арга зүйд:

- Ногоон хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд, тооцох аргачлал;
- Эрчим хүчний балансын урсгалын дансыг байгуулах аргачлал
- Материалын урсгалын дансыг байгуулах аргачлал
- Байгаль орчны татварын дансыг байгуулах аргачлал тус тус орно.

ҮСХ нь 2019 онд “Усны данс”, “Хог хаягдлын данс” болон “Агаар бохирдуулагч ялгаруулалтын дансыг” байгуулах сургалтыг зохион байгуулсан бөгөөд ингэснээр эдгээр дансны хүрээнд биологийн олон янз байдлыг үзүүлэлтийг тооцоолох боломжтой болох юм.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд БОНХЯ-наас “Байгалийн нөөцийн эдийн засгийн статистикийг шинэчилж, эдийн засаг болон санхүүгийн салбарт үзүүлж байгаа эрдэс баялгийн салбарын нөлөөллийг системтэй тооцоолох аргачлал” бий болгох санал оруулсан байна.

Гэсэн хэдий ч Засгийн газраас төлөвлөсөн “Биологийн олон янз байдлыг үнэлэх суурь мэдээллийг цуглуулах загвар, аргачлалыг шинэчлэх”, “Байгаль орчин, Эдийн засгийн дансны системийг үе шаттайгаар бий болгох зөвлөмж боловсруулах” зэрэг үйл ажиллагаануудын эхлэл удаашралтай байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2017 он гэхэд Ногоон хөгжлийн үзүүлэлтэд биологийн олон янз байдлын шалгуур, үнэлгээнүүд орсон байна.
- 2020 он гэхэд Нийгэм, эдийн засгийн хөгжилд байгаль орчноос оруулах хувь нэмрийг үндэсний бүртгэлийн системд оруулах судалгааг хийж, холбогдох зөвлөмжийг гаргасан байна.

Ногоон хөгжлийн бодлого нь 6 стратегийн зорилттой, зорилт бүр нь өөрийн салбар арга замуудыг тодорхойлсон бөгөөд 1-р үе шат нь 2014-2020 оны хэрэгжиж эхлэх бөгөөд 6 шалгуур үзүүлэлт нь биологийн олон янз байдлын түлхүүр үзүүлэлтийг хамарсан.

Үндэсний Статистикийн Хороо нь Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”-г үнэлэх 20 шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшнийг тодорхойлсон бөгөөд эдгээрийн гурван шалгуур үзүүлэлт нь биологийн олон янз байдалтай шууд хамааралтай юм. Үндэсний Хөгжлийн газар нь “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”-н дунд хугацааны 2020-2025он хэрэгжилтийг үнэлэх 52 шалгуур үнэлгээний зорилтот түвшнийг тодорхойлсны ес нь байгаль орчин болон биологийн олон янз байдалтай холбогдож байна. Гэсэн хэдий ч биологийн олон янз байдлыг үнэлэх дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй, мөн эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь тодорхой бус, үндэсний бүртгэлийн системд оруулах үйл явж удаашралтай байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/law/details/1148>

<https://www.legalinfo.mn/annex/details/7310>

<https://www.legalinfo.mn/annex/details/6438>

<https://www.legalinfo.mn/law/details/11886>

<http://sdg.gov.mn/>

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө. (2018). БОАЖЯ

Монгол Улсын байгаль орчин-эдийн засгийн зарим дансууд, ҮХГ, 2018

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө. (2018). ЗГХЭГ

Монгол Улсын дунд хугацааны (2018-2025) хөгжлийн хүрээ: судалгааны тайлан. (2018). ҮХГ, НҮБХХ. р. 68

ҮСХ-ны даргын 2017 оны 07 сарын 03-ны А/103 тоот тушаал

ҮСХ-ны даргын 2018 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А/64 тоот тушаал

Зорилго 11. Биологийн олон янз байдлын талаарх шалгуур үзүүлэлтийг үндэсний тооцооны системд нэвтрүүлж, холбогдох салбарын хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд тусган хэрэгжүүлэх

Зорилт 23. Биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглах асуудлыг холбогдох салбаруудын бодлого, хөтөлбөртэй уялдуулах

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Үндэсний хөгжлийн газрын судалгаагаар 1990 оноос хойш 570 орчим хөгжлийн бодлого, баримт бичиг батлагдсан байдаг бөгөөд одоогийн байдлаар 203 нь хүчин төгөлдөр, 68 нь хүчин төгөлдөр бус, 294 нь хугацаа нь дууссан, 3 баримт нь цуцлагдсан байна.

Хүснэгт 14. Хүчин төгөлдөр үйлчилж буй хөгжлийн бодлогын баримт бичгүүд

| УИХ-ын тогтоолоор баталсан - 51 | | | Засгийн газрын тогтоолоор баталсан - 145 | | |
|---------------------------------|----------------------|-----|--|----------------------|-----|
| № | Баримт бичгийн төрөл | Тоо | № | Баримт бичгийн төрөл | Тоо |
| 1 | Үзэл баримтлал | 5 | 1 | Бодлого | 12 |
| 2 | Бодлого | 23 | 2 | Стратеги | 9 |
| 3 | Бодлогын үндэс | 1 | 3 | Үндэсний хөтөлбөр | 70 |
| 4 | Стратеги | 2 | 4 | Хөтөлбөр | 30 |
| 5 | Үндсэн чиглэл | 6 | 5 | Дэд хөтөлбөр | 3 |
| 6 | Үндэсний хөтөлбөр | 8 | 6 | Мастер төлөвлөгөө | 1 |
| 7 | Хөтөлбөр | 1 | 7 | Төлөвлөгөө | 17 |
| 8 | Төлөвлөгөө | 3 | 8 | Чиглэл | 6 |
| 9 | Чиглэл | 1 | 9 | Жагсаалт | 3 |
| 10 | Жагсаалт | 1 | | | |

Эх сурвалж. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн судалгаа, Үндэсний хөгжлийн газар, 2019 он.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдахаас өмнө хэрэгжиж байсан эдгээр хөгжлийн бодлогын баримт бичгийн зарим нийтлэг дутагдлуудыг дурдвал:

- Төрөл бүрийн үзэл баримтлал, удирдамж, үндэсний хөтөлбөр, хөтөлбөр, дэд хөтөлбөр, төлөвлөгөө, чиглэл болон жагсаалтад нэгтгэгдсэн бодлогын олон баримт бичгийг боловсруулан баталдаг.
- Эдгээр баримт бичиг нь хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэргүй, Их хурлын сонгуулийн дараа ч гэсэн Засгийн газраас үүнийг өөрчлөөгүй.

- Салбарын хөгжилд чиглэсэн Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүд нь салбарын асуудалд голчлон төвлөрч байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ болон хамгааллын асуудал орхигдсон байна.
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хянах, болон дүн шинжилгээ хийх явц нь тодорхойгүй байв.

Үндэсний аудитын газрын 2018 оны “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн тайлан”-д хөгжлийн уялдаа холбоо, салбарын бодлого болон Хөгжлийн бодлогын тухай хуулийн хэрэгжүүлэлт сул мөн зарим шаардлагагүй бодлогыг цуцлах, түдгэлзүүлэх үйл явц удаашралтай байна.

Салбарын хөгжлийн бодлого болон хөтөлбөрүүдэд биологийн олон янз байдлыг хамгаалах, зохистой ашиглах талаарх бодлогын хэрэгжилт хангалтгүй байгааг дараах хоёр салбараас харж болно.

Хөдөө аж ахуйн салбарт байгаль орчныг хамгаалахын тулд “Монгол мал” үндэсний хөтөлбөрт (2010-2021):

3.4.1.3 - Малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулах, бэлчээрийн даац хэтэрсэн нутагт байлгах малын тооны дээд хязгаарыг тогтоож, түүнээс давуулахгүй байлгах эдийн засгийн хөшүүргүүдийг бий болгох;

3.4.1.4 - Малчин болон мал бүхий иргэдээс малынх нь төрөл, бүс нутгийн онцлогийг харгалзан бэлчээр ашигласны төлбөр авах эрх зүйн орчныг бүрдүүлж, түүний тодорхой хэсгийг бэлчээр хамгаалах, сайжруулахад ашиглах;

Гэсэн хэдий ч эдгээр заалтуудын алин нь ч хэрэгжээгүй байна.

2014 онд Улсын Их Хурлаар “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг баталсан бөгөөд уг бодлогын 2.1.2 -т “олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэт техник, технологи, инновацыг дэмжих;” гэж оруулсан зорилт нь тогтвортой хөгжлийн зарчмыг хангах юм.

Гэхдээ, эдийн засаг түргэн өсөж байгаагийн хирээр энэ зорилтын хэрэгжилт хангалтгүй байна.

БОАЖЯ-аас Ногоон Хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд олон улсын хамтын нийгэмлэгүүд тухайлбал НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл, Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага (ДДНХБ) болон Цэвэр хөгжлийн механизм -тай хамтарсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ингэснээр биологийн олон янз байдлыг бусад салбаруудын хөтөлбөр, бодлогуудтай холбох юм.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2016 он гэхэд, Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийг Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр болон бусад хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай уялдуулсан байна.
- 2018 он гэхэд, Үндэсний тооцооны системд биологийн олон янз байдлын шалгуур үзүүлэлтийг тусган хэрэгжүүлэх боловсон хүчнийг чадавхжуулсан байна.

Үндэсний аудитын газрын 2018 оны “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн тайлан”-д хөгжлийн уялдаа холбоо, салбарын бодлого болон Хөгжлийн бодлогын тухай хуулийн хэрэгжүүлэлт сул мөн зарим шаардлагагүй бодлогыг цуцлах, түдгэлзүүлэх үйл явц удаашралтай байна.

Хэдийгээр хөдөө аж ахуй болон уул уурхай зэрэг аж үйлдвэрийн салбарын бодлогод байгаль орчинд ээлтэй ногоон үйл оруулдаг ч эдгээр арга хэмжээний хэрэгжилт нь эдгээрт зориулсан хөрөнгө санхүү болон тохирсон хяналт-шинжилгээ, үнэлгээ байхгүйн улмаас ихэвчлэн учир дутагдалтай байдаг.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/annex/details/3340?lawid=7039>

<https://www.legalinfo.mn/law/details/9756>

Бодлогын баримт бичгүүдийн нэгтгэл. (2019). Үндэсний хөгжлийн газар. Улаанбаатар

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн судалгаа. (2019). Үндэсний хөгжлийн газар. Улаанбаатар

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн тайлан. (2018). Үндэсний Аудитын Газар. Улаанбаатар

Зорилго 12. Байгаль орчны стратегийн үнэлгээнд үндэслэн хөдөө аж ахуй, эрдэс баялаг, дэд бүтэц, эрчим хүч, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаас хэрэгжүүлж байгаа биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа болон нөлөөлөх магадлалтай үйл ажиллагаанд төсвөөс татаас болон хөнгөлөлт үзүүлэхгүй байх эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт 24. Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа эдийн засгийн хөшүүргийг бууруулах арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Биологийн олон янз байдалд учирч болзошгүй сөрөг нөлөө үзүүлж байгаа татаасыг бууруулж багасгах нь түүнийг хамгаалах өртөг багатай хөрөнгө оруулалт болох юм. Гэсэн хэдий ч эдийн засгийн янз бүрийн салбарт биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж болох татаасыг бууруулах талаар судалгааны ажил хомс байна. Дэлхийн банкнаас “Монгол улсын хөдөө аж ахуйн татаасыг үнэлэх, дүн шинжилгээ хийх” судалгааг 2014 онд хэвлүүлсэн. Энэхүү судалгаа

нь 2008-2012 оны хооронд үеийг хамарч, төрөөс татаас олгох бодлого, түүний хэлбэр болон мал аж ахуй, газар тариалан болон жижиг үйлдвэрлэлд олгосон урамшууллын талаар судалсан.

Уг тайланд үр тариа үйлдвэрлэл (үр болон бордоо)-д олгосон татаас болон урамшуулал, ноолуур, ноос, мал эмнэлгийн үйлчилгээнд дэх улсын дэмжлэг, хадлан болон бэлчээрийн усжуулалтыг дэмжих татаас мөн боловсруулах үйлдвэрлэлд олгосон зээл зэрэг олон хэлбэрийн татаас болон дэмжлэгийн сул болон давуу талуудыг үнэлсэн болно. Эдгээр дэмжлэг, татаасны ихэнх нь одоо хүртэл үргэлжилж байна.

Тухайлбал мал аж ахуйд өгсөн татаас нь малын тоо толгойг ихэсгэхэд түлхэц үзүүлсэн гол хүчин зүйл болсон гэж үздэг юм. Гэсэн ч Дэлхийн Банкны судалгаагаар хонины ноосонд өгсөн татаас нь хонины тоо толгойг өсөх гол шалтгаан болоогүй хийгээд гарсан зөвлөмжид нь “мал аж ахуйн салбарт татаас олгох асуудлыг байгаль орчны асуудлуудтай тухайлбал бэлчээрийн тэтгэх даац болон бэлчээрийг урт хугацаанд тогтвортой ашиглах зэрэгтэй харгалзан үзэхийг зөвлөжээ.”

2017 онд Б.Чимэд-Очир нь НҮБХХ санхүүжүүлсэн BIOFIN төслийн хүрээнд хийсэн “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийн шийдэл ба түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө” ажлын тайланд Монголын биологийн олон янз байдалд шууд нөлөө үзүүлдэг зургаан татаасыг тодорхойлсон байна (хүснэгт 15).

Хүснэгт 15. Биологийн олон янз байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй Монголд хэрэгжүүлж буй татаас

| Татаасын хэлбэр | Тайлбар | Болзошгүй сөрөг нөлөө | Одоогийн байдал |
|--|--|---|-----------------|
| Нэг. Мал аж ахуйн салбар: | | | |
| Хувь хүний орлогын албан татвар | Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу мал бүхий иргэдээс авдаг байсан “малын хөлийн” татварыг 2009 оны VI сард хүчингүй болгосон | Энэ нь малын тоо толгойг өсгөх, бэлчээрийн даацыг хэтрүүлэх нэг хүчин зүйл болсон. | Хүчин төгөлдөр |
| Малчин өрхийг бэлчээр, хадлангийн төлбөрөөс чөлөөлсөн | Газрын төлбөрийн хуулиар малчин өрхийг чөлөөлсөн боловч мал бүхий өрх буюу тавиул малыг татвараас чөлөөлөөгүй. | Малын тоо толгойг өсгөх, бэлчээрийн даацыг хэтрүүлэх нэг хүчин зүйл болсон | Хүчин төгөлдөр |
| Малын гарал-тай түүхий эдийн урамшуулал | Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор үйлдвэрт тушаасан ноос, арьс ширэнд олгох урамшуулал | Малын тоо толгой өсөхөд тодорхой хэмжээгээр нөлөөлж болзошгүй | Хүчин төгөлдөр |
| Ноолуурын дэмжлэг | Дотоодын ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ямааны тоо толгойд олгосон бэлэн мөнгөний урамшуулал | Сүргийн бүтцийг алдагдуулах нэг хүчин зүйл | Нэг удаа |
| Бэлчээрийн менежментэд дэмжлэг үзүүлэх буцалтгүй тусламж | Бэлчээрийн хортон шавж, мэрэгчтэй тэмцэх, бэлчээр усжуулах зорилгоор төс-вөөс ихээхэн хэмжээний зардал гаргадаг | Мал, зэрлэг амьтдын амьдрах орчны өрсөл-дөөн, мэрэгч, хортонтой тэмцэх зорилгоор химийн хор хэрэглэх нь тэдгээрээр хооллодог махчин амьтадад сөрөг нөлөөтэйгөөс гадна үр дүн муутай | Үргэлж |
| Хоёр. Газар тариалангийн салбар | | | |

| | | | |
|--------------------|------------------|------------------------------------|----------|
| Бордооны хөнгөлөлт | Хөнгөлөлтэй зээл | Гадаргын болон гүний усны бохирдол | Заримдаа |
|--------------------|------------------|------------------------------------|----------|

Хэдийгээр байгаль орчинд үзүүлэх шууд сөрөг нөлөөгүй ч төрөөс ноолуурын үйлдвэрлэл, улаан буудай болон гурилын үйлдвэрт ихээхэн хэмжээний мөнгөн урамшууллыг дэмжлэг, татаас хэлбэрээр олгодог. ХХАХХҮ-ийн сайдын тушаалаар 2016 онд 292.4 мянган тонн үр тариа хурааж гурилын үйлдвэрүүдэд нийлүүлсэн бөгөөд 726 аж ахуйн нэгж, иргэнд 14.9 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. 2017 онд улсаас 14.8 тэрбум төгрөгийг улаан буудайнд олгохоор төлөвлөсөн бөгөөд нийлүүлсэн 118.0 мянган тонн үр тарианд 7.8 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал, 2018 оны тариалалтад зориулан 31.8 мянган тонн улаан буудайн үр худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 7.0 тэрбум төгрөгийн тус тус зарцуулсан байна.

Хайрцаг 8. Монголын биологийн олон янз байдалд сөрөг нөлөөтэй зарим татаас

Алтны нөөц ашигласны төлбөр. 2014 оноос хойш Засгийн газар Ашигт малтмалын тухай хуульд удаа дараа нэмэлт өөрчлөлт оруулж ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2.5 хувьд хүргэсэн нь биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлсөн. Энэ журмын дагуу Монгол банк болон эрх бүхий арилжааны банкуудад тушаасан алтны хэмжээ жилээс жилд нэмэгдэж мөн алтны орлого өсөж 2014 он гэхэд 20 тоннд хүрсэн боловч байгаль орчинд асар их нөлөө үзүүлсэн юм.

Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.13 заалтын дагуу малчин өрх, малд ноогдох малын татварыг 2009 оноос чөлөөлж ирсэн. Энэ хугацаанд малын тоо толгой хоёр дахин өсөж бэлчээрт үзүүлэх нөлөө эрс өссөн. Мэдээжийн хэрэг энэ нь бэлчээрийн доройтол болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа хөнгөлөлтийн хэлбэр юм.

Хуулийн цоорхойгоос ашиг хүртэх. “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг 2009 онд баталсан. Хуулийг дэмжсэн Засгийн газрын тогтоол гарсан хэдий ч 2014 оноос хойш 7 удаа нэмэлт өөрчлөлт оруулж, өөрчлөлт бүр нь хуулийн шаардлагыг зөөлрүүлж ирсэн нь хуулийн идэвхтэй үр нөлөөг бууруулсаар байна.

Сөрөг нөлөө үзүүлэгч урамшуулал. 2013 оны Улсын Их Хурлын “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоол, Засгийн газрын “Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам” 122-р тогтоол аль аль нь хүчинтэй байна. Эдгээр шийдвэрийн улмаас малчдад улсын сангаас их хэмжээний татаас олгосон нь бэлчээрийн тэтгэх даацад сөрөг нөлөө үзүүлэхэд хүргэсэн юм.

2012 оноос “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд Байгаль орчны стратеги үнэлгээний тухай оруулсан байдаг. Уг хуулийн хэрэгжилтийг хангахын тулд БОНХЯ-наас дараах дагаж мөрдөх журам, дүрмийг баталсан байна. Үүнд:

- “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”, □ / 03, 2014;

- “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал” сайдын А-117 тоот тушаал

Хуулийн дагуу бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулагч салбарын яам нь уг баримт бичгийг боловсруулах явцад стратегийн үнэлгээ хийлгэж Засгийн газарт хэлэлцүүлэхээс өмнө уг үнэлгээний тайланг бодлогын баримт бичгийн төслийн хамт БОАЖЯ-нд хүргүүлнэ.

Одоогоор ямар нэгэн хөтөлбөр, төслүүд стратегийн үнэлгээ хийлгээгүй байна. Стратегийн үнэлгээг орхигдуулж байгаа гол хүчин зүйл нь стратегийн үнэлгээ хийх хувийн салбарын мэргэжилтнүүдийг ажиллуулах шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгаагүйтэй холбоотой юм. Цаашид Хөгжлийн Бодлогын төлөвлөлтийн бодлогод стратегийн асуудлын зохицуулгыг нарийн тодорхойлох шаардлагатай.

Хэдийгээр стратегийн үнэлгээ орхисон байсан ч Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай үнэлгээг нь хуульд заасны дагуу төсөл, хөтөлбөрүүдэд хийгдэж байгаа. БОАЖЯ-наас гаргасан албан ёстой статистик мэдээгээр 2014-2018 оны хооронд уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт 2106 байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийсэн байна.

2014 онтой харьцуулан үзэхэд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ 86.4 хувиар өсөж, хүлээн авсан тайлангийн эзлэх хувийг салбараар үзүүлбэл: үйлчилгээний салбарт 55.6%, уул уурхайн салбарт 18.2%, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт 17.6% үлдсэн 8.6% нь дэд бүтцийн төслүүдэд хийсэн нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Unkn□wn

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2017 он гэхэд, Байгаль орчны стратегийн үнэлгээ хийх хувийн хэвшлийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлсэн байна
- 2020 он гэхэд, ХАА, эрдэс баялаг, дэд бүтэц, эрчим хүч, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бодлогын баримт бичиг, хөтөлбөрт байгаль орчны стратегийн үнэлгээ хийдэг болсон байна.

Биологийн олон янз байдалд нөлөө үзүүлэх олон татаас, хөнгөлөлт нь хөдөө аж ахуй болон уул уурхайн салбарт байсаар байна. Гэсэн хэдий ч байгаль орчин болон биологийн олон янз байдалд эдгээр татаас, урамшууллын үзүүлэх нөлөөг үнэлсэн нарийвчилсан судалгаа, дүн

шинжилгээ байхгүй байгаа нь эдгээр татаас, урамшууллын талаар мэдээлэлд суурилсан шийдвэр гаргахад төвөгтэй байдалд хүргэж байна. 2012 оноос “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд Байгаль орчны стратеги үнэлгээний тухай оруулсан байдаг. Уг хуулийн хэрэгжилтийг хангахын тулд БОНХЯ-аас дараах дагаж мөрдөх журам, дүрмийг баталсан байна.

Хуулийн дагуу бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулагч салбарын яам нь уг баримт бичгийг боловсруулах явцад стратегийн үнэлгээ хийлгэж Засгийн газарт хэлэлцүүлэхээс өмнө уг үнэлгээний тайланг бодлогын баримт бичгийн төслийн хамт БОАЖЯ-нд хүргүүлнэ. Гэсэн хэдий ч байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үр дүнтэй байлгахын тулд шаардлагатай эдийн засаг, хууль эрх зүйн дэмжлэг дутмаг байсаар байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/annex/details/6909?lawid=11359>

<https://www.legalinfo.mn/law/details/11644?lawid=11644>

<https://www.legalinfo.mn/law/details/12972?lawid=12972>

<https://www.legalinfo.mn/law/details/12973?lawid=12973>

<https://www.legalinfo.mn/law/details/9576?lawid=9576>

<https://www.legalinfo.mn/law/details/11003?lawid=11003>

<https://www.legalinfo.mn/law/details/8665?lawid=8665>

Annor-Frempong, C. and Gunjal, K. (2015) Review, Estimation and Analysis of Agricultural Subsidies in Mongolia. World Bank. Washington DC.

National Program on Biodiversity (NPBDs), 2015

Чимэд-Очир Б. (2017). Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн шийдэл, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө. Ажлын тайлан. НҮБХХ, БИОФИН төсөл. Улаанбаатар.

Зорилго 12. Байгаль орчны стратегийн үнэлгээнд үндэслэн хөдөө аж ахуй, эрдэс баялаг, дэд бүтэц, эрчим хүч, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаас хэрэгжүүлж байгаа биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа болон нөлөөлөх магадлалтай үйл ажиллагаанд төсвөөс татаас болон хөнгөлөлт үзүүлэхгүй байх эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт 25. Биологийн олон янз байдлыг хамгаалах, зохистой ашиглахыг дэмжих эдийн засгийн механизмыг боловсруулж хэрэгжүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол Улсад одоо байгаа хуулиудын хүрээнд биологийн олон янз байдлыг хамгаалах болон зүй зохистой ашиглахад эдийн засгийн механизмыг хоёр арга замаар зохицуулдаг. Эхнийх нь, бохирдуулагч төлөх зарчим буюу нь ус, агаар гэх мэт хүрээлэн буй орчныг бохирдуулж байвал төлбөр төлөх шаардлагатай; хоёр дахь нь, биологийн олон янз байдлын эсрэг хууль бус

үйлдлийн талаар холбогдох төрийн байгууллагад мэдээлэл өгсөн хүнд урамшуулал олгох, хэрвээ өгсөн мэдээлэл нь үнэн зөв байвал шагнал, урамшуулал авна.

Бохирдуулсны төлбөр:

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус болон рашаан усны нөөцийг ашигласан, мөн усны чанарыг бохирдуулсны төлөө ус бохирдуулсны төлбөр төлнө. Төлбөрийн хэмжээ нь усан дахь бохирдуулах бодисын хэмжээ болон төрлөөс хамаарна.

Уг хуульд 2017 онд ус бохирдуулсны төлбөрийг “Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн, усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ болон нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах” гэсэн нэмэлт өөрчлөлт оруулсан. Хуульд мөн урамшууллын тодорхой механизмыг оруулсан. Жишээлбэл, ус бохирдуулагчийг дараах нөхцөлд төлбөрөөс чөлөөлнө:

- Хаягдал усыг усны чанарын стандартын хэмжээнд хүртэл цэвэрлэсэн хэмжээгээр;
- Хаягдал саарал усыг цэвэрлэж, эргүүлэн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан бол дахин ашигласан хэмжээгээр

2010 оноос эхлэн “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хуулиар агаар бохирдуулагч, агаарын бохирдлын төлбөр ногдуулах, төлбөрийн хувь хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх асуудлыг зохицуулна. Энэ хуулийн 8.1-т хэрвээ түүхий нүүрсийг гүн боловсруулах замаар үйлдвэрлэсэн, стандартын шаардлага хангасан шинэ төрлийн түлш үйлдвэрлэсэн тохиолдолд боловсруулсан нүүрсний хэмжээгээр төлбөрөөс чөлөөлнө гэж заасан байна.

Хууль бус үйл ажиллагааны илчилсний урамшуулал:

Амьтны тухай хуулийн 38.1 зүйл нь амьтны тухай хууль тогтоомж зөрчсөний этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно.

Ойн тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтуудад урамшууллын тухай оруулсан. Тухайлбал:

- Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, дэвшилтэт технологи нэвтрүүлсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах;
- Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг өгсөн иргэнд урамшуулал олгоно;
- Хууль бусаар мод бэлтгэсэн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн эрх бүхий албан тушаалтанд урамшуулал олгоно;

Сүүлийн үед олон улсын төсөл, хувийн салбан болон төрийн бус байгууллагуудаас биологийн олон янз байдлыг хамгаалах, зүй зохистой ашиглах салбарыг дэмжих эдийн засгийн хөшүүргийн олон хувилбарыг боловсруулж туршихаар санал, санаачилгууд гарч байна.

БОАЖЯ, МБХ, Сангийн Яам, Дан дэлхийн дэлхий ногоон хөгжлийн байгууллага хамтран хувийн салбар, иргэдийн санал, санаачилгыг дэмжих зэрэгцээ дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх, байгаль орчинд ээлтэй бусад санаачилгуудыг дэмжих хөрөнгө оруулалт

хийх зорилготой “Ногоон хөгжлийн сан”-г үүсгэн байгуулсан. Энэ нь бага хүүтэй, уян хатан нөхцөл бүхий ногоон зээлийг бий болгох нэг алхам юм.

ХАС банк, Мерси Коп олон улсын байгууллага, Бодлого судлалын төв хамтран бэлчээрийн менежментийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн “Ногоон бэлчээр” төслийн эхлүүлэн, 2018 оны 12-р сард Хэнтий аймгийн Баян-Овоо суманд хэрэгжүүлэв. ХААН банк болон бусад банкнууд нь малчдад зээлийн хүүгээс бага хүүтэй зээл олгох замаар бэлчээрийн тэтгэх даацыг хэтрүүлээгүй дагаж мөрдөж байгаа малчдыг дэмжиж байна. НҮБХХ-өөс санхүүжүүлсэн “Тогтвортой үнэ цэний гинжин хэлхээ” төслийн зорилго нь урт хугацааны туршид ноолуурын гинжин хэлхээг бий болгодог үйлдвэрлэл болон малчдын хоорондын хамтын ажиллагааг дэмжих явдал юм. Төслийн зорилго нь ноолуурын гарц, чанарыг дээшлүүлэх замаар бэлчээрийн доройтлыг бууруулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх, чанарт тулгуурласан үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх, хувийн салбар болон хүртээмжтэй нээлттэй бизнесийг дэмжих замаар хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн байна.

3. Урамшууллын бусад хэлбэрүүд: Засгийн газар, БОАЖЯ бусад урамшууллын хэлбэрийг бий болгох зорилгоор урамшуулах санаачилгыг эхлүүлээд байна. Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах ” журмаар дээрх урамшууллыг олгож байна. Тухайлбал:

- Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи дэвшүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад “Ногоон гэрчилгээ” олгоно.

- Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд “Эко-тэмдэг” олгоно.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд, БОЯБ-ыг хамгаалж зохистой ашиглаж байгаа салбарыг урамшуулах эдийн засгийн хөшүүргийн хувилбаруудыг боловсруулсан байна.

- 2020 он гэхэд, БОЯБ-ыг хамгаалж зохистой ашиглаж байгаа салбарыг урамшуулах эдийн засгийн хөшүүргийг холбогдох салбарын бодлого, эрх зүйд тусгасан байна.

Монгол улсад одоо байгаа хуулиудын хүрээнд биологийн олон янз байдлыг хамгаалах болон зүй зохистой ашиглахад эдийн засгийн механизмыг хоёр арга замаар зохицуулдаг. Эхнийх нь, бохирдуулагч төлөх зарчим буюу нь ус, агаар гэх мэт хүрээлэн буй орчныг бохирдуулж байвал төлбөр төлөх шаардлагатай; хоёр дахь нь, биологийн олон янз байдлын эсрэг хууль бус үйлдлийн талаар холбогдох төрийн байгууллагад мэдээлэл өгсөн хүнд урамшуулал олгох, хэрвээ өгсөн мэдээлэл нь үнэн зөв байвал шагнал, урамшуулал авна.

Биологийн олон янз байдлыг зүй зохистой ашиглах, хамгаалах эдийн засгийн механизмын эрх зүйн орчин байгаа хэдий ч тэдгээрийн хэрэгжилтийн талаар хийсэн нарийвчилсан судалгаа дутагдалтай байна.

Дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүчийг хэмнэх болон байгальд ээлтэй бусад санаачилга, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор хувийн хэвшлийнхэн ялангуяа арилжааны банкнууд нь санаачилга гарган хэрэгжүүлж байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/law/details/8684>

<https://www.legalinfo.mn/law/details/30>

<https://www.legalinfo.mn/law/details/8670>

<https://www.legalinfo.mn/law/details/12171>

<https://www.legalinfo.mn/law/details/8935>

<https://mba.mn/sustainable-finance-in-mongolia-mn/>

Энх-Амгалан, А. (2019). *Хэнтий аймгийн Баян-Овоо суманд мал аж ахуйн хөгжлийн шинэ загвар нэвтрүүлж байна*. Өдрийн сонин 2019.02.25, №038, 039 (61398 6140). Улаанбаатар: Бодлого судлалын төв, www.cpr.mn.

Зорилго 13. Бэлчээр, усны нөөц, ойн экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, ач холбогдлыг тооцож нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг тогтвортой хадгалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх
Зорилт 26. Экосистемийн үйлчилгээг үнэлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол Улсын хувьд газрын төлбөр, агаар бохирдуулсны, ан агнах, агнуурын зөвшөөрөл, ус, рашаан усны нөөцийг ашиглах, байгалийн ургамлыг ашигласны төлбөр, мод, мод бэлтгэх зэрэгтэй холбоотой хууль, журмаар экосистемийн үйлчилгээний төлбөрийг зохицуулдаг.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь ургамал, ус, ой болон байгалийн нөөцийн харилцааг зохицуулдаг. Хуульд заасны дагуу:

- ✓ Нэн ховор, ховор, элбэг ургамал ашигласны төлбөр

- ✓ Хүн амны унд, ахуйн болон үйлдвэрлэл, уул уурхай үйлдвэрлэлийн зорилгоор ашигласан ус, эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл үйлчилгээний зорилгоор ашигласан рашаан ус, эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамлыг үржүүлэх зэрэг үйлдвэрлэл болон үйлчилгээний чиглэлээр ашигласан ус;
- ✓ Аливаа зориулалтаар ашигласан бүх төрлийн мод, түлээ, дагалт баялаг болох самар, мөөг, давирхай, шилмүүс, мөчир, үр болон хусны шүүс ашиглахад
- ✓ Ахуйн зориулалтаар агнасан, барьсан, төлбөртэй агнасан, барьсан болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнасан, барьсан бол төлбөр тус тус төлнө.

Хуульд мөн дээр дурдсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн дээд болон доод хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх болон хөнгөлөх харилцааг заасан байдаг.

Монголын уламжлалт мал аж ахуйн салбар нь биологийн олон янз байдлыг хамгаалах болон хөдөө орон нутгийн амьжиргааны суурь нь болж байгаа хэдий ч Монгол Улсад бэлчээрийн нөөцийн тогтвортой ашиглалт болон менежментийн талаар үр дүнтэй бодлого арга хэмжээ байхгүй байна. Одоогийн байдлаар бэлчээр хамгаалах болон ашиглахтай холбогдсон харилцааг Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлд тодорхойлсон байна.

Монгол оронд бэлчээрийн газар нь хотжилт, үйлдвэржилт болон уул уурхай хөгжлийн улмаас жилээс жилд буурсаар байна. Жишээлбэл 1945 онд 130 сая га талбай бүхий бэлчээртэй байсан бол 1964 онд 122.1 сая га, 1989 онд 122.7 сая га, 2008 онд 113.3 сая га, 2018 онд 110.5 сая га болж тус тус багасжээ. Улсын хэмжээнд бэлчээр, хадлангийн талбайг 1989 он буюу зах зээлийн эдийн засагт шилжсэн үетэй харьцуулж үзэх юм бол 12.2 сая га (9.9 хувь) талбайгаар багассан байна.

Шилжилтийн 30 жилийн хугацаанд Монгол орны малын тоо толгой бараг гурав дахин өсөж 100 га бэлчээрт оногдох малын тоо 2.3 дахин (бэлчээрийн дарамт), малчдын тоо 2.2 дахин, нэг малчинд ноогдох малын тоо 26.6 хувь тус тус өссөн байна. Эдгээр тоо баримт нь улсын хэмжээнд бэлчээрийн дарамт нь богино хугацаанд эрс нэмэгдсэн болохыг харуулж байна.

Монгол улсад нүүдлийн мал аж ахуйгаас олох орлого нь гурван хүчин зүйлээс хамаардаг: малын тоо толгой, малын ашиг шим, мөн зах зээл дээрх түүхий эдийн үнээс хамаардаг. Сүүлийн жилүүдэд нэг малаас авах ашиг буурсаар байгаа, мөн түүхий эдийн үнэ өсөхгүй байгаагаас малчид өдөр тутмын хэрэгцээ, ахуй амьдралаа хангахын тулд бэлчээрийн менежментийн цоорхойг ашиглан бүх эрсдэлийг бэлчээрт үүрүүлэх замаар өөрсдийн малын тоо толгойг өсгөдөг.

Бэлчээрийг хамгаалах асуудал үндсэндээ орхигдсон. Улсын их хурлын гишүүд нь “Бэлчээрийн тухай хууль” хуулийн төслийг 1990 оны дунд үеэс хойш их хурлаар хэлэлцүүлэхээр олон удаа оролдож байна. ХХААХҮЯ-аас 2017 онд “Бэлчээрийн тухай хууль” боловсруулах ажлын хэсгийг гаргаж хуулийн төсөл, зарчмыг боловсруулсан хэдий ч Улсын Их Хуралд өргөн бариагүй байна. Үүний улмаас бэлчээрийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Аялал жуулчлалын салбар нь экосистемийн үйлчилгээнд бүхлээрээ түшиглэж мөн тусгай хамгаалалттай газар нутгийн ой мод болон ус санд мэдэгдэхүйц дарамт нөлөө үзүүлэхийн зэрэгцээ экосистемдээ буцааж хөрөнгө оруулахгүй байна. БОАЖЯ-ны мэдэгдсэнээр 2018 онд аялал жуулчлалын салбарт 58.0 мянган хүн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 4.9 хувь нь болж байна. Монгол улсын хэмжээнд 2014 онд 65.6 мянган гадаадын жуулчин, 299.2 мянган дотоодын жуулчин тусгай хамгаалалттай газар нутагт зорчсон байна. 2018 оны байдлаар тусгай хамгаалалттай газар нутагт зорчсон гадаадын жуулчдын тоо 81.9 мянга, дотоодын жуулчдын тоо 380.6 мянгад хүрсэн нь сүүлийн 4 жилийн хугацаанд 26.9%-иар өсжээ. Хэдийгээр

жуулчдын тоо өссөн ч жуулчдын төлбөрөөс тусгай хамгаалалттай газар нутагт буцаан хөрөнгө оруулалт хийсэн баримт байхгүй байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

- 2016 он гэхэд, Экосистемийн үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, боломжит хувилбарыг боловсруулсан байна.

Монгол улсын хувьд газрын төлбөр, агаар бохирдуулсны, ан агнах, агнуурын зөвшөөрөл, ус, рашаан усны нөөцийг ашиглах, байгалийн ургамлыг ашигласны төлбөр, мод, мод бэлтгэх зэрэгтэй холбоотой хууль, журмаар экосистемийн үйлчилгээний төлбөрийг зохицуулдаг.

Гэсэн хэдий ч олон улсын хөгжлийн агентлагуудын бэлтгэсэн зарим судалгааны тайлан, зөвлөмжийг эс тооцох юм бол экосистемийн ялгаатай, шууд бус үйлчилгээг мөнгөний эргэлтэд оруулах хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна. Тийм учраас Монгол улсад экосистемийн үйлчилгээний төлбөрийг хэрэгжүүлэх, сайн нэгтгэн буулгахын тулд хууль, дүрмийн шинэчлэл хийхдээ эдгээр зөвлөмжийг харгалзан үзэх шаардлагатай юм.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/law/details/8663>

<https://www.legalinfo.mn/law/details/216?lawid=216>

<https://www.legalinfo.mn/law/details/9687>

Орхон Уулсын Статистикын Нэгж, 2015-2016. (2017). Орхон Уулсын Статистикын Нэгж, 2015-2016. (2017). Орхон Уулсын Статистикын Нэгж, 2015-2016. (2017). Орхон Уулсын Статистикын Нэгж, 2015-2016. (2017).

Орхон Уулсын Статистикын Нэгж, 2017-2018. (2019). Орхон Уулсын Статистикын Нэгж, 2017-2018. (2019). Орхон Уулсын Статистикын Нэгж, 2017-2018. (2019). Орхон Уулсын Статистикын Нэгж, 2017-2018. (2019).

Монгол Улсын статистикийн эмхэтгэл, ҮСХ, 2000-2017

Бакей, А. (2016). Монголын бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийн зарим асуудал. УБ. 204 дэх тал

Ганзориг Г. нар. (2015). Хан Хэнтийн дархан цаазат газрын экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ ба цаашдын хандлага.

Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үйлчилгээний салбарын хөгжилд оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнэ: судалгааны тайлан. (2014) НҮБХХ, БОАЖЯ.

Монгол Улсын статистикийн эмхэтгэл, ҮСХ, 2018 он

Зорилго 13. Бэлчээр, усны нөөц, ойн экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, ач холбогдлыг тооцож нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг тогтвортой хадгалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх

Зорилт 27. Экосистемийн үйлчилгээний төлбөр (“ЭҮТ”)-ийг нэвтрүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Монгол Улсын “Ногоон хөгжлийн бодлого”-н зорилгод “алслагдсан нутагт бэлчээрийн даацад тохируулан мал аж ахуй эрхэлж, усны эх, булаг, шандыг арчилж тордох зэргээр бэлчээрийн доройтлоос сэргийлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж байгаа малчдад экосистемийн үйлчилгээний төлбөрийн урамшуулал олгох механизмыг бүрдүүлэх” гэж заасан байдаг. Монгол улсад бэлчээрийн экосистемийн үйлчилгээг хадгалах үнэ цэнийг албан ёсоор тогтоогоогүй байна. Гэсэн хэдий ч ургамлын экологи, эдийн засгийн үнэлгээг тодорхойлсон байна.

Байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулийн 14.1 зүйлд байгалийн ургамлын нөөцийг ашигласны төлбөрийг заасан (экологи, эдийн засгийн үнэлгээний хувиар тооцсон); хуулийн 15.1 болон 15.2 зүйлд ус, рашаан усны нөөц ашигласны төлбөр; хуулийн 16 зүйлд ойн нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ; хуулийн 17 зүйлд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тус тус заасан байна. Байгалийн ургамлыг түүхэд төлбөр төлөх болов.

БОАЖЯ-ны А-282 тоот тогтоол “Нэн ховор, ховор, зарим элбэг ургамлын экологи, эдийн засгийн үнэлгээ”, 2014 оны Засгийн газрын тогтоолоор “Ан амьтны экологи, эдийн засгийн үнэлгээ” болон “Усны экологи, эдийн засгийн үнэлгээ” -г тус тус шинэчлэн баталсан. Түүнчлэн байгаль орчны хохирлыг тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулна.

Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог бүрийн гектарын суурь үнэлгээ, жилийн төлбөрийн доод хязгаар” баталж тойрог бүрийн эдийн засгийн нөхцөл болон байгалийн ялгаатай байдалтай нийцүүлэх Алтай, Хангай, Говь болон Хээрийн дөрвөн тойрогт бэлчээр болон хадлангийн талбайн үнэлгээг ялгаатай баталсан.

НҮБХХ-с санхүүжүүлсэн “Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь” төслийн хүрээнд “Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээ” тайланд Алтайн нуруу, Их Нууруудын хотгор, Зүүн Монголын хээр, Монгол дагуурын бүс нутагт ус, бэлчээр болон ойн экосистемийн эмзэг байдлыг үнэлэн экосистемээс хүртэх үр шим, экосистемийн дэмжих үйлчилгээний талаар зөвлөмжийг оруулан тайлагнасан байна.

2011 онд БОАЖЯ болон Дэлхийн банкнаас хамтран Монгол улсад экосистемийн үйлчилгээний төлбөрийн зарчмыг нэвтрүүлэх боломжийн судалгааг явуулсан. Төсөл нь экосистемийн үйлчилгээний төлбөр болон үндэслэлийг дахин нягтлах мөн Монголд экосистемийн үйлчилгээний төлбөрийг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан юм. Төслийн хүрээнд Туул голын эхэн хэсгийн экосистемийн эдийн засгийн үнэ цэнийг үнэлж Туул гол дээр экосистемийн үйлчилгээний төлбөрийг нэвтрүүлэх арга замыг тодорхойлсон.

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд БОАЖЯ болон олон улсын байгууллагууд хамтран 2019-2020 онд экосистемийн үйлчилгээний төлбөрийг тогтоох шалгуурыг боловсруулсан боловч хэрэгжүүлэх ажил хараахан эхлээгүй байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд, БОЯБ-ыг тэтгэх салбарын ЭҮТ-ийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.
- 2020 он гэхэд, ЭҮТ-ийн эдийн засгийн үнэлгээг байгалийн бүс бүслүүр тус бүрээр ялгавартай тогтоох, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийг хянан сайжруулж боловсронгуй болгосноор ЭҮТ-ийн хөтөлбөрийг боловсруулсан байна.

Байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулийн хүрээнд экосистемийн үйлчилгээний төлбөрийг хэрэглэх зохицуулга нь хязгаарлагдмал байна. Гэсэн хэдий ч олон улсын хөгжлийн агентлагуудын бэлтгэсэн зарим судалгааны тайлан, зөвлөмжийг эс тооцох юм бол экосистемийн ялгаатай, шууд бус үйлчилгээг мөнгөний эргэлтэд оруулах хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна. Иймд Монгол улсад экосистемийн үйлчилгээний төлбөрийг нэвтрүүлэхдээ хууль, дүрмийн шинэчлэл хийх, экосистемийн үйлчилгээний төлбөрийг ялгаатай салбарууд дээр хэрэгжүүлэхдээ эдгээр зөвлөмжийг харгалзан үзэх шаардлагатай юм.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

Ногоон хөгжлийн бодлого. (2014). Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт. 3.4.7 дугаар зүйл.

Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016 он. (2018). Байгаль орчин, аялал жуулчлалын яам. 31-32 дахь тал.

Энх-Амгалан, А. (2017) “Бэлчээр ашиглалтын төлбөр нэвтрүүлэх арга зүй”. НҮБХХХ, БИОФИН төсөл. 3 – 5 дахь тал.

Эрдэнэсайхан, Н. (2011). “Экосистемийн үйлчилгээний төлбөрийн зарчмыг Монгол Улсад нэвтрүүлэх боломж” судалгааны ажлын тайлан. Дэлхийн Банк.

Зорилго 14. Биологийн олон янз байдлын стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн боломжит гол эх үүсвэрийг тодорхойлж, үр нөлөөтэй ашиглах тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 28. Биологийн олон янз байдалд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Засгийн газрын бүх тусгай санд байгаль орчинд ээлтэй байх шалгуур үзүүлэлтийг тусгах

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг Улсын их хурал 2006 онд баталсан бөгөөд Нэгдүгээр бүлэг нь Нийтлэг үндэслэл; Хоёрдугаар бүлэг нь Засгийн газрын тусгай сан, түүний төрөл, ангилал; Гуравдугаар бүлэг нь Тусгай санг бүрдүүлэх, зарцуулах; Дөрөвдүгээр бүлэг нь Тусгай сангаас санхүүжилт олгох журам; Тавдугаар бүлэг нь Тусгай сангийн гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих журам; Зургаадугаар бүлэг нь Бусад зүйл гэж тус тус заасан байна. Харамсалтай нь энэ маш чухал хууль нь популист улс төрчдийн нөлөөгөөр хамгийн олон удаа шинэчлэгдэж байгаагаас түүний хэрэгжилт, хамрах хүрээ хамгийн тогтворгүй байна. Энэ хуулиар эдийн засгийн бодит салбар, байгаль орчны чиглэлээр дараах тусгай сангууд байгуулахыг заажээ:

- Байгаль орчин, уур амьсгалын сан
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
- Засгийн газрын нөөц сан
- Мал хамгаалах сан
- Тариалан дэмжих сан/үрийн аж ахуйг дэмжих
- Улсын авто замын сан
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- Шинжлэх ухаан, технологийн сан
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
- Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
- Агаарын бохирдлын эсрэг сан


2015 онд долоон тусгай сан үүнд (Сэргээгдэх эрчим хүчний сан орно) хаагдсан бөгөөд, 2019 онд Засгийн газрын шийдвэрээр Хөгжлийг дэмжих сан, Олон улсын хамтын ажиллагааны сан, Цэвэр агаар санг тус тус татан буулгасан бөгөөд Газар тариалан, Мал сүргийг хамгаалах, Жижиг, дунд үйлдвэрлэлийн санг нэгтгэх шийдвэр гарсан.

Байгаль орчныг хамгаалах сан байгуулах, зарцуулах журамд тухай хуульд байгаль орчинд ээлтэй нөлөөлөх байдлын тухай заасан. Байгаль орчин уур амьсгалын сан болон Агаарын бохирдлын эсрэг сангаас бусад сангууд нь тодорхой салбарын эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн бөгөөд шалгаруулах үзүүлэлтүүдэд нь байгаль хамгаалах тухай заалт байдаггүй. Үндэсний аудитын газраас 2014-2016 гаргасан дүгнэлтэд засгийн газрын зарим тусгай санд менежментийн буруу удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байгаа нийтлэг зөрчлүүд байна гэж үзжээ.

2014 онд Засгийн газраас “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” тогтоолыг баталсан. Энэхүү журмын зорилго нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт (газар, ус, рашаан, ой,

байгалийн нөөц, газар ашиглах) “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуульд заасан төлбөрийн орлогын тодорхой хэсгийг бүрдүүлэх, төсвийн зарлагад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төлөвлөх, зарцуулах, тайлагнах хянахтай холбоотой харилцааг зохицуулах юм. БОАЖЯ-наас мэдээлснээр “Байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай” хуулийн хүрээнд 2016-2018 оны хооронд 77.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. Гэсэн хэдий ч ердөө 10.2 тэрбум төгрөгийг байгаль хамгаалахад зарцуулж, хуулийн хэрэгжилт 36.9% байна.

НҮБХХ-ийн “Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга (БИОФИН)” төслийн хүрээнд Монгол орны биологийн олон байдлын эдийн засгийн үнэлгээг хийхдээ “БИОФИН ажлын дэвтэр” ашиглан гаргасан. Уг үнэлгээгээр 2008-2018 оны хооронд биологийн олон янз байдлын санхүүжилт 207.7 сая ам. доллароор өссөн нь улсын төсвийн 0.35-0.79%, дотоодын нийт бүтээгдэхүүний 0.15-0.25% болж байна. Нийт зардлын 44.4 хувийг улсын төсвөөс, 55.6 хувийг нь олон улсын хандивлагч байгууллагуудаас гаргасан байна.



Зураг 16. Улсын төсөв болон ДНБ-д БОАБ-ын зарцуулалтын эзлэх хувь

“Биологийн олон янз байдлын зарцуулалтын тайлан 2008-2015 (Эх сурвалж. Т.Оюунчимэг)

Үндэсний хэмжээнд байгалийн нөөц ашигласны орлого нь дөрвөн томоохон эх үүсвэрээс бүрддэг.

Хүснэгт 16. Монгол Улсын төсвийн нийт орлого ба байгалийн нөөцийн зарим төлбөрийн орлогын эзлэх хувь хэмжээ, тэрбум төгрөг

| Орлогын төрөл | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|--------|--------|--------|--------|--------|
| Нийт орлого, тусламжийн хэмжээ | 4244.3 | 3834.0 | 3854.0 | 5832.9 | 7563.1 |
| 1.Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | 44.3 | 37.3 | 34.8 | 37.8 | 38.9 |
| 2.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | 173.3 | 180.6 | 101.0 | 192.6 | 320.6 |
| 3.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр | 1.8 | 2.4 | 1.7 | 4.5 | 3.0 |
| 4.Агаарын бохирдлын төлбөр | 32.6 | 13.9 | 19.4 | 36.6 | 42.1 |
| Дээрх дөрвөн төрлийн төлбөр (1+2+3+4)-ийн дүн | 252.0 | 234.2 | 157.0 | 271.6 | 404.6 |
| Улсын төсвийн нийт орлогод дөрвөн төрлийн төлбөрийн эзлэх хувийн жин, % | 5.9 | 6.1 | 4.1 | 4.7 | 5.3 |

Эх сурвалж. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, ҮСХ, 2014-2017 он

Жилийн дундаж орлого 263.9 тэрбум төгрөг бөгөөд энэ нь улсын төсвийн 5 хувийг эзэлж байна. Дээр дурдсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн татвар нь жилд дунджаар 193.6 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж байна.

Орон нутгийн төсөвт газрын төлбөр, байгалийн нөөц ашигласны төлбөр болон хог хаягдлын үйлчилгээний төлбөр нь чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хүснэгт 17. Орон нутгийн төсвийг бүрдүүлж буй байгалийн нөөц ашигласны төлбөрийн болон бусад төлбөр, хураамжийн орлогын хэмжээ, сая төгрөг

| Орлогын төрөл | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|--|-------|-------|-------|-------|-------|
| 1.Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 13.2 | 16.0 | 15.9 | 17.8 | 18.9 |
| 2.Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 3.1 | 4.5 | 1.7 | 2.4 | 3.6 |
| 3.Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж | 0.3 | 0.4 | 0.4 | 0.1 | 0.0 |
| 4.Газрын төлбөр | 65.5 | 59.6 | 53.4 | 62.2 | 66.9 |
| 5.Байгалийн нөөц ашигласны төлбөр | 38.9 | 44.5 | 53.3 | 68.0 | 56.8 |
| - Ойн нөөц ашигласны төлбөр | 3.0 | 3.7 | 4.3 | 10.6 | 4.0 |
| - Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 1.0 | 2.4 | 3.3 | 4.9 | 5.6 |
| -Ус рашааны нөөц ашигласны төлбөр | 34.3 | 35.7 | 40.6 | 47.7 | 46.7 |
| -Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр | 0.5 | 2.8 | 5.1 | 4.7 | 0.5 |
| Нийт дүн (1+2+3+4+5) | 121.1 | 125.0 | 124.6 | 150.6 | 146.2 |

Эх сурвалж. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, ҮСХ, 2014-2017 он

Тухайлбал, 2014-2018 оны хооронд авч үзэхэд жилд дунджаар 53.4-66.9 тэрбум төгрөг, байгалийн нөөц ашигласнаас 38.6-68.0 тэрбум төгрөг, хог хаягдлын менежментийн төлбөрөөс 13.2-18.9 тэрбум төгрөгийн орлого тус тус олжээ.

2013-2015 оны хооронд орон нутгийн төсөвт ус, рашаан усны нөөц, ой мод болон ан амьтан, байгалийн ургамал ашигласны төлбөр нь 120.8 тэрбум төгрөгийн орлого оруулснаас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хуулийн дагуу 63.4 тэрбум төгрөгийг буцаан зарцуулсан байна. Гэсэн хэдий ч хуулийн хэрэгжилт нь ердөө 48.9-49.2%-тай байсаар байна.

2007 оноос эхлэн Үндэсний Статистикийн хороо байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулсан зардлын мэдээллийг цуглуулж эхэлсэн байна.

Статистикийн газраас 6 ангиллаар зарцуулалтын мэдээллийг цуглуулдаг: 1) Байгаль орчны төвлөрсөн арга хэмжээ; 2) Байгаль хамгаалах сан; 3) Тусгай хамгаалалттай газар нутаг; 4) Ойжуулалт, ойн ах ахуйн арга хэмжээ; 5) Газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд; 6) Байгаль орчны алба, байгаль хамгаалагчдын үйл ажиллагаа. Хэдийгээр эдгээр ангилал нь дүн шинжилгээ хийхэд хангалттай биш хэдий ч энэ нь хяналт шинжилгээ явуулах, тайлагнах анхны алхам болж байгаа юм.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилгод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ::

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2019 он гэхэд БОЯБ-д шууд болон шууд бусаар нөлөөлдөг Засгийн газрын тусгай сангуудын журам, хэрэгжилтэд үнэлгээ өгч, дүгнэлт гаргасан байна.
- 2019 он гэхэд Засгийн газрын тусгай сангийн журамд байгаль орчинд ээлтэй байх шалгуур үзүүлэлтийг тусгаж оруулсан байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг Улсын их хурал 2006 онд баталсан. Гэсэн хэдий ч энэ маш чухал хууль нь популист улс төрчдийн нөлөөгөөр хамгийн олон удаа шинэчлэгдэж байгаагаас түүний хэрэгжилт, хамрах хүрээ хамгийн тогтворгүй байна. Байгаль орчны асуудлыг хамарсан сангаас бусад бүх л тусгай сангууд нь тодорхой салбарын эдийн засгийн хөгжилд чиглэсэн зорилготой бөгөөд шалгаруулах үзүүлэлтүүдэд нь байгаль хамгаалах тухай заалт байдаггүй мөн эдгээр сангуудын ихэнх нь менежментийн буруу удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй зэрэг асуудалтай байна..

Биологийн олон янз байдлын санхүүжилт 2008-2018 оны хооронд 207.7 сая ам. доллароор өссөн нь улсын төсвийн 0.35-0.79%, дотоодын нийт бүтээгдэхүүний 0.15-0.25% болж байна. Нийт зардлын 44.4 хувийг улсын төсвөөс, 55.6 хувийг нь олон улсын хандивлагч байгууллагуудаас гаргасан байна.

Байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулийн хүрээнд санд тодорхой орлого хуримтлагдах хэдий ч хуулийн хангалт бүрэн бус байж хуулийн хэрэгжилт 36.9%-тай байна.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/law/details/278>

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, зарцуулалтын мэдээ, БОАЖЯ,
Засгийн газрын зарим тусгай санд хийсэн нийцлийн аудит. (2017). Үндэсний аудитын газар.
Монгол Улсын статистикийн эмхэтгэл, ҮСХ, 2014-2017 он
Оюунчимэг, Т. (2019). Биологийн олон янз байдлын зарцуулалтын шинжилгээний тайлан 2008-
2018. НҮБХХ, БИОФИН төсөл. 15 дахь тал

Зорилго 14. Биологийн олон янз байдлын стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн боломжит гол эх үүсвэрийг тодорхойлж, үр нөлөөтэй ашиглах тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 29. Биологийн олон янз байдлыг хамгаалахад чиглэсэн орлогын эх үүсвэр (тухайлбал: экологийн үйлчилгээний төлбөр, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал)-ийг тодорхойлж нэвтрүүлэх

Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээ

Улсын Их Хурлаас 2012 онд баталсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай” хуулийн 3.1.11 -д “биологийн олон байдлыг дүйцүүлэх хамгаалах гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг” заасан байдаг.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь ихэнх улс орны хувьд сан дурын үндсэн дээр хэрэгждэг бол Монгол улсын хувьд хуулиар зохицуулагддаг юм. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь Монголд харьцангуй шинээр зарчим ойлголт хийгээд хууль батлагдсанаас хойш хэрэгжиж амжаагүй байна. Гэсэн хэдий ч НҮБХХ, Даян Дэлхийн Байгаль орчны Сангийн санхүүжилтээр Монгол орны баруун хэсэгт хэрэгжүүлсэн газрын доройтол болон хөгжлийн хөтөлбөр одоогийн хууль эрх зүйн хүрээг бэхжүүлэхэд нэмэр болох сургамж, сайн туршлагыг бий болгоно гэж үзэж байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын талаарх дүн шинжилгээний тайланд тусгагдсан Монгол улсад хэрэгжүүлж байгаа биологийн олон янз байдлын дүйцүүлэх зарчмыг дараах байдалтай байна.

1. 2014-2017 оны хооронд хийгдсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний 217 тайлангаас үзэхэд 94 төсөл буюу нийт тайлангийн 43.3% нь биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг агуулсан байна. Үлдсэн 123 төсөл буюу нийт тайлангийн 56.6% нь биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг тусгаагүй байна.
2. Дээрх биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг агуулсан 94 төсөлд нарийвчилсан дүн шинжилгээ хийж үзэхэд 30 төсөл (32%) л зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу биологийн олон янз байдлын арга хэмжээг тусгаж боловсруулсан байна. Үлдсэн 64 төсөл нь шаардлага хангах тоо мэдээлэл, төлөвлөгөө байхгүй учир Байгаль орчинд нөлөөлөх байдлын тайлан дээр нь үндэслэн дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг боловсруулах боломжгүй байна.
3. Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний цөөн хэдэн төсөл л сонгож авсан талбай дээрээ суурь судалгааг гүйцэтгэж биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлж болох талбайг нарийвчлан тодорхойлсон байна. Үүний шалтгаан нь оролцогч олон талуудын зөвлөгөөг авах, баталгаажуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох, төлөвлөхөд цаг хугацаа их шаардлагатай байдагтай холбоотой. Хоёр үе шаттай хэрэгждэг энэ

арга нь төслийн эхний жилийн үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийхэд шаардлагатай зардлын дэлгэрэнгүй тооцоог болон төслийн газарзүйн байршил, хамрах хүрээг нарийвчлан тодорхойлсон байхыг шаарддаг.

4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангууд нь орон-зайн дүн шинжилгээ болон биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг тодорхойлох аргачлалыг ихэнхдээ мөрдөөгүй байдаг.

5. Байгаль орчинд нөлөөлөх байдал нь нүүсний тээвэрлэлт болон төмрийн хүдрийн уурхайн төслүүдэд өндөр байна. Гэвч одоо хэрэгжиж байгаа хууль зохицуулгын хүрээнд эдгээрийг хамардаггүй байна.

6. Ашигт малтмалын нэг орд нь хэд хэдэн аж ахуйн нэгжид хуваагдсан байдаг. Тэгвэл иймэрхүү төслүүд дээр хэрэгжүүлэх байгаль хамгааллын төлөвлөгөө болон зохицуулгын арга хэлбэр, хэрхэн хэрэгжүүлэх тухай эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь биологийн олон янз байдлын үндэсний болон Айчигийн зорилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлно уу



Хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилгыг биелүүлэхэд нөлөөлсөн эсэх үнэлгээ:

- Сонгосон арга хэмжээ үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ зарим талаар үр дүнтэй байсан
- Сонгосон арга хэмжээ үр дүнгүй байсан
- Тодорхойгүй

Сонголт хийсэн шалтгаан, боломжтой бол дээр дурдсан үр нөлөөг үнэлэхэд ашигласан арга хэрэгсэл, аргачлалыг зааж өгнө үү

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн дунд хугацааны үр дүн:

- 2018 он гэхэд БОЯБ-ыг дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулсан байна.

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь Монголд харьцангуй шинээр зарчим ойлголт хийгээд хууль батлагдсанаас хойш хэрэгжиж амжаагүй байна. Биологийн олон янз байдлын дүйцүүлэх хамгааллыг зохицуулсан хуулийн заалт, дагалдах дүрэм журмыг сайн туршлага, сургамж дээр үндэслэн боловсронгуй болгох шаардлагатай.

Холбогдох веб хуудас, холбоос болон файлууд

<https://www.legalinfo.mn/law/details/8665?lawid=8665>

Уул уурхайн хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх ба иргэдийн оролцоо. (2018). ТНС-н Монгол дахь Хөтөлбөр, НҮБХХХ


III. Үндэсний зорилт тус бүрийн ахиц, дэвшил

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн 2015-2025 онд хэрэгжүүлэх үйл явцыг (БОЯБҮХ) үл хамааралтай шинжээч, мэргэжилтнүүдийн найман баг 2019 оны 1-р сараас 4-р сарын хооронд нарийн үнэлгээ хийсэн. Шинжээчдийн дүгнэлтийг салбарын яамд, академи, их сургуулиуд болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан 2019 оны 4-р сарын 11-ний өдөр оролцогч талуудын өргөн хүрээнд танилцуулсан. Шинжээчдийн ажлын хэсгийн зөвлөлдөх уулзалт 2019 оны 5-р сарын 14- ний өдөр хийгдэж БОЯБҮХ-ийн зорилт бүр дээр Айчигийн зорилтуудад оруулсан хувь нэмрийг салбар бүрийн шинжээчид дахин нягтлан, хянасан байна. Тайлангаас гаргасан зөвлөмжийг ашиглан шинжээчдийн баг Үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Монгол улсын гүйцэтгэлийг үнэлэх мөн Биологийн олон янз байдлын 2011-2020 он стратеги (Айчигийн зорилтууд) төлөвлөгөөтэй нийцүүлэх онооны үнэлгээг боловсруулсан байна.

Хүснэгт 18. Монгол улсын Айчигийн болон Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөрийн биелэлтийн гүйцэтгэлийн үнэлгээ

| Түвшин | Оноо |
|-------------------------------------|------|
| Сайн үр дүнд хүрсэн | 5 |
| Хэрэгжүүлэлт сайн явцтай байгаа | 4 |
| Хэрэгжүүлэлт дунд зэрэг байгаа | 3 |
| Огт хэрэгжээгүй /хийх ёстой боловч/ | 2 |
| Хэрэгжилт эхлэх болоогүй | 1 |
| Хамааралгүй | 0 |

Засгийн газрын баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах боломжгүй мөн Айчигийн зарим зорилт тухайлбал далай болон шүрэн аралтай холбоотой зорилт нь Монгол оронд шууд хамааралгүй байх тул энэхүү гүйцэтгэлийн үнэлгээний онооны системд “Зорилтоос холдсон” мөн “Тодорхойгүй” гэсэн шалгуурыг дараах байдлаар “Хэрэгжүүлж эхлээгүй”, “Хамааралгүй” гэсэн гэж тодорхойлон сольж хэрэглэх нь зүйтэй.



Зураг 17. Монгол улсын Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилтуудын хэрэгжилтийн түвшин.

(Сайн үр дүнд хүрсэн -5; Хэрэгжүүлэлт сайн явцтай байгаа - 4; Хэрэгжүүлэлт дунд зэрэг байгаа - 3; Огт хэрэгжээгүй /хийх ёстой боловч/ - 2; Хэрэгжилт эхлэх болоогүй - 1; Хамааралгүй - 0)

Тогтвортой хөгжлийн ахиц дэвшлийн үнэлгээний тайлан нь Монгол улс нь тогтвортой хөгжлийн зарчмуудыг сурталчлах, хэрэгжүүлэхээр зогсолтгүй урагшилж байгаа хийгээд боловсролын системийн бүх түвшинд уг зорилтууд аль хэдийн нэвтэрч эхэлснийг онцлон дурдсаны зэрэгцээ зарим зайлгүй сайжруулах зүйлс байгааг ч тэмдэглэсэн байна.

Үүнтэй төстэй, Монгол улс нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний менежментийн бий болгоход маш сайн ахиц гаргасан юм. 2019 оны 5 сарын байдлаар Монгол улс нь өөрийн газар нутгийн 20.01%-ийг хамарсан ТХГН-ийн сүлжээг байгуулж чадсаныг эс тооцвол эдгээр ТХГН-ийн сүлжээнд менежмент болон санхүүгийн цаашдын тогтвортой дэмжлэг шаардлагатай байна.

Өөр нэг чиглэл буюу байгалийн нөөцийг тухайлбал ой модны нөөц, ан, амьтны нөөцийг хамгаалах болон тэдгээрийн тогтвортой менежментийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд, мөн нөхөрлөлд суурилсан байгалийн нөөцийн менежментийг орон нутагт хүргэх сурталчлах чиглэлд Монгол улс амжилттай ахиц гаргасан юм. 2018 оны байдлаар Монгол улс нь агнуурын 171 бүс нутгийг байгуулж тэдгээрийн менежментийг 25 иргэдийн нөхөрлөл, 7 ТББ, 11 хувийн аж ахуйн нэгж хариуцаж ажиллаж байгаагийн зэрэгцээ орон нутгийн иргэдийг чадавхжуулах орчныг бий болгож байна. Ойн салбарт 1281 ойн нөхөрлөл нь 3,345.4 мянган га талбай бүхий ойг хариуцаж байгаагийн зэрэгцээ 90 хувийн аж ахуйн нэгж 681.4 мянган га талбайд үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Засгийн газраас ойн салбарт менежментийн олон талт байдлыг хангахаар хийсэн үйл ажиллагааны үр дүн юм.


Бусад есөн зорилгын хувьд ахиц дэвшил гаргахын тулд, эдгээр зорилго дотроос 9-р зорилго буюу мал сүргийн тоо толгой, бэлчээрийн даацтай уялдуулсан хууль эрх зүйн орчин, эдийн засгийн хөшүүрэг бий болгон бэлчээрийн доройтлыг 70 хүртэл хувиар буулган бэлчээрийн менежмент, бэлчээрийн чанарыг сайжруулах, Зорилго 12 буюу байгаль орчны стратегийн үнэлгээнд үндэслэн хөдөө аж ахуй, эрдэс баялаг, дэд бүтэц, эрчим хүч, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаас хэрэгжүүлж байгаа биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа болон нөлөөлөх магадлалтай үйл ажиллагаанд төсвөөс татаас болон хөнгөлөлт үзүүлэхгүй байх эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг хэрэгжүүлэхэд илүү хүчин чармайлт шаардлагатай байна.

IV. Биологийн олон янз байдлын Айчигийн зорилтод оруулсан үндэсний хувь нэмрийн тодорхойлолт

Биологийн олон янз байдлын Айчигийн зорилтуудын үр дүнд оруулсан хувь нэмэр

2019 оны 1-р сараас 4-р сарын хооронд биологийн олон янз байдлын Айчигийн зорилтуудад Монгол улсын оруулсан хувь нэмрийг нарийвчлан дүгнэх бие даасан шинжээчдийн найман баг ажиллаж дүгнэсэн. Шинжээчдийн ажлын хэсгийн зөвлөлдөх уулзалт 2019 оны 5-р сарын 14- ний өдөр хийгдэж БОЯБҮХ-ийн зорилт бүр дээр Айчигийн зорилтуудад оруулсан хувь нэмрийг салбар бүрийн шинжээчид дахин нягтлан, хянасан байна. Шинжээчдийн баг өмнөх хэсэгт тодорхойлсон (хүснэгт 18) онооны үнэлгээг ашиглан биологийн олон янз байдлын Айчигийн зорилтуудад оруулсан Монгол улсын хувь нэмрийг үнэлсэн юм.

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн 2015-2025 тайланг биологийн олон янз байдлын Айчигийн зорилтуудын дагуу бэлтгэсэн. Эдгээр стратегийн зорилгуудад өөрийн орны онцлог, хэрэгцээг уялдуулах нь даян дэлхийн биологийн олон янз байдлын хамгааллын хүрээнд Монгол улсын үүрэг хариуцлагыг өндөр түвшинд хүргэх юм. Хараат бус зөвлөх болон салбарын шинжээчдийн оролцоотой хийсэн үнэлгээнээс үзэхэд Айчигийн зорилтод нийлүүлэн нийт 20 зорилтоос 18 зорилтыг нь тусгасан үндэсний Биологийн олон янз байдлын хөтөлбөрийн зорилго нь даян дэлхийн биологийн болон янз байдлын хамгааллын зорилгуудыг маш сайн хангаж байгааг харуулсан байна. Хоёр зорилт буюу загас агнуур болон шүрэн аралтай холбогдсон зорилт 6, зорилт 10 -н хувьд Монгол улсын үзүүлэх нөлөө сул юм.



Зураг 18. Айчигийн зорилтыг биелүүлэхэд оруулж буй Монгол улсын хувь нэмэр.

(Сайн үр дүнд хүрсэн -5; Хэрэгжүүлэлт сайн явцтай байгаа - 4; Хэрэгжүүлэлт дунд зэрэг байгаа - 3; Огт хэрэгжээгүй /хийх ёстой боловч/ - 2; Хэрэгжилт эхлэх болоогүй - 1; Хамааралгүй - 0)


Талуудын III чуулганы үеэр өөрийгөө тодорхойлсон Монголын үнэлгээнээс үзэхэд Айчигийн 1-р зорилтыг биелүүлэхэд их нэмэр оруулсан зүйл бол Тогтвортой хөгжлийн боловсролд гаргасан ахиц дэвшлийн үр дүнд иргэдийн биологийн олон янз байдлын талаарх үнэ цэнэ, үр шимийн тухай мэдлэг их өссөн байдал нөлөөлсөн гэж үнэлсэн байна. Мөн Айчигийн 5-р зорилт дээр Монгол улс нь өндөр

оноо авсан нь ой амьдрах орчныг хамгаалахад хүчтэй анхаарсан нь нөлөөлсөн гэж өөрийн үнэлгээндээ үзсэн байна.

Айчигийн 11-р зорилтод өндөр оноо авсан нь Риогийн уулзалтаас хойш өөрийн газар нутгийн 30%-ийг ТХГН-ын сүлжээн байгуулах гэсэн зорилго байсан бөгөөд одоогоор нийт газар нутгийн 20.1% буюу Польш улсын нийт нутаг дэвсгэртэй тэнцэх хэмжээний газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулаад байгаа явдал юм. Байгаль хамгааллын үзэл баримтлал нь “хэрэглэгч нь өөрөө үнэлэх” зарчимд шилжин орсны дүнд Монгол улс нь орон нутгийн иргэд өөрсдийн амьдарч байгаа газар нутгийн байгалийн баялаг, амьтан, ургамлын нөөцийн тогтвортой менежмент болон хамгааллын үйл ажиллагаанд оролцох болсон нь ахиц дэвшил гаргахад хүргэсэн байна. Энэ нь мөн Айчигийн 12, 16 болон 19-р зорилтууд дээр оруулсан Монгол улсын хувь нэмэр өндрөөр үнэлэгдэх нөхцөлийг бүрдүүлжээ.

Айчигийн шалгуур үзүүлэлт түвшинд Монгол улсын гүйцэтгэлийг нарийвчилсан үнэлгээнээс үзэхэд Айчигийн 225 үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 129-д нь Монгол улс өөрийн хувь нэмрийг оруулсан хийгээд эдгээр үнэлгээний шалгуурын 48 нь ерөнхий, 81 нь тусгай шалгуур байна.

Зорилт бүрийн онооны нарийвчилсан мэдээг тайлангийн хавсралтад оруулсан Нэгдсэн хүснэгтээс үзэж болно (Хавсралт 1).




Зураг 19. Айчигийн зорилтуудад оруулж байгаа Монгол улсын хувь нэмрийг тодорхойлсон үнэлгээний түвшин.

2018 оны үнэлгээгээр Айчигийн зорилтод оруулсан Монгол улсын хувь нэмэр тогтвортой байгаа бөгөөд зорилтын шалгуур үзүүлэлтүүдийн 6 хувь нь “улсын хэмжээнд зорилтыг давуулсан”, 37% буюу 48 шалгуур үзүүлэлтийн үнэлгээ нь “зорилтод хүрэхэд ойрхон”, 45% нь “зорилтод хүрэхэд ахиц дэвшил байгаа хэдий ч хангалтгүй үзүүлэлттэй” гэсэн дүнг харуулж байна.

Тогтвортой хөгжлийн зорилгууд оруулж байгаа хувь нэмэр

Монгол улсын биологийн олон янз байдлын хөтөлбөр нь Айчигийн зорилтуудад хувь нэмэр оруулахын зэрэгцээ ТХЗ-ын 25 зорилтод шууд нэмэр оруулж байна. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн 14 зорилгын 10 нь буюу 4-7, 10-14 дүгээр зорилго нь ТХЗ-ын 1 зорилготой “газрыг шударга, тэгш хүртэх” гэсэн утгаар; 2-р зорилготой “хөдөө аж ахуйн салбарт олгож тогтворгүй татаас, тогтвортой хөдөө аж ахуй болон ургамал, амьтны генетик нөөцийн менежмент”; 5-р зорилготой “байгаль хамгааллын менежментэд орон нутгийн иргэдийн эрх мэдлийг хангах”; 6-р зорилготой “усны чанарын, голын сав газрын нэгдсэн менежмент, усны эхийг хамгаалах”; 12-р зорилготой “ЭҮТ-ийн зарчмыг сурталчлах, үйлдвэрлэлийн салбарт сөрөг нөлөөтэй татаас болон санхүүгийн зөвлөгөө үзүүлэх”; 15-р зорилготой “ТХГН-ийн сүлжээ, тогтвортой байгалийн нөөцийн менежмент, генетик нөөц, газрын доройтол болон устаж болзошгүй зүйлийн хамгаалал” агуулгаар тус тус хувь нэмэр оруулж байна.



Зураг 20. Айчигийн зорилтод оруулж байгаа Монгол улсын хувь нэмэр

Гүйцэтгэлийн тайлангаас (зураг 20) ТХЗ-д биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрөөс оруулж буй оролцоог үнэлэн үзэхэд ТХЗ-ын 6 болон 15-р зорилгод “зорилтод хүрэх гэж байгаа”, ТХЗ-ын 2, 5 болон 12-р зорилгын хүрээнд “зорилтод хүрэхэд ахиц дэвшил байгаа хэдий ч хангалтгүй үзүүлэлттэй”, ТХЗ-ын 1-р зорилгын хүрээнд “ач холбогдолтой өөрчлөлт байгүй” гэсэн дүнгүүд нь өнгөрсөн арван жилүүдэд Монгол улс нь тогтвортой бэлчээрийн менежментийн хууль эрх зүйн орчныг бий болгож чадахгүй байгаатай холбоотой юм.

V. Биологийн олон янз байдлын төлөв байдал



Үндэсний бахархалт цэцэг- Бэрцэцэг (*Scabiosa comosa* Fisch.)

Зургийг С. Гомбобаатар, Mongolica Publishing

Ургамлын аймаг

Гуурст дээд ургамал

Гуурст ургамлын анхны бүртгэл бичгийг 1955 онд, “Монгол орны гуурст дээд ургамал таних бичиг”-ийг 1982 онд Оросын нэрт эрдэмтэн В. И. Грубов гаргав. Н.Өлзийхутаг өөрийн “Монгол орны ургамлын аймгийн тойм (1989)” бүтээлдээ Монголын ургамлын аймагт 122 овгийн 625 төрөлд хамаарах 2,443 зүйл, Оросын эрдэмтэн И. А. Губанов (1996) “Гадаад Монголын ургамлын аймгийн конспект” номондоо Монголын ургамлын аймагт 128 овгийн 662 төрлийн 2,823 зүйл, дэд зүйл гуурст ургамлыг бүртгэж байжээ. ШУА-ийн Ботаникийн хүрээлэн болон МУИС-ийн Биологийн тэнхимийн ургамал судлаачдын хамтран 2014 онд хэвлэгдсэн туурвисан “Монгол орны гуурст ургамлын бүртгэл” бүтээлд Монгол орны ургамлын аймагт 3 дэд аймгийн (ойм, нүцгэн үртэн, далд үртэн) 5 хүрээнд багтах 14 ангийн 39 багийн 112 овгийн 683 төрөлд хамаарах 3,127 зүйл, дэд зүйл (131 дэд зүйл, 32 вариаци) гуурст дээд ургамлыг жагсаажээ (Urgamal et al., 2014). Тэдгээрийн нэршил, ангилал, тархалт, хамгааллын статус зэрэг холбогдох мэдээллүүдийг мөн багтаасан байна. Дээрх бүтээл нь И. А. Губановын 1996 онд хэвлэгдсэн бүртгэл бичгээс хойшх 20 шахам жилийн хугацаанд Монголын ургамлын аймагт шинээр 1 овог, 21 төрөл, 412 зүйл, дэд зүйлийг нэмсэн төдийгүй 62 төрөл, 480 орчим зүйлд нэршлийн өөрчлөлт оруулж, 1,250 орчим зүйлийн тархалтын 2,700 орчим шинэ нутаг цэгийг нэмж илрүүлснээрээ онцлог байв.

Монгол орны гуурст дээд ургамлын аймаг нь 2013 онд 5 хүрээний 14 ангид багтах 39 багийн 112 овогт хамаарах 676 төрлийн нийт 3,014 зүйлээс бүрдэж байлаа (Urgamal et al., 2013). Харин 2018 оны байдлаар Монголын гуурст ургамлын аймагт 3 дэд аймгийн (ойм, нүцгэн үртэн, далд үртэн) 5 хүрээнд багтах 39 багийн 684 төрлийн 3,163 дэд зүйл, зүйл бүртгэгджээ. Монгол орны ургамлын

аймагт бүртгэгдсэн 3,163 дэд зүйл, зүйл ургамалд Банзрагч (1965), Грубов (1982), Өлзийхутаг (1984, 2003), Лигaa нар (2008, 2009), Манибазар (2010) болон Uргamal & Оуунтсетег (2017) нарын бүтээлд тулгуурлан монгол нэрийг оноосон ба Монгол орны гуурст ургамлын ангилал зүйн салбар зөвлөлийн шийдвэрээр 702 зүйлд монгол нэрийг шинээр оноов (Ургамал нар, 2019).



Жамъянмядаг

Зургийг С.Гомбобаатар, Mongolica Publishing

Гуурст ургамлын дэд зүйл, зүйлийн тоо өмнөх жилүүдийн судалгааны дүнтэй харьцуулахад нэмэгджээ (хүснэгт 1). Овгийн нэр цөөрөх шалтгаан нь гуурст ургамлын ангилал зүйд гарсан өөрчлөлттэй холбоотой.

Хүснэгт 1. Монгол орны гуурст дээд ургамлын зүйлийн бүрдлийн өөрчлөлт

| Ангиллын нэгж | 1955 | 1982 | 1989 | 1996 | 2005 | 2009 | 2010 | 2013 | 2018 |
|---------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Овог | 97 | 103 | 122 | 128 | 130 | 134 | 132 | 112 | 108 |
| Төрөл | 555 | 599 | 625 | 662 | 666 | ~ 680 | ~ 680 | 676 | 684 |
| Зүйл | 1,897 | 2,239 | 2,443 | 2,823 | 2,930 | 2,946 | 2,950 | 3,014 | 3,163 |

Монгол орны ургамлын аймгийн томоохон овгуудад Asteraceae (451 зүйл), Fabaceae (349 зүйл), Роасеае (257 зүйл), Rosaceae (156 зүйл), Brassicaceae (149 зүйл), харин олон зүйлтэй томоохон төрлүүдэд: *Astragalus* (128 зүйл), *Artemisia* (105 зүйл), *Oxytropis* (97 зүйл), *Carex* (92 зүйл), *Potentilla* (69 зүйл) зэрэг багтдаг (хүснэгт 2) (Uргamal *et al.*, 2013).

Хүснэгт 2. Монгол орны ургамлын аймаг дахь томоохон овгууд

| Овгийн нэр | Төрлийн тоо | Зүйлийн тоо | Эзлэх хувь |
|-----------------|-------------|-------------|------------|
| Asteraceae | 84 | 451 | 14.95 |
| Fabaceae | 27 | 349 | 11.57 |
| Poaceae | 62 | 257 | 8.52 |
| Rosaceae | 28 | 156 | 5.17 |
| Brassicaceae | 58 | 149 | 4.94 |
| Cyperaceae | 13 | 132 | 4.37 |
| Ranunculaceae | 21 | 131 | 4.34 |
| Lamiaceae | 24 | 101 | 3.34 |
| Amaranthaceae | 28 | 99 | 3.28 |
| Caryophyllaceae | 21 | 91 | 3.01 |

Монгол орны ургамлын аймаг сүүлийн гучаад жилд зүйлийн бүрэлдэхүүн болон тоо ихээхэн өөрчлөгджээ. Томоохон бүлгүүдийн зүйлийн бүрдлийн хувьд 232 зүйл дээд мөөг, 1,366 зүйл замаг, 81 зүйл хаг, 176 зүйл хөвд, 684 зүйл гуурст ургамал шинээр нэмэгдсэн. Ингэснээр манай орны ургамлын аймгийн зүйлийн бүрдэл сүүлийн гучин жилд 2,815 зүйлээр буюу 40 орчим хувиар өсч, өнөөгийн байдлаар нийт 7,315 зүйлд хүрээд байна (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016).

Монгол орны гуурст ургамлын хувьд унаган ургамал 120 зүйл, завсрын унаган 532 зүйл (Urgamal & Oyuntsetseg, 2017), нэн ховор 133 зүйл, ховор 356 зүйл, харь ургамал 51 зүйл (Gombobaatar et al., 2018), хөл газрын 438 зүйл, усны ургамал 186 зүйл, үлдэц (үлдвэр) ургамал 70 зүйл (Urgamal, 2018), зэрлэгшиж буй таримал 47 зүйл (Urgamal et al., 2014), Улаан номд (2013) багтсан 135 зүйл, Улаан дансанд (2011) орсон 148 зүйл, CITES-ийн хавсралтад бүртгэлтэй 8 зүйл тус тус ургана (Urgamal, 2018).

Монгол улсын төдийгүй дэлхийн ургамал судлалын шинжлэх ухаанд онцгой ач холбогдолтой, олон жилийн судалгааны үр дүнг нэгтгэсэн “Монголын ургамлын аймаг” 20 дэвтр бүхий цуврал бүтээлийг туурвих ажил эхэлж, одоогоор ээлжит 10, 17-р дэвтрүүд хэвлэгдэн гарлаа. Эдгээр дэвтэрт 3 овгийн 49 төрөлд багтах нийт 204 зүйл ургамлын адилцах нэрсийн тойм, төрөл ба зүйл таних түлхүүр, зүйл тус бүрийн дэлгэрэнгүй ойллого, ургах хугацаа ба орчин, Монгол орны болон ерөнхий тархалт, тэмдэглэл зэрэг холбогдох бусад мэдээллүүд багтжээ (Urgamal, 2018; Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016).

Биологийн олон янз байдлын конвенцын дэргэд Биологийн олон янз байдлын ангилал зүйн санаачилгын хүрээнд Гуурст ургамлын ангилал зүйн салбар зөвлөлийг С. Гомбобаатарын санаачилгаар С. Баярхүү, н. Ариунтуяа, М. Ургамал, Б. Оюунцэцэг болон бусад судлаачдын дэмжлэгтэйгээр 2018 онд байгуулсан нь ургамлын ангилал зүй, зүйлийн бүрдлийн өөрчлөлт зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой байх юм.

БОАЖЯ-ны захиалга болон бага хэмжээний санхүүгийн дэмжлэг, Лондоны амьтан судлалын нийгэмлэгийн санхүүжилтээр “Монгол орны ургамлын Улаан данс” төслийг С. Гомбобаатарын удирдлагаар МУИС, ШУА, МУБИС-ийн судлаачид –М. Ургамал, Б. Оюунцэцэг, Р. Тунгалаг, Гүндэгмаа олон бусад судлаачид хамтран “Ургамлын улаан дансны үндэсний 2-р уулзалт”-ыг 2018 онд зохион байгуулав. Энэхүү уулзалтаар Монгол орны гуурст ургамлын 489 зүйлийг Олон улсын Байгаль хамгаалах холбооны улаан дансны шалгуураар үнэлсэн ба Устаж байгаа 31, Устаж болзошгүй 109, Эмзэг 164, Ховордож болзошгүй 78, Анхааралд өртөхгүй 42, Мэдээлэл дутмаг 60, Үнэлэх боломжгүй 5 зүйл байгааг тогтоов. Монгол орны гуурст ургамлын нийт 635 зүйлийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуураар 2011 болон 2019 онд үнэлсэн бөгөөд нийт үнэлгээ хийсэн зүйлийн 47 нь Устаж байгаа, 148 нь Устаж болзошгүй, 217 нь Эмзэг, 100 нь Ховордож болзошгүй, 52 нь Анхааралд өртөхгүй, 64 нь Мэдээлэл дутмаг, 7 зүйл нь Үнэлэх боломжгүй зэрэглэлтэй. Улаан дансны шалгуураар 2011, 2019 онд үнэлсэн гуурст ургамлын 195 зүйл нь Устаж байгаа болон Устаж болзошгүй зэрэглэлтэй тул Монгол улсын Засгийн газрын нэн ховор, 217 зүйл ургамал Эмзэг зэрэглэлтэй учир Монгол улсын ховор ургамлын жагсаалтанд оруулахаар төлөвлөж байна. Монгол улсын Засгийн газраар батлагдах нэн ховор, ховор ургамлын жагсаалтад оруулахаар 412 зүйл гуурст ургамлын материалыг бэлтгэж байна (Нямбаяр нар, 2012; Ургамал нар, 2019).

БОАЖЯ захиалж, Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй МУИС-ийн хэрэгжүүлсэн “Монгол орны амьтан, ургамлын аймаг, бичил биетний ангилал зүйн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд 471 зүйл эмийн ургамлын таних шинж, ургах орчин, тархалт, анагаах ухааны хэрэглээ, түүхий эд болон бэлтгэх хугацаа, ургамлын статус, ховордлын зэрэглэлийг багтаасан мэдээллийн сан бэлтгэж, ховор болон нэн ховор гуурст ургамлын 221 зүйлийн таних шинж, амьдрах ба ургах орчин, экологийн статус, амьдралын хэлбэр, тархац, хамгаалал, ховордлын шалтгаан, гэрэл болон тархацын зураг зэрэг мэдээ, баримтыг гео-оффлайн-онлайн мэдээллийн санг <http://mongolspecies.mn/> хаяг дээр үүсгээд байна (Гомбобаатар нар, 2018).

Ургамлын зүйлүүд Монгол орны ургамал-газарзүйн 16 тойрогт харилцан адилгүй тархдаг ба 1982-1996 оны дүнгээр хамгийн олон зүйлтэйд Хангайн уулын тойрог, 2014 оны судалгаагаар Монгол Алтайн уулын хээрийн тойрог, харин хамгийн цөөн зүйлтэйд Алашаа говийн тойрог орж

байна. Сүүлийн 30-аад жилд хамгийн олон зүйл нэмэгдсэн (704 зүйл) тойрог нь Монгол Алтай, хамгийн цөөн зүйл нэмэгдсэн нь (106 зүйл) Алашаа говийн тойрог байна (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

БОАЖЯ-тай хамтран Лондоны амьтан судлалын нийгэмлэг, Дэлхийн байгаль хамгаалах сан, Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн хэрэгжүүлсэн Зэрлэг амьтан, ургамлын худалдааны талаарх төсөлт ажлуудын хүрээнд САЙТИС-ын конвенцод бүртгэлтэй амьтан, ургамлын худалдааны тухай мэдээ, баримт дээр тулгуурлан хууль бусаар худалдаж буй зарим гуурст ургамлын тухай товч мэдээ, баримтыг багтаасан бүтээлүүд хэвлэгдэн гарав (Гомбобаатар, Мягмарсүрэн, 2018; Чимэддорж нар, 2018; Wingard et al., 2018).

Ойн зарим дагалт баялгийн атлас (тархац, нөөц, үнэлгээ) бүтээл (2011)-д нэн хэрэгцээт Сибирь хуш, 9 зүйл жимс жимсгэнэ, 7 зүйл мөөгийг тус тус сонгон тархац, нөөцийн судалгааг гүйцэтгэж, био-экологийн үнэлгээг хийсэн байна. Энэ бүтээл нь ойн дагалт баялгийг ашиглах үйл ажиллагааг зохицуулах болон бэлтгэлийн нөөцийг тогтоох лавлагаа болохын зэрэгцээ энэ чиглэлээр төр, захиргааны байгууллагын мэдээллийн үндэс болж байгаа зэргээрээ ач холбогдолтой.

ШУА-ийн гуурст дээд ургамлын цуглуулгын мэдээллийн санд 12 овгийн (Ariaceae, Crassulaceae, Ericaceae, Paeoniaceae, Papaveraceae, Ranunculaceae, Fumariaceae, Grossulariaceae, Saxifragaceae, Grossulariaceae, Pyrolaceae, Vacciniaceae) 80 орчим төрөлд хамаарах 120 орчим зүйлийн 2,600 гаруй хуудас хатаадас байна. Мөн гуурст дээд ургамлын цуглуулгын 5 хүрээний нийт 119 овогт хамаарах 600 орчим төрлийн 2,500 гаруй зүйлийн 63,464 хуудас цуглуулга дижитал хэлбэрт оров. Өдгөө Ботаникийн хүрээлэнгийн Гербарийн сан 124,000 орчим хувь цуглуулгатай (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016).

Хөвд

Хөвд судлаачид “Флора мхов Монголии”, “Флор Северной Монголии” зэрэг томоохон бүтээлүүдийг 2010 онд ОХУ-д хэвлүүлээ. Эдгээр бүтээлд Умард Монголын ургамлын аймгийн талаар болон Монгол орны хөвдийн 41 овгийн 164 төрөлд багтах 456 зүйл, 4 дэд зүйлийн хөвдийг бүртгэж дэлхийд сүүлийн үед мөрдөгдөж байгаа хөвдийн ангиллын шинэ системд оруулсан. Мөн энэ бүтээлд хөвдийн бие бүтцийн болон 444 зүйл хөвдийн тархцын зураг, төрөл, зүйл таних бичиг, тайлбарын хамт бичсэн.

Хөвд судлаачид 2018 оны байдлаар Монгол оронд элгэн болон навчит хөвдийн 2 ангид хамаарах 24 багийн 74 овог, 210 төрлийн 570 зүйл (10 дэд зүйл) бүртгэжээ. Монгол орны хөвд хэлбэртний хүрээний зүйлийн бүрдлийн жагсаалтыг гаргахдаа Игнатов & Игнатова (2003, 2004), Coffinet & Buck (2004), Ignatov et al. (2006), Цэгмэд (2010), Потёмкин & Софронова (2009) зэрэг бүтээлийг шүүж үзсэн. Хөвдийн ангилал зүйн системийн дараалал, зүйлийн жагсаалтыг Buck &

Coffinet (2000), латин буюу шинжлэх ухааны нэрийг Ignatov et al. (2006), Цэгмэд (2010) нарын бүтээлийг харгалзан боловсруулсан. Хөвдийн монгол нэрийг оноохдоо Цэгмэд (2001, 2010) бүтээлийг ашигласан ба зарим төрөл, зүйлийн нэрийг латин болон орос хэлнээс орчуулан оноолоо (Энхжаргал, 2019).

Монгол орны хөвдийн зүйлийн бүрдэл 1990-1995 онд 36 зүйл, 1996-2000 онд 10 зүйл, 2001-2005 онд 58 зүйл, 2006-2010 онд 11 зүйл, 2011-2016 онд 61 зүйлээр нэмэгдэн бүртгэгдээд байна.



Rhabdoweisia crispata Э. Энхжаргал, ШУА

ШУА-ийн хөвдийн цуглуулгын сан нь 18,700 орчим цуглуулгатай бөгөөд эдгээр нь сургалт, судалгаа, хамгааллын чиглэлийн олон үйл ажиллагаанд ашиглагдаж байна.

БОАЖЯ-ны захиалгат Лондоны амьтан судлалын нийгэмлэгийн бүрэн санхүүжилтээр “Монгол орны ургамлын Улаан данс-2” төслийн хүрээнд хөвдийн 15 зүйлийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуураар үнэлсэн бөгөөд 1 зүйл нь Устаж байгаа, 10 зүйл нь Устаж болзошгүй, 4 зүйл нь Эмзэг зэрэглэлтэй байна (Энхжаргал, 2019).

Улаан дансны шалгуураар 2019 онд үнэлсэн хөвдийн 11 зүйл нь Устаж байгаа болон Устаж болзошгүй зэрэглэлтэй учир Монгол улсын Засгийн газрын нэн ховор ургамлын жагсаалт, 4 зүйл Эмзэг зэрэглэлтэй тул Монгол улсын ховор ургамлын жагсаалтад оруулахаар төлөвлөж байна.

БОАЖЯ захиалж, Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй МУИС-ийн хэрэгжүүлсэн “Монгол орны амьтан, ургамлын аймаг, бичил биетний ангилал зүйн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд 454 зүйлийн тархалт, 267 зүйлийн ургах орчин, 41 зүйлийн таних шинж тэмдэг, 17 зүйлийн гэрэл зураг, 31 зүйлийн тархалтын зураг бүхий мэдээллийн сан үүсгэв. Эдгээр зүйлийн таних шинж, амьдрах ба ургах орчин, экологийн статус, амьдралын хэлбэр, тархац, хамгаалал, ховордлын шалтгаан, гэрэл болон тархцын зураг зэрэг мэдээллийг

багтаасан гео-оффлайн-онлайн мэдээллийн санг <http://mongolpecies.mn/> хаяг дээр үүсгээд байна (Гомбобаатар нар, 2018)

Хөвсгөлийн баруун хойд хэсэгт орших Дархадын хотгорын нутаг орчимд сүүлийн жилүүдэд хөвдийн судалгааг дагнан хийсний дүнд тус нутагт нийт 50 овог, 130 төрлийн 286 зүйлийн хөвд бүртгэгдээд байна. Үүнээс Хөвсгөлийн районд 49 зүйл, *Gollania*, *Bryobrittonia* гэсэн 2 төрөл, *Encalypta procera*, *Bryobrittonia longipes*, *Didymodon leskoides*, *Racomitrium panschii*, *Gollania turgens* зэрэг 5 зүйлийн хөвд Монгол орны хөвдийн аймагт шинээр тэмдэглэсэн (Tsegmed et al., 2007; Игнатов нар, 2009).

Шарын гол дахь ойн суурин судалгааны бүс нутагт нийт 32 овог 75 төрөл 117 зүйлийн хөвд байгааг тогтоов. Цаашид хөвдийн ангилал зүйн судалгааг үргэлжлүүлэн хийх нь тухайн бүс нутгийн хөвдийн зүйлийн бүрдлийн бүрэн жагсаалт гарах төдийгүй, Монгол орны хөвдийн сан хөмрөг арвижих, тархалтын цэг нэмэгдэх, түүнчлэн шинэ зүйл хөвд илрэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Замаг

Монгол орны замгийн судалгааны үр дүнд 10 хүрээний 2,200 гаруй зүйл, дэд зүйл замаг бүртгэгдээд байна. Үүний дийлэнх хувийг буюу 1,400 гаруй зүйл нь цахиурт замаг, 233 зүйл, дэд зүйл хөх ногоон замаг, 26 зүйл эвглен замаг, 43 зүйл хрофит замаг, 20 зүйл миоз, 236 зүйл ногоон замаг, 225 зүйл хара замаг, криптофит замаг 6 зүйл мөн 3 зүйлийн улаан замаг тус тус байна. Cavalier Smith (2014)- ийн шинэ системээр цианофит замгууд нь жинхэнэ бактерийн аймагт Kingdom Eubacteria-д, Rhodophyte, Chlorophyte, Charophyte нь Kingdom Plantae бүлэгт, Euglenophyta нь Protozoa-Euglenozoa бүлэгт хамрагдаж буй хэдий ч бактерийн болон ургамлын аймагт багтах эдгээр бүлгийг замаг гэдэг ойлголтод хамруулан үзлээ. Дээрх шинэ системээр Kingdom Chromista бүлэгт Bacillariophyta, Cryptophyta, Miozoa, Ochrophyta хүрээнүүд багтаж байгаа хэдий ч бусад хүрээний замгийн бүртгэлийн хувьд Bukhchuluun & Baigal-Amar (2018) – ыг эш болгов (Бөхчулуун, 2019).



Ногоон замаг Ц. Бөхчулуун, ШУА

Монгол орны замгийн зүйлийн бүрдэл 1990-1995 онд 10 зүйл, 1996- 2000 онд 114 зүйл, 2001-2005 онд 409 зүйл, 2006-2010 онд 66 зүйл, 2011-2016 онд 363 зүйлээр шинэчлэгдэв.

БОАЖЯ-ны захиалгатай Лондоны амьтан судлалын нийгэмлэгийн санхүүжилтээр 2018 онд С. Гомбобаатарын хамтран хэрэгжүүлсэн “Монгол орны ургамлын Улаан данс-2” төслийн хүрээнд замгийн 35 зүйлийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуураар үнэлсэн бөгөөд 5 зүйл нь Устаж байгаа, 12 зүйл нь Устаж болзошгүй, 18 зүйл нь Эмзэг зэрэглэлтэй байна (Бөхчулуун, 2019).

Улаан дансны шалгуураар 2019 онд үнэлсэн хагийн 17 зүйл нь Устаж байгаа болон Устаж болзошгүй зэрэглэлтэй учир Монгол улсын Засгийн газрын нэн ховор ургамлын жагсаалт, 18 зүйл нь Эмзэг зэрэглэлтэй тул Монгол улсын ховор ургамлын жагсаалтад оруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

БОАЖЯ захиалж, Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй МУИС-ийн хэрэгжүүлсэн “Монгол орны амьтан, ургамлын аймаг, бичил биетний ангилал зүйн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд 2,216 зүйлийн тархалт, 10 зүйлийн таних шинж тэмдэг болон ургах орчин, гэрэл зурагтай мэдээллийн сан үүсгэсэн (Гомбобаатар нар, 2018).

Мөөг

Монгол оронд 2016 оны байдлаар 3 баг, 22 овогт хамаарах 73 төрлийн 217 зүйл малгайт мөөг (Хэрлэнчимэг, 2013), Баруун Хэнтийд Дүлийтэн овогт хамаарах 6 төрлийн 14 зүйл дүлий мөөг (Бүрэнбаатар, 2013) ургадаг болохыг бичжээ (Байгаль орчны төлөв байдал, 2015-2016).

Монгол улс өөрийн орны мөөгний аймгийн овог, төрөл, зүйлийн бүртгэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, олон улсад мөрдөгдөж буй Олон улсын Мөөг судлалын нийгэмлэгээс баталсан

дээд мөөгний жагсаалтын зарчмыг харгалзан гаргах нь зайлшгүй болсон. Өнөөдөр Монгол орны мөөгний аймагт 31 баг, 88 овог, 237 төрөлд хамаарах 631 зүйл бүртгэгджээ. Энэхүү жагсаалтад багтсан Монгол орны дээд мөөгний 6 баг, 21 овог, 111 төрөл, 340 зүйлд монгол нэрийг шинээр оноов (Хэрлэнчимэг, 2019).



Lepista caespitosa Н. Хэрлэнчимэг, ШУА

Ерөнхий олон сорилын хүрээлэнгийн мөөгний сан 3,000 орчим дугтуй цуглуулгатай бөгөөд эдгээр цуглуулга нийтдээ 535 орчим зүйлд хамаарна. Дээр дурдсан бүх мэдээллийг нэгтгэж, “Монголын мөөгийн аймаг ба цуглуулгын мэдээллийн сан”-г 2008-2017 онд бүрдүүлээд байна.

Хэнтийн тойрогт 5 зүйл, Хангайн тойрогт 13 зүйл, Монгол Дагуурын тойрогт 13 зүйл, Дорнод Монголын тойрогт 3 зүйл, Их нууруудын хотгор, Монгол Алтай, Ховдын тойрогт 1998-2012 онд тус бүр 1 зүйл шинээр бүртгэгдлээ.

Монгол орны дээд мөөгний 26 зүйл нь хээрт ургадаг хөрсний сапрофит, эсвэл копрофиль мөөг (*Melanoleuca*, *Agaricus*, *Conocybe*, *Agrocyste*, *Macrolepiota* төрлийн ихэнх зүйл), 212 зүйл нь ойд ургадаг бөгөөд тэдгээрээс 152 зүйл нь дээд ургамалтай хамтран амьдарч микориз бүрэлдүүлэгч мөөг (*Hygrophorus*, *Russula*, *Lactarius*, *Tricholoma*, *Boletus*, *Suillus*, *Gomphidius* төрлийн зарим зүйл), 41 зүйл нь хөвхний сапрофит мөөг (*Marasmius*, *Collybia*, *Mycena*, *Clitocybe*, *Leucopaxillus*, *Lepiota* төрлийн ихэнх зүйл), 19 зүйл нь лигнофиль мөөг (*Coprinus*, *Stropharia* төрлийн зарим зүйл) байгаа юм. Ойн ихэнх мөөг модлог ургамалтай микориз үүсгэн тэдгээрийн өсөлт хөгжлийг дэмждэг тул ойн экосистемд мөөгний гүйцэтгэх үүрэг асар их юм.

Boletinus asiaticus Sing., *Leccinum aurantiacum* (Bull.) S.F. Gray, *Agaricus tabularis* Pers., *Chlorophyllum agaricoides* (Czern.) Vellinga, *Lepistacae spitosa* (Bres.) Sing., *Leucopaxillus giganteus* (Sibthorp: Fr.) Sing., *Tricholoma mongolicum* Imai, *Fomitopsis officinalis* (Vill.) Bond. et Sing.,

Ganoderma lucidum (Leyss ex Fr.) Karst., *Inonotus obliquus* (Pers.; Fr.) Pilat, *Calvatia gigantea* (Batsch) Lloyd, *Lycoperdon molle* Pers. зүйлийг Монгол улсын Улаан ном (2013)-д бүртгэж тархац нутгийг хэсэгчлэн хамгаалалтад авлаа.

Монгол орны дээд мөөг 1990-1995 онд 8 зүйл, 1996- 2000 онд 23 зүйл, 2001-2005 онд 53 зүйл, 2006-2010 онд 46 зүйл, 2011-2016 онд 102 зүйлээр тус бүр шинээр нэмэгджээ.

Хүнс, эмчилгээний ач холбогдолтой ховор мөөгний цэвэр өсгөвөр гаргах, мицел үйлдвэрлэх, тэдгээрийг үржүүлэх судалгаа эрчимтэй хийгдэж, хясаан мөөгний (*Pleurotus ostreatus*) polymysel- 107 омгийн тариалалтын технологийн үндсэн параметруудийг тодорхойлон (Гантулга, 2010), хясаан мөөг (Мөнхзаяа, 2010), хусны онгол (*Inonotus obliquus*) (Хэрлэн, 2010) мөөгний хөхний хорт хавдарт үзүүлэх нөлөөг судалж, хавдрын эсийн ургалтыг дарангуйлдаг болохыг тогтоосон юм. Иймд Монгол оронд ургадаг Хусны онгол, Хясаан мөөгнөөс хорт хавдрын эсрэг бэлдмэл гарган авах, эмчилгээнд хэрэглэх боломжийг цаашид нарийвчлан судлах шаардлагатай. Дэлхийн дулаарал, хуурайшилт болон хүний үйл ажиллагааны улмаас байгалийн ховор хүнсний болон эмийн мөөгний нөөц өөрчлөгдөх зүй тогтлыг илрүүлж, түүнийг зохистой ашиглах, хамгаалахад төр засгийн бодлогыг хандуулах, шийдвэр гаргахад тулгуур баримт бүрдүүлэх зорилгоор мөөгний тархац, нөөцийн нарийвчилсан судалгааг гүйцэтгэж, өргөн тархалттай 7 зүйлийн биологийн ба бэлтгэлийн нөөцийг тодорхойлов (Хэрлэнчимэг нар, 2011).


БОАЖЯ-ны захиалгаар Лондоны амьтан судлалын нийгэмлэг, БОАЖЯ-ны санхүүжилтээр 2018 онд хэрэгжүүлсэн “Монгол орны ургамлын Улаан данс-2” төслийн хүрээнд мөөгийн 21 зүйлийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуураар үнэлсэн бөгөөд 2 зүйл нь Устаж байгаа, 5 зүйл нь Устаж болзошгүй, 14 зүйл нь Эмзэг зэрэглэлтэй байна (Хэрлэнчимэг, 2019).

Улаан дансны шалгуураар 2019 онд үнэлсэн мөөгний 7 зүйл нь Устаж байгаа болон Устаж болзошгүй зэрэглэлтэй учир Монгол улсын Засгийн газрын нэн ховор ургамлын жагсаалт, 14 зүйл нь Эмзэг зэрэглэлтэй тул Монгол улсын ховор ургамлын жагсаалтад орох боломжтой хэмээн үзэж, мэдээ, баримтыг нэгтгэж байна.

БОАЖЯ захиалж, Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй МУИС-ийн хэрэгжүүлсэн “Монгол орны амьтан, ургамлын аймаг, бичил биетний ангилал зүйн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд мөөгний 631 зүйлийн экологи, амьдралын хэлбэр болон тархалт, 446 зүйлийн ургах орчин, 142 зүйлийн таних шинж тэмдэг, субстрат, 99 зүйлийн гэрэл зураг, 96 зүйлийн тархалтын зураг бүхий мэдээллийн сан үүсгэв. Эдгээр зүйлийн таних шинж, ургах орчин, ховордлын шалтгаан, тархацын зураг зэрэг мэдээллийг багтаасан гео-оффлайн-онлайн мэдээллийн санг <http://mongolspecies.mn/> хаяг дээр үүсгээд байна (Гомбобаатар нар, 2018).

Хаг

Дэлхийд 26,000 гаруй зүйл хаг байдаг. Монгол оронд 3 хүрээ, 8 анги, 26 багийн 68 овогт хамаарах 208 төрөлд багтах 1,067 зүйл хаг бүртгэгдсэн (Энхтуяа, 2019). Олон улсын Ботаникийн конгрессын 2011 онд Мельбурнд болсон ээлжит хуралдаанаас баталсан Ботаникийн олон улсын нэр томъёоны кодексыг “Замаг, мөөг ба ургамлын олон улсын нэр томъёоны кодекс” (ICN, McNeill нар, 2012)–ийг мөрдөхийг уриалсныг харгалзав. Иймд хагийн ангиллын нэгжийн нэршлийг Santesson *et al.* (2004), Hawsworth *et al.* (2008) болон Esslenger (2009) нарын боловсруулсан суурь зарчимд тулгуурласан ба зарим нэг өөрчлөлтийг Urbanavichus (2010), Roux (2012) нарын оруулсанчлан CABI Bioscience Database (<http://www.speciesfungorum.org>)–ыг дагаж бичсэн (Энхтуяа, 2019). Зүйлийн бүрэлдэхүүний энэ дүнг 2010 оны судалгааны дүнтэй харьцуулахад 20 гаруй зүйлийн хаг шинээр бүртгэгджээ. Үүнд: *Arthonia mediella*, *Basidia circumspect*, *Blastenia furfuracea*, *Calicium viride*, *Caloplaca chlorine*, *Cyphelium karelicum*, *Lecanora allophana*, *L.boligera*, *L.cadubriae*, *L.subintricata*, *Lepraria ecorticata*, *L.rigidula*, *Leptogium subtile*, *Ochrolechias zatalalmsis*, *O.turneri*, *Placynthiella dasaea*, *Rinodina freyi*, *R.septentrionalis*, *R.trevisanii* зэрэг болно.



Rhizocarpon riparium Эх сурвалж: С. Жавхлан, ШУА

Монгол орны хагийн аймаг Голарктик, Газрын Дундад Тэнгисийн болон Зүүн Азийн шинжийг хадгалсан онцлогтой. Тэр дотроо Голарктикийн шинжийг илэрхийлэгч Physciaceae, Cladoniaceae, Peltigeraceae, Parmeliaceae зэрэг овог нь манай орны умард хэсгээр өргөн тархацтай. Эртний Газрын Дундад Тэнгисийн хагийн аймгийн шинжийг илэрхийлсэн Lecanoraceae, Ascarosporaceae, Collemataceae, Verrucariaceae, Teloschitaceae зэрэг овгууд баруун бүс нутгаар түгээмэл тархдаг. Монгол орны хагийн зүйлийн бүрдэл 1990-1995 онд 13 зүйл, 1996- 2000 онд 1 зүйл, 2001-2005 онд 13 зүйл, 2006-2010 онд 43 зүйл, 2011-2016 онд 11 зүйл тус бүр шинээр нэмэгдэж бүртгэгдсэн байна. Манай оронд одоогийн байдлаар унаган хаг 4 зүйл, завсрын унаган 58 зүйл

бүртгэгдсэн. *Aspicilia hedinii* (H. Magn.) Oksner, *Cladonia mongolica* Ach., *Peltula zabolotnoji* (Elenkin) N.S. Golubk. унаган хагийг 2013 онд шинээр; *Aspicilia changaica* (Klem.) N.S. Golubk., *Lobaria retigera* (Bory.) Trevis, *Rhizoplaca baranowii* (Poelt) Goluk., *Squamarina pamirica* N.S. Golubk., *Aspicilia esculenta* (Pall.) Flagey., *Cetraria alverensis* (Wahlenb.) Vain., *Nephromopsis komarovii* (Elenkin.) J. C. Wei, *Cetraria potaninii* Oksner., *Cetraria steppae* (Savicz) Cogt, *Cladonia kanewskii* Oksner, *Caloplaca lenae* Sochting et Figueras, *Tonina gobica* Golubk хагийг Монгол Улсын улаан ном (2013)-д бүртгэж тархац нутгийг нь хэсэгчлэн хамгаалалтад авлаа.

ШУА-ийн хагийн цуглуулгын санд 15,000 орчим ширхэг цуглуулга зохих стандартын дагуу хадгалагдаж, сургалт, судалгаанд ашиглагдаж байна.

БОАЖЯ-ны захиалгаар Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, БОАЖЯ-ны санхүүжилтээр 2018 онд хэрэгжүүлсэн “Монгол орны ургамлын Улаан данс-2” төслийн хүрээнд хагийн 32 зүйлийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуураар үнэлэв. Үүнээс 4 зүйл нь Устаж байгаа, 14 зүйл нь Устаж болзошгүй, 14 зүйл нь Эмзэг зэрэглэлтэй байна (Энхтуяа, Жавхлан, 2019).

Улаан дансны шалгуураар 2019 онд үнэлсэн хагийн 18 зүйл нь Устаж байгаа болон Устаж болзошгүй зэрэглэлтэй учир Монгол улсын Засгийн газрын нэн ховор ургамлын жагсаалт, 14 зүйл нь Эмзэг зэрэглэлтэй тул Монгол улсын ховор ургамлын жагсаалтанд орох боломжтой тул эдгээр зүйлийн талаарх мэдээ, баримтыг нэгтгэж байна.

БОАЖЯ захиалж, Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй “Монгол орны амьтан, ургамлын аймаг, бичил биетний ангилал зүйн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд хагийн 1,061 зүйлийн тархалт, 370 зүйлийн ургах орчин, 17 зүйлийн таних шинж тэмдэг, 202 зүйлийн гэрэл зураг бүхий мэдээллийн сан үүсгэв. Эдгээр зүйлийн таних шинж, ургах орчин, экологийн статус, амьдралын хэлбэр, тархац, хамгаалал, ховордлын шалтгаан, гэрэл болон тархацын зураг зэрэг мэдээллийг багтаасан гео-оффлайн-онлайн мэдээллийн санг <http://mongol-species.mn/> хаяг дээр үүсгэв (Гомбобаатар нар, 2018).

Ургамал хамгаалах, зохистой ашиглах

БОАЖЯ нь ургамлын сан хөмрөгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг бодлогоор дэмжин дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газарт өргөн барихаар бэлтгэж байна (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

Байгалиас үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэхийг шат дараатай хориглох байгалийн ургамлыг тарималжуулах ажлыг бодлогоор дэмжин, БОАЖ-ын Сайдын 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/43 дугаар тушаалаар байгалийн ховор ургамлын жагсаалтад орсон дэрэвгэр жиргэрүү ургамлыг байгалиас түүж бэлтгэхийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 5 жилийн хугацаатай хориглосон. Эрэлт, хэрэгцээ өндөртэй, байгальд нөөцгүй тарималжуулах шаардлагатай ургамлын зүйлийн жагсаалт гарган, гарын авлага, зөвлөмж хэвлүүлэв. Ашиглалтад өртөмтгий дэрэвгэр жиргэрүү, монгол хунчир, алтан гагнуур, их шүүдэргэнэ зэрэг ургамлын үрийн жишиг талбайг Хэнтий аймгийн Хэрлэнбаян улаан багийн нутагт 2018 онд байгуулах ажлыг зохион байгуулсан. Ашиглалтад өртөмтгий их шүүдэргэнэ, час улаан долоогоно, эмийн бамбай, эмийн сөд, юлдэн тарваган шийр, долгиотсон гишүүнэ, дэрэвгэр жиргэрүү, нангиад зээргэнэ, хэвтээ дэгд, ээрэм шарилж (царван) зэрэг 10 зүйл ургамлыг түүж бэлтгэх, хатаах, савлах, тээвэрлэх, хадгалах стандартыг боловсруулан батлууллаа (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр”-ийн тодорхой стратеги заалтуудын хүрээнд Ботаникийн цэцэрлэгт Монгол орны байгалийн ургамлын генофондыг *ex situ* хэлбэрээр хамгаалах, үржүүлэх эрдэм шинжилгээ-интродукцийн судалгаа хийж **59** овог, **141** төрөлд хамаарах **305** зүйл мод, сөөг, өвслөг ургамлын амьд цуглуулгыг бүрдүүлсэн. Үүнээс нэн ховор, ховор 70 зүйл, гадаадын 10 гаруй сорт ургамал *ex situ* орчинд тарималжуулан цуглуулгын бүртгэл-мэдээллийн нэгдсэн санд чухал үүрэгтэй эрдэм шинжилгээний материал хуримтлагдаад байна (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Устах аюулд орсон болон аж ахуйн гоц ашигт ургамлыг сэргээн нутагшуулах, тарьж ургуулах ажлыг хөрөнгө, санхүү, татварын бодлогоор дэмжинэ” гэсэн зорилтын хүрээнд байгалийн ургамлыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагаар тарималжуулах ажлыг бодлогоор дэмжин ажиллаж, байгалийн ашигт ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар тарималжуулах ажлууд амжилттай хийгдэж байна (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын зорилт 1-д “Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална”, мөн Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.2.9.3-т “Нэн ховор, ховор амьтан, ургамлын амьдрах орчныг тэтгэх, тархац нутгийг хамгаалах арга хэмжээ авах” гэж тус тус заасны дагуу байгалиас үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэхийг шат дараалан багасгах

зорилт тавин ажиллаж байна. Монгол улсаас 2017-2018 онд гадаадад гарсан ургамлын 98%-ийг хушны самар эзэлж байна (хүснэгт 3).

Хүснэгт 3. 2017, 2018 онд үйлдвэрлэлийн зориулалтаар экспортолсон ургамлын хэмжээ (тн)

| ДД | Монгол нэр | 2017 | 2018 |
|----|------------------------------|----------|---------|
| 1 | Орос махирс | 0.52 | |
| 2 | Цагаан мөөг | 0.5 | 0.6 |
| 3 | Унаган туруу мөөг | 0.55 | |
| 4 | Чонон хармаг | 2 | |
| 5 | Нарийн навчит цахилдаг | 2 | |
| 6 | Сибирь хуш модны самрын идээ | 13,286.2 | 2,782.4 |

Бичил биетэн

Бичил биетний төрөл, зүйл, омгийн нэгдсэн мэдээлэл одоо хир гараагүй. БОАЖЯ захиалж, Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй “Монгол орны амьтан, ургамлын аймаг, бичил биетний ангилал зүйн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд 243 төрлийн бичил биетний жагсаалтыг нэгтгэн гаргасан төдийгүй 30 төрлийн биологийн идэвх хэрэглээ, тэжээлт орчин, өсгөвөрлөх хэм, дээжийн эх үүсвэр зэрэг мэдээллийг бүрдүүлэн, байгаль орчны нэгдсэн мэдээллийн санд оруулаад байна (Энх-Амгалан, 2019; Гомбобаатар нар, 2018).

НҮБХХ, БОАЖЯ хамтран “Нагояагийн протоколыг хэрэгжүүлэх хүний нөөц, эрх зүйн орчин, байгууллагын чадавхыг бэхжүүлэх” төслийг 2017 оны 9-р сараас 3 жилийн хугацаанд хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тус төслийн үндсэн бүрэлдэхүүн хэсгийн 2-т зааснаар генетик нөөцийн ашиглагчид ба эзэмшигчдийн хооронд итгэлцлийг бий болгох, генетик нөөцийг илрүүлэх, цуглуулах, боловсруулах био-хайгуулын судалгааг хамтран санаачлах нөхцөлийг бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна. Тус бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд генетик нөөц, уламжлалт мэдлэгийн үнэ цэнийг өсгөхийн тулд судалгааны чадавхыг бэхжүүлэх, энэ чиглэлийн салбарт ажиллагсдын (засгийн газрын албан хаагчид, судлаачид, орон нутгийнхан болон холбогдох үйлдвэр, хувийн хэвшлийнхэн) генетик нөөц, уламжлалт мэдлэгтэй холбогдох хууль тогтоомжийг ойлгуулах зэрэг зорилт тавьсан нь Монгол Улсын нутаг дэвсгэр дэх малын үүлдэр, омог, унаган болон таримал ургамлын сорт, тэдгээрийн зэрлэг овог, төрөл, зүйлийг бүртгэлжүүлэх, төлөв байдлын үнэлгээ хийх, хомсдолоос хамгаалах зорилтыг хангах үндсэн суурь бүрдсэн гэж үзэж байна.

Төслийн баримт бичигт өгүүлснээр энэ хууль нь “Монгол улсын нутаг дэвсгэр дэх амьтан, ургамал, ялангуяа бичил биетний гаралтай үнэ цэнэ бүхий генетик нөөц болон тэдгээртэй холбоотой уламжлалт мэдлэгийг судлах, бүртгэх, хадгалж хамгаалах, ашиглах, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, тэдгээрийн өмчлөлтэй холбоотой харилцааг зохицуулах” зорилготой.

Дээрх төслийн хүрээнд байгуулсан бичил биетний мэдээллийн санд одоогийн байдлаар 53 омгийн бичил биетнийг бүртгэсэн. Генетик нөөц бүхий дээрх бичил биетнийг ялгаж авсан эх үүсвэр нь монгол орны хөрс, ургамлын үндэс, уламжлалт аргаар бэлтгэсэн исэг цагаан идээ, төрөл бүрийн исгэлтийн хөрөнгө /талхны хөрөнгө/, монгол оронд ургадаг байгалийн жимс жимсгэнэ, өвчин үүсгэгчийг тээгч шавж, мэрэгч амьтад, төл өсвөр малын ходоод, гэдэсний агуулагдахуун, нефть зэрэг болно.

Амьтны аймаг

Шавж

БОАЖЯ захиалж, Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй С. Гомбобаатарын удирдаж, “Монгол орны амьтан, ургамлын аймаг, бичил биетний ангилал зүйн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд Trematoda - Хос соруулт шимэгч хорхой -15, Cestoda -Туузан хорхой -94, Rotifera - Хүрд хорхой-92, Acanthocephala - Хатгуурт толгойт хорхой- 9, Mollusca - Зөөлөн биетэн -34, Nematelminthes - Дугариг хорхой 115, Arthropoda - Үет хөлтөн: Arachnida - Аалз хэлбэртэн- 551, Hexanauplia - Олон хөлтөн – 32, Branchiopoda - Заламгай хөлтөн -50, Шавьжийн ангийн Ephemeroptera – Өдөрч-103, Odonata – Соно- 59, Orthoptera - Шулуун далавчтан- 159, Plecoptera – Хаварч – 54, Coleoptera - Хатуу далавчтан-3,166, Anoplura – 9, Hymenoptera - Сарьсан далавчтан-143, Hymenoptera: Formicidae – Шоргоолж- 71, Trichoptera – Хоовгон- 198, Siphonaptera- 166, Lepidoptera - Хайрсан далавчтан- 578, Diptera: Culicidae – Шумуул- 34, Diptera: Tipulidae – Тэмээлзгэнэ-166 зүйл, нийт 5,898 зүйлийн жагсаалтыг гаргасан (Гомбобаатар ба Шар, 2019). Мэдээллийн санг зүйл бүрээр үүсгэх зорилгоор зүйлийн жагсаалтыг мэдээллийн санд байршуулаад байна.

Зарим үе хөлтөн амьтдыг тодорхой экосистемүүдийн түвшинд судалж, амьдрах орчны хэлбэрүүдээс хамаарсан шавжийн төрөл, зүйлийн талаарх суурь мэдээллийг бүрдүүлэх чиглэлд судалгааг хандуулж ирлээ. Гэсэн хэдий ч судлаачид нугаламгүй амьтдын цөөн бүлгийг хамруулсан зарим судалгааг гүйцэтгэсэн ч бүлгийг хамруулсан ангилал зүй, биологи, экологийн цогц судалгааг хийгээгүй хэвээр.

Монгол орны ойн сангийн тодорхой цэгүүдэд, тухайлбал, Хэнтийн нурууны баруун хойд хэсгийн ой, Хөвсгөл нуурын баруун эргийн өндөр уулсын шилмүүст ой, Монгол-Алтай болон Хангайн нурууны шинэсэн ойд 2008 оноос хойш гүйцэтгэсэн судалгааны дүнд 20 орчим овгийн 300 гаруй зүйл бүгэг эрвээхэй тэмдэглэсэн (Muehlenberg *et al.*, 2011; Энхбаяр, 2013). Хэнтийн нурууны баруун хойд хэсгийн ойн шавжийн судалгаагаар тодорхой овог, төрлийн хүрээнд нарийвчилсан судалгааг гүйцэтгэж, *Carabus canaliculatus* Ad., *Carabus arcensis* Herb., *Pterostichus interruptus* Dej., *Pterostichus dauricus* Geb., *Pterostichus (Euryperis) eximius* Mor., *Cicindela gracilis* Pal., *Carabus (Carabus) billbergi* Man., *Carabus (Morphocarabus) hummeli* F-W., зэрэг жийгээ цохыг (Carabidae, Coleoptera), мөн *Xylotrechus rusticus* Lin., *Monochamus urussovi* F-W., *Saperda scalaris* Lin., *Xylotrechus ibex* Geb. болон *Xylotrechus hircus* Geb. Зэрэг зүйлийн эвэрт цох (Cerambycidae, Coleoptera) тархаж буйг тогтоосон (Гантигмаа нар, 2012; Буянжаргал, 2010). Хэнтийн нурууны зүүн хэсгийн шилмүүст ойн шавжийн төрөл зүйлийн судалгааны явцад Онон голын сав газарт нийт 13 баг, 109 овог, 265 төрөлд хамрагдах 362 зүйлийг бүртгэснээс 13 зүйл нь тухайн бүс нутгийн амьтны аймагт шинээр тэмдэглэгдсэн (Пунцагдулам, 2011). Онон голын сав газарт бүртгэгдсэн шавжаас

Монгол улсын Улаан номонд орсон дамнуурга цэнхэр соно (*Aeshna juncea mongolica*), аполлон (*Parnassius apollo*), махаон дэвүүр (*Papilio machaon*), бэр цэцэгч шумбуур (*Hemaris tityus*) зэрэг хайрсан далавчтан, мөн спорадикус үхэр хэдгэнэ (*Bombus sporadicus*) гэх хальсан далавчтан тохиолджээ. Энэ бүс нутагт модлог болон бутлаг ургамлын эд эрхтнээр хооллодог 7 баг, 34 овог, 97 төрлийн 151 зүйл шавж тохиолдож байгааг илрүүлсэн (Пунцагдулам, 2011). Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Биндэр, Дадал сумын ойн санд сибирь хүр, өрөөсгөл хүр эрвээхэйн тархалтын голомт байгааг тогтоов (Бадамжаргал, 2010). Түүнчлэн Булган аймгийн Орхон сумын Хүрэнбулагийн даваа, Сүүдрийн хавтгай, Хутаг-Өндөр сумын Цагаан даваа, Сайхан модны ам, Баянагт сумын Агтын нуруунд сибирийн хүр эрвээхэй (*Dendrolimus sibiricus*), Хөвсгөлийн Чандмань- Өндөр, Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдын нутгийн ойн сан, Эг-Үүр голын хөндийн навчит ойд өрөөсгөл хүр эрвээхэй (*Lymantria dispar*), Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт яacobсоны төөлүүрч эрвээхэй (*Erannis jacobsoni*) олширч байгааг илрүүлэн улсын хэмжээгээр нийт 22,980 га талбайд тэмцлийн ажлыг зохион байгуулж байна. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт Цагаан Мааньтын голын эх орчмын шинэсэн ойд олширсон эгэл бийрэн сүүлт эрвээхэйн (*Orgyia antiqua* Lin.) голомтод тэмцлийн ажлыг зохион байгуулж популяцийн тоо толгойн хэт өсөлтийг хянасан (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016).



Соно С. Гомбобаатар, Mongolica Publishing

Монгол орны говь цөлийн бүсэд тархах шавж, нугаламгүй амьтдын төрөл зүйлийн судалгааны явцад *Bryodema gebleri* F-W., *Bryodema mongolicum* Zub., *Calliptamus barbarus* Costa., *Compsorhipis bryodemoides* Bei-Bienko., *Compsorhipis davidiana* Saus., *Gryllus desertus* Pall., *Leptopternis gracilis* Evers., *Mongolotmethis kozlovi* Bey-Bienko., *Zichya baranovi* Bei-Bienko., *Zichya sp.* зүйлүүд түгээмэл тохиолдож байв. Эдгээрээс *Compsorhipis bryodemoides* Bei-Bienko., *Mongolotmethis kozlovi* Bey-

Bienko., *Zichya baranovi* Bei-Bienko. зэрэг зүйл Монголын эндемик бөгөөд сүүлийн жилүүдийн судалгаагаар ажиглагдаагүй байсан загийн бөгтрөгт царцааг (*Dericorys annulata roseipennis* Redtenbacher) эндээс илрүүлэв. Говь цөлийн бүсийн уст цэгүүдэд амьдрах шавжийн бүлгэмдлээс хоовгоны (Trichoptera) багийн төлөөлөгчдийн хувьд сонирхолтой мэдээлэл хуримтлуулсан. Энэ бүсэд орших 40 гаруй булаг шандад хийсэн судалгааны үр дүнд *Apatania mongolica* Martynov, *Limnephilus primoryensis* Nimmo гэх хоёр зүйл хоовгон зэргэлдээ орших хоёр булагт буюу тархалтын хувьд маш хязгаарлагдмал орчинд буйг тогтоожээ. *Apatania mongolica* Martynov зүйлийн хоовгоно, *Limnephilus primoryensis* Nimmo зүйлийг шинжлэх ухаанд 1995 онд шинээр бичиглэв. Цаашид эдгээр зүйлийн биологи, экологийн судалгаанд анхаарал хандуулж, хамгааллын төлөвлөгөөг боловсруулах нь зүйтэй.

Тус орны аалз хэлбэртэн (Arachnida), хавч хэлбэртэн (Branchiopoda) өргөст хорхой (Clitellata), хүрд хорхой (Eurotatoria), хэвэл хөлтөн (Gastropoda), хануур хорхой (Hirudinea) зэрэг 9 ангид хамрагдах 30 гаруй зүйлийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт Ханбогд уул, Галбын говь, Ундайн голын сайр, мөн аймгийн Гурвантэс сумын нутагт Нарийн Сухайтын хөндий, Нэмэгтийн нуруунд гүйцэтгэсэн судалгааны явцад тэмдэглэжээ (Гантигмаа нар, 2012; Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016).



Аалз С. Гомбобаатар, Mongolica Publishing

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт 2011-2012 онд гүйцэтгэсэн судалгааны явцад ажиглалт хийсэн нийт 20 булгаас 7 булаг нь хатаж, ширгэжээ. Энэхүү 7 булагт *Paracorixa* spp., *Callicorixa* sp. болон *Sigara* sp., *Sigara lateralis* (Corixidae, Hemiptera) гэх сэлэгч бясаны зүйлүүд, *Gerris sahlbergi* (Gerridae, Hemiptera) зүйлийн тэшигч бясаа, *Ishnura elegans* (Coenagrionidae, Odonata) зүйл соны авгалдай, усны цохоос үрчлээт цохын овгийн нэг зүйл (*Helophorus* sp., Helophoridae), мөн *Hygrotus (Coelambus) flaviventris* зүйлийн сэлэгч цох тэмдэглэгдэж байв. Хавч хэлбэртний төлөөлөгчдөөс *Branchinecta ferox* M. Milne-Edwards,

Branchinecta minuta Smirnov, *Branchinecta orientalis* Sars, *Ceriodaphnia pulchella* Sars, *Daphnia carinata* King болон *Moina brachiata* Jur. тохиолдов (Гантигмаа нар, 2012; Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016).

Ойн зарим хөнөөлт шавжийн тархалт. Монгол оронд 700 гаруй зүйлийн хөнөөлт шавж тэмдэглэгдсэнээс 7 баг, 56 овог, 168 төрөл, 300 гаруй зүйлийн шавж жил бүр ойд хөнөөл учруулдаг. Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох судалгааг 2015-2016 онд 4617.4 мян.га талбайд гүйцэтгэж, 901.1 мян.га талбайд хөнөөлийн голомт байгааг тогтоолоо. Сүүлийн жилүүдэд санхүүжилтийн хүндрэлээс шалтгаалж тэмцлийн ажлыг зайлшгүй явуулах шаардлагатай талбайг бүрэн хамруулж чадахгүй байгаагаас хөнөөлийн голомтыг бүрэн хяналтад авч чадахгүй хэвээр. Ойн хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажилд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, химийн бодисын хэрэглээнээс үе шаттайгаар татгалзаж, байгаль орчинд халгүй, биологийн арга, технологид бүрэн шилжүүлэх шаардлагатай (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016).

ШАВЖ БОЛОН БУСАД ҮЕ ХӨЛТНИЙ АШИГЛАЛТ: Монгол орны ахуй, амьдралын онцлогоос хамааран шавж зэрэг нугаламгүй амьтдын төрөл зүйлийг ашиглах явдал харьцангуй ховор боловч тэдгээрийн экосистемд гүйцэтгэх үүрэг, үйлчилгээний үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг (зөгийн бал, эмийн ургамал, амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн) өргөн хэрэглэдэг. Тухайлбал, хар цохын (*Blaps sp.*, Tenebrionidae) өөрийгөө хамгаалах зорилгоор ялгаруулдаг шүүрэл болон биеийн гадаргуугийн биополипид нэгдлийг уламжлалт эмчилгээнд ашиглаж байна (Gunbilig *et al.*, 2009; Алдармаа нар, 2010). Түүнчлэн хүн, малын амьсгалын замын багтраа өвчний үед *Bryodema*, *Angaracris*, *Caliptamus* төрлийн царцааны (Acrididae, Orthoptera) хандыг бэлтгэн эмчилгээнд ашигладаг. Өнөөдрийн байдлаар дээрх зүйл шавжийн популяцийн чиг хандлага, экосистемд гүйцэтгэх үүргийн талаар нарийвчилсан судалгаа хийгдээгүй тул уг төрөл зүйлд учирч буй дарамт болон тухайн зүйлийн зүгээс хүн ардын сайн сайханд үзүүлж буй ач холбогдлыг үнэлэх бололцоогүй. Иймд бид экосистемд болон хүнд чухал үүрэг гүйцэтгэдэг эдгээр амьтдыг тодорхойлон бүртгэл хийж, цаашид нарийвчилсан судалгааг зохион байгуулах чиглэлд гол анхаарлаа хандуулах нь зүйтэй.

ШАВЖ БОЛОН БУСАД ҮЕ ХӨЛТНИЙ ХАМГААЛАЛ: Монгол улсын БОАЖЯ санхүүжүүлэн 2012 онд тус улсын хэмжээнд ховор болон ховордож буй шавж болон бусад нугаламгүй амьтдын тархалтын судалгааг зохион байгуулж, Монгол орны нэн ховор болон Улаан номонд “Ховор” гэсэн статустай зүйлүүдийн мэдээллийг шинэчлэн эмхэтгэв (Монгол улсын Улаан ном, 2013). Монгол орны шавжийн олон янз байдал, популяцийн төлөв байдлын талаарх мэдээ дутмаг байгаа ч өнгөрсөн 4 жилд тодорхой бүс нутгийн зарим экосистем дэх шавж болон бусад нугаламгүй амьтдын бүлгэмдлийн судалгааг гүйцэтгэж, биологийн олон янз байдлын суурь мэдээллийг бүрдүүлэв.

Монгол оронд тэмдэглэгдэж байсан ч сүүлийн жилүүдэд илрэхгүй байгаа зүйлүүдийг хянах, одоогоор бүртгэлтэй зүйлийн төлөв байдлыг тодорхойлох нь зүйтэй. Тухайлбал, шулуун далавчтны багаас Симилисийн царцаа (*Eclipophleps similis* Mishch.), цайвар царцаа (*Eclipophleps lucida* Mishch), говийн үрчлээт царцаа (*Rhinotmethis beybienkoi* Chog.), таршаа (*Bryodema nigripennis* Mishch), андриа төрлийн царцаа (*Andrea gorochovi* Mishch), тарчигнуур царцаа (*Psophus stridulus* Lin.), цөлийн царцааны нэг зүйл (*Beybienkia lithophila* Gorochov & Mishchenko), мишенкогийн ногоон царцаа (*Mongolotettix mistshenkoi* Chog.) гэх зүйл сүүлийн 30 орчим жилийн хугацаанд дахин тэмдэглэгдээгүй.

Загас

ЗАГАСНЫ ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ: Монгол оронд загасны 8 баг, 1 дэд багийн 15 овгийн, 47 төрлийн 78 зүйл, дэд зүйлийн бүртгэлийг гаргав. Монгол орны загасны зүйлийн жагсаалтыг Berg (1911, 1912), Dashdorj et al. (1964, 1970), Nelson (1976), Rass et al. (1983), Sokolov et al. (1983), Baasanjav et al. (2001), Bogutskaya et al. (2004), Mendsaikhan et al. (2017), Prokofiev (2002, 2003, 2006, 2007) зэрэг бүтээлийг шүүв. Загасны ангилал зүйн нэгжүүдийн дараалал, зүйлийн ангилал, латин буюу шинжлэх ухааны болон англи нэрийг William Eschmeyer & Ronald Fricke (1980), <http://Eschmeyer's Catalog of Fishes>, Froese & Pauly (2003), Kottelat (2006) нарын боловсруулсан бүтээл, Reshetnikov et al. (eds) (2003)-ын Оросын цэнгэг усны загасны атлас номын зүйлийн жагсаалтыг дагаж бичлээ. Өөр хоорондоо ялгаатай дэлхийн загасны ангилал зүйн жагсаалтанд Америк болон Европын эрдэмтэд Евразийн зарим загасны төрөл, зүйлийн нэрийг оруулсан бөгөөд сүүлийн жилүүдэд Оросын эрдэмтэд болон Швейцарийн загас судлаач, эрдэмтэн М. Kottelat-ын нөр их хөдөлмөрийн ачаар Евразийн загасны зүйлийн нэр томьёонд ихээхэн өөрчлөлт орж байна. Монгол нэрийг оноохдоо Dashdorj et al. (1964, 1970), Baasanjav et al. (2001), Mendsaikhan et al. (2017) нарын бүтээлийг ашигласан ба зарим монгол нэрийг Монгол орны биологийн олон янз байдлын ангилал зүйн шинжээчдийн Загасны салбар зөвлөлийн шийдвэрээр өөрчлөв (Мэндсайхан, 2019).



Сугас С. Гомбобаатар, Mongolica Publishing

Төв Азийн гадагш урсгалгүй ай савд 12 зүйл, Хойд мөсөн далайн ай савд 32 зүйл, Номхон далайн ай савд 44 зүйл загас бий. Тус орны загасны зүйлийн бүрэлдэхүүний 56 орчим хувийг мөргийн (Cyprinidae) овгийн загас эзэлнэ.

МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ: Уг үнэлгээгээр Устаж байгаа гэсэн зэрэглэлд 1 зүйл (Шивэр хилэм), Устаж болзошгүй зэрэглэлд 6 зүйл (говийн эрээлж, зүүнгарын сугас, цагаан загас, Амарын хадран, Хөвсгөлийн хадран, тул), Эмзэг зэрэглэлд 4 зүйл (алтайн сугас, давжаа сугас, монгол хадран, зэвэг), Ховордож болзошгүй зэрэглэлд 3 зүйл (хатгуурт халбаган загас, бух сугас, шивэр хадран) тус тус оржээ. Харин Мэдээлэл дутмаг зэрэглэлд 22 зүйл багтсан. Нийт 12 зүйл загасыг Анхааралд өртөхөөргүй хэмээн үнэлжээ. Монгол улсын Улаан номонд хорхой загас, шивэр хилэм, амарын хилэм, тул, омуль, шаргал үхэрдээ, зантгар загас зэрэг амьтад оржээ (Осоок *et al.*, 2006).

БОАЖЯ захиалж, Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтэй “Монгол орны амьтан, ургамлын аймаг, бичил биетний ангилал зүйн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд 79 зүйл загасны таних шинж, амьдрах орчин, экологийн статус, амьдралын хэлбэр, тархац, хамгаалал, ховордлын шалтгаан, гэрэл болон тархацын зураг зэрэг мэдээллийг багтаасан гео-оффлайн-онлайн мэдээллийн санг <http://mongolspecies.mn/> хаяг дээр үүсгээд байна (Гомбобаатар нар, 2018).

НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ, АШИГЛАЛТ: Монгол орны загасны зүйлийн бүрэлдэхүүний 80 гаруй хувь нь ямар нэг хэмжээнд ховордсон, эсвэл судалгааны мэдээ баримт дутмаг, цөөрөх магадлал өндөр түвшинд байгаа нь анхаарал татаж байна.

Монгол орны загасны тархац, биологи, экологи, тоо толгой динамик, нөөц, олборлолт, ашиглалтын талаар нарийвчилсан судалгаа хийж, цаашдын чиг хандлагын талаарх мониторингийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нь энэ бүлэг амьтдын олон янз байдлыг хамгаалахад чухал ач холбогдолтой.

Сүүлийн 60 жилд Сэлэнгэ мөрний сав газарт уур амьсгалын өөрчлөлт, ахуйн зориулалтаар зөвшөөрөлгүй загас нутагшуулах үйл ажиллагааны нөлөөгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт харь зүйл загасны тархац тэлсээр байна. Амьдрах орчин нь доройтолд орсноор цэнгэг, хүйтэн усны шинж чанарыг тодорхойлогч зүйл- зэвэг (*Brachymystax lenok*), шивэр хадран (*Thymallus arcticus*)-гийн тоо толгой буурч, орчны өөрчлөлтийг тэсвэрлэх чадвартай мөргийн овгийн мөнгөлөг хэлтэг (*Carrasius gibelio*), улаан нүдэн (*Rutilus rutilus*), шивэр сугас (*Leuciscus leuciscus*) зэрэг зүйлийн бодгалийн тоо нэмэгдэж байна. Усны түвшний бууралт, ус хурах талбай дахь ойн нөөцийн багасалт, ойн түймэр, хууль бус агнуур, амьдрах орчны доройтол болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр загасны нөөц 4-16 дахин багассан байна (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016).

Эрчимтэй агнуурын нөлөөгөөр Буйр нуурт махан идэшт Амарын цурхай (*Esox reichertii*) загасны эзлэх хувь буурч, спорт агнуурын гол төлөөлөгч тул (*Hucho taimen*), зэвэг (*Brachymystax lenok*) загас үзэгдэхээ больж, харин холимог болон ёроолын амьтдаар хооллогч булуу цагаан (*Cyprinus rubrofuscus*), мөнгөлөг хэлтэг (*Carassius gibelio*), амарын сугас (*Leuciscus waleckii*) давамгайлж, агнуурын загасны бүрэлдэхүүнд өөрчлөлт орсоор байна.

Сэлэнгэ мөрөн, Орхон голын загасны бүлгэмдлийг бүхэлд нь, эсвэл зарим зүйл нэн ховор загасыг хамгаалах, хянах, нөхөн үржүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай болжээ. Дархадын хотгорын Дээд цагаан нуурт 1980–аад оны үед агнуурын загасны 70%-ийг цагаан загас эзэлж байсан бол сүүлийн жилүүдэд нэн ховордож, харин шивэр сугас, шивэр хадран, тул загас агнуурт (33-52%) илүү өртөж байна. Загас агнуур эрчимжсэн тул том биетэй, махчин загасны эзлэх хувь буурч, агнуурын ашигтай загасны нөөц хомсдож, харин холимог болон ёроолын амьтдаар хооллогч загас дийлэнх хувийг эзэлснээр агнуурын загасны зүйлийн бүрдэл, таваарлаг чанар өөрчлөгдөж, агнуурын зонхилох загасны биеийн хэмжээ жижгэрч, давжаарч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Сүүлийн 13-14 жилийн хугацаанд говь, хээрийн бүсийн нуурын ус дундарч, урд өмнө байгаагүйгээр хамгийн бага түвшинд хүрчээ. Цаг уур, орчны шинжилгээний газрын тайланд дурдсанаар (2010), 2009 оны байдлаар Хар-Ус нуурын жилийн дундаж усны түвшин 2001 оноос хойш 32 см, Тэрхийн цагаан нуурынх 2000 оноос хойш 42 см, Өгий нуурынх 2004 оноос хойш 144 см, Буйр нуурынх 1999 оноос хойш 183 см, Хяргас нуурынх 1998 оноос хойш 281 см, Бөөнцагаан нуурынх 1998 оноос хойш 603 см-ээр тус тус дундарсан байна. Ийнхүү томоохон усан сангуудын усны түвшин байнга буурах хандлагатай байгаа нь тухайн экосистемийн байгалийн тогтолцоо

алдагдан, тэнд амьдрах олон зүйлийн загас болон усны бусад организмын амьдралд аюул занал учруулах магадлал тун өндөр байгааг гэрчилнэ.

Өгий нуур нь ёроолын амьтны зүйлийн бүрдлээр хамгийн өндөр (35 зүйл) байв. Энэ нь нэг талаас, тус нуур нь хүний ахуйн нөлөөгөөр нэлээд бохирдож, агнуурын загасны нөөц хомсдож буйн илрэл юм. Дархадын хотгорын Хармай, Доод нуураас жилдээ 5-10 тонн цагаан загас барих боломжтой. Тарган нуурын зарам загасны үржлийн хугацаа 11 сарын эхээс 12 сарыг дуустал үргэлжилж байна. Найман, Улаагчны Хар болон Дархадын хотгорын нууранд зарим загасны үржлийн хугацаанд агналтыг эрчимтэй явуулж байгаа нь эдгээр загасны нөөцөд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Өвөрхангай аймгийн Найман нуурын 1,258 бодгаль цагаан зарам загасны биометрийн үзүүлэлтэд дисперс шинжилгээ, харьцуулалт хийснээр загасны экологийн нөхцөл сайн, бие гүйцсэн загасны хэмжээ өсөж байгааг илрүүлжээ. Иймд загасыг үржлийн үед нь барихгүй байх хугацааг дахин хуульчлан тогтоох шаардлагатай.

Загасыг тооцоо судалгаагүйгээр хэтрүүлэн олборлох, хууль бусаар агнах явдал ихээр гарч байна. Энэ нь загасны төрөл, зүйлийг хомсдолд хүргэж буй хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй үндсэн шалтгаан болно. Сүүлийн 20 шахам жилийн хугацаанд Их нуурын хотгорын Хар-Ус, Хар, Дөргөн нууранд загас агнуур тасралтгүй үргэлжилсээр байна (Тэрбиш, 2014).

Хойд мөсөн далайн ай савын Өгий нуурт үйлдвэрлэлийн зориулалтаар загас агнуурын үйл ажиллагаа явуулж, 1960-1983 онд агнуурын нэг улиралд дунджаар 900 ц загас олборлож байжээ. Харин 1983-1993 онд загас олборлолтын хэмжээ жилд дунджаар 320 ц болж буурсан. Сүүлийн 15 жилд загас агнуурын талаарх нэгдсэн мэдээ баримт улсын хэмжээнд байхгүй нь энэ асуудлаар үнэн бодит үнэлгээ өгөх боломжийг хязгаарлаж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас сүүлийн жилүүдэд Өгий нуурын усны түвшин үлэмж татарсан нь энд идээшин амьдардаг агнуурын үнэт загаснуудын нөхөн үржилд ихээхэн таагүй нөхцөлийг үүсгэдэг.

Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон голуудын савд уул уурхайн үйлдвэрлэл эрчимжсэн нь тухайн усан санг бохирдуулан, олон зүйл загасны хэвийн амьдрах нөхцөлийг алдагдуулав. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас Орхон голын ус ихээр бохирдсон нь энд амьдардаг омуль загасны үржлийн нүүдлийн зам богиносон, төрц нь хорогдож байна. Судалгааны дүнгээс үзвэл Орхон голыг өгсөн явдаг омуль загасны үржлийн нүүдэл Сүхбаатар хотоос 5 км зайд үргэлжлээд л зогсох болжээ. Эдгээр баримт нь омуль загасны үржлийн нүүдэлд Орхон гол тодорхой ач холбогдолгүй болжээ гэж үзэхэд хүргэнэ (Дгебуадзе нар, 2009).

Туул голын усны өөрчлөлт нь тул, зэвэг, шивэр хадран зэрэг реофиль загаснуудын үржлийн хэвийн нөхцөлийг алдагдуулахад хүрчээ. Заамар орчимд явуулсан хяналтын судалгааны явцад дээр дурдсан зүйлийн загаснаас нэг ч бодгаль баригдаагүй нь үүний нэг нотолгоо болно.

Монголчуудын хувьд загас агнуурын уламжлал бага, төдийлөн ач холбогдолгүй явж ирсэн хэдий ч сүүлийн жилүүдэд сонирхогчдын загас агнуур ихээр өргөжиж, ялангуяа хот, суурин газрын оршин суугчдын дунд нэн өргөжиж, тул, зэвэг, хадран, цагаан загасыг хууль бусаар их хэмжээгээр агнаж байгаагаас тоо толгой, нөөц нь илт багаслаа. Гэвч загасны хууль бус агнуурт тавих хяналт, шалгалт сул байгаагаас ямар хэмжээний хор хохирол учирч байгаа талаар бодит үнэлгээ өгөх боломжгүй.

Монгол улсад аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжиж байна. Энэ салбарын үйл ажиллагааны нэг чиглэл нь спортын загас агнуур боллоо. Загасчлах аяллаар дагнасан аж ахуйн нэгжүүдийн тоо ч олширчээ (Тэрбиш, 2014).

ЗАГАС ХАМГААЛАЛ БА ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА: Амьтны тухай Монгол улсын хуулиар амарын хилим (*Acipenser schrenckii*), шаргал үхэрдээ (*Tinca tinca*) зэрэг зүйлийг нэн ховор, Засгийн газрын шийдвэрээр (Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолын 1-р хавсралт) хорхой загас (*Lethenteron reissneri*), тул (*Hucho taimen*) зэрэг зүйлийг ховор амьтны жагсаалтад тус тус оруулж, тусгайлан хамгаалж байна.

Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр “Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төв”-ийг байгуулсан нь загасны нөөц баялгийг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой арга хэмжээ боллоо. Уг төвөөс эрхлэн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг болон Цагааннуур сумын Доод Цагаан нуурт загас үржүүлгийн лаборатори байгуулан ашиглалтад оруулав.

Монгол улсын зохих хууль тогтоомжид оморь загасыг 8 дугаар сарын 30-ны өдрөөс 10 сарын 30-ны өдөр хүртэл, цагаан зарам буюу пельд загасыг 9 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 1 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл тус тус барихыг хориглох тухай заалт оруулахаар санал боловсруулсан нь эдгээр зүйл загасны өсөлтийн хэвийн явцыг хангахад чухал ач холбогдолтой эрх зүйн зохицуулалт болох юм.

Урд өмнө загасгүй байсан Улаагчны Хар нуурын сав газрын нууруудад тэжээлийн шинэ холбоо буй болгож Монгол орны загасны аймгийн төрөл зүйлийг шинэ эх сүргээр баяжуулсан нь байгалийн уурагт баялаг, эрүүл хүнсний шинэ бүтээгдэхүүн бий болгох эх үндсийг тавилаа.

Хоёр нутагтан

ХОЁР НУТАГТАН АМЬТДЫН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ: Өнөөгийн байдлаар Монгол оронд тархан амьдарч буй 2 баг, 4 овог, 5 төрөлд хамаарах 6 зүйлийн хоёр нутагтан бүргэгджээ (хүснэгт 4) (Тэрбиш, 2019). Уг жагсаалтыг гаргахдаа Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн судалгааны тулгуур бүтээлүүд (Мөнхбаяр, 1976; Ананьева нар, 1997; Terbish et al., 2013; Kuzmin et al., 2017)-ийг эш үндэс болгов. Олон улсын герпетологийн хорооны (International herpetological Committee) зөвлөмжийг удирдлага болгон хоёр нутагтан, мөлхөгчдийн шинжлэх ухааны болон англи нэрийг

бичлээ. Х.Мөнхбаяр (1976), Х.Мөнхбаяр нар (2010), Kh.Terbish *et al.* (2013) нарын бүтээлд бичсэний дагуу ихэнх зүйлийн оноосон монгол нэрийг оруулав. Харин сүүлийн жилүүдэд шинжлэх ухаанд Монгол орноос шинээр нээж бичсэн (Orlova *et al.*, 2017) болон шинээр олж тэмдэглэсэн (Kropachev *et al.*, 2016) зүйлүүдэд монгол нэрийг Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн ангилал зүй ба ховор тохиолдох зүйлийг бүртгэх салбар зөвлөлийн шийдвэрийг үндэслэн өгсөн болно.

Хүснэгт 4. Монгол орны хоёр нутагтны зүйлийн бүрэлдэхүүн

| Баг | Овог | Зүйл |
|---------------------------------|------------------------------|--|
| Сүүлтэй хоёр нутагтан (Caudata) | Гүлмэрийн овог (Hynobiidae) | Шивэр гүлмэр (<i>Salamandrella keyserlingii</i>) |
| Сүүлгүй хоёр нутагтан (Anura) | Бахын овог (Bufonidae) | Монгол бах (<i>Bufo raddei</i>) Певцовын бах (<i>Bufo pewzovi</i>) |
| | Модны мэлхийн овог (Hylidae) | Модны мэлхий (<i>Hyla japonica</i>) |
| | Мэлхийн овог (Ranidae) | Шивэр мэлхий (<i>Rana amurensis</i>) Дорнодын мэлхий (<i>Rana chensinensis</i>) |



Шивэр гүлмэр С. Гомбобаатар, Mongolica Publishing

Хоёр нутагтны зүйлийн тоо хязгаарлагдмал цөөн байгаа нь тус орны газар зүйн байршлын онцлог болон эх газрын эрс тэс уур амьсгалтай холбоотой. Эдгээр цөөн зүйл хоёр нутагтан амьтад Монгол орны байгалийн муж, бүс бүслүүрт харилцан адилгүй тархсан. Тухайлбал, гол мөрөн, нуур цөөрөм зэрэг гадаргын усан сан харьцангуй элбэг, Хангай-Хэнтийн уулархаг болон Монголын Дорнод талын их мужуудад хоёр нутагтны зонхилох зүйлүүд тархан нутагшсан байдаг. Харин

гадаргын усан сан багатай Говийн их муж болон хүйтэн ширүүн уур амьсгалтай Алтайн уулархаг их мужид хоёр нутагтны зүйлийн бүрэлдэхүүн ядмаг.

МОНГОЛ ОРНЫ ХОЁР НУТАГТНЫ ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ: Олон улсын байгаль хамгаалах холбооны шалгуураар Монгол орны хоёр нутагтан амьтдын ховордлын зэргийг үнэлэхэд, шивэр гүлмэр, Певцовын бах, модны болон Дорнодын мэлхий гэсэн 4 зүйл эмзэг зэрэглэлтэй (Terbish *et al.*, 2006). Эдгээр баримт тус орны хоёр нутагтан амьтдын цаашдын төлөв байдал таатай биш байгааг илтгэнэ. Эдгээр ховор хоёр нутагтнууд бүгд үндсэн тархцынхаа захын популяциуд болно (Тэрбиш, 2014).

ХОЁР НУТАГТНЫ ТӨРӨЛ ЗҮЙЛД УЧИРЧ БУЙ АЮУЛ ЗАНАЛ, СӨРӨГ НӨЛӨӨ: Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал болон хүний үйл ажиллагаа, хотжилт, суурьшлын нөлөөнөөс гол, горхи, нуур, цөөрөм, намаг олноор хатаж ширгэснээс хоёр нутагтны тархац нутаг хумигдан, тоо толгой нь цөөрч байна. Улаанбаатар хотын дэвсгэр нутагт хамаарах Туул голын савын шивэр гүлмэр, шивэр мэлхийн эгэл популяци байхгүй болж, бас монгол бах үзэгдэхгүй болов. Дархадын хотгорын Үхэртийн голын савын Бөөрөг хэмээх газарт геологийн урт удаан хугацаанд үүсэн бүрэлдсэн мөнх цэвдгийн гаралтай 30 гаруй жижиг нуурын талаас илүү нь хатаж ширгэснээс энд идээшин амьдарч байсан шивэр гүлмэрийн популяцийн хэвийн амьдралд таагүй байдал үүсэв. Таацын Цагаан, Улаан, Адгийн Цагаан зэрэг говийн томоохон нуурууд бүрэн ширгэснээс эндхийн монгол бахын популяцийн тоо толгой эрс цөөрч, дэлхэц нутаг нь тасарч хумигдсаар байна. Сүүлийн жилүүдэд Түйн голын урсац эрс татарснаас Орог нуур үе үе ширгэх болсон нь энд амьдарч буй монгол бахад мөн л сөргөөр нөлөөлөх магадлал өндөр. Монгол орны хоёр нутагтан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 66.6% нь идээшин амьдардаг (шивэр гүлмэр, монгол бах, модны мэлхий, шивэр мэлхий) Орхон-Сэлэнгийн сав нутагт бас ийм сөрөг байдал ажиглагдаж байна (Тэрбиш, 2014).

Монгол-Оросын хамтарсан биологийн иж бүрэн экспедицийн судлаачид Шаамарын орчимд хоёр нутагтан амьтад идээшин амьдардаг хоёр бүлэг тогтмол усан санг сонгон 1983-1984 онуудад судалгаа хийсэн байдаг. Эдгээр бүлэг усан сангуудад дээр дурдсан 4 зүйлийн хоёр нутагтны 1-ээс дээш настай бодгалиудын тоо толгой 1,000 м² талбайд 880, тухайн жилийн залуу амьтдын тоо 10,800-д тус тус хүрч байжээ (Боркин нар, 1988). Гэтэл 24 жилийн дараа буюу 2008 онд энд давтан судалгаа явуулахад эхнийх нь бүлэг усан сан бүрэн ширгэж, нугажсан тул ямар ч зүйлийн хоёр нутагтан эндээс олдсонгүй. Харин хоёр дахь бүлэг усан санд хоёр нутагтан амьтад амьдарч байгаа ч зүйлийн бүрэлдэхүүн, тоо толгой нь эрс багасчээ (Кузьмин, 2009). Судалгаагаар энэхүү хоёр дахь бүлэг усан санд шивэр гүлмэр, модны мэлхий зэрэг Монгол орны ховор амьтад огт үгүй болсон нь тогтоогдсон. Орхон-Сэлэнгийн сав нутагт ийнхүү хоёр нутагтны популяцийн тоо толгой хорогдон, тархац нутаг хумигдаж байгаа нь үндсэндээ хүний үйл ажиллагаанаас хамаарсан байна. Эдгээр усан сангийн эргийн ургамлыг ихээр устгаж, ойр орчмын үлэмж хэмжээний талбайг жимс, жимсгэнэ, хүнсний ногооны талбайн зориулалтаар боловсруулан ашигласны зэрэгцээ дээрх тогтмол усан

сангуудын усыг таримал ургамлын талбайг услахад ашигласан зэрэг нь ийнхүү хоёр нутагтны амьдрах нутаг хомсдож, тоо толгой нь буурах үндсэн шалтгаан болжээ (Тэрбиш, 2014).

Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Хараагийн зүүн гар талаас цутгадаг Шатангийн голын шивэр мэлхийн популяцид альбинос бодгаль илэрчээ (Мөнхбаатар, 2008). Хэрлэн, Балж голын савын монгол бахын зарим популяцийн дотроос олигодактил шанаганцрууд олноор олжээ (Боркин нар, 2011). Тэдний судалгаагаар, Дорнод аймгийн төвөөс холгүй Хэрлэн голын эргээр орших хэдэн жижиг цөөрмийн нэгд нь метаморфозын төгсгөлд орж байгаа монгол бахын шанаганцар дотор аль нэгэн хойд хөл байхгүй бодгалиуд олноор тохиолдсон байна. Тухайлбал, эндхийн зулзаган бахын популяцийн 40 хувь нь ийм эрэмдэг зэрэмдэг болсон байжээ. Эдгээрийн амьдарч буй цөөрмийн усны рН-8.3. Гэтэл ойр зэргэлдээх цөөрмийн бахын шанаганцар дотор ийм бах илрээгүй байна. Хэнтий аймгийн Дадал сумын нутаг, Манхаадай хэмээх горхиноос бас дээрх үзэгдэл илэрчээ (Мөнхбаатар, Тэрбиш, 2008). Тэнд тооцоо хийхэд нийт шанаганцрын 35 хувь нь ийм зэрэмдэг байв. Энэ бүхэн нь усны бохирдлоос үүдэлтэй байх бүрэн үндэстэй юм.

ХОЁР НУТАГТАН АМЬТДЫН ХАМГААЛАЛ БА ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА: Монголын ховор амьтны жагсаалт (Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолын 1-р хавсралт), Монгол улсын Улаан номонд 4 зүйлийн хоёр нутагтан (*Salamandrella keyserlingii*, *Bufo pewzovi*, *Hyla japonica*, *Rana chensinensis*) бүртгэгджээ.

Эдгээр амьтдын тархцын төлөв байдал, тоо толгойн хэлбэлзэл, нөлөөлж буй хүчин зүйлсийг гүнзгийрүүлэн судлах, тэдгээрийг хамгаалах менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Энэ арга хэмжээний хүрээнд шивэр гүлмэр, модны мэлхий, шивэр мэлхий, монгол бах хамт амьдардаг Сэлэнгэ аймгийн Шаамар сумын нутаг Бүүрэг толгой орчмын газар нутгийг нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах тухай урд өмнө гарч байсан саналыг дэмжиж байна (Тэрбиш, 2014).

Мөлхөгчид

МӨЛХӨГЧДИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ТӨЛӨВ БАЙДАЛ: Монгол оронд 1 баг, 2 салбар баг, 7 овог, 15 төрөлд багтах 23 зүйлийн мөлхөгчид тэмдэглэжээ. Уг бүртгэлийг гаргахдаа Монгол орны мөлхөгчдийн судалгааны тулгуур бүтээлүүд (Мөнхбаяр, 1976; Ананьева нар, 1997; Terbish et al., 2013; Kuzmin et al., 2017)-ийг эш үндэс болгов. Олон улсын герпетологийн хорооны (International herpetological Committee) зөвлөмжийг удирдлага болгон мөлхөгчдийн шинжлэх ухааны болон англи нэрийг бичлээ. Х. Мөнхбаяр (1976), Х. Мөнхбаяр нар (2010), Kh. Terbish et al. (2013) нарын бүтээлд бичсэн дагуу ихэнх зүйлийн оноосон монгол нэрийг оруулав (Тэрбиш, 2019).



Замба гүрвэл С. Гомбобаатар, Mongolica Publishing

Монгол орны мөлхөгчдийн зүйлийн бүрэлдэхүүний 50 гаруй хувийг жинхэнэ гүрвэл (Lacertidae) ба хар могойн овгийн (Colubridae) амьтад эзэлнэ. Монгол орны харьцангуй дулаан, хуурай амьсгалтай Говийн их мужид мөлхөгчдийн зонхилох зүйлүүд тархсан байдаг онцлогтой.

К.Ж.Ваг (2012) нарын судлаачид хадны замба гүрвэлийн (*Laudakia*) ангилал зүйн талаар явуулсан нарийвчилсан судалгааны үр дүнд *Paralaudakia* хэмээх шинэ төрлийг ялган, Монгол оронд тархсан замба гүрвэлийн зүйлийг уг төрөлд хамааруулсан байна. Иймээс урд өмнө *Laudakia stoliczkana* гэж нэрлэдэг байсан замба гүрвэлийн зүйлийг энэхүү тайланд *Paralaudakia stoliczkana* хэмээн орууллаа. Хээрийн загалмайт могойг (*Vipera ursini*) Оросын байгаль шинжээч В.В. Сопожников 1906 онд Монгол Алтайн нурууны баруун хэсгээс олж тэмдэглэснээс (Кашенко, 1909) өөр судалгааны ямар нэг мэдээ баримт өнөө хир үгүй.

Ангилал зүйн судалгааны үр дүнд *Eremias przewalskii tuvensis* Szczerbak, 1970 (Щербак, 1970), *Eremias multiocellata bannikowi* Szczerbak, 1973 (Щербак, 1973), *Eremias multiocellata tsaganbogdensis* Munkhbayar et Borkin, 2010 (Мунхбаяр, Боркин, 2010), *Paralaudakia stoliczkana altaica*, Munkhbayar, 1971 (Мөнхбаяр, 1971) зэрэг салбар зүйлүүдийг шинжлэх ухаанд шинээр бичжээ. Гэсэн хэдий ч Монгол орны мөлхөгчдийн элдэв хэлбэрийг салбар зүйлийн түвшинд судалж бүрэн дуусаагүй. Ялангуяа цоохор хонин гүрвэл, могой гүрвэл, говийн гүрвэл, бамбай хоншоорт могойн зүйлийн дотоод ангиллыг нарийвчлан судлах зайлшгүй шаардлагатай (Тэрбиш, 2014).

Сүүлийн жилүүдэд шинжлэх ухаанд Монгол орноос шинээр 1 зүйл гүрвэлийг бичсэн (Orlova et al., 2017) ба 1 зүйл могойг манай оронд шинээр тэмдэглэсэн (Kropachev et al., 2016).

МӨЛХӨГЧДИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛД УЧИРЧ БУЙ АЮУЛ ЗАНАЛ, СӨРӨГ НӨЛӨӨ: Монгол орны хувьд мөлхөгчдийг хүнс, тэжээл, эмийн болон үйлдвэрийн түүхий эдийн зориулалтаар ашиглах, худалдаалах явдал бараг үгүй. Ийм учраас мөлхөгчдийн элдэв хэлбэрт хүний зүгээс үзүүлэх шууд

нөлөө тун бага. Гэвч хүний үйл ажиллагааны улмаас амьдрах орчин доройтон, мөлхөгчдийн тархац нутаг хумигдаж, тоо толгой нь хомсдож болзошгүй байна. Малын тоо толгойн хэт өсөлттэй уялдсан бэлчээрийн талхагдал, цөлжилт, тал хээрийн болон ойн түймэр, хөнөөлт шавж, мэрэгчидтэй тэмцэх зорилгоор химийн төрөл бүрийн бэлдмэл хэрэглэх, байгалийн нөөц, баялгийг ашиглах явцад үүсэж буй хөрс, газрын гадаргуугийн элэгдэл эвдрэл зэргийг нэн тэргүүнд дурдах нь зүйтэй. Гэхдээ эдгээр хүчин зүйлс мөлхөгч амьтдад хэрхэн, ямар сөрөг нөлөө үзүүлж байгаа талаар тодорхой баримт, мэдээ үндсэндээ байхгүй (Тэрбиш, 2014).

МӨЛХӨГЧ АМЬТДЫН ХАМГААЛАЛ БА ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА: Монголын ховор амьтны жагсаалт (Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолын 1-р хавсралт), Монгол улсын Улаан номонд 6 зүйлийн мөлхөгч (*Cyrtopodion elongatus*, *Phrynocephalus helioscopus*, *Eremias arguta*, *Eryx tataricus*, *Coluber spinalis*, *Vipera berus*) буюу нийт зүйлийн бүрэлдэхүүний 27.2 хувь нь оржээ.

Монгол орны мөлхөгчдийн тархац, биологи, экологи, тоо толгойн динамикийн талаар нарийвчилсан судалгаа хийж, цаашдын чиг хандлагын талаарх мониторингийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нь энэ бүлэг амьтдын элдэв хэлбэрийг хамгаалахад чухал ач холбогдолтой. Ховор болон зах хязгаарын тархалттай мөлхөгчдийн зүйлүүд шүтэн амьдардаг Алтайн өвөр Говийн Ногоон цавын хоолой, Нөмрөг зэрэг зарим чухал нутгийг улсын тусгай хамгаалалтанд авах шаардлагатай байна. Энэ асуудлыг өмнөх 4-р тайланд санал болгож байсныг дашрамд тэмдэглэх нь зүйтэй (Тэрбиш, 2014).

Шувуу

ШУВУУДЫН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ БА СТАТУС: Монгол оронд нийт 476 зүйл шувуу бүртгэгджээ (Gombobaatar *et al.*, 2011).



Идлэг шонхор С. Гомбобаатар, Mongolica Publishing

Тэдгээрээс өвөл Монгол оронд орж ирдэг болон суурин өвөлждөг нийт 45 зүйл (нийт зүйлийн дотор 6%), тохиолдлоор таарах нийт 67 (8%), суурин өндөглөдөг 91 (12%), нүүдлийн өндөглөдөг буюу үрждэг 263 (33%), нүүдлийн дайрч өнгөрдөг 329 (41%) зүйл байна (график 1) (Gombobaatar *et al.*, 2011).

График 2. Монгол орны шувууны статус



Зарим зүйл шувуу манай оронд нүүдлийн өндөглөдөг боловч бас дайрч өнгөрдөг, эсвэл суурин өндөглөдөг зүйлүүд нь өвөлждөг бүлэгт багтдаг зэргээс шалтгаалан график 1-т үзүүлсэн зүйлийн тоо 476-аас олон байгааг анхаарна уу.

Монгол орны шувууны зүйлийн бүрэлдэхүүн жил бүр нэмэгдэх хандлагатай байна. 2019 оны байдлаар Монгол орны шувуу 23 багийн 69 овгийн, 235 төрлийн 513 зүйлээс бүрдэнэ (Гомбобаатар ба Цэвээнмядаг, 2019). Энэхүү зүйлийн жагсаалтыг Bold & Stepanyan (1988), Fomin & Bold (1991), Dawaa et al. (1994), Reading et al. (1994), Bold et al. (2001, 2007), Stepanyan (2003), Gombobaatar (2009), Gombobaatar et al. (2011) зэрэг бүтээлийг шүүж үзэв. Шувууны ангилал зүйн нэгжүүдийн дараалал, зүйлийн ангилал, латин буюу шинжлэх ухааны болон англи нэрийг Gill and Donsker (eds) (2018) боловсруулсан International Ornithologists' Union буюу Олон Улсын Шувуу Судлаачдын Холбооны (ОУШСХ) (2018) зүйлийн жагсаалт (IOC WORLD BIRD LIST (8.2); <http://dx.doi.org/10.14344/IOC.ML.8.2>)-ыг дагаж бичлээ. Ангилал зүйн философи болон зорилгоосоо хамаарсан, өөр хоорондоо ялимгүй ялгаатай дэлхийн шувууны 3 томоохон ангилал зүйн жагсаалт болох “The Clements Checklist of the Birds of the World”, “The Howard & Moore Complete Checklist of the Birds of the World, 4th Edition”, “HBW Alive/Bird Life International” бүтээлийг харгалзан шинэчилсэн бүтэцтэйгээр дэлхийн шувууны ангилал зүйн жагсаалтыг ОУШСХ гаргасан юм. Энэ жагсаалтыг дэлхийн олон улс орны шувуу судлаач, хамгаалагчид мөрдөж байна. Бид өмнө нь Birdlife International (2018)-ын шувууны жагсаалтыг даган мөрдөж байсан ч энэ жагсаалтын зүйлийн нэр, зүйлийн ангилал, овгийн дараалал бараг байнга өөрчлөгддөг, мөн махчин шувууд хоёр бүлэг болон салсан зэрэг манай орны хувьд хэрэглэхэд тохиромжгүй байв. Иймээс зүйл, төрөл, овгийн дараалал харьцангуй тогтвортой төдийгүй салбар зүйлийн тархалтыг багтаасан ОУШСХ-ны ангиллыг хэрэглэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол нэрийг оноохдоо Bold et al. (2001), Bold et al. (2007), Gombobaatar (2009), Gombobaatar et al. (2011) нарын бүтээлийг ашигласан ба зарим монгол нэрийг Монгол орны шувууны ангилал зүй ба ховор тохиолдох зүйлийг бүртгэх салбар зөвлөлийн шийдвэрээр өөрчлөн, нийт 513 зүйл шувууны нэрийг хянаж, зарим зүйлд монгол нэрийг шинээр оноолоо (Гомбобаатар, 2019).

Монгол орны шувууны зүйлийн тоо 2009-2011 онд 476, 2011-2017 онд 502, 2019 онд 513 байна. Сүүлийн үед шувуу судлаачид (шувуу судлалын чиглэлээр магистраас дээш эрдмийн зэрэгтэй) болон шувуу сонирхогч, гэрэл зурагчид шувууны зураг авч, нийгмийн сүлжээний олон сувгийг ашиглан цацсан, шувуу судлал, хамгааллын ажил эрчимжсэн, мөн шувуу ажиглах, гэрэл зураг авах аяллыг олон байгууллагууд зохион байгуулсан зэргээс хамааран зүйлийн тоо нэмэгдэх хандлагатай. Шувууны зүйлийн тоо нэмэгдэх хамгийн чухал шалтгаан бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэд Биологийн олон янз байдлын конвенцын Ангилал зүйн санаачилга үйл ажиллагааны

хүрээнд Монгол орны шувууны ангилал зүй, ховор тохиолдох зүйлийг бүртгэх зөвлөл байгуулагдсантай шууд холбоотой. Энэ зөвлөлийн гишүүдийн идэвхтэй үйл ажиллагаагаар Монгол улсад шинээр бүртгэгдэж буй шувууны бүртгэлийн баримт бичгийг албан ёсоор хүлээн авах, хэлэлцэх, Монгол улсад бүртгэж авах эсэх талаар шийдвэр гаргах, гарсан шийдвэрийг хэвлэн нийтлэх зэрэг тодорхой системтэйгээр зүйлийг бүртгэн авч заншиж байна. Энэхүү үйл ажиллагааг шувуу судлаач, сонирхогч, байгаль судлал, хамгааллын байгууллагууд дэмжин ажиллах шаардлагатай байна.

МУИС, Монголын шувуу судлалын нийгэмлэгийн судлаачид монгол хэл шинжлэлийн эрдэмтэдтэй хамтран дэлхийн 4700 зүйл шувуунд монгол нэрийг оноогоод байна.

МОНГОЛ ОРНЫ ШУВУУНЫ ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ: Монгол орны шувуудын амьдрах орчин, ховордлын болон нөлөөлөх хүчин зүйлсийн үнэлгээг нэгдсэн байдлаар 2009 оноос өмнө гаргаагүй байсан юм. Харин тухайлсан цөөн зүйл шувууд дээр энэ үнэлгээг хийсэн нь бий. Монгол орны шувууны Улаан дансны олон улсын хурлыг 2009 онд зохион байгуулж, уг хурлаар Монгол орны шувуудтай холбоотой олон асуудлыг хөндөв. Олон улсын Улаан дансны шалгуураар шувууны зүйл бүрийг үндэсний болон олон улсын баг хамтран үнэлсэн бөгөөд энэ ажлаар манай оронд бүртгэгдсэн нийт 476 зүйл шувууны 9.3% бүс нутгийн буюу Монгол улсын хэмжээнд ховордлын зэрэглэлд багтаж байна. Гэхдээ энд ховордож болзошгүй зүйлийг оруулан тооцсон болно.

Манай орны шувуудын 0.5% бүс нутгийн хэмжээнд Устаж байгаа, 1.5% нь Устаж болзошгүй, 3.2% нь Эмзэг, харин 4.1% нь Ховордож болзошгүй гэсэн зэрэглэлтэй. Зүйлийн бүрэлдэхүүний 7.7% нь Мэдээлэл дутмаг, 83% нь Анхааралд өртөхөөргүй, харин 18.3% нь Улаан дансны шалгуураар Үнэлэх боломжгүй зэрэглэлд багтсан (график 2) (Gombobaatar et al., 2011).




График 2. Монгол орны шувууны ховордлын зэрэглэл

Нийт 36 зүйл нь ховордлын зэрэглэлд багтсан ба үүнээс 2 зүйл нь бүс нутгийн хэмжээнд Устаж байгаа, 6 нь Устаж болзошгүй, 12 нь Эмзэг, харин 16 зүйл нь Ховордож болзошгүй гэсэн үнэлгээтэй гэсэн үнэлгээтэй (хүснэгт 4).

Хүснэгт 4. Монгол орны ховор шувуудын ховордлын зэрэглэл

| Устаж байгаа (CR) | Устаж болзошгүй (EN) | Эмзэг (VU) | Ховордож болзошгүй (NT) |
|--|--|--|--|
| Борцгор хотон <i>Pelecanus crispus</i> | Цагаантолгойт ямаансүүл <i>Oxyura leucosephala</i> | Одой галуу <i>Anser erythropus</i> | Усны бухшувуу <i>Botaurus stellaris</i> |
| Цагаан тогоруу <i>Grus leucogeranus</i> | Реликт цахлай <i>Larus relictus</i> | Байгалийн нугас <i>Anas formosa</i> | Бичил одойбух <i>Ixobrychus minutus</i> |
| | Бор бүргэд | Ундар шумбуур <i>Aythya nyroca</i> | Зээрд дэглий <i>Ardea purpurea</i> |

| | | |
|--|---|---|
| <i>Aquila clanga</i> | Ооч ёл | Манхин галуу |
| Усны нөмрөгбүргэд <i>Haliaeetus leucorhynchus</i> | <i>Cyrcetus barbatus</i> | <i>Anser albifrons</i> |
| Могойч загалай <i>Circaetus gallicus</i> | Хан бүргэд <i>Aquila heliaca</i> | Хошуу галуу <i>Anser cygnoides</i> |
| Бахимхушуут хурагчбор <i>Paradoxornis heudei</i> | Идлэг шонхор <i>Falco cherrug</i> | Хуруут хун <i>Cygnus olor</i> |
| | Цэн тогоруу <i>Grus vipio</i> | Гэээгт нугас <i>Anas falcata</i> |
| | Хар тогоруу <i>Grus monacha</i> | Цагаансүүлт нөмрөгбүргэд <i>Haliaeetus albicilla</i> |
| | Азийн цууцал <i>Limnodromus semipalmatus</i> | Алтайн хойлог <i>Tetraogallus altaicus</i> |
| | Хонин тоодог <i>Otis tarda</i> | Зэрлэг гургуул <i>Phasianus colchicus</i> |
| | Жороо тоодгой <i>Chlamydotis undulata</i> | Хархираа тогоруу <i>Grus grus</i> |
| | Монгол хуланжороо <i>Podoces hendersoni</i> | Ойн шийхнүүхэй <i>Anthus trivialis</i> |
| | | Өгөөлэй шулганаа <i>Saxicola insignis</i> |
| | | Загийн бор шувуу <i>Passer ammodendri</i> |


| | | | |
|--|--|--|--|
| | | | Шарэлэгт хөмрөг <i>Emberiza aureola</i> |
| | | | Наран хөмрөг <i>Emberiza yessoensis</i> |

Бүс нутгийн хэмжээнд ховордсон шувуудаас олон улсын хэмжээнд ховордсон олон зүйл (борцгор хотон, манхин болон хошуу галуу, цагаантолгойт ямаансүүл, байгалийн нугас, бор ба хан бүргэд, усны нөмрөгбүргэд, идлэг шонхор, цагаан, цэн ба хар тогоруу, хонин тоодог, жороо тоодгой, реликт цахлай, өгөөлэй шулганаа, шарэлэгт хөмрөг) бий.

Шувууны бүлэг дотор боршувууны баг хамгийн олон зүйлтэй ч ховордлын зэрэглэлд орсон зүйлийн тоо харьцангуй цөөн байгаа нь энэ бүлэг шувууд орчны хүчин зүйлийн нөлөөнд тэсвэртэй, орчны нөхцлийн өөрчлөлтөнд хурдан зохилдох чадвартай, мөн тэдний түүхэн хөгжлийн замтай нь холбоотой.

ШУВУУНЫ ТАРХАЛТ БА ЗҮЙЛИЙН БАЯЛАГ: Манай орны ховор шувуудын тархалтын онцлог нь байгалийн бүс, бүслүүр, тусгай хамгаалалттай газар нутаг бүрт харилцан адилгүй.

Монгол орны шувууны зүйлийн баялаг нь байгалийн бүс, бүслүүр, амьдрах орчин бүрээр ялгаатай. Монгол Дагуур, Дорнод Монголын хээрийн Буйр нуурын хэсэг, Их Хянган, Хангай, Их Нууруудын хотгор, Хөвсгөлийн Дархадын Хотгор зэрэг газрууд шувууны зүйлийн баялаг ихтэй бол Говийн тойргууд бүрхлээрээ, цөлийн хээрийн бүс нь баялаг багатай байна. Эдгээр нутгууд зүйлийн баялаг ихтэй байдаг нь дэлхийн шувууны нүүдлийн Төв болон Баруун Азийн болон Зүүн Ази, Австрали-Азийн зам дээр оршдогтой холбоотой. Ховор шувуудын хамгаалалд Дорнод Монгол, Их Нууруудын Хотгорын тусгай хамгаалалттай газрууд чухал ач холбогдолтой. (зураг 1).



Зураг 1. Монгол орны шувууны тархалт ба зүйлийн баялаг

ШУВУУДАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС: Манай орны шувуудад нөлөөлөх хүчин зүйлийг Олон улсын байгаль хамгаалах холбооны Улаан дансны нөлөөллийн үнэлгээний шалгуур болон хамгаалах арга хэмжээний төвшин тогтоох арга (IUCN, 2003, Lamoreux *et al.*, 2003)-аар үнэлэн үзэхэд нийт нөлөөлж буй хүчин зүйлийн дотор тэргүүлэх байр суурьтай нь амьдрах орчин доройтох, алдагдах 38.1%, хүний шууд хүчин зүйлийн нөлөө 13.6%, элдэв бохирдол 11%, зүйлийн тоо болон бодгалийн тооноос хамаарах нөлөө 10.7% хүрсэн (Gombobaatar *et al.* 2011 & 2011a). Эдгээрээс манай орны шувуудад хамгийн сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл бол уул уурхай, дэд бүтцийн хөгжил, аялал жуулчлалын баазуудын нөлөө, хавар болон намрын үед гарах түймэр, хуурайшилтай холбоотой амьдрах орчны доройтол учир цаашид шувуу хамгааллын төлөвлөгөөнд эдгээр хүчин зүйлийг тооцох шаардлагатай.

Шувууг хууль бусаар агнах явдал буурахгүй байна. Ялангуяа олон нийтийн газар үзмэрийн зориулалтаар байршуулах, ардын эмнэлэг болон эмчилгээний зорилгоор алтайн хойлог, сохор элээ, монгол хулан жороог агнасаар байна. Үзмэрийн зориулалтаар тавих хандлага эрс буурч байгаа ч эмчилгээний зориулалтаар агнах үйл явц буурахгүй хэвээр.

Өндөр хүчдэлийн шон болон шугамын бүтцийн алдаанаас шалтгаалан олон зүйл шувууд өндөр хүчдэлд цохиулан эндэж байгааг үндэсний болон олон улсын судалгааны багийн судлаачид тогтоожээ. Энэ талаар МШСН болон БОНХЯ санаачлан, МУИС, ШУА, Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв зэрэг байгууллагууд хамтран цаашид авах арга хэмжээг боловсруулахаар ажиллаж байна. Сүүлийн үед баригдаж буй 15КВ-ын өндөр хүчдэлийн шугамд цохиулан эндэж буй махчин шувуудын тоо хавар, намрын улиралд ихсэх хандлагатай.

Нөлөөллийн хоёрдугаар зэрэглэлд багтах хүчин зүйлд усны шувууд загасны торонд орооцолдон эндэх, агаарын болон усны бохирдол (ялангуяа уул уурхайн компаниудын үйл ажиллагаатай холбоотой), махан идэшт амьтдын нөлөө, шувууны ханиад, бусад өвчин зэрэг багтана.

Нөлөөлж буй хүчин зүйлсийн үйлчлэл нь шувууны бүлэг бүрд харилцан адилгүй. Тухайлбал, тахианы багийн шувуудад хулгайн агнуур, тогоруу болон усны шувуудад хүн, мал, хуурайших үйл явцаас хамаарсан амьдрах орчны хомсдол, алдагдал, махчин шувуудад өндөр хүчдэл болон хор эрс сөргөөр нөлөөлж байна. Эдгээр хүчин зүйлийн нөлөө, ялангуяа уул уурхай болон дэд бүтцийн хөгжилтэй холбоотой сөрөг нөлөө харьцангуй ихсэх хандлага ажиглагдаж байна.

Монгол орноос Идлэг шонхорыг 1994 оноос Арабын орнуудад шинжлэх ухаан, арилжааны зорилгоор гаргаж ирлээ. Монгол улсын Засгийн газарт Соёл, спорт, аялал жуулчлалын яам, МШСН, МУИС-ийн судлаачдын хамтарсан баг “Шонхор шувууг” үндэсний бахархалт шувуугаар зарлан тунхаглах асуудлыг 2012 онд оруулж, олон нийтийн санал асуулгаар хамгийн олон саналыг “Идлэг шонхор” авснаар үндэсний бахархалт шувуу боллоо (Гомбобаатар, 2013). Байгаль орчин, ногоон хөгжлийн яам 2013 оноос хойш идлэг шонхорыг арилжааны зорилгоор 5 жил гадаадад гаргахгүй байх асуудлыг Монгол улсын Засгийн Газраар батлуулав. Энэ зүйл шувууны амьдралыг харуулсан С Гомбобаатарын бичсэн “Монгол орны идлэг шонхор” бүтээл 2013 онд хэвлэгдэж, нийтийн хүртээл болов.

Монгол орны шувуудын нүүдлийн судалгааг үндэсний болон олон улсын судлаачид хамтран амжилттай хэрэгжүүлж, хошуу галуу, хээрийн галуу, гангар хун, идлэг шонхор, нөмрөг тас, амарын шонхор, цэн тогоруу, хавтгаалж зэрэг шувуудын нүүдлийн зам болон нөлөөлөх хүчин зүйлсийг амжилттай тодорхойлж байна.

Монгол орны томоохон уул уурхай болох Оюу толгойн компани Өмнөговь аймгийн өөрийн уурхай орчмын нутаг дахь ховор зүйл шувууд-идлэг шонхор, жороо тоодгой, могойч загалай зэрэг шувуудын мониторингийн судалгааг гадаад, дотоодын судлаачдын тусламжтай гүйцэтгэж байна. Гэхдээ уул уурхайн компани бүхэн энэ чиглэлийн мониторингийн судалгааг гүйцэтгэхгүй байгаа нь харамсалтай.

Үлийн цагаан оготны эсрэг Бромадиолон нэртэй химийн хорыг хэрэглэснээр нэн олон махан идэшт амьтад тухайлбал хээрийн махчин шувууд олноороо эндсэн билээ. Төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран хорыг хэрэглэхгүй байх талаар нэгдсэн ойлголтод хүрсэн юм. Гэхдээ тодорхой сумын зарим нутагт бага хэмжээгээр хэрэглэсээр байна.

МОНГОЛ ОРНЫ ШУВУУДЫН ПОПУЛЯЦИЙН ЕРӨНХИЙ ХАНДЛАГА: Монгол орны шувуудын популяцийн ерөнхий хандлагыг Birdlife International (2011)-ын аргачлалаар 2000-2011 онд харьцуулав. Харьцуулалтаас үзэхэд нийт 476 зүйл шувууны хувьд популяцийн байдал нь харьцангуй тогтвортой байгаа зүйлийн эзлэх хэмжээ 64.9%, популяцийн хэмжээ буурах хандлагатай байгаа зүйлийн тоо 4%, популяци нь буурч байгаа 0,1%, харин популяцийн хандлага тодорхойгүй нь 31% хүрч байв (Gombobaatar *et al.*, 2011&2011a).

Энэхүү ерөнхийлсөн үнэлгээнээс үзвэл шувууны популяцийн ихэнх хувь нь харьцангуй тогтвортой байгаа хэдий ч шууд хүний хүчин зүйл болон орчны нөхцлийн өөрчлөлттэй холбоотойгоор зарим шувуудын тоо толгой эрч цөөрөв. Гэхдээ нийт зүйлийн 31% -д хамаарах зүйлийн популяцийн хандлагыг үнэлэх боломжгүй байгааг анхааран цаашид популяцийн судалгаа, үнэлгээг үргэлжлүүлэн гүйцэтгэх, шувууны Улаан дансны үнэлгээг 2019 онд дахин хийж, харьцуулах замаар хандлагыг тогтоох шаардлагатай.

Монгол орны шувуудын тоо толгойн өөрчлөлт нь Монголчуудын амьдралд шууд сөргөөр нөлөөлөх нь бага. Учир нь тэдний амьжиргаа, амьдралын хэв маяг нь шувуудаас бага хамааралтай. Харин шувуу хамгаалах чиглэлтэй байгуулагдсан тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа болон малчдын хооронд хүрээнд үүсдэг бэлчээр, усны маргаан байсаар байна.

Тусгай сонирхлын аялал, хариуцлагатай болон тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нутгийн иргэдийг хамруулан амьд байгаль түшиглэсэн аяллыг хөгжүүлэх нь нэг талаар шувууд, тэдгээрийн амьдрах орчныг иргэдийн оролцоотой хамгаалах, нөгөө талаар нутгийн иргэд байнгын орлоготой байх боломжтойг бодлогод суулгах нь зүйтэй.

БОАЖЯ захиалж, Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй МУИС-ийн хэрэгжүүлсэн “Монгол орны амьтан, ургамлын аймаг, бичил биетний ангилал зүйн бүртгэл,

мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд шувууны 502 зүйлийн тархалт, таних шинж тэмдэг болон ургах орчин, гэрэл зурагтай мэдээллийн сан үүсгэсэн (Гомбобаатар нар, 2018).

Монгол орны Нөмрөг, Алтан элс, Монгол Дагуур, Онон-Балж, Хөгнөхаан, Отгонтэнгэр, Увс, Хар-Ус нуур, Цамбагарав, Тосон Хулстай, Хар Ямаат, Их Нарт зэрэг тусгай хамгаалалттай газрууд нь зүйлийн баялгаар их бөгөөд шувуу хамгааллын арга хэмжээг эдгээр газарт эрчимжүүлэх нь зүйтэй (Gombobaatar *et al.*, 2011).

Судалгаагаар “Мэдээлэл дутмаг” зэрэглэлд багтсан 30 зүйл шувуу байгааг анхаарч, мэдээллийг нэгтгэх, судалгаа хийх шаардлагатай байгааг бодлогод тусгах хэрэгтэй.

Хөхтөн

ХӨХТӨНИЙ ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ: Манай оронд нийт 128 зүйлийн хөхтөн амьтан бүртгэгджээ (Clark *et al.* 2006). Монгол орны биологийн олон янз байдлын жагсаалтад хөхтний 9 баг, 24 овог, 81 төрөл, 140 зүйлийг оруулсан (Батсайхан, 2019). Монгол орны хөхтөн амьтдын зүйлийн тоо харьцангуй тогтвортой ч ангилал зүйн молекул биологийн судалгаагаар гар далавчтан, мэрэгчдийн багийн зарим зүйлийн нэр болон тоо нэлээд өөрчлөгдсөн. Монгол орны хөхтнөөс мангис дорго, шарнад цөөвөр зэрэг хөхтний бүртгэлийн баримт одоо хир тодорхойгүй. Нэгэн зүйл мий шинээр Монгол оронд бүртгэгдсэн боловч одоо хир албан ёсоор зүйлийн жагсаалтад ороогүй. Монгол орны хөхтөн амьтдын ангилал зүй, зүйлийн өөрчлөлт, монгол нэр зэрэг олон асуудлыг шийдвэрлэхэд Монгол орны хөхтөн амьтдын ангилал зүйн салбар зөвлөл чармайлттай ажиллах шаардлагатай бөгөөд хөхтөн судлаачид энэ зөвлөлийг дэмжин ажиллах нь чухал байна.



Хар сүүлт зээр С. Гомбобаатар, Mongolica Publishing

МОНГОЛ ОРНЫ ХӨХТНИЙ ХОВОРДЛЫН ЗЭРЭГЛЭЛ: Нийт 128 зүйл хөхтний 16% нь бүс нутгийн хэмжээнд ховордлын зэрэглэлд орсон ба 2% нь Устаж байгаа (мазаалай баавгай, тахь адуу, халиун буга), 11% нь Устаж болзошгүй (монгол тарвага, Евразийн минж, гозоорой зурам, давжаа алагдаага, зүүнгар даахай ба бусад), 3% нь Эмзэг (соотон алагдаахай, ойн булга, хар сүүлтий, цаа буга) байна. Ховордож болзошгүй зэрэглэлд нийт зүйлийн 6% нь багтав. Шарнад цөөвөр бүс нутгийн хэмжээнд устжээ (хүснэгт 5) (Clark *et al.* 2006).

Хүснэгт 5. Монгол орны хөхтөн амьтдын ховордлын зэрэглэл

| Устаж байгаа | Устаж болзошгүй | Эмзэг | Ховордож болзошгүй |
|---|---|--|--|
| Мазаалай баавгай <i>Ursus arctos gobiensis</i> | Монгол тарвага <i>Marmota sibirica</i> | Соотон алагдаахай <i>Euchoreutes naso</i> | Бараан хэрэм <i>Sciurus vulgaris</i> |
| Тахь адуу <i>Equus ferus przewalskii</i> | Гозоорой зурам <i>Spermophilus alashanicus</i> | Ойн булга <i>Martes zibellina</i> | Евразийн шилүүс <i>Lynx lynx</i> |
| Халиун буга <i>Cervus elaphus</i> | Евразийн минж <i>Castor fiber</i> | Хар сүүлтий <i>Gazella subgutturosa</i> | Мануул мий <i>Otocolobus manul</i> |
| | Давжаа алагдаага <i>Allactaga elater</i> | Цаа буга <i>Rangifer tarandus</i> | Саарал чоно <i>Canis lupus</i> Хярс үнэг <i>Vulpes corsac</i> |
| | Зүүнгар даахай <i>Stylodipus sungorus</i> | | Шар үнэг <i>Vulpes vulpes</i> |
| | Сухайн чичүүл <i>Meriones tamariscinus</i> | | Зэрлэг гахай <i>Sus scrofa</i> |
| | Цоохор ирвэс <i>Uncia uncia</i> | | Янгир ямаа <i>Capra sibirica</i> |

| | | | |
|--|--|--|--|
| | Хулан адуу <i>Equus hemionus</i> | | |
| | Хавтгай тэмээ <i>Camelus bactrianus</i> <i>ferus</i> | | |
| | Аргаль хонь <i>Ovis ammon</i> | | |
| | Цагаан зээр <i>Procapra gutturosa</i> | | |
| | Татаар бөхөн <i>Saiga tatarica</i> | | |
| | Баданга хүдэр <i>Moschus</i> <i>moschiferus</i> | | |
| | Молцог хандгай <i>Alces</i> <i>alces</i> | | |

ХӨХТӨН АМЬТНЫ ЗАРИМ ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ:

Монгол орны Хавтгайн (*Camelus bactrianus ferus*) популяцийн тоо толгойн чиг хандлага 2012 онд хийсэн хавтгайн популяцийн үнэлгээний дүнгээс үзэхэд тоо толгой нь өмнөх олон жилийн дунджаас бага зэрэг өссөн дүнтэй байна.

МАЗААЛАЙ БААВГАЙ (*Ursus arctos gobiensis*)-Н ТОО ТОЛГОЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА: Мазаалай баавгайн тархац нутаг бүхэлдээ Говийн Их Дархан Цаазат Газрын “А” хэсэгт багтах ба нийтдээ 18 000 км² талбайг хамрах бөгөөд сүүлийн 10 жил үргэлжилсэн гантай нөхцөлд ч тоо толгой, тархац нутгийн хэмжээ өөрчлөгдөөгүй байгаа нь тухайн газар нутагт сайн дасан зохицож амьдарч байгаагийн илрэл юм. Мазаалай баавгайн тоо толгойн тухай мэдээ, баримт болон сүүлийн жилүүдийн генетикийн судалгаагаар тоо толгой нь харьцангуй тогтвортой гэж хэлэхээр байна.

Мазаалай баавгайн ангилал зүйн асуудлыг 2014 онд генетикийн шинжилгээгээр илтэд ялгарах дэд зүйл болохыг тогтоосон (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

БНХАУ-ын Засгийн газрын тусламжийн Монгол орны мазаалайг хамгаалах техникийн туслалцааны төсөл хэрэгжиж, 2018 онд нийт 250 орчим сая төгрөгийн техник хэрэгслийн тусламж үзүүлээд байна. Энэ ажлын хүрээнд 2 орны судлаачдын баг Говийн их дархан цаазат газарт ажиллаж, мазаалай баавгайн амьдрах орчныг хэрхэн сайжруулах, тоо толгой, генетикийн судалгаа хийж байна (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

Монголын говьд цөөн тоотой үлдсэн энэ ховор зүйл амьтны хувьд сүүлийн жилүүдэд тухайлбал 2013 оноос эхлэн төрийн болон төрийн бус байгууллагууд анхаарал хандуулж, тэдгээрийн амьдрах орчныг зориудын хур тунадас оруулах замаар тэтгэх, тоо толгой болон ангилал зүйн судалгаа хийх зэргээр анхаарлын төвд оруулаад байна (хүснэгт 6).

Хүснэгт 6. Мазаалай баавгайн тоо толгой

| Тоо толгойн судалгаа хийсэн он | Тоо толгой | Эх сурвалж |
|--------------------------------|------------|--|
| 1960 | 15-20 | Болд, 1967 |
| 1970 | 20< | Болд, Дуламцэрэн, 1981 |
| 1980 | 20-25 | Даш, Төмөр, 1983; Бугаев, Төмөр, 1985 |
| 1985 | 25-30 | Жирнов, Ильинский, 1985 |
| 1990 | 20< | Шаллер нар, 1993; McCarthy, 2000 |
| 1995 | 30-35 | Тулгат, 1995 |
| 2004 | 20< | Batsaikhan <i>et al.</i> , 2004; Амгалан нар, 2005 |
| 2011 | 22-31 | Одбаяр нар, 2011 |
| 2013 | 30< | Мижиддорж, 2013 |
| 2018 | 33 | Р. Самьяа, н. Баттогтох (аман мэдээ, 2018) |


МОНГОЛ БӨХӨН (*Saiga tatarica*)-ГИЙН ТОО ТОЛГОЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА:

Монгол бөхөнгийн тархац нутгийг тусгай хамгаалалтад бүрэн хамруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн зэрэглэлийг дээшлүүлэх, өргөтгөх экологийн судалгааны ажлыг 2018 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр хийж гүйцэтгэв. Дэлхийн байгаль хамгаалах сангийн санаачилга, төслөөр монгол

бөхөнг сэргээн нутагшуулах газрыг сонгох судалгааны ажлыг 2019 оны 6 дугаар сараас эхлүүлэхээр төлөвлөж байна.

Монгол бөхөнгийн тоо толгой 2016-2017 оны бог малын мялзан өвчин, 2017-2018 оны өвөлжилт хүндэрсэн зэргээс шалтгаалан тоо толгой ихээр буурч, 2018 оны 3 дугаар сарын тооллогоор 3,000 гаруйд хүрсэн бол 2018 оны 12 дугаар сард хийсэн тооллогоор бага зэрэг өссөн хандлагатай байна (график 2) (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

График 2. Монгол бөхөнгийн тоо толгойн хэлбэлзэл




Монгол бөхөнгийн тархац нутаг 2017 оны байдлаар өвчин гарсан голомтот нутаг буюу Дөргөний хүрэн тал болон Хүйсийн говьд хумигдсан, харин өвчлөл хожуу гарсан Шаргын говьд харьцангуй жигд тархаж байсныг судалгаагаар тогтоов.

Манай Улс 1998 оноос хойш авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон монгол бөхөн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд монгол бөхөн түүхэн тархац нутаг буюу Увс аймгийн Завхан сумын нутаг, Завхан аймгийн Дөрвөлжин, Говь-Алтай аймгийн Хөхморьт, Ховд аймгийн Дөргөн сумдын нутагт бөхөн шинээр нутагших болсон байна. Дээрх аймгийн нэгдсэн дүнгээр нийт 201 толгой бөхөн 2017 онд тоологдсоноос Ховд, Манханы Өөшийн хөдөө, Тэвшид хамгийн олон бөхөн тоологдсон (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

Байгаль цаг уурын нөхцөл, идэш тэжээлийн хомсдол, бэлчээрийн талхлагдал, мал, зэрлэг амьтны халдварт өвчин зэргээс шалтгаалан монгол бөхөнгийн тоо толгой ихээхэн хэлбэлзэлтэй байгаа нь тухайн зүйлийн тархац нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, зэрэглэлийг дээшлүүлэх өргөтгөх, тохиромжтой нутагт сэргээн нутагшуулах, генийг хадгалах шаардлагатай байгааг харуулж байна.

ТАХИЙН ПОПУЛЯЦИЙН ТОО ТОЛГОЙН ДИНАМИК, ХАНДЛАГА: Монгол оронд тахь нутагшуулах ажил гадаадын судлаачдын дэмжлэгтэйгээр амжилттай хэрэгжиж ирлээ. Голланд, Герман, Швейцарь, Австрали, Франц зэрэг улсаас тахь зөөвөрлөн нутагшуулах ажлыг 1992 оноос гүйцэтгэж байгаа бөгөөд анх Говь-Алтай аймгийн Бугат сумын Биж багийн нутаг Тахийн талд Христиан Освальдын сангийн дэмжлэгээр 5 тахийг авчирсан. Сүүлийн жилүүдэд Прага хотын амьтны хүрээлэн, Чехийн хөгжлийн агентлаг хамтран Монгол тахийг эх нутагт нь сэргээн нутагшуулах хөтөлбөрийг 2011 оноос санхүүжүүлэн, зохион байгуулж байна. 1992-2019 онд Хустайн нуруунд 84, Тахийн талд 128, Хомын талд 26 тахь авчирсан бөгөөд 2018 оны байдлаар Хустайн нуруунд 336, Тахийн талд 236, Хомын талд 77, нийт 649 толгой буюу дэлхийн хамгийн олон тахьтай улс болоод байна (график 3) (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

График 3. Монгол оронд сэргээн нутагшиж буй тахийн тоо толгой



МОНГОЛ ОРНЫ БУСАД ХӨХТӨН АМЬТДЫН ТОО ТОЛГОЙН ТӨЛӨВ БАЙДАЛ: Монгол орны ойн туруутан амьтдын популяцийн тоо толгойн өнөөгийн төлөв байдлыг үзүүлэв. Сүүлийн үеийн судалгааны үр дүнгээс үзвэл туруутан амьтдын дотроос хандгай, буга, хүдрийн популяцийн тоо толгой буурах хандлагатай, харин зэрлэг гахай, бор гөрөөсний популяцийн тоо толгой өсөх хандлагатай байв.

Сүүлийн 20 гаруй жилийн судалгааны дүнгээр Монгол орны нэн ховор, ховор амьтан болох мазаалай 28, хүрэн баавгай 500, баданга хүдэр 6,500, Төв Азийн минж 300, голын халиу 100, суусар булга 3,500, цоохор ирвэс 900-1,200, тахь 538, халиун буга 10,000 орчим, хулан 10,000, янгир 11,000, аргаль 13,000, молцог хандгай 16,400, хавтгай 800-1,200, цаа буга 140-200, хар сүүлт 12,000 (нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр 2011), зэрлэг гахай 35,000, бөхөн 1,000 орчим тоо толгой тус тус байгаа ажээ (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018). Түүнчлэн цагаан зээр 3 сая орчим байна. Ан амьтны тоо толгойг 1970-1980 онд гүйцэтгэсэн тооллогын дүнтэй харьцуулбал 70-50% буурсан 1990-2000 оны дүнтэй жишвэл 20-40% өссөн байна. Сүүлийн 6 жилд улсын хэмжээнд амьтны нэгдсэн тооллого, үнэлгээ хийсэнгүй. Зөвхөн шаардлагатай бүс нутагт зарим амьтны нөөцийг тогтоох ажлыг зохион байгуулсан (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

Монгол орны тал хээрийн бүсэд тархсан тураг хөхтөн амьтдын хувьд 2009 оноос хойш (4-р тайлангаас хойш) тоо толгойн онцгой өөрчлөлт гараагүй байгааг судлаачдын мэдээ харуулж байна. Тухайлбал, 2010 онд Монгол орны хэмжээнд хийсэн хээрийн туруутан амьтдын популяцийн тоо толгойн үнэлгээнээс үзэхэд Монгол орны янгирын тоо 35,300, цагаан зээр 5,700,000, хар сүүлт зээр 11,900, хулан 14,000 орчим байна (Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018).

Дэлхийн байгаль хамгаалах сан, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон бусад төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран бүс нутгийн болон олон улсын хэмжээнд ховор хавтгай, мазаалай баавгай, тахь, хулан, монгол бөхөн, хар сүүлт зээр зэрэг 6 зүйл амьтныг судлах, хамгаалах чиглэлээр “Их говийн 6” буюу “Great Gobi -6” санаачилгыг 2016 онд эхлүүлэн амжилттай ажиллаж байна.

Германы Засгийн газар ба KfW хөгжлийн банкны санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн “биологийн олон янз байдлын суурь мэдээлэл бүрдүүлэх судалгаа хийх ажлыг Монголын шувуу судлалын нийгэмлэг, МУИС-ийн Биологийн тэнхим, Монголика консалтинг ХХК, Шинжлэх ухааны академи, Тул хамгаалах сан зэрэг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн судлаач, эрдэмтэд, нийт 15 тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны оролцоотой 2016 онд гүйцэтгэсэн юм. Судалгаанд нийт 13 зүйл амьтныг үндсэн, 6 зүйлийг нэмэлтээр сонгож, судалгаа хийжээ. Хан

Хэнтийд тул, хүдэр (нэмэлтээр зэвэг), Горхи-Тэрэлжид Монгол тарвага, Хустайд Монгол тарвага, халиун буга, идлэг шонхор, Дорнод Монголд цагаан зээр, Монгол тарвага, Монгол Дагуурт цагаан зээр, цэн тогоруу, хошуу галуу (нэмэлтээр Амарын хадран), Тосон Хулстайд цагаан зээр, Монгол тарвага, Онон-Балжид хонин тоодог, цэн тогоруу, тул (нэмэлтээр Амарын хадран), Орхоны хөндийд Монгол тарвага, халиун буга, Отгонтэнгэрт вансэмбэрүү, халиун буга, янгир (нэмэлтээр өгөөлэй шулганаа), Тарвагатайд янгир, Монгол тарвага (нэмэлтээр Алтайн хойлог), Хангайн нуруунд янгир, Монгол тарвага (нэмэлтээр Алтайн хойлог), Зэд-Хантай-Бүтээлийн нуруунд тул, хандгай (нэмэлтээр хилэм), Улаан тайгад тул, халиун буга (нэмэлтээр олби), Хорьдол Сарьдагт аргаль, янгир, хандгай (нэмэлтээр олби), Тэнгис- Шишгэдэд тул, халиун буга (нэмэлтээр цаа буга) зэрэг зүйл амьтны судалгаа хийсэн байна. Судалгааны дүнгээс үзвэл нийт 15 тусгай хамгаалалттай газар нутагт зорилтот буюу сонгосон зүйлийн нягтшил, нөөц харилцан адилгүй байв (хүснэгт 7).

Хүснэгт 7. Монгол орны зарим тусгай хамгаалалттай газар нутаг дахь зорилтот зүйлийн нягтшил

| ДД | УТХГН-ийн нэр | Зүйлийн ангилал зүй | Хамгааллын статус | | УТХГ дахь тархац нутгийн хэмжээ (га) | Тоо толгой, нягтшил, нөөц | Нөлөөлж буй хүчин зүйлс | Эмзэг байдлын үнэлгээ |
|----|----------------|-------------------------------|-------------------|-----------|--------------------------------------|---------------------------|--|-----------------------|
| | | | Олон улс | Бүс нутаг | | | | |
| 1 | Хан Хэнтий ДЦГ | Хуш (<i>Pinus sibirica</i>) | - | - | 268,376 | 51,642,750 шоо метр | <ul style="list-style-type: none"> ▪ Ойн түймэр ▪ Боргоой хэт ихээр бэлтгэх ▪ Болц гүйцээгүй боргоойг гол ишрүү мунаар цохин түүх ▪ Ойн хортон шавьж ▪ Байгалийн дагалт баялгийг зүй бусаар түүх, ашиглах | 9.45 |
| | | Тул (<i>Hucho taimen</i>) | - | EN | 555 км | 1 км-0.0072 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус загасчлал ▪ Уул уурхай ▪ Амьдрах орчны доройтол | 10.95 |

| | | | | | | | | |
|---|------------------|--|----|----|---------|---|---|------|
| | | Баданга хүдэр (<i>Moschus moschiferus</i>) | VU | EN | 679,535 | 1000 га-д 0.35 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Ойн түймэр ▪ Хууль бус агнуур ▪ Бэлчээрийн давхцал ▪ Мод бэлтгэл ▪ Амьдрах орчны доройтол ▪ Махчин амьтны нөлөө ▪ Самарчид жимсчдийн нөлөө | 12.9 |
| 2 | Горхи-Тэрэлж БЦГ | Хуш (<i>Pinus sibirica</i>) | - | - | 24,702 | 5,059,040 шоо метр | <ul style="list-style-type: none"> ▪ Ойн түймэр ▪ Боргоцой хэт ихээр бэлтгэх ▪ Болц гүйцээгүй боргоцойг гол ишрүү мунаар цохих ▪ Ойн хортон шавьж ▪ Байгалийн дагалтат баялгийг зүй бусаар түүх, ашиглах | 10.4 |
| | | Монгол тарвага (<i>Marmota sibirica</i>) | LC | EN | 25,325 | 1000 га-д 69.7 бодгаль Нөөц: 1,763.9 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус ан ▪ Амьдрах орчны доройтол ▪ Махчин амьтны нөлөө ▪ Хүн, малын нөлөө | 13.1 |
| | | Баданга хүдэр (<i>Moschus moschiferus</i>) | VU | EN | 37,387 | 1000 га-д 0.05 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Ойн түймэр ▪ Хууль бус агнуур ▪ Бэлчээрийн давхцал ▪ Мод бэлтгэл ▪ Амьдрах орчны доройтол ▪ Махчин амьтны нөлөө ▪ Самарчид, жимсчдийн нөлөө ▪ Аялал жуулчлал | 9.5 |

| | | | | | | | | |
|---|-------------------|---|----|----|-----------|--|---|------|
| 3 | Хустай БЦГ | Монгол тарвага (<i>Marmota sibirica</i>) | LC | EN | 19,464 | 1000 га-д 4600 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус ан ▪ Махчин амьтны нөлөө ▪ Мал, хүний нөлөө ▪ Амьдрах орчны доройтол | 7.5 |
| | | Халиун буга (<i>Cervus elaphus</i>) | LC | CR | 26,797 | 1000 га-д 11.5 бодгаль Нөөц:585 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус ан ▪ Амьдрах орчны доройтол ▪ Махчин амьтны нөлөө | 8.25 |
| | | Идлэг шонхор (<i>Falco cherrug</i>) | EN | VU | - | 1000 га-д 0.03 бодгаль Нөөц: 16 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Өндөр хүчдэлийн шугам ▪ Мал, хүний нөлөө | 8.4 |
| 4 | Дорнод Монгол ДЦГ | Цагаан зээр (<i>Procarpa gutturosa</i>) | LC | EN | 2,423,962 | 1000 га-д 15.4 бодгаль Нөөц:37, 340.7 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Газрын тос олборлолтын нөлөө ▪ Хээрийн түймэр ▪ Шүлхий зэрэг халдварт өвчин ▪ Ган, зудад өртөмтгий | 12.3 |
| | | Монгол тарвага (<i>Marmota sibirica</i>) | LC | EN | - | 1000 га-д 1.4 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Махчин амьтны нөлөө ▪ Хүн, малын нөлөө | 14.1 |
| 5 | Монгол Дагуур ДЦГ | Цагаан зээр (<i>Procarpa gutturosa</i>) | LC | EN | 690,158 | 1000 га-д 90 бодгаль Нөөц:66, 696.2 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хээрийн түймэр ▪ Гал тэрэгний зам амьдрах орчныг хуваадаг ▪ Шүлхий зэрэг халдварт өвчин ▪ Ган, зудад өртөмтгий ▪ Амьдрах орчны доройтол | 13 |

| | | | | | | | | |
|---|-------------------|---|----|----|-------------|---|--|-------|
| | | Хошуу галуу (<i>Anser cygnoides</i>) | VU | NT | 50,000 | 1000 га-д 100.4 бодгаль Нөөц:11, 905 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Амьдрах орчны алдагдал (Гол горхи ширгэх г.м) ▪ Хүн малын нөлөөгөөр амьдрах орчин доройтох ▪ Зөвшөөрөлгүйгэ эр усны шавьж түүж БНХАУ-руу экспортлох | 10 |
| | | Цэн тогоруу (<i>Grus vipio</i>) | VU | VU | 50,000 | 1000 га-д 0.7 бодгаль Нөөц:34. 7 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Амьдрах орчин алдагдал, доройтол ▪ Хүн, малын нөлөө их | 13 |
| 6 | Тосон Хулстай БНГ | Цагаан зээр (<i>Procarpa gutturosa</i>) | LC | EN | 450,48 0 | 1000 га-д 201.8 бодгаль Нөөц:90, 902.6 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хүн, малын нөлөө их ▪ Хээрийн түймэр ▪ Шүлхий зэрэг халдварт өвчин ▪ Ган, зудад өртөмтгий ▪ Амьдрах орчны доройтол | 12.1 |
| | | Монгол тарвага (<i>Marmota sibirica</i>) | LC | EN | 450,48 0 | 1000 га-д 106.6 бодгаль Нөөц:455 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хүн, малын нөлөө их ▪ Хээрийн түймэр ▪ - Амьдрах орчны доройтол | 11.3 |
| 7 | Онон-Балж | Цэн тогоруу (<i>Grus vipio</i>) | VU | VU | 76,520 | 1000 га-д 3 бодгаль Нөөц:254 .9 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Амьдрах орчин алдагдал, доройтол ▪ Хүн, малын нөлөө их | 13.05 |
| | | Хонин тоодог (<i>Otis tarda</i>) | VU | VU | 466,56 0 | 1000 га-д 0.14 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хүн, малын нөлөө их ▪ Амьдрах орчны доройтол | 12.9 |

| | | | | | | | | |
|---|---------------|--|-----------|-----------|------------------|--|--|-------|
| | | | | | | Нөөц:66.5 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Махчин амьтны нөлөө | |
| | | Тул (<i>Hucho taimen</i>) | - | EN | 518 км голын урт | 1 км-т 1.09 бодгаль (Цогтсай хан, 2013) | <ul style="list-style-type: none"> ▪ Уул уурхай, эрдэс олборлолт ▪ Амьдрах орчны доройтол ▪ Хууль бус агнуур | 11.85 |
| 8 | Орхоны хөндий | Монгол тарвага (<i>Marmota sibirica</i>) | LC | EN | 25,299 | 1000 га-д 84,9 бодгаль Нөөц: 2148.2 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хүн, малын нөлөө их ▪ Амьдрах орчны доройтол ▪ Нарийн ам орчимд аялал жуулчлалын нөлөө их | 13 |
| | | Халиун буга (<i>Cervus elaphus</i>) | LC | CR | 55,737 | 1000 га-д 2.1 бодгаль Нөөц: 100-120 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хүн, малын нөлөө их ▪ Амьдрах орчны доройтол ▪ Зохион байгуулалтгүй аялал жуулчлал | 7.2 |
| 9 | Отгонтэнгэр | Халиун буга (<i>Cervus elaphus</i>) | LC | CR | 109,169 | 1000 га-д 2.8 бодгаль Нөөц: 310 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хүн, малын нөлөө их ▪ Ойн түймэр ▪ Мод бэлтгэл ▪ Амьдрах орчны доройтол, алдагдал ▪ Ган, зуд | 9.6 |
| | | Янгир (<i>Capra sibirica</i>) | LC | NT | 4,342 | 1000 га-д 4.25 бодгаль Нөөц: 18 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хүн, малын нөлөө их ▪ Амьдрах орчны доройтол ▪ Ган, зуд | 11.1 |

| | | | | | | | | |
|----|--------------------|---|----|----|---------|--|--|------|
| | | Нөмрөгт Банздоо, Вансэмбэрүү (<i>Saussurea involucrate</i>) | - | EN | 2,204 | 1000 га-д 11.34 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Амьдрах орчны доройтол ▪ Хууль бусаар түүх, бэлтгэх | 13.7 |
| 10 | Тарвагатай н нуруу | Янгир (<i>Capra sibirica</i>) | | | 26,892 | 1000 га-д 1.8 бодгаль Нөөц: 49 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хүн, малын нөлөө их ▪ Амьдрах орчны доройтол ▪ Ган, зудад өртөмтгий | 11.1 |
| | | Халиун буга (<i>Cervus elaphus</i>) | LC | CR | 95,458 | 1000 га-д 2 бодгаль Нөөц: 199 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хүн, малын нөлөө их ▪ Ойн түймэр ▪ Мод бэлтгэл ▪ Амьдрах орчны доройтол ▪ Ган, зудад өртөмтгий | 7.6 |
| 11 | Хангайн нуруу | Монгол тарвага (<i>Marmota sibirica</i>) | LC | EN | 136,503 | 1000 га-д 48 бодгаль Нөөц: 6595 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хүн, малын нөлөө их ▪ Амьдрах орчны доройтол | 12.9 |
| | | Янгир (<i>Capra sibirica</i>) | LC | NT | 146,354 | 1000 га-д 2 бодгаль Нөөц: 282 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хүн, малын нөлөө их ▪ Амьдрах орчны доройтол ▪ Ган, зудад өртөмтгий | 12.1 |
| | | Алтайг хойлог (<i>Tetraogallus altaicus</i>) | LC | NT | 146,354 | 1000 га-д 2.6 бодгаль Нөөц: 313 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус агнуур ▪ Хүн, малын нөлөө их ▪ Амьдрах орчны доройтол ▪ Гэнэтийн хүйтрэл, цас их унах | 10.9 |

| | | | | | | | | |
|----|-----------------------------------|---------------------------------------|----|----|-----------|--|--|-------|
| 12 | Зэд-Хантай- Бүтээлийн нуруу | Тул (<i>Hucho taimen</i>) | | EN | - | 1 км-т 1 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Амьдрах орчны доройтол ▪ Хууль бус ан | 13.1 |
| | | Хандгай (<i>Alces alces</i>) | LC | EN | 256,850 | 1000 га-д 0.36 бодгаль Нөөц: 93.99 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Махчин амьтны нөлөө ▪ Амьдрах орчны доройтол ▪ Хууль бус ан ▪ Намар жимсчид, самарчид | 11.1 |
| | | Зэрлэг гахай (<i>Sus scrofa</i>) | LC | NT | 605,008.9 | 1000 га-д 0.88 бодгаль Нөөц: 535.9 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус ан ▪ Махчин амьтны нөлөө ▪ Амьдрах орчны доройтол ▪ Намар жимсчид, самарчид | 9.3 |
| 13 | Улаан тайга | Тул (<i>Hucho taimen</i>) | | EN | - | 1 км-т 0.42 | <ul style="list-style-type: none"> ▪ Амьдрах орчны доройтол ▪ Хууль бус ан | 11 |
| | | Халиун буга (<i>Cervus elaphus</i>) | LC | CR | 543,499.8 | 1000 га-д 0.49 бодгаль Нөөц: 264.25 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус ан ▪ Ойн түймэр ▪ Амьдрах орчны доройтол ▪ Мод бэлтгэл, самар, жимс түүх | 7.5 |
| 14 | Хорьдол Сарьдаг | Аргаль (<i>Ovis ammon</i>) | VU | EN | 84,303.2 | 1000 га-д 0.69 бодгаль Нөөц: 57.98 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Махчин амьтны нөлөө ▪ Амьдрах орчны доройтол ▪ - Хууль бус ан | 12.15 |
| | | Янгир (<i>Capra sibirica</i>) | LC | NT | 127,861.3 | 1000 га-д 1.29 бодгаль Нөөц: 165.29 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Махчин амьтны нөлөө ▪ Амьдрах орчны доройтол ▪ Хууль бус ан | 12.15 |
| | | Хандгай (<i>Alces alces</i>) | LC | EN | 79,680.3 | 1000 га-д 0.4 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Махчин амьтны нөлөө ▪ Амьдрах орчны доройтол ▪ Хууль бус ан ▪ Намар жимсчид | 11.1 |

| | | | | | | | | |
|----|-------------------|---------------------------------------|----|----|---------------|--|---|-------|
| | | | | | | Нөөц: 32.38 бодгаль | | |
| 15 | Тэнгис- Шишгэд | Тул (<i>Hucho taimen</i>) | | EN | | 1 км-т 1.09 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Амьдрах орчны доройтол ▪ Хууль бус ан | 10.95 |
| | | Халиун буга (<i>Cervus elaphus</i>) | LC | CR | 487,70 2.4 | 1000 га-д 0.34 бодгаль Нөөц: 167.69 бодгаль | <ul style="list-style-type: none"> ▪ Хууль бус ан ▪ Ойн түймэр ▪ Амьдрах орчны доройтол ▪ Мод бэлтгэл, самар, жимс түүх | 7.65 |

ХӨХТӨНД ҮЗҮҮЛЖ БҮЙ СӨРӨГ НӨЛӨӨ:

Монгол орны байгалийн нөхцөл өөрчлөгдөж, хуурайшиж байгаа нь зэрлэг хөхтөн амьтдын хувьд тааламжгүй нөлөөлөх нь эргэлзээгүй. Говь, цөлийн хуурай гандуу нутагт тархсан мазаалай, хавтгай, монгол бөхөн, хар сүүлт зээр, хулан зэрэг ховор амьтдын хувьд усан хангамж хомс, улмаар тэдгээрийн амьдрах орчин доройтож байгаа нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн сөрөг нөлөө юм. Энэ сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр сүүлийн үед Монголын төрийн болон төрийн бус байгууллага хамтран зарим арга хэмжээг авч эхэлсэн байна. Тухайлбал, 2013 оноос мазаалайг хамгаалах, түүний амьдрах орчныг дэмжих зорилгоор Их говийн дархан газрын нутагт газрын генератор хэмээх төхөөрөмжийг суурилуулж, хур тунадсыг нэмэгдүүлэх арга хэмжээ авчээ.

Цөлжилт, усны хомсдол, газрын эвдрэл зэрэг дээр дурдсан хүчин зүйлийн нөлөөгөөр тэнд амьдрах зэрлэг хөхтөн амьтдын амьдрах орчин өөрчлөгдсөнөөс шалтгаалан, тэдгээр амьтдын байршил нутаг жилээс жилд өөрчлөгдөж байна. Ялангуяа говийн зарим баян бүрд ширгэснээс тэнд амьдрах хавтгай, хулан, хар сүүлт зээр зэрэг амьтдын улирлын байршил өөрчлөгдөж, амьдрах орчны таагүй нөхцөл бий болсоор байна.

Монгол орны зэрлэг амьтад хил давж нүүх нь элбэг байгаа бөгөөд хилийн наад хэсэгт амьтад идээшин нутаглах боломж хумигдсаар. Түүнчлэн мод бэлтгэл, ойн түймэр зэрэг хүчин зүйлийн сөрөг нөлөө ихсэх хандлагатай байгаа юм.

Монгол улсын үндсэн хуульд заасны дагуу аливаа ан амьтан төрийн өмч бөгөөд хамгаалах зохистой ашиглахтай холбогдсон харилцааг үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах хууль (1995), Амьтны тухай хууль (2012) болон эдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна. Агнуурын амьтдыг агнах, барихыг хориглох хугацаа, хориотой аргаар агнахыг амьтны тухай хуулиар зохицуулсан юм.

Монгол орны ан амьтны баялгийг хамгаалах, зөв зохистой ашиглах нь Монголын иргэдийн амьжиргаа эдийн засагт чухал ач холбогдолтой. Тухайлбал, ан амьтан агнуулсны төлбөрийн орлогоос Монгол улсын төсөвт багагүй хэмжээний мөнгө төвлөрдөг. Түүнчлэн энгийн иргэдийн хүнс, ахуйн хэрэглээнд ч ан амьтны орлого тодорхой байр суурийг эзэлж байна

Бүлэг V – Иш татсан бүтээлийн жагсаалт

Adiya, Ya., D. Enkhbileg and B. Ariunbayar. (2010). *Evaluation of National Programme on Conservation of Biodiversity Mongolia*. “Community-based Conservation of Biodiversity in the Mountain Landscape of Mongolia’s Altai Sayan Eco-Region Project” (MON/04/G/41 39250).

Ananieva, N. B., Munkhbayar, Kh., Orlov, N. L., Orlova, V. F., Semenov, D.V. and Terbish, Kh. (1997). *Amphibians and reptiles*. Moscow. KMK. 415 pp.

Baasanjav, G. and Tsend-Ayush, Ya. (2001). *Fishes of Mongolia*. Ulaanbaatar. 180 pp. (in Mongolian)

Baig, K.J., P. Wagner, N. B. Ananjeva and Bohme, W. (2012). A morphology-based taxonomic revision of *Laudakia* Gray, 1845 (Squamata: Agamidae). *Vertebrate Zoology* **62** (2): 213-260.

Banzragch, Ts. (1965). Dictionary of Latin-Mongolian-Russian names of vascular plants in the People’s Republic of Mongolia. *Scientific Proceedings of the State Terminology Commission*, No. 65-72. Ulaanbaatar. (in Mongolian).

Batsaikhan, N., Samiya, R., Shar, S., Lkhagvasuren, D., King, S. R. B. (2014). A field guide to the mammals of Mongolia. 2nd edition. Ulaanbaatar, Mongolia.

Berg, L.S. (1911). *Freshwater fishes of the USSR and adjacent countries*. V.5. (in Russian)

Berg, L.S. (1912). *Freshwater fishes of the USSR and adjacent countries*. V.3. (in Russian)

Biazrov, L.G. (2010). *Checklist of the Mongolian lichens*. http://www.sevin.ru/laboratories_eng/biazrov.html

Biazrov, L.G., Ganbold, E., Gubanov, I.A. and Ulzjhutag, N. (1989). *Flora Khangaya*. Nauka, Leningrad, Russia. 191pp.

BirdLife International. (2011). *IUCN Red List for Birds*. Downloaded from <http://www.BirdLife.org> on 18/01/2011.

Bogutskaya, N.G. and Naseka, A. M. (2004). *Catalogue of Agnathans and Fishes of freshwater and brackish waters of Russia with comments on nomenclature and taxonomy*. KMK Scientific Press Ltd., Moscow. (in Russian)

Bold, A. and Stepanyan, L.S. (1988). A checklist of birds of the Mongolian People’s Republic. *Ornithology* 5:23. (In Russian)

Bold, A., Tsevenmyadag, N., Boldbaatar, Sh. and Mainjargal, G. (2007). A checklist of Mongolian birds in ten different languages. *State Terminology* 2 (150). (In Mongolian)

- Bold, A., Tseveenmyadag, N., Boldbaatar, Sh. Sumiya, D., Gombobaatar, S. and Mainjargal, G. (2001). Review of names of species, genera, family and orders of birds of Mongolia. *The Proceedings of the Institute of the Philology* 1:80-91. (In Mongolian)
- Buck, W.R. and Goffinet, B. (2000). *Morphology and classification of the mosses*. In: Shaw, A.J. and Goffinet, B. (eds.). *Bryophyte Biology*. Cambridge University Press, Cambridge. p. 71–123.
- Bukhchuluun, Ts. And Baigal-Amar, T. (2018). *The conspectus of algae in Mongolia (diatoms excluded)*. Mongolia, Ulaanbaatar. 314 pp.
- Clark, E. L., Munkhbat, J., Dulamtseren, S., Baillie, J. E. M., Batsaikhan, N., Samiya, R. and Stubbe, M. (compilers and editors. 2006. *Mongolian Red List of Mammals. Regional Red List Series Vol. 1*. Zoological Society of London, London.
- Cogt, U. (1995). Die Flechten der Mongolei. *Willdenowia* 25 (1): 289-397.
- Cogt, U. (1997). Lichens: *Mongolian Red Book*. Ministry of Nature and Environment. Ulaanbaatar, Mongolia. p. 354-364.
- CSIC. (2011). *Environment and natural resources' management report 2010*. A document of sustainable development in East Asia and Pacific region. The department of sustainable development in East Asia and Pacific region. World bank. Washington DC. P.24.
- Dashdorj, A., Lindberg, G.U. and Chu Shi-Pin. (1964). *A dictionary of commercial fishes of western part of the Pacific Ocean*. Beijing. 440 pp. (in Mongolian).
- Dashdorj, A., Tsendsuren, A. and Dulmaa, A. (1970). *A dictionary of water organisms of Mongolia*. Ulaanbaatar. 189 pp. (in Mongolian).
- Dawaa, N., Busching, W.-D., Sumijaa, D., Bold, A. and Samijaa, R. (1994). *Kommentierte checkliste der Vogel und Sauger der Mongolei*. Naumann-Museum, Kothlen, Germany. (In German)
- Dorofeyuk, N.I and Kulikovskiy, M.S. (2012). *Diatoms of Mongolia*. Moscow. 367 pp.
- Enkhtuya, O. (2007). *The lichen flora of Bogd Khan Mountain and air pollution (sinus and indicator)*. Ulaanbaatar, Mongolia. 232 pp.
- Enkhtuya, O. (2013). *Lichens: Mongolian Red Book*. Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar, Mongolia. p. 481-497.
- Enkhtuya, O. and Javkhlan, S. (2017). *Photo guide to lichens of Mongolia*. Mongolian Academy of Sciences. Ulaanbaatar, Mongolia. 220 pp.
- Eriksson, O.E. (ed.). (2006). Outline of Ascomycota. *Myconet* 12:1-82.

Esslinger, T. L. (2012). *Accumulative checklist for the lichen-forming, lichenicolous and allied fungi of the continental United States and Canada*. North Dakota Univ., USA.

Fomin, V. E. and Bold A. (1991). *Catalogue of the birds of the Mongolian People's Republic*. Nauka, Moscow. (In Russian)

Garnica S, Riess K, Schon ME, Oberwinkler F, Setaro SD. (2016). Divergence Times and Phylogenetic Patterns of Sebaciniales, a Highly Diverse and Widespread Fungal Lineage. *PLoS ONE* 11(3): e0149531. doi:10.1371/journal.pone.0149531

Gill, F. and Donsker, D. (eds). (2018). *IOC World Bird List (v 8.2)*. <http://www.worldbirdnames.org/>

Goffinet, B. and Buck, W.R. 2004. *Systematics of the Bryophyta (mosses): from molecules to a revised classification*. In: Goffinet, B., Hollowell, V., and Magill, R. (eds.). *Molecular Systematics of Bryophytes*. Missouri Botanical Garden Press, St. Louis. p. 205–239.

Golubkova, N.S. (1981). *Conspectus Lichen Flora of the Mongolian People's Republic*. Nauka, Leningrad, Russia. 200 pp. (in Russian).

Gombobaatar, S. (2009). *A dictionary of vertebrate animals of Mongolia*. (In nine different languages). Ulaanbaatar. 317 p. (in English)

Gombobaatar, S. and Monks, E. M. (compilers), Seidler, R., Sumiya, D., Tseveenmyadag, N., Bayarkhuu, S., Baillie, J. E. M., Boldbaatar, Sh. and Uuganbayar, Ch. (eds.). (2011). *Regional Red List Series Vol.7. Birds*. Zoological Society of London, National University of Mongolia and Mongolian Ornithological Society. 1036 pp. (In English)

Gombobaatar, S. (compiler), Brown, H.J., Sumiya, D., Tseveenmyadag, N., Boldbaatar, Sh., Baillie, J.E.M., Batbayar, G., Monks, E.M., Stubbe, M. (Editors) (2011a). *Summary Conservation Action Plans for Mongolian Birds. Regional Red List Series Vol. 8*. Zoological Society of London, Mongolian Ornithological Society and National University of Mongolia. p.145. (In English)

Gombobaatar Sundev, Nathan Conaboy, Urgamal Magsar, Terbish Khayankhirvaa, and Gantigmaa Chuluunbaatar. (2018). Biodiversity in Mongolia. *Global Biodiversity*. Vol.1. Selected Countries in Asia. Apple Press, Canada. 548 pp.

Grubov, V.I. (2001). *Key to the vascular plants of Mongolia*. Science Publishers. USA. p.1-817.

Gunbilig, D. and Boland, W. 2009. Defensive Agents of *Blaps femoralis*, a traditional Mongolian Medicinal Insect. *Scientia Pharmaceutica*. **77**: 597-604.

Igantov, M.S. and Ignatova, E. A. 2003. *Moss flora of middle part of European Russia*. Moscow. Vol. 1. 608 pp.

Igantov, M.S. and Ignatova, E. A. 2004. *Moss flora of middle part of European Russia*. Moscow. Vol. 2. 352 pp.

Igantov, M.S., Afonina, O.M. and Ignatova, E.A. with contributions on regional floras from: A.A. Abolina, T.V. Akatova, E.Z. Baisheva, L.V. Bardunov. 2006. *Check-list of mosses of East Europe and North Asia*. – Arctoa. 2006. Vol. 15. p. 1–130.

IOC World Bird List. 2018. Update (8.2) <http://dx.doi.org/10.14344/IOC.ML.8.2>

IUCN, 2003. *IUCN Red List Categories*. V.3.0. Prepared by the IUCN Species Survival Commission. IUCN, Gland, Switzerland.

Kherlenchimeg, N. 2014. Brief conspectus of the order Agaricales Underw to the flora fungus of Mongolia. *Proc. of the Inst. of Botany, Mongolian Academy of Sciences*. 26: 56-69.

Kherlenchimeg, N. and Burenbaatar, G. 2017. Conspectus of Mongolian higher fungi. Ulaanbaatar, Mongolia. 193 pp.

Kirk, P. M., Cannon, P. F., Minter, D. W. and Stalpers, J. A. (eds). (2008). *Dictionary of the fungi*. 10th Edition. Trowbridge: Cromwell Press. 771 pp.

Kottelat, M. (2006). *Fishes of Mongolia. A check-list of the fishes known to occur in Mongolia with comments on systematics and nomenclature*. Washington, DC. USA.

Kropachev, I.I., Orlov, N. L. and Orlova, V. F. (2016). *Gloydus ussuriensis* (Emelianov, 1929) (Serpentes: Viperidae: Crotalinae) - A new snake species for the herpetofauna of Mongolia. *Russian Journal of Herpetology* 23(2): 108-114.

Kuzmin, S.L., Dunayev, E.A., Munkhbayar, Kh., Munkhbaatar, M., Oyunchimeg, J. and Terbish Kh. (2017). *The amphibians of Mongolia*. KMK Scientific Press. Moscow. 274 pp.

Manibazar, N. 2010. *Dictionary of Latin-Mongolian species name of vascular plants in Mongolia*. Ulaanbaatar, Mongolia. 244pp. (in Mongolian).

Mendsaikhan, B., Dgebuadze, Yu. and Surenkhorloo, P. (2017). *Guide book to Mongolian fishes*. World Wide Fund for Nature (WWF) Mongolia Programme Office. Ulaanbaatar. 203 pp.

Mongolian Red Book. 1997 and 2013. Ministry of Nature, Environment and Tourism. Ulaanbaatar, Mongolia. 390 pp.

Muehlenberg, M., M. Eva-Horn, A. Enkhmaa and Erdenetungalag L. (2011). *Biodiversity survey at Khonin Nuga research station West Khentey*. Mongolia.

Munkhbayar, Kh. (1976). *Amphibians and reptiles of Mongolia*. The Ministry of State Education's publication. Ulaanbaatar. 166 pp.

Munkhbayar, Kh., Terbish, Kh. and Munkhbaatar, M. (2010). *Amphibians and reptiles of Mongolia*. Ulaanbaatar. 78 pp.

Nelson, J. S. (1976). *Fishes of the World*. First edition. USA.

Ocock, J., Baasanjav, G., Baillie, J. E. M., Erbenabat, M., Kottelat, M., Mendsaikhan, B. and Smith, K. (compilers and editors). (2006). *Mongolian Red List of Fishes*. Regional Red List Series Vol. 3. Zoological Society of London, London. (In English and Mongolian)

Orlova, V.F., Poyarkov, N.A., Chirikova, M.A., Nazarov, R.A., Munkhbaatar, M., Munkhbayar, Kh. and Terbish Kh. (2017). MtDNA differentiation and taxonomy of Central Asian racerunners of *Eremias multiocellata*-*E. przewalskii* species complex (Squamata, Lacertidae). *Zootaxa* 4282 (1): 001-042.

Potemkin, A. O. and Sofronova, E. V. (2009). *Liverworts and hornworts of Russia*. Vol. 1. Boston- Spectr., Saint Petersburg & Yakutsk. 368 pp.

Prokofiev, A. M. (2002). Stone loaches (Balitoridae: Nemacheilinae) from the Uvs Nuur Lake basin at the boundary of Tuva and Mongolia. *Journal of Ichthyology* 42: 45-59.

Prokofiev, A. M. (2003). Materials of the Revision of common stone loaches (Balitoridae: Nemacheilinae; Orthrias Jordan and Fowler 1903) from Mongolia and adjacent areas: Two new species from Tuva and Mongolia. *Journal of Ichthyology* 43: 725-738.

Prokofiev, A. M. (2006). Two new species of the loach genus *Triplophysa* Rendahl 1933 from Western Mongolia and North Western China, with a key of the species from the interior drainages of Tien, Karakurun and Altai Mountains. *Senckenbergian Biology*. p. 235-259.

Prokofiev, A. M. (2007). *Cobitis Olivia* Nalbant, Holcik & Pivnicka 1970, a valid species of spined loaches from Mongolia: redescription and comparison with *C. melanoleuca* Nicols 1925 (Osteichthys, Cypriniformes, Cobitidae). *Senckenbergian Biology*. p. 111-124.

Roux, C. and Navarro-Rosines, P. (2011). *Trimmatothelopsis* (Acarosporaceae, Ascomycota lichenisati), le nom legitime de *Silobia*. *Bull. Soc. Linn.* 62: 167- 187.

Santesson, R., Moberg, R., Nordin, A., Tonsberg, T. and Vitikainen, O. (2004). *Lichen-forming and lichenicolous fungi of Fennoscandia*. Museum of Evolution, Uppsala Univ. 359 pp.

Stepanyan, L. S. (2003). *Conspectus of ornithological fauna of Russia and neighbouring territories*. Nauka. Moscow, Russia.

Terbish Kh., Munkhbayar Kh., Clark E.L., Munkhbat J. and Monks E.M. 2006. *Mongolian Red List of Reptiles and Amphibians. Regional Red List Series Vol. 5.* Zoological Society of London, London.

Terbish, Kh., Munkhbayar, Kh. and Munkhbaatar, M. (2013). *A guide to the amphibians and reptiles of Mongolia.* Ulaanbaatar. 80 pp.

Tsegmid, Ts. (2001). *Identification guide to the moss of Mongolia.* Ulaanbaatar, Mongolia. 473 pp.

Tsegmid, Ts. (2010). *Flora moss of Mongolia.* Joint Russian and Mongolian biological complex expeditions. Moscow. Vol. 56. 634 pp.

Urbanavichus, G.P. (2010). *A checklist of the lichen flora of Russia.* Nauka, St Peterburg, Russia. 194 pp.

Urgamal, M. (2018). *Species catalogue of rare and threatened plants of Mongolia.* Ulaanbaatar, Mongolia. Bembi san. 193 pp.

Urgamal, M. & Oyuntsetseg B. (2017). *Atlas of the endemic vascular plants of Mongolia.* Ulaanbaatar. Mongolia. “Bembi San“ Press. 108 pp.

Urgamal, M. (2012). The databases on the herbarium and the flora of Mongolia. *Erforschung Biologischer Ressourcen Der Mongolei. Proceedings of the International Conference of the Biodiversity of Research in Mongolia.* Halle (Saale). Germany. 25-29 March. p. 39-40.

Urgamal, M., Oyuntsetseg, B., Nyambayar, D. & Dulamsuren, Ch. (2014). *Conspectus of the vascular plants of Mongolia.* (Editors: Sanchir, Ch. & Jamsran, Ts.). Ulaanbaatar, Mongolia. 334 pp.

Urgamal, M., B. Oyuntsetseg, and D. Nyambayar. (2013). Synopsis and recent additions to the flora of Mongolia. *Scientific Proceedings of the Institute of Botany, Mongolian Academy of Sciences.* 25: 53-72.

Wingard, J., Pascual, M., Rude, A., Houle, A., Gombobaatar, S., Bhattacharya, G., Munkhjargal, M., Conaboy, N., Myagmarsuren, S., Khaliun, T., Batsugar, T., Bold, T. 2018. *Wildlife Trade Crisis, Ten Years Later.* Zoological Society of London, London UK, Legal Atlas and IRIM. 218 pp.

Азжаргал, Ж. (2013). *Баян-Өлгий аймгийн Даян нуур орчмын жинхэнэ аалзны (Araneae) бүлгэмдлийн судалгаа.* Магистрын зэрэг горилсон бүтээл. х. 1-75.

Айбек, У. (2019). Бүлэг: шоргоолж (Insecta: Formicidae). *Монгол орны биологийн олон янз байдал: нугаламт болон нугаламгүй амьтдын зүйлийн жагсаалт.* (С. Гомбобаатар, С. Шар (редактор)). Боть 1. Монгол улсын их сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс. Х.1-312.

Алдармаа, Ж., Б. Дагвацэрэн, Э. Энхтөр, Л. Хишигжаргал, До. Наранцэцэг. (2010). Хар хорхойн *Blaps ferroralis* бэлдмэлийн фармакологийн зарим үйлдэл. *ШУА-ийн ЭШБ* 1: 3-17.

Ананьева, Н.Б., Х. Мунхбаяр, Н.Л. Орлов, В. Ф. Орлова, Д. В. Семенов, Х. Тэрбиш. (1998). *Земноводные и пресмыкающиеся.* Москва. с.1-415.

Аюушсүрэн Ч. ба Мэндсайхан, Б. (2019). Бүлэг: загас (Vertebrata: Pisces). *Монгол орны биологийн олон янз байдал: нугаламт болон нугаламгүй амьтдын зүйлийн жагсаалт*. (С. Гомбобаатар, С. Шар (редактор)). Боть 1. Монгол улсын их сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс. Х.1-312.

Баасанжав, Г., Я. Цэнд-Аюуш. (2001). *Монгол орны загас*. Улаанбаатар. х.180.

Бадамжаргал, С. (2010). *Хэнтий аймгийн ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэдгээртэй тэмцэл явуулсан ажлын тухай товч мэдээ. БОЯ-ны Ойн хайгууль, судалгааны төвийн тайлан*.

Байгалийн Ургамлын тухай хууль. (1995). Хуулийн эмхэтгэл. Азийн Сан (2008). Улаанбаатар. х. 273-280, 353-355.

Байгаль орчин аялал жуулчлалын яам. (2011). *Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох, тэмцлийн ажил зохион байгуулах төслийн тайлан*. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Ойн газар.

Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2015-2016. (редактор: Г.Нямдаваа, Ц.Шийрэвдамба, А.Энхбат, С.Гомбобаатар, З.Батжаргал, Г.Даваа, Ш.Халгар, Б.Удвал, О.Батхишиг). Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Улаанбаатар хот, Монгол улс. Х.1-264.

Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2017-2018. Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Улаанбаатар хот, Монгол улс. Х.1-200.

Байгаль орчны хуулийн эмхтгэл. (2012). Монгол улсын Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яам. Улаанбаатар хот. 2013.

Батсайхан, Н. (2019). Бүлэг: хөхтөн (Vertebrata: Mammalia). *Монгол орны биологийн олон янз байдал: нугаламт болон нугаламгүй амьтдын зүйлийн жагсаалт*. (С. Гомбобаатар, С. Шар (редактор)). Боть 1. Монгол улсын их сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс.

Батцэцэг, Ж. (2019). Бүлэг: бөөс, бүүрэг, хос далавчтан (Insecta: Si phonaptera, Anoplura & Diptera), хачиг (Arachnida: Parasitiformes, Mesostigmata & Trombidiformes). *Монгол орны биологийн олон янз байдал: нугаламт болон нугаламгүй амьтдын зүйлийн жагсаалт*. (С. Гомбобаатар, С. Шар (редактор)). Боть 1. Монгол улсын их сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс. Х.1-312.

Бөхчулуун, Ц. (2019). Бүлэг: замаг. *Монгол орны биологийн олон янз байдал: ургамал, мөөг, бичил биетний зүйлийн жагсаалт*. Боть 2. (С. Гомбобаатар, Д. Суран, Н. Сонинхишиг, Д. Батжаргал (редактор)). Монгол улсын их сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс. Х.1-420.

Бөхчулуун, Ц. (2019). Бүлэг: замаг. *Монгол орны ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөө. Хоёрдугаар цуврал. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 11.* Монгол улсын их сургууль, Шинжлэх ухааны академи, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг. Улаанбаатар, Монгол улс.

Буянжаргал, Б., Намхайдорж Б. (2010). *Ойн экосистемд эвэрт цохын (Ceratbycidae) элдэв хэлбэр нутагших орчин нөхцөл.* Хөдөө аж ахуй, биотехнологийн салбарын семинар. Хүрэлтогоот. х 27-33.

Бүрэнбаатар, Г. (2013). *Хэнтийн уулсын зарим нутгийн дүлийтэн (Lycoperdaceae) мөөгийн судалгаа.* Биологийн ШУ-ны магистрын зэрэг горилсон бүтээл. МУИС. х. 57.

Ганзориг, С. (2019). Бүлэг: шувууны шимэгч хорхой (Plathelminthes, Acantoccephala & Nemathelminthes). *Монгол орны биологийн олон янз байдал: нугаламт болон нугаламгүй амьтдын зүйлийн жагсаалт.* (С. Гомбобаатар, С. Шар (редактор)). Боть 1. Монгол улсын их сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс. Х.1-312.

Гантигмаа, Ч. (2019). Бүлэг: үе хөлтний хүрээний шавьжийн анги (Arthropoda: Insecta: Ephemeroptera, Odonata, Orthoptera, Plecoptera, Coleoptera, Hymenoptera, Lepidoptera & Diptera). *Монгол орны биологийн олон янз байдал: нугаламт болон нугаламгүй амьтдын зүйлийн жагсаалт.* (С. Гомбобаатар, С. Шар (редактор)). Боть 1. Монгол улсын их сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс. Х.1-312.

Гантигмаа, Ч., Б. Баяртогтох, У. Айбек, Д. Алтанчимэг, Д. Энхнасан. 2012. “Монгол орны шавьж, сээр нуруугүйтны тархацын судалгааг зохион байгуулах” сэдэвт ажлын тайлан.

Гомбобаатар, С ба Цэвээнмядаг, Н. (2019). Бүлэг: шувуу (Vertebrata: Aves). *Монгол орны биологийн олон янз байдал: нугаламт болон нугаламгүй амьтдын зүйлийн жагсаалт.* (С. Гомбобаатар, С. Шар (редактор)). Боть 1. Монгол улсын их сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс. Х.1-312.

Гомбобаатар, С. ба Ургамал, М. (2019). Бүлэг: ерөнхий бүлэг. *Монгол орны ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөө. Хоёрдугаар цуврал. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 11.* Монгол улсын их сургууль, Шинжлэх ухааны академи, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг. Улаанбаатар, Монгол улс.

Гомбобаатар, С. ба Шар, С. (редактор). (2019). *Монгол орны биологийн олон янз байдал: нугаламт болон нугаламгүй амьтдын зүйлийн жагсаалт.* Боть 1. Монгол улсын их сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс. Х.1-312.

Гомбобаатар, С., Мягмарсүрэн, Ш. (2018). Монгол орны хууль бус худалдаанд өртөж буй ургамал, амьтан. Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, Степ форвард хөтөлбөр, Монгол улсын их сургууль. Улаанбаатар, Монгол. х.1-138.

Грубов, В.И. (1982). *Определитель сосудистых растений Монголии (с атласом)*. Наука, Ленинград. 444 стр. (Орос хэлээр)

Губанов, И.А. (1996). *Конспект флоры внешней Монголии (сосудистые растения)*. Валанг, Москва, 136 стр. (Орос хэлээр)

Дариймаа, Ш. (2009). Монгол орны ургамлын аймагт бүртгэсэн шинэ зүйлүүд. *ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн ЭШБ* 21: 44-50.

Дгебуадзе Ю.Ю. А.М. Прокофьев, Ю.В. Слынько, М. Эрдэнэбат, Б. Мэндсайхан. (2009). Водные экосистемы бассейна Селенги. *Биологические ресурсы и природные условия. Монголии*. Том LV. Москва. с. 233-312.

Лигаа, У., Дариймаа, Ш., Цэрэннадмид, П., Жанчивдорж, Н., Сарангэрэл, У. ба Бат-Энэрэл, Б. (2008). *Монгол орны нэн ховор ургамлын зурагт лавлах*. Улаанбаатар. 212 х.

Лигаа, У., Дариймаа Ш., Жанчивдорж, Н., Сарангэрэл, У., Жамъяндорж, Х. ба Бат-Энэрэл, Б. (2009). *Монгол орны ховор ургамлын зурагт лавлах*. Улаанбаатар. 388 х.

Мижиддорж, Б. (2013). *Мазаалай*. Нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар.

